Нар аргамждагаараа алдаршсан
Наро Банчэн хутагтын намтар цадиг

НОГООН ДЭВТЭР

Наймдугаар цуврал

Наро Банчэн хутагтын намтар, цадиг Завхан аймагт зохиогдох хутагтын номын уриаг орчуулан эмхэтгэн бичсэн МБШТөв Гандандэгчэлэн хийдийн гавж Доктор, Ph/D нэрийг зүүгч Ц.Отгонбаяр

Улаанбаатар, 2015 он

Хянасан: Ц.Бямбаа
Д.Саруул
П.Яньдий
П.Цэвэгмид
Г.Жалсрайжамц

Эх бэлтгэсэн: О.Ширавжамц
О.Ширавсингэ
Ж.Дагийжанчив
Ч.Мандалсүрэн

Printed for free distribution by
The Corporate Body of the Buddha Educational Foundation
11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.
Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415
Email: overseas@budaedu.org
Website:http://www.budaedu.org
Mobile Web: m.budaedu.org
This book is strictly for free distribution, it is not to be sold.
ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Завхан аймаг дахь сүм хийдийн түүхийн товчоон. 5
Завхан нутгаас төрсөн хутагт хувилгаад
болон дээдэс лам нарын цадигаас. 40

ХОЁРДУГААР БҮЛЭГ
Наро Банчэн хутагт Данзанлхүндүв гэгээнтний тодрон
ширээнд залрахад тохиосон билэг дэмбэрэл
ард зоны хүсэлт илэрхийлсэн бичиг баримт,
урьд гэгээдийн бошго лүндэн намтар цадигаас 47
Наро Банчэн гэгээнтний өлмийг бататгах
залбирал оршвой. 50
Наро Банчэн хутагт Данзанлхүндүвийн ерөөл 52
Гэгээнтний минь өлгий нутаг Отгонтэнгэр. 53
Наро Банчэн Данзанлхүндүв гэгээнтний намтарын
далайгаас өчүүхэн төдий дурьдваасуу 57

ГУРАВДУГААР БҮЛЭГ
Наро Банчэн хутагтын тухай архивын болон ном, бүтээл,
туурвилд дурдагдсан ишлэлүүд 85

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Хутагтыг тодруулахаас өмнө Наро Банчэн судлалаар
хоёронтоо эрдэм шинжилгээний бага хурал зохион
байгуулсан ба түүнд илтгэл тавьсан
эрдэмтэн мэргэдийн ишлэл. 130

ТАВДУГААР БҮЛЭГ

Наробанчэн хутагтын номын уриа
Долоон бурхан одны тахилга 271
Эзэн Чингис богдод сэржим өргөх ёс хийгээд үйлсээ
захируулж санасан зүйлийг түргэн бүтээх сэлт оршвой. 280
Очирвааний хувилгаан эзэн Чингис хааны
залбирал тахил өргөх зан үйл 283
Наро Банчэн хутагт бээр тахилга хийх сүсэгтэн олонд
сожин хайрлахуй 289
Дүншаг буюу уналыг наминчлахуй. 294
Жившаг буюу ер уналыг наминчлахуй 298
Ямандаг нэг баатарт 300
Богд Очирваань хайрханы тахилгын зан үйл 304
Очирвааны сэржим буюу алтан ундалгаа өргөхүй 324
Монгол орны сан 331
Мандал өргөх ёсон оршвой. 335
Түй буюу угаал өргөхүй. 338
Бурханы шашин дэлгэрэхийн ерөөл. 342

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ СҮМ ХИЙДИЙН ТҮҮХИЙН ТОВЧООН

Алдархаан

1. Яруугийн хүрээ

Баянтэс

2.Гандандэчэнравжаалин (Дашчойнпэллин) хийд
3. Зайгалын харуулын сүм
4. Хачиг харуулын хүрээ

Баян-Хайрхан

5. Баянхайрханы хурал

Идэр

6. Дашпэлжээданжаглин хийд
7. Хамба гэгээний хүрээ
8. Ялгуугсан хутагтын баруун хүрээ

Их уул

9. Дашравжаалин хийд
10. Зодын хурал
11. Хуягтын хүрээ
12. Зартын хийд
13. Зартын шинэ хийд
14. Юмын хурал

Нөмрөг

15. Хатавчийн хүрээ
16. Самданпунцоглин хийд

Отгон

17. Голын хүрээ
18. Халтарын хүрээ

Сантмаргац

19. Ганданпэлжээлин хийд
20. Холбоогийн хурал

Сонгино

21. Нарангийн хурал
22. Олон булагийн дуган
23. Пунцагжанчивлин хийд
24. Тариатын хурал

Тосонцэнгэл

25. Байшинтын хүрээ
26. Дашпэлжэйлин хийд
27. Харганатын хурал
28. Шумуултайн хүрээ

Түдэвтэй

29. Аргалантын хүрээ
30. Лэгвийжүдлин хийд

Тэлмэн

31. Бэлчирийн хүрээ
32. Дашпэлжэйлин хийд
33. Шургахын хүрээ

Тэс

34. Гандан хүрээ
35. Шадавлин хийд

Улиастай

36. Дашпунцаглин
37. Дэчиндаржаалин хийд
38. Манба дацан
39. Очирпүрэв цогт эрдэнэ хийд
40. Төгсбуянт жавхлант хийд

Цагаан-Хайрхан

41. Агьтын хүрээ
42. Дуутын хүрээ

Цэцэн-уул

43. Тэгшийн хүрээ
44. Галуутайн хүрээ

Шилүүстэй

45. Өргөн ширээгийн хурал

Эрдэнэхайрхан

46. Санжжанчивлин хийд

Яруу

47. Дашчойнпэл хийд

Завхан аймгийн сүм хийдүүдийн байршлын зураг.
1937 оны байдлаар

Алдархаан сум.

1. Яруугийн хүрээ

Засагт хан аймгийн Баатар вангийн хошуу, одоогийн Завхан аймгийн Алдархаан сумын нутаг Яруу гол дахь энэ хүрээ нь 1811 онд Ялгуулсан хутагтын арвангуравдугаар дүрийн хувилгаан Лувсандамбадаржаа Улиастайн ойр Алдар хэмээх газар сүм байгуулсанд Манжийн эзэн хаанаас “Хол дахиныг тогтоогч” хэмээх нэр шагнажээ. Энэ хийд 1867 онд Хотонгуудын хулгай дээрэмд өртөн сүйдсэн байна. Бадаргуулалт төрийн үед байгуулаад гээгдсэн сүмийг сэлбэн засаж гэр хүрээ нэмэн байгуулж, Очирдар Богд гэгээнд айлдсанд “Дашпунцаглин” хэмээн нэр хайрлажээ. Яруугийн хүрээ нь Богд цэцгийн хүрээ хэмээн алдаршжээ. Энэ хүрээнээс олон арван алдартай маарамба нар төрөн гарчээ. Маарамба Адарсүрэн, Чунаг, Уламбаяр нарыг дурьдаж болно. Дашпунцаглин хийдэд нийт 17 сүм дуган, 29 байшин, дөрвөн дацантай байсан байна. Тус хийдэд нийт байнга хурал ном хурдаг 540 лам, шавилан суугчид 300 орчим, бусад лам хуврагууд хөдөө суудаг байжээ. Энэхүү хүрээнд Манба, Майдар, Дүйнхор, Дэчиндаржаалин гэсэн дацангууд байхаас гадна 18 настай байжээ. 1938 онд эл хийд нь эзгүйрч МАХН-ын Төв хорооны 2234 тоот тушаалын дагуу хаагдсан байна.

Баянтэс сум

2. Гандандэчинравжаалин (Дашчойнпэллин) хийд

Энэ хийд нь Мөнхбаяр, Пүүжиндорж нарын санаачлагаар 2002 онд анх байгуулагдсан. Тус хийд нь долоон лам, нэг дуган нутгийн хэлмэгдсэн лам нарт зориулан босгосон гурван суваргатай, маанийн гурван хүрдтэй.

3. Зайгалын харуулын сүм

Завхан аймгийн Баянтэс сумын нутагт орших эл сүмд Эрдэнэ бишрэлт, Засагт хан зэрэг хошуудаас уг харуулын сүмд нуусан 108 лам суудаг байжээ.

4. Хачиг харуулын хүрээ

Засагт хан аймгийн ёст бэйс Мишигдорж сайд Зоригт бэйл Наваанцэрэн, Эрдэнэ дүүрэгч ван Намхайжанцан, Цогтой гүн Дамдин-Авшаа нарын хошуунаас уг харуулын сүмд 98 лам суудаг байжээ.

Баянхайрхан сум.

5. Баянхайрханы хурал

Завхан аймгийн Баянхайрхан сумын нутагт шургуун голын хөндий Наран уулын аманд эл хурал оршиж байжээ.

Идэр сум.

6. Дашпэлжээданжиглин хийд

Энэ хийдийг 1990 онд тус сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас санаачлан байгуулжээ. 2004 онд шинэ дуганыг ашиглалтанд оруулсан байна. Хамбын хүрээ, Ялгуусан хутагтын хүрээнд тахиж байсан бурхан тахилтай. Энэ хийд нь 40 гаруй лам хуваргатай, өдөр бүрийн Цогчин хуралтай мөргөл явуулж сүсэгтэн олны сүсэг бишрэлийг ханган бурхан шашны дэг жаяг ёсыг даган үйл ажиллагаа явуулж байна.

7. Хамба гэгээний хүрээ



Сайн ноён хан аймгийн Хамба хутагтын шавийн хошуу, одоогийн Завхан аймгийн Идэр сумын нутаг Түнэл голын ойролцоо Тэнгэр тэтгэгчийн гучиннэгдүгээр (1766) онд хамба хутагт номч цорж Агваангончиг эл хүрээг үүсгэн байгуулжээ. Тэрээр Буянт баясгалант сүм, Цогчин, Агва хурал байгуулж, 1767 онд Нүннай, Манба дацан,

1771 онд Жүд, Дүйнхор, 1776 онд Чойр, Ядамын хурал тус тус байгуулжээ. Тус хүрээний гол шүтээн нь Улаан сахиус, Лхам, Майдар бөгөөд 300 гаруй лам хуврагатай байжээ. Хүрээг 1870 онд Лувсангэндэн-Осор лам өргөжүүлэн Тануу хэмээх газар зөөн шилжүүлжээ. Хамба гэгээний анхны дүр нь Агваангончиг, II дүрийн хувилгаан Цэрэндорж, III дүрийн хувилгаан Дарамсэд, IV дүрийн хувилгаан Жамбалдорж нар үе улиран залагдан суудаг байжээ.

8. Ялгуугсан хутагтын баруун хүрээ

Засагт хан аймгийн Ялгуугсан Хутагтын шавийн хүрээг Ялгуугсан хутагтын арвангуравдугаар дүрийн хувилгаан Лувсандамбадаржаа 1811 онд одоогийн Завхан аймгийн Идэр сумын нутаг Идэрийн голын ойролцоо байгуулжээ. Энэ сүм Манжийн хааны зарлигаар “Хол дахиныг тогтоогч” нэр шагнажээ. Ялгуугсан хутагт нь Засагт хан аймгийн шавь өрх захирсан тамгатай хутагт байв. 1877 онд XIV дүрийн хувилгаан Лувсансандив, шанзодва засаг лам Дамба-Осор лам нар Гэсэрийн цам, Гүнрэгийн хурал, 1918 онд Ялгуугсан хутагтын сүүлийн хувилгаан Чимэдцэрэн, Шанзодва засаг лам Гэндэн нар Жүд дацанг тус тус байгуулжээ. 2007 онд Ялгуугсан гэгээн Чимэдцэрэнгийн 90 насны ойд зориулсан хүрээний туурин дээр суварган цогцолбор бүтээжээ.

Их-Уул сум

9.Дашравжаалин хийд

Завхан аймгийн Их-Уул сумын төвд орших Дашравжаалин хийдийг 1990 онд Дашрагчаагийн санаачлагаар байгуулжээ. Тэр жилдээ Дамдинчойжоо бурхан бүтээж залсан байна. 1992 онд хоёр давхар шинэ дуган ашиглалтанд оруулж, хурал номын үйл ажиллагаагаа өргөжүүлжээ. Тус хийд нь 30 гаруй лам хуваргатай, өдөр тутмын Цогчин хуралтай, цагаан сарын дараа Алтанганжуур 10 хоног хурж сахиус тахидаг байна. Буддын шашны томоохон төлөөлөгч Бакула Ринбүүчи лам тус хийдэд гурван удаа морилон ирж байжээ.

10. Зодын хурал

Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуунаас салж байгуулагдсан Баатар бэйс Бирваарагчаагийн хошууны нутаг, Одоогийн завхан аймгийн Их-Уул сумын Хуягт голын эхэнд Зостын аманд энэ хурал байжээ.

11. Хуягтын хүрээ

Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуунаас салж байгуулагдсан Баатар бэйс Бирваарагчийн хошуу, одоогийн Завхан аймгийн Их-Уул сумын нутагт эл хүрээ оршиж байжээ.

12. Зартын хийд

Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуунаас салж байгуулагдсан Баатар бэйс Бирваарагчаагийн хошуу, одоогийн Завхан аймгийн Их-Уул сумын Цартайн голд эл хийд байжээ. Зартын хийдэд 100 гаруй лам хурал хурдаг байв.

13. Зартын шинэ хийд

Завхан аймгийн Их-Уул сумын нутаг, Цартын голын аманд орших Зартын шинэ хийдийг 1995 онд нутгийн иргэдийн санаачлагаар хоёр модон дуган түүний голд хуучин Зартын хийдийн шүтээн байсан Доржнамжим бурхныг (5м өндөр 2.7м өргөнтэй) боржин чулуун дээр бүтээн залсан байна. Энэ хийдэд нутгийн иргэд дүйчэн өдрүүдэд ном залж, зул хүж өргөн сан тавьдаг. Шинэ дуганд одоогоор хурал ном хурдаггүй.

14. Юмын хурал



Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуунаас салж байгуулагдсан Баатар бэйс Бирваарагчаагийн хошуу, одоогийн Завхан аймгийн Их-Уул сумын төвөөс 16 км зайд оршиж байжээ. Эл хуралд 10 гаруй лам хурал хурдаг, цагийн хуралтай байв.

15. Хатавчийн хүрээ



Засагт хан аймгийн Автай гүний хошуу, одоогийн Завхан Нөмрөг сумын нутаг Хатавчийн хүрээ (Самданпунцаглин) 1839 онд Баруун зууд сууж байсан Пунцаг Лхаарамба гэгч байгуулжээ. 1938 онд мяндагтан лам нар баригдан доод лам нар хар болсноор энэ хүрээ хаагдсан байна. Тухайн үедээ эл хийдэд сүм дуган 23 байхаас гадна байнгын хуралд хурдаг 307 лам (1929 оны байдлаар), гавжаас дээш мяндагтай лам 65 байжээ.

16. Самданпунцоглин хийд

Завхан аймгийн Нөмрөг сумын төвд орших тус хийдийг 1990 онд Б.Сэрээтэрдорж, Д.Лхагвадорж нарын санаачлагаар үүсгэн байгуулжээ. 1991 онд шинэ дуган барьж ашиглалтанд оруулсан байна. Хийдийн гол сахиус нь Гомбо. Тус хийд нь өдөр тутмын Цогчин хуралтай.

Отгон сум.

17. Голын хүрээ



Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн засгийн хошуу, одоогийн Завхан аймгийн Отгон сумын нутагт 1832 онд байгуулагджээ. Энэ хүрээ нь Цогчин, Хангал, Ганжуур, Дөрвөн үндэс, Хайлан, Чойнпрүл, Нүннай зэрэг хуралтай байжээ. Тус хүрээний туурин дээр 1990 онд нутгийн иргэн Б.Дугайн санаачлагаар шинэ дуган байгуулсан боловч ламгүй учир хурал ном хурдаггүй.

18. Халтарын хүрээ

Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн засгийн хошуу, одоогийн Завхан аймгийн Отгон сумын нутагт 1842 онд Агьт хэмээх газар гүн Гүрсэд эл хүрээг байгуулжээ. 1890 онд Дара эх дацанг засаг бэйс Өлзийтөмөрийн үед байгуулжээ.

Сантмаргац сум.

19. Ганданпэлжээлин хийд

Завхан аймгийн Сантмаргац сумын нутагт орших Ганданпэлжээлин хийдийг 1990 оны зургадугаар сарын 3-нд хамба лам Т.Баяр, лам Д.Роломжав иргэн Заграабаатар, С.Багаа, Жалцан нарын санаачлагаар дахин сэргээсэн байна. Хийдийг сэргээхэд Гандантэгчэнлин хийдийн лам Цагаанхүү гуай өөрт хадгалагдаж байсан бурхан, цан, хэнгэрэг зэргийг хийдэд өргөсөн байна. Анх хийд гэр дуганд хурал номын үйл ажиллагаа явуулж байгаад 1994 онд шинэ дуганыг барьж ашиглалтанд оруулжээ. Хийдийн гол шүтээн Балданлхам бурхан юм. 1998 онд хийдийн хамба лам Т.Баяр Утай Гүнбэнгээс Ганжуурын 108 боть, дүнчүүр маанийн хүрд, бурхан багш залж, их бодь суварга бүтээсэн байна. Одоо хийдийн хамба лам Ц.Батбаатар, гэсгүй лам Бааяа нар хурлын есөн ламтай ажиллаж байна.

20. Холбоогийн хурал

Засагт хан аймгийн Сэцэн Сартуул хошуу, одоогийн Завхан аймгийн Сантмаргац сумын нутагт эл хурал байжээ.

Сонгино сум.

21. Нарангийн хурал

Засагт хан аймгийн Сэцэн Сартуулын хошуу, одоогийн Завхан аймгийн Сонгино сумын нутагт эл хурал байжээ. 2005 онд нутгийн иргэдийн санаачлагаар шинэ дуган байгуулсан боловч хурал номын үйл ажиллагаа явуулдаггүй.

22. Олон булагийн дуган

Засагт хан аймгийн Сэцэн сартуулын хошуу, одоогийн Завхан аймгийн Сонгино сумын нутагт эл хурал оршиж байсан бөгөөд нутгийн иргэдийн санаачлагаар туурин дээр нь шинэ дуган сэргээн байгуулжээ.

23. Пунцагжанчивлин хийд

Завхан аймгийн Сонгино сумын нутагт орших Пунцагжанчивлин хийдийг 1998 онд Д.Пунцагийн санаачлагаар үүсгэн байгуулжээ. 2007 онд иргэн Тогтохбаяр эцэг эхийн дурсгалд зориулан гэр дуган бариулж ганжуурын 108 боть залсан. Тус хийд нь шинийн 8,15, 29-ний битүүний өдөр хурал хурдаг. Энэ хийдэд одоогоор таван лам хурал номын үйл ажиллагаа явуулж байна.

24. Тариатын хурал

Засагт хан аймгийн Сэцэн Сартуулын хошуу, одоогийн Завхан аймгийн Сонгино сумын нутагт тариатын хурал байжээ. Тариатын хурал нь Богд ламын чога их хурдаг байв. 1990 онд нутгийн иргэдийн санаачлагаар хуучин хурлын дээр тахилын сүм, суварга бүтээсэн байна. Тус сүм нь хурал номын үйл ажиллагаа явуулдаггүй, тахилын сүмд нутгийн иргэд онцгой өдрүүдээр зул, хүж өргөдөг ажээ.

Тосонцэнгэл сум.

25. Байшинтын хүрээ

Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуунаас салж байгуулагдсан Баатар бэйс Бирваарагчийн хошуу, одоогийн Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутагт орших Байшинтын хүрээ нь байжээ. XX зууны эхэнд Бирваа бэйсийн хошууны Галбаг тайжийн

багуудын ардууд шүтэн биширч байсан Байшинтын хүрээ ганц дугантай байсан бөгөөд тэр нь олон жил болж өгөршин муудаж хурал номын үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй болсон тул 1916 оны үед шинэ дуганыг Номт доргот хэмээх газраас сайн чанарын мод огтлон, сүсэгтнүүд хувийн хөсгөөр модыг зөөж Монгол, Хятад мужаанууд барьж босгосон гэж нутгийн хөгшчүүд хуучилдаг.

Шинэ сүм нь өнгө хийц, донж маяг сайтай гоё уран барилга байсан бөгөөд Эрдэнэцогт гэгч дархан дуганыг барилцаж бүх хадаасыг нь хөөргөөр төмөр ширээж давтан хийсэн байна. Намрын хуй хурахдаа дотоод цам харайж, сор залж хүрээгээ эргэдэг байсан. Хүрээ дотроо босоо хүнтэй чацуу шахуу модоор сийлж урласан Улаан сахиус, Майдар, Жанрайсиг голд нь байрлуулсан Бурхан багш зэрэг олон суумал болон хөрөг бурхан Лавран , баруун, зүүн хойд өнцөгт нь Ганжуур, Данжуурын бүрэн боть залаастай байжээ. Дуган дотор зургаан эгнээ жавдангууд улаан цэмбэн бүтээлгэтэй, нэг жавдан дээр 10 орчим лам суудаг байв. Хандсүрэн, Цогт, Хорлоо, Шагдаржав, Чойжилжав, Намхай, Чүлтэмдагва, Гүндсамбуу, Ойдов, Жанцан, Очир зэрэг эрдэм номтой лам хуврагууд энэ хүрээг тэргүүлж байв. Байшинтын хүрээ 300-400 орчим лам оршин суудаг 2-3 ам.км орчим нутаг газар эзэмшсэн хүрээ байсан хэмээн нутгийнхан ярилцдаг юм.

26. Дашпэлжэйлин хийд

Завхан аймгийн Тосонцэнгэл сумын төвд орших Дашпэлжэйлин хийдийг Б.Ням-Очир тойн, Р.Дашдаваа, Ган-Очир нарын

санаачлагаар хуучин Шумуултайн хүрээний туурин дээр 1990 оны зургадугаар сард байгуулж, хурал номын үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Тус хийдийг сэргээн байгуулсан Ням-Очир тойн, Дашдаваа нар нь бага залуудаа Шумуултайн хүрээнд шавилан сууж байжээ. Хийдийн гол сахиус Гомбо бурхан. Дашпэлжэйлин хийд нь өдөр тутмын Цогчин хуралтай, шинийн 8-нд Дара эхийн мандал шива, 15-нд Сандуйн жүд, 19-нд Хангал, 22-нд Таравчамба, 25-нд Найдан Чога, Дивааажингийн чога зэрэг хурал хурдаг байна. Одоо тус хийдийн хамба ламаар гэвш Б.Болдбаатар, арван нэгэн лам хуврагатай хурал номын үйл ажиллагаа явуулж байна. Энэ хийдийн нэр дээр Энэтхэг улсад дөрвөн лам суралцаж байна.

27. Харганатын хурал

Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуунаас салж байгуулагдсан Баатар бэйс Бирваарагчаагийн хошуу, одоогийн Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутагт бага залуудаа шавилан сууж байв.

28. Шумуултайн хүрээ

Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуунаас салж байгуулагдсан Баатар бэйс Бирваарагчаагийн хошуу, одоогийн Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутагт Цогт уулын өвөр Идэр голын хөвөөнд 1740 онд гэр дугантай Цогчин хурал анх хуржээ. Сайшаалт ерөөлтийн арвандөрөв дүгээр /1802/ онд засаг тэргүүн зэргийн тайж Дамирангийн үед Сэрийн игчааны Цанид дацан, төр гэрэлтийн тэргүүн /1821/ онд засаг тайж Хасбазарын үед Манба дацан, түгээмэл элбэгтийн хоёрдугаар /1852/ онд засаг Бумдарийн үед Дүйнхор, Чойнпрүл, Номын хурлын сургууль байгуулагдав. Бадаргуулалт төрийн тавдугаар /1879/ онд Бадма ёго дацангууд тус тус байгуулагдаж, 1906 онд Жанрайсигийн Мөнх, Нүннай, маань мэгзмийн бүтээл, диваажингийн чога хурдаг болжээ. Олноо өргөгдсөний гуравдугаар /1913/ онд Ганжуур, До дүдвийн хурал, 1916 онд Гүнриг, Дара эхийн дацан сургууль байгуулагджээ. Шумуултайн хүрээ нь Заяын хүрээний дэг жаягтай, 500 орчим ламтай байв. Цам цамнаж, Майдар эргэдэг байжээ. Мөн гүн ухааны судлах чойрын дацантай байжээ. 1932 оны зуны эхэн сард улаантны цэрэг хүрээний баруун талаас дайрч шатаахад тэнд байсан лам нар дүрвэн гарсан байна.

Түдэвтэй сум.

29. Аргалантын хүрээ

Засагт хан аймаг Авьшаа гүний хошуу, одоогийн Завхан аймгийн Түдэвтэй сумын нутаг зүүн Аргалант уулын өвөрт орших Өвөр булаг гэдэг газарт Манжийн хааны зөвшөөрлөөр 1700 онд эл хүрээ байгуулагджээ. Аргалантын хүрээ нь таван дацан зуу гаруй ламтай байж байгаад 1938 оны үед хаагдсан байна.

30. Лэгвийжүдлин хийд

Завхан аймгийн Түдэвтэй сумын төвд орших Лэгвийжүдлин хийд нь 1992 онд хуучин хурал номонд хурж байсан настай лам нарын санаачлагаар дахин сэргээсэн байна. Одоо тэдгээрийн нэг болох Цэдэндорж өөрийн ном зааж сургасан дөрвөн шавийн хамтаар хурал номын үйл ажиллагаа явуулж байна. Хийдийн гол шүтээн нь Гомбо юм. Тус хийдийн сүсэгтэн П.Батсайхан Дилова хутагтад зориулсан суваргыг сумын төвд бүтээсэн байна.

Тэлмэн сум.

31.Бэлчирийн хүрээ

Бэлчирийн хүрээг Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт 1868 онд Магсар тайж байгуулжээ.

32. Дашпэлжэйлин хийд

Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт орших Дашпэлжэйлин хийдийг Шумуултайн хүрээ, түүний харьяа Шургахын хүрээ, Бэлчирийн хүрээнд шавилан сууж байсан унаган шавь нар санаачлан 1991 онд Сүсэгтний холбоо байгуулан шийдвэр гаргаж сүсэгтний хандиваар сүм барихыг санаачлан Галуутайн хүрээнд сууж байсан энэ нутгийн лам Шаравдомий Шумуултайн хүрээний лам Л.Батхуяг, Шургахын хүрээний лам Д.Шагдар, Г.Гончигсүрэн, О.Жамган, Г.Чойсүрэнжав зэрэг лам нар Сүсэгтний холбооны тэргүүн Ү.Гэлэг-Ёндон удирдаж мужаан Ц.Санжаа, Б.Жанчив, А.Зундуйгочоо, Б.Пүрэвжав, Л.Ванданпэрэнлэй, Дүгэрсүрэн,

Ц.Баярсайхан нар сүсэгтэн олонтой хамтран байгуулж одоог хүртэл тасралтгүй хурал хурж байна.

Тус хийд нь шашны өндөр мэдлэгтэй боловсон хүчин бэлтгэхийн тулд Энэтхэг улсад Далай багшийн дэргэдэх шашны сургуульд гэвш лам Б.Шаарав, Т.Сундуй, Б.Отгонбаатар нар сурч байна. Хийдийн хамба ламаар О.Батсайхан, 11 ламтай үйл ажиллагаа явуулж байна. Хийдийн гол шүтээн нь хуучин Шургахын хүрээний гол шүтээн ирээдүй цагийн Их Бурхан Майдар шүтээн юм.

33. Шургахын хүрээ

Энэ хүрээг нь Завхан аймгийн Тэлмэн суманд Дээд Шургах гэдэг газар 1828 онд Равжамба лам эл хүрээг үүсгэн байгуулсан. Тус хүрээ нь үргэлжийн суух тавь гаруй ламтай байжээ.

Тэс сум.

34. Гандан хүрээ

Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу, одоогийн Завхан аймгийн Тэс сумын нутагт байсан Гандан хүрээ нь 1000 гаруй ламтай томоохон хүрээ байжээ. Гандан хүрээнд Гүн ухааны Цанид дацан, Жүд дацанд Гавж аграмбын дамжаа барьдаг байв.

35. Шадавлин хийд

Завхан аймгийн Тэс сумын төвд орших Шадавлин хийдийг Дашцэрэнгийн санаачлагаар 2006 оны хоёрдугаар сарын 9-нд байгуулсан.

Улиастай сум.

36. Дашпунцаглин хийд

Завхан аймгийн улиастай сумын төвд орших Дашпунцаглин хийд нь Яруугийн хүрээнд шавилан сууж байсан хэсэг сүсэгтний санаачлагаар хийдийн гол дуганыг сэргээж хурал номын үйл ажиллагаа эхэлсэн байна.

Энэ үйлсэд хөдөлмөрийн баатар С.Адьшаажав, лам Очиржав, Алтангэрэл, Баатар, Гончигсүрэн, Магсар Жадамба нар идэвхийлэн оролцжээ. Хүрээний дахин сэргэлтийн анхны шавыг Л.Магсар , Н.Муна нар тавьж, хийдийн хамба ламаар Жадамба ажиллаж, Цэрэндаш, М.Шарав, Гарав, Авирмэд, Дансран Доржпунцаг нарын хамт анхны хурал номыг хурж байжээ.

1993-2005 онд хамба ламаар М.Шарав ажиллаж Алдар толгойн шавар хэрэм, Алдархаан сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаад, 2005 оны 4-р сарын 15-нд лам, ажилчдын хурлын шийдвэр, сүсэгтэн олны саналаар Улиастай сумын Богдын гол багт шилжин суурьшиж үйл ажиллагаа явуулж байна. Тус хийд нь 15 лам, дөрвөн ажилчинтай, дуган, бурхан, ном судар болон бурхан шашны үнэт зүйлтэй юм.

Дашпунцаглин хийд нь урьдын уламжлалаа сэргээж Майдар эргэх ёслолыг өөрийн аймгийн сумд төдийгүй Тува улсад үйлддэг.

37. Дэчиндаржаалин хийд

Завхан аймгийн Улиастай сумын нутагт орших Дэчиндаржаалин хийдийг анх 15 хүний бүрэлдэхүүнтэй сүсэгтний зөвлөлийн хурлаас санаачлан хуучин улаан сүмийн буурин дээр “Алтан элст” хэмээх газар хийдийн анхны хамба П.Чойжин, Лүндэг, Санж, Очир тойн, Даваасамбуу, Доржготов, Баатархүү нар очиж шав тавиад 1990 оны “Дэчиндаржаалин” хийдийн газрыг ёсчлон авч уншлага ёслол үйлдсэн байна. Анхны хурлыг П.Чойжин, доороомбо Сангажав, Очир тойн, Даваасамбуу зэрэг 30 гаруй лам хуварга хурсан байна. Энэ хийдийн анхны хамба ламаар П.Чойжин, дэд хамбаар Санжхүү, унзад ламаар Т.Цэрэндаш, гэсгүй ламаар Л.Сампил, да ламаар Санж томилогдож байжээ. 1990 оны 7-р сард дуганы нээлтэнд Бакула Ринбүүчи залран ном тавьсан. 1995 онд хамба лам П.Санж Утай Гүмбэмээс 112 боть Ганжуурын их хөлгөн судар хийддэ залж есөн суварга бүтээсэн байна. 1997 онд хамба лам П.Санж санаачлан хийдийн зүүн талд жижиг дуган бариулж, тохижуулан сахиус тахидаг болжээ. Тус хийдэд Төвдөөс лхаарамба Галсанравсал, гэвш Лувсандамба нарыг урьж лам нартаа Чойр болон гүрмийн ном заалгаж эхэлсэн. Мөн Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын 12 хүүхдийг өөрийн хийддээ шавилан суулгаж сургах ажил эхлээд байна. 1999 онд хийдийн анхны шавь Д.Пүрэвсүрэнг хийдийн хамба ламаар, гэсгүй ламаар Ц.Дашпунцагийг томилсон. Тус хийд нь өдөр тутмын Цогчин уншлагатай, битүүнд Цэдэр Лхам, шинийн 29-нд Лха сүм тахидаг. Жил бүрийн хавар майдар эргэдэг.

38. Манба дацан хийд

Завхан аймгийн Улиастай сумын нутагт орших Мамба дацан хийдийг 2001 онд хүний их эмч Д.Зоригтбаатарын санаачлагаар лам Ц.Сүх-Очир, Ц.Дашпунцаг, Г.Отгонбаяр, Д.Батбилэг, Н.Жадамба, А.Агваанжамбал болон бусад олон шавь нартай хамтран хуралдаж үүсгэн байгуулжээ. Монголчуудын оюуны өв соёл болох уламжлалт “Манба дацан”-г сэргээн хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэж байгаа учраас хүний эрүүл мэндийг дааж явдаг Их оточ Манал бурхныг хийдийнхээ гол шүтээн болгон үйл ажиллагаа явуулж байна. Барилга нь ардын хувьсгалаас өмнө маарамба, зурхайч бэлтгэн гардаг байсан халхад алдартай «Яруу»-гийн хүрээний гол дуганы материалаар барьж босгосон нь түүх соёлын үнэт өв дурсгал юм. Тус хийд нь хурал, ном айлтгал, сэтгэл засал эмчилгээ хийх, эм тан аравнайлах, Отгонтэнгэрийн рашаан ус, газар нутгаа аргадах тахих зэрэг үйл ажиллагааг сүсэгтэн олныхоо сайн сайхны төлөө хийж гүйцэтгэж байна. Мөн бурхан шашны холбогдолтой ховор чухал эд өлгийн зүйл, ном судрыг цуглуулах, бүртгэх маарамба, зурхайч нарын намтар бүтээлийг судлах, суралцах олны хүртээл болгох чиглэлээр ажиллаж байна. Хийдийн зөвлөх ламаар ажиллаж байсан М.Сүрэндорж нь Яруугийн хүрээнд суралцаж байсан лам нарын хамгийн сүүлийн маарамба юм. Одоо хийдийн хамба ламаар Г.Отгонбаяр, нийт хорин гурван лам хурал номын үйл ажиллагаа явуулж байна.

39. Очирпүрэв Цогт-Эрдэнэ хийд

Завхан аймгийн Улиастай сумын нутагт орших Очирпүрэв Цогт-Эрдэнэ хийдийг 1992 онд Иргэдийн Хурлын тогтоолоор Улаанбаатар хот дахь Дэчинчойнхорлин хийдийн Завхан аймаг дахь салбар хийд болгон байгуулжээ. Буддын шашны улааны урсгал чиглэлийн хийд юм. Хийдийн Улаанбаатар хот дахь Дэчинчойнхорлин хийдийн сургагч багш болон лам нараас ирж Очирпүрэв Цогт-Эрдэнэ хийддээ үйл ажиллагаа явуулдаг. Анх хийдийн хамба ламаар Занданбат, унзад ламаар Батзориг, голч ламаар Шийдэр Дунагсүрэн Нямдорж Энхбаатар, Отгонбүрэн, Лхагважаргал, гэсгүй Бямбадорж, үзмэрчээр Баяраа лам нар ажиллаж байсан. Тус хийдийн хамба ламаар 1994-1996 онд Пүрэвсүрэн, 1996-2001 онд Энхбаатар, 2002 оноос А.Дашдондов ажиллаж байна. Одоо хийдийн А.Бямбадорж, Р.Нямсанж, Ц.Чойжамц, А.Гэрэлт-од зэрэг лам нар сүсэгтэн олон түмэндээ буяныхаа хишиг номыг айлтган хүртээж байна. Очирпүрэв Цогт-Эрдэнэ хийдийн гол шүтээн нь ловон Бадамжунай бурхан бөгөөд түүнийг хүрээлсэн олон арван бурхан байхаас гадна сар бүрийн шинийн 10, 25-нд мацаг барих өдөр болгон ловон Бадамжунайн чога, Самбалхүндэв, Барчиднамсал, лүйжин хурж 1000 зул өргөдөг байна.

40. Төгсбуянт Жавхлант хийд

Төгсбуянт Жавхлант хийд нь Арван хутагтын есөн цагаан суврагаа түшиглэн 2003 оны арван сарын 12-нд Завхан аймгийн Нөмрөг сумын харьяат Анод банкны тэргүүн захирал Э.Гүр-Аранзын хандив хөрөнгөөр үүсгэн байгуулагдсан. Анх тус хийдийн ловон ламаар С.Баяндорж, да лам Д.Пүрэвсүрэн, их унзад Г.Энэбиш, бага унзад Ц.Баянзул, гэсгүй Я.Баттөр, Човомбо Б.Дашдорж, нар томилогдон нийт 35 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл өдөр бүрийн тогтмол уншлагатай, сүсэгтэн олны хүсэлтийн дагуу хурал номын үйл ажиллагаагаа шашны ёс жаягийн дагуу явуулж байна.

2004 онд Энэтхэг улсын Гомон дацанд хоёр лам, Занабазарын нэрэмжит Монголын Бурхан Шашны их сургууль болон “Ур эрдмийн Урлахуй ухаан”-ы дээд сургуульд хоёр лам суралцуулж байна. Тус хийд нь шинээр лам сурагч элсүүлэн авч бурханы ном шашны зан үйл зааж байна. 2005 онд Завхан аймгийн Бурханы Шашинтны төв болон өргөжсөн. Түүнчлэн аймгийн бүх сумуудаар орж сүм хийдүүдийн болон лам хуврагуудын судалгааг авсан.

2006 оны долдугаар сард Жадо Ринбүүчи лам тус хийдэд морилж лам хуврагуудад сахил хүртээж, аймгийн сүсэгтэн олонд “Цагаан дара эхийн цэвээний ван” хүртээсэн.

Төгсбуянт Жавхлант хийд нь байгуулагдсанаас хойш жил бүр “Майдар” эргэх их ёслолыг үйлдэж сүсэгтэн олны сэтгэлд хүрч эргэл мөргөл үйлдүүлж заншиж байна. Мөн лам сурагчдын хичээлийн байр болон гал тогооны барилгыг эхлүүлээд байна.

Цагаанхайрхан сум.

41. Агьтын хүрээ

Засагт хан аймгийн хошууч мэргэн бэйс Дугаржавын хошуу, одоогийн Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нутагт 1747 онд Хошууны бэйс ноён Норовжав тэргүүлэн Агьтын хүрээг байгуулжээ. Тус хүрээ долоон сүм дуган, 150 лам хуврагатай байжээ. 1990 онд Чойжил, Дамдинсүрэн нар тус хийдийг дахин сэргээн шинэ дуган барьсан боловч одоогоор хурал номын үйл ажиллагаа явуулдаггүй байна.

42. Дуутын хүрээ

Засагт хан аймгийн Хошууч мэргэн бэйс Дугаржавын хошуу, одоогийн Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нутаг цэцэг уулын өвөрт засаг гүн Гүрсэдийн үед 1841 онд үүсгэн байгуулжээ. Тус хүрээ нь Цогчин, Хангал, Дөрвөн үндэс, Чойнпрүл, Нүннай,

Ганжуур, Данжуур, Хайлан зэрэг хурал хурдаг байжээ. 1875 онд Манжийн эзэн хаанаас “Сайн итгэмжит сүм” хэмээн нэр шагнажээ. Хүрээний шүтээн нь Майдар, Лхам бурхан байв. 1866 онд засаг ноён Эрхэмжаргал удирдан Манба дацан, 1900 онд засаг бэйс Дугаржав удирдан Жүд дацанг тус тус байгуулжээ. Тус хүрээ нийт 500 гаруй лам хуваргатай байжээ. Хийд 1938 онд эзгүйрч хаагдсан байна. Тухайн үедээ хүрээнд арван сүм дуган, 15 байшин, таван дацан байжээ.

Цэцэн-Уул сум

43. Тэгшийн хүрээ

Засагт хан аймгийн Сэцэн сартуулын хошуу, одоогийн Завхан аймгийн Цэцэн-Уул сумын нутагт Тэгш буянт хэмээх газар 1880 онд байгуулагдсан. Гүн ухааны сургалт нь Сэрийн игчааг голлон баримталдаг байжээ. Энэ хүрээнээс төрөн гарсан алдарт гүн ухаантан Сартуулын Доржбал гавж нь төвд хэлээр нилээд бүтээл туурвисан бөгөөд “Төвд Монгол даяг” нь нэрд гарсан ихэд алдартай бүтээл байв. Тэгшийн хүрээний хувилгаан лам Сартуулын Хорол цорж Лувсандамбийдомэ, Ачит хутагт Лувсандамба нар залагдан суудаг байв. 1990 онд Г.Пүрэв, Д.Дагвадорж, З.Жадамба нарын санаачлагаар шинээр байгуулагдсан Ганданпэлжээлин хийд нь хуучин Тэгшийн хүрээний гол Цогчин дуганы туурин дээр баригдсан. Тус хийд нь өдөр тутмын Цогчин хуралтай хуучин Тэгшийн хүрээний ая дангаар хурал номоо уншдаг. Шинэ сүмийн барилгын ар талд хийдийн хашаан дотор хуучин хэд хэдэн туурь орсон. Үүнээс гадна шинэ сүмээс 600 метр зайд Батсуурь уулын зүүн энгэрт Тэгшийн

хүрээний том лам нар болон шашны нэрт зүтгэлтэн Номч мэргэн гэгээн Лувсандамбийдомэгийн жасааны туурь байдаг.

44. Галуутайн хүрээ

Засагт хан аймгийн Сэцэн сартуулын хошуу, одоогийн Завхан аймгийн Цэцэн-Уул сумын нутагт Галуут голын хүрээ нь 1865 онд байгуулагдаж, Манжийн эзэн хаанаас “Илэрхийлэн гийгүүлэгч сүм” хэмээх нэр шагнажээ. Сэцэн засаг төрийн бэйл Жалчингомбоцэдэн ноёны үед 1914 онд төвдийн гүн ухаантан Сэра Живзунбын онолын дагуу гүн ухааны дацан байгуулав. Цогчин, Дүйнхор, Жүд, Манба, Майдар, Гүнриг, Нүннай, Хажид, Диваажин зэрэг сүм, дацангуудтай байв. Энэ хүрээнд Билэгт ламын хувилгааныг залан суулгадаг байв. Галуутайн хүрээ нь Гүн ухааны сургалтаараа алдартай бөгөөд гүн ухаантан олон лам төрөн гарчээ. Галуутайн хүрээний анги гэвш Гүрлхажав нь Гандантэгчилэн хийдэд 1960-1980 он хүртэл хурал хурж байв.

Шилүүстэй сум.

45. Өргөн ширээгийн хурал

Сайн ноён хан аймгийн хошууч бэйсийн хошуу, одоогийн Завхан аймгийн Шилүүстэй сумын нутагт 1906 онд Мянган уулын өвөрт Лашин хувилгаан Агваанпринлэйжамц эл хурлыг үүсгэн байгуулжээ. Энэ хийд 50 гаруй ламтай хийд байв. Энэ хийдийг үүсгэн байгуулагч Лашин хувилгаан нь Сайн ноён хан аймгийн

Хошууч бэйс Дугаржавын хошууны эрдэмтэн лам юм. Тэрээр төрөлх нутагтаа сүм хийд байгуулснаас гадна түвд хэл дээр VIII Богд Живзундамба хутагтын намтар зэрэг нэг боть ном туурвижээ. Хуучин хийдийн туурин дээр «Дэчинчойлин» нэртэй шинэ дуганыг Дэмбэрэлдорж, Дончин нар санаачлан Гүрцог, Цэрэнсодном, Санжшийрэв нарын хүмүүс толгойлон 1998 оны наймдугаар сарын 18-нд барьж ашиглалтанд оруулжээ. Анх энд бага гэр дуган барьж, 1990-1998 онд айлуудаа дагаж хурал хурж байгаад 1998 оноос тасралтгүй гурван жил энэ дуганд шинийн найманд Дара эхийн мандал , Цогчин, Алтангэрэлийн даллага, Шинийн 9,10-нд Гомбо, Чойжоо, Лхам сахиус хурна. Хийдийн гол сахиус нь Лхам. Тус хийд нь 2001 оноос эхлэн жил бүрийн хаврын эхэн сарын шинийн 15-нд Майдар эргэдэг. Одоо тус хийдээс Дашчойлин хийдэд таван хүүхэд Чойрын гүн ухаан судлаж байна.

Эрдэнэхайрхан сум.

46. Санжжанчивлин хийд

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт орших Санжжанчивлин хийд нь анх 1990 онд хуучин Галуутайн хүрээний ор улбаа болгож лам Д.Диваасамбуу, Мишигдорж, иргэн В.Мэндбаяр, Т.Бат-Очир нарын санаачлагаар сүсэгтэн олны эрэлт шаардлагаар байгуулагдаж, нутгийн 16 ламтайгаар 1990 оны намрын эхэн сарын 15-нд анх нээлтээ хийж “Найдан чога” хурж үйл ажиллагаагаа эхэлсэн байна. 1994 онд Жадо Ринбүүчи ламыг залж ирүүлэн хийддээ Санжжанчивлин нэр хүртээж шинээр дуган нэгийг барьж, одоо хоёр дуган, хоёр суварга, найман лам хуврагатай хурал номын

үйл ажиллагаа явуулж байна. Хийдийн гол шүтээн нь Балданлхам, Манал, Ригсүнгомбо бурхад юм. Энэ хийдэд шавилан сууж байсан лам нараас гэвшийн дамжаа барьсан дөрвөн лам, Монголын бурхан шашны их сургуульд гурван лам суралцаж байна.

Яруу сум.

47. Дашчойнпэл хийд

Завхан аймгийн Яруу сумын төвд орших Дашчойнпэл хийдийг 1990 онд Мөнгөөлөө, Цэрэнбат, Дүгэржав нарын санаачлагаар үүсгэн байгуулжээ. 2004 онд шинэ дуган ашиглалтанд оруулсан. Тус хийд нь өдөр тутмын цогчин хуралтай, жил бүрийн зургаан сард Майдар эргэдэг. Хийдийн гол сахиус нь Балданлхам. Одоогоор тус хийд нь таван ламтай хурал номын үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗАВХАН НУТГААС ТӨРСӨН ХУТАГТ ХУВИЛГААД БОЛОН ДЭЭДЭС ЛАМ НАРЫН ЦАДИГААС

НАРО БАНЧЭН ХУТАГТ

Энэтхэгийн 84 шидтэний нэг Банчин Наровын хувилгаан дүрүүдийг Төвд, Монголд удаа дараалан залж байсан түүхтэй. Монголд хувилсан анхдугаар дүр Наро Банчэн хутагт Бадамдорж (1699-1737)

II дүр Наваанчойранданзанжамц (1738-1817)

III дүр Түгжжав (1818-1860)

IV дүр Бирваа (1861-1883)

V дүр Пүрэвжав (1884-1903)

VI дүр Жүгдэрнамжил (1904-?) Наро Банчэн хутагтын VII дүр

Пүрэвжавын үед нутаг ойроос төрсөн Дилова хутагт Жамсранжавыг Наро Банчэнгийн хүрээнд мандал өргөж ширээнд залж байжээ. Энэ хоёр хутагт нь Наро Банчэнгийн V, Дилова хутагтын V дүр тус тус бөгөөд нас ойр эрдэм номд хамт суралцаж нууц тарнийн ид шидийг үзүүлдэг байсныг шавь нар нь дурсан яриадаг байв. Наро Банчэн хутагтын VI дүр хувилгаан Жүгдэрнамжилыг бага наснаас нь ном эрдэмд тэтгэсэн багш нь Дилова хутагт Жамсранжав байжээ.

VI НАРО БАНЧЭН ХУТАГТ ЖҮГДЭРНАМЖИЛ (1904-1931)

Бадаргуулалт Төрийн 27-р (1904) онд түүхийн эх сурвалжид тэмдэглэгдсэнээр Дуутын Ар Гашуун гэдэг газар харъяат шавийн ард Лувсанцэрэнгийн гэрт хувилжээ. Хэвт Ёсны 2-р (1910) онд уул шавьд нийлүүлэн суулгажээ. Монгол улсын Олноо өргөгдсөний 8-р (1918) онд улсын санд мөнгө хариулан өргөсний учир хамбын бүрэн эрх ямба, Дотоод яамнаас хишиг тараах зарлигаас хоцрогдсон учирыг айлтгаад Цоржийн ямба тус тус шагнан хүртээжээ. Энэ Наро Банчэн хутагтын нэрийг түүх шашдирт Жүгдэрнамжил гэж бичсэн байдаг. Сахилын нэр нь Жанцанлувсаннамхайноров, анхны нэр нь Цэрэннамжил гэдэг байсан ба Хүүхнээ гэж авгайлдаг байв. Гэгээнтний эцэг Лувсанцэрэнгийн талаар Дилов хутагт Жамсранжав дурьдатгалдаа “надаас хоёр ах хүн байсан” гэж бичсэнээс үзвэл 1882 онд төрсөн байх үндэстэй.

Түүний хүү Цэрэннамжилыг Наро Банчэн гэгээнээр тодорсноос хойш төрсөн газар Гашууны худгийг Эрдэнэбадрахын худаг, эцэг Лувсанцэрэнг Билэгт хэмээн өргөмжилдөг болсон юм. Цэрэннамжил хутагт өмнөх дүрүүдээс өөр ном эрдэмд шамдан суралцаж, хүрээ хийдээ эзэгнэн хурал номыг удирдан хуруулдаг байв. Зун, намар хааяа шүтээний Шинэ ус, Эрдэнэбадрах зэрэг газар хөдөөлдөг байсан. Тэрээр махлагдуу, өндөр, царайлаг цагаан залуу байсан гэж одоо сэрүүн тунгалаг амьдарч буй цөөн шавь нар нь дурсан ярьдаг юм. Дилов хутагт Жамсранжав Богдын зарлигаар төр, шашны хэрэгт томилогдон идэвхтэй оролцох болсноос хойш хүрээ хийдийн асуудлыг ихэвчлэн Хүүхнээ гэгээн дангаар захирах болсон юм. Төр засгийн харилцаанд өөрчлөлт гарч сүм хийд, хурал номын ажил хаагдахын өмнө буюу 1931онд Жүгдэрнамжил хутагт бурхны тааллаар жанч халжээ.

Гэгээнтнийг Салхитын шинэ усны баруун дэнж дээр нирваан дүрийг үзүүлэх үед хэдэн чулуугаар овоо босгож, Шилүүстэй

уулын өвөр, Шарилын хунхуйд хайлахаар аваачжээ. Түүнийг харж хамгаалж байсан Дэлдэн даяанч, гэгээнтний нагац Жалцав гэлэн гэдэг хоёр лам морь услах, хоол хүнс олж ирэх нэрээр Асгатын булаг руу явсан хойгуур нь гэгээнтний ариун шарилыг буруу санаатан Дорж гэлэн гэгч хөндөж, эрдэнийн гавал тэргүүнийг авч алга болсон нь уй гашууд автсан түмэн олон шавь нарыг орчлонгийн нарны гэрлээс харанхуйлж, түүхэнд хар ул мөр үлдээсэн гунигт бараан явдал болсон юм. Гэгээнтэн амьд сэрүүн үедээ"Энэ Дорж гэлэн хэзээ нэгэн цагт миний толгойг авна шүү" гэж захидаг байсныг үл анзаарснаас нутгийн олон түмэнд энэ харамсалтай бөгөөд жигшүүрт явдал тохиолдсон түүхтэй. Гэгээнтний тэргүүнийг ийнхүү ёс бусаар алдсаны дараа түүний шарилыг хүрээний баруун хойд талд Битүүгийн бууцан дээр Дэмбийн Түвдэн нарын хэдэн лам хоёр том тогоонд хийж хөмрөөд дээр дороос нь гал түлж чандарласан гэдэг.



МИЛ БОГДЫН ХУВИЛГААН Н.ЦЭРЭНДОНДОВ (1919-1996)

Цэрэндондов хувилгаан нь XV жарны шаргачин хонин жил (1919) оны намрын эхэн сарын арван таванд Засагт хан аймгийн хошууч бэйсийн хошуу, одоогийн Завхан аймгийн Шилүүстэй сумын Баян улаан багийн Хүрэн толгойн Өвөр булаг гэдэг газар ард Нацагшугарын хүү болон мэндэлжээ. VIII Богд Живзундамба хутагт Мил Богдын хувилгаан Отгонтэнгэр хайрханы өвөрт мэндэлжээ гэж айлдан, хойт дүрийг тодруул хэмээн Наро Банчэн хутагт, Дилова хутагт, Арь гэгээн нарт зарлиг хайрлажээ. 1924 онд Наро Банчэн хутагт, Дилова хутагт, Арь гэгээн нар Цэрэндондов хүүг Мил богдын хувилгаанаар мөн хэмээн тодруулж Агваанчанравданзансамбуу хэмээх нэр соёрхож Завхан аймгийн Отгон сумын Гэндэнчилин хийдэд хутагтын сэнтийд залжээ. Цэрэндондов хувилгаанд зориулж Арь гэгээн, Дилова хутагт Жамсранжав нар тус тус залбирал солдив зохиосон байна.

Цэрэндондов хувилгаан 1937 онд нийтийн адил хар болж, энгийн дүрээр саатан 1939-1945 онд Өмнөговь аймгийн Ноён Сэврээ, Ханхонгор суманд цэргийн алба хааж, 1947 оноос Завхан аймгийн Шилүүстэй суманд сүү тосны эрхлэгч, намын хэсэг, худалдаа бэлтгэлийн ангид агентын ажил эрхэлж, улсад дөчин жил тасралтгүй хөдөлмөрлөжээ. Ингэхдээ гурван удаа аймгийн аварга ажилтнаар шалгарч байжээ. Завхан нутгийнхан болон олон шавь нарынхаа дунд Агент багш гэж алдаршсан юм. Цэрэндондов хувилгааны хөдөлмөрийг төр засгаас өндрөөр үнэлэн Алтан гадас одон, Ардын хувьсгалын ойн медаль, таван жилийн гавшгайч, Худалдааны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнажээ. 1990-ээд оны сүүлчээр Энэтхэг улсаас Монголд сууж байсан Бакула ринбүүчи багш очиж уулзан ихэд үнэлж байжээ. Цэрэндондов хувилгаан 1996 онд жанч халжээ.

АРЬ ГЭГЭЭН Б.ЧАНРАВ (1872-1931)

Арь гэгээн Чанрав нь Чин улсын Бадаргуулалт төрийн хөх нохой жилийн намрын дунд сарын арван таванд Засагт хан аймгийн гүн Загдсамбарын хошуу, одоогийн Завхан аймгийн Нөмрөг сумын Дархан уул багийн Бугын толгойн өвөрт 1872 оны есдүгээр сарын арванд ард Бадраагийн гуравдугаар хүү болон төржээ. Арь гэгээн таван наснаасаа эхлэн урд төрлийн түүх эрдмийн ид шидийг үзүүлж эхэлсэнд Хатавчийн хүрээний хамба лам Жамсранжав VIII Богдод уламжлан айлтгахад Арь гэгээний V дүрийн хувилгаан мөн хэмээгээд Дамдин Чогдан гэдэг нэр хайрлажээ 1882 онд Арь гэгээнийг Яруугийн хүрээнд сэнтийд залсан байна. 1890 онд Арь гэгээнд VIII Богд Живзундамба хутагтаас “Номч мэргэн” цол хайрлаж байжээ. Арь гэгээн Үндэсний эрх чөлөөний үйл хэргийг тууштай дэмжигчдийн нэг байв. Арь гэгээн 1930 онд Ховд хотод хилс хэрэгт хэлмэгдэн хоригдож байгаад 1931 оны өвөл жанч халжээ.

АЧИТ ЛАМЫН ХУВИЛГААН Х.ВАНДАН (1916-1937)

Ачит ламын хувилгаан Вандан нь XVI жарны гал луу жилийн намрын эхэн сарын арван таванд Засагт хан аймгийн Цэцэн сартуул хошуунд одоогийн Завхан аймгийн Яруу сумын Өгөөмөр багийн Мөөгний хавчиг гэдэг газар 1916 оны есдүгээр сарын арванд Хас тайжийн гэрт лагшин мэндэлжээ. Вандан хувилгаан нь дөрвөн сүүдэртэйн үеэс ид шид үзүүлж байжээ. Галуутайн хүрээний хамба лам Шагдараас VIII Богдод хүүгийн тухай айлтгахад Богдоос Ачит ламын хувилгаан мөн хэмээснээр таван настайд нь Галуутайн хүрээнд сэнтийд залжээ. Ачит лам Вандан хувилгааны залбирал солдивийг Их хүрээний Номч номун хан зохиосон байна. Вандан хувилгаан 1937 онд хилс хэргээр хэлмэгджээ.

БИЛЭГТ ЛАМЫН ХУВИЛГААН Б.ДАШДОРЖ (1917-1937)

Номч багш Билэгт ламын хувилгаан Б.Дашдорж нь XVI жарны улаагчин могой жилийн өвлийн эхэн сарын арван таванд Засагт хан аймгийн Цэцэн сартуул хошуунд буюу 1917 оны арван нэг дүгээр сарын арван нэгэнд одоогийн Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Алтай багийн нутаг “Зүү зосын дугуй улаан” гэдэг газар Хүүхэн мээрэнгийн хүү Батхүү тайжийн гэрт лагшин мэндэлжээ. Таван настайд нь Галуутайн хүрээний хамба лам Шагдар хүүгийн ер бусын байдлыг болгоон VIII Богдод айлтгахад Богдоос Билэгт ламын хувилгаан мөн гэснээр Галуутайн хүрээнд сэнтийд залжээ. Хувилгаан Дашдоржийн залбирал солдивийг Их хүрээний Номч номун хан зохиожээ. Дашдорж хувилгаан 1937 онд хилс хэргээр хэлмэгджээ.

БУУРАЛ БАГШИЙН ХУВИЛГААН Г.ГЭНДЭНЖАМЦ (1919-1986)

Буурал багшийн хувилгаан Гэндэнжамц нь XVI жарны шар төмөр бичин жилийн өвлийн тэргүүн сард Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу, одоогийн Завхан аймгийн Баянтэс сумын хоёрдугаар багийн нутаг “Хүртэн” гэдэг газар малчин ард Гончигийн гуравдугаар хүү болон мэндэлжээ. 1924 онд таван настайд нь төвдийн гэгээн багш Чойжоо бурханы хувилгаан, Буурал багшийн хойд дүр мөн хэмээн тодруулсан байна. Таван настайгаасаа эхлэн ном эрдмийн шидийг үзүүлжээ. Могойн хүрээний унаган шавь Жансан гэлэнд шавь орон ном заалгасанд Цүлтэмням хэмээх сахилын нэр хайрласан.

Баянбулгийн Могойн хүрээний гавж Гэндэнпил VIII Богд Живзундамба хутагтад айлтгаснаар Чойжоо бурхны хувилгаан, Баянбулгийн хүрээг үүсгэн байгуулагч Буурал багшийн хойд дүр мөн хэмээсэнд Баянбулгийн хүрээ буюу Дэчинравжаалин хийдэд хувилгааны сэнтийд залсан байна. 1937-1938 онд хүрээ хаагдсанаар Цүлтэмням хувилгаан нь энгийн дүрээр залран жин тээж, сүүн заводын мастер зэрэг ажлыг хийхийн зэрэгцээ хүнд бэрх цаг үед Тува, Монгол даяар шашин амьтанд тасралтгүйгээр тус хүргэж байгаад 1986 оны 8-р сарын 11-нд жанч халжээ.

МААРАМБА Д.НАЦАГДОРЖ

Д.Нацагдорж нь 1957 онд Сайн ноён хан аймгийн хошууч бэйсийн нутаг одоогийн Завхан аймгийн Цагаанчулуут суманд төрсөн.

Усны аж ахуйн техникум, Бурхан Шашны Их Сургууль, Монгол Улсын Их Сургууль, Энэтхэгийн Дармасала дахь Эмнэлэг Зурхайн Институтэд тус тус суралцаж Гидротехникч, Буддын судлаач, Англи хэлний багш орчуулагч, Уламжлалт Анагаахын эмч мэргэжил эзэмшсэн.

1760 онд Да Хүрээнд байгуулагдаж 1938 онд устсан Бусдад туслахуй анагаах ухааны Манба Дацан хийдийг 1990 онд дахин шинээр сэргээн байгуулж уламжлалт анагаах ухааны сургалт, эм үйлдвэрлэл, эмчилгээ үйлчилгээ, эрдэм судлал, Буддын шашны хурал номын ажлыг цогцоор нь бүтээн буй болгож Монгол улсын эрүүл мэнд, боловсрол, шашин соёлын салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан. 1991 онд “Оточ Манрамба” Дээд Сургуулийг байгуулж эрүүл мэндийн салбарт олон арван эмч мэргэжилтнийг бэлтгэн гаргаж гадаад дотоодод сурталчлан таниулж Уламжлалт Анагаах Ухааныг хөгжүүлсэн. “Бурхан эмч сахиус”, “Өвчний ангилал зүй”, “Түвд хэлний сурах бичиг”, 20 гаруй дууны шүлэг, ном зохиол туурвихын зэрэгцээ “Богд Очирваань — Отгонтэнгэр хайрханы адистидийн тахилга оршвой”, “СПапт.5 от ПеаПпд МеСюте ВиССПа” СЭ, “Ум аа хум” утлага, “Таван эрдэнэ сахиус”, “Оюу-25”, “Шүр-25” эрдэнийн эм зэргийг бүтээж Монгол Улсын шинэ бүтээл, зохиогчийн эрхийн патент авч нийтийн хүртээл болгосон. Монгол Улсын эрүүл мэндийн яамны мэргэжлийн зөвлөл, Их дээд сургуулиудын холбоо, Итали- Монголын хооронд эмч мэргэжилтэн солилцох хөтөлбөрийн зохицуулагч зэрэг 20 гаруй олон нийтийн байгууллагын сонгуульт ажилтай.

Монголын Уламжлалт Эмнэлэг Сургалтын Төв “Манба Дацан”-гийн тэргүүн билгүүн номч хамба лам, гэвш, Монгол улсын “Хүний гавъяат эмч”, “Оточ Манрамба” дээд сургуулийн захирал.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НАРО БАНЧЭН ХУТАГТ ДАНЗАНЛХҮНДҮВ ГЭГЭЭНТНИЙ ТОДРОН ШИРЭЭНД ЗАЛРАХАД ТОХИОСОН БИЛЭГ ДЭМБЭРЭЛ АРД ЗОНЫ ХҮСЭЛТ ИЛЭРХИЙЛСЭН БИЧИГ БАРИМТ, УРЬД ГЭГЭЭДИЙН БОШГО ЛҮНДЭН НАМТАР ЦАДИГААС



ДАЛАЙ ЛАМ

Монгол орны Гандантэгчэнлин хийдийн хамба Чойжамц бээр Наро Банчэнгийн 6-р дүрийн дараа төрөл 7-р дүрийн төрлийн хүрээг шинжсэн айлтгалыг учруулсанд, ажиглан шинжилж үйлдсэний утга нь:

Баянмөнхийн хүү Цэдэн-Иш нэртийг Наро Банчэн хувилгааны дараа дүр мөн гэдгийг сайн шинж ургасан учраас тодруулж үйлдсэний улмаас тодруулж танин барьсан.

Хувилгаан өөрийнхөө зүгээс ч гэсэн шашны тусыг сэтгэлдээ хадгалан үйлдэж, шагшаабад, сонсох, санах, суралцахад шамдаж, хичээн үйлдэх нь чухал аа.

Аврал ерөөл сэлттэйгээр

Далай лам бээр нийтийн тооллын

2014.09.11-ны өдөр үйлдэв.

༦༥། །པཏ་ཆེན་ནུ་རོ་པའི་ཞབས་བརྟན་གསོལ་འདེབས་བཞུགས་སོ། །

༦༥། །ཨོ་སྭ་སྟི། དམིགས་མེད་བདེ་ཆེན་ཆོས་སྐུའི་རོལ་བ་ལས། །བག་ཡས་གཟུགས་སྐུའི་བློས་གར་བྱ་བ་འབྱམ། །ཐུགས་རང་རྒྱས་མཛད་ཁྱབ་བདག་འགོར་ཡོའི་མགོན། །རྟེ་བཙུན་བླ་མའི་ཞབས་ལ་གསོལ་བ་འདེབས། །རྒྱལ་ཀུན་མཁྱེན་བརྩེའི་དྲི་མེད་ཟླ་བའི་དཔལ། །སྐྱེ་དགུའི་ཕན་བདེ་འབྱེར་ཕྱིར་ཕེགས་ཤར་བ། །ཐར་འདོད་ཀུན་གྱི་ཚོགས་ཀྱི་གཉེན་གཅིག་བྱ། །མཚོག་སྦྱལ་འགྲོ་བའི་མགོན་པོར་གསོལ་བ་འདེབས། །བསྟན་འགྲོར་སྨན་པའི་ཐུགས་བསྟེད་གྲུབ་པའི་མཐུས། །གང་ལ་གང་འཚམ་ཐབས་མ་ཁས་སྟོད་པ་ཡི། །འཕྲིན་ལས་རྣམ་བཞིས་འགྲོ་བའི་དོན་མཛད་པ། །འགྲོ་བའི་འདྲེན་པ་མཚོག་ལ་གསོལ་བ་འདེབས། །ངག་ལ་དབང་བསྡུར་བློ་གྲོས་བཟང་པོ་ཡི། །བཤད་སྒྲུབ་ཆོས་ཀྱི་རྒྱལ་མཚན་སྲིད་པའི་རྩེ་བ། །སྨད་ལྷུང་ཐུགས་བསྟེད་དགེང་པའི་མཛོན་མ་ཁས་པ། །གསུམ་ལྡན་ཏོ་ཏེ་འཛིན་ལ་གསོལ་བ་འདེབས། །ཡུལ་དང་དུས་ཀྱི་སྟེགས་མའི་ཡང་མཐའི་འདིར། །ཐ་མལ་ཚུལ་བཟུང་གཟུགས་སྐུའི་ཟ་མ་ཏོག། །མ་རྟོགས་འགོར་བའི་མཚོ་ལས་བསྒྲོལ་བའི་བར། །སྒོ་བཙན་མི་འདའ་བཏུན་པར་བཞུགས་གསོལ་འདེབས། །ཅི་མའི་གཉེན་གྱི་ལུགས་སར་འཛིན་པའི་མཚོག། །གྲུབ་ཆེན་ན་རོ་པ་ཡི་འཕྲུང་རབ་གཅིག །གོང་ས་མཆོག་གིས་བྱིན་རླབས་མཚན་གཤད་ཁང་། །བསྟན་འཛིན་ལྷུན་གྲུབ་བཏུན་པར་བཞུགས་གསོལ་འདེབས། །དེ་ལྟར་ཕྱི་གཅིག་གསོལ་བ་བཏབ་པའི་མཐུས། །སྐྱེ་བའི་འཕེད་བར་བླ་མ་ལྟ་མཚོག་གི། །ཐུགས་རྟེའི་ཀྱོ་བ་རྟོན་པོས་ལེགས་བཟུང་ཏེ། །མཐའ་མེད་སྲིད་པའི་མཚོ་ལས་སྒྲོལ་བར་མཛད། །བསྒྲེ་མེད་བླ་མ་མཚོག་གསུམ་བྱིན་རླབས་དང་། །ཡི་དམ་བསྟན་བསྲུང་རྒྱ་མཚོའི་ནུས་མཐུ་ཡིས། །འགྲོ་ཀུན་ཆོས་འབྱོར་བའི་དགས་འཚོ་བ་ཡི། །དེས་ལེགས་རྒྱ་མཚོ་ལྷོགས་ཀུན་ཁྱབ་ཀྱང་ཅིག་ཅེས་གྲུབ་པའི་དབང་ཕྱུག་པཏ་ཆེན་ནུ་རོ་པའི་མཚོག་སྒྲུལ་རིན་པོ་ཆེའི་ཞབས་བརྟན་གསོལ་འདེབས་འདི་ལྟ་བུ་ཞིག་དགོས་ཞེས། ཕྱུག་མཛོད་པ་གཅུ་རྒྱུབས་ཆོས་རྟེ་བསྟན་དར་སོགས་སེར་སྐྱ་སྟེ་ནས་བསྐལ་བཟང་། ༢ བཙུན་གཟུགས་པ་ཏུ་ལ་བླ་མ་སྐུ་ཕྲེང་དགུ་པ་བློ་བཟང་ལུང་ཏོགས་རྒྱ་མཚོས་སྟོར་བའི་གསོལ་ལ་འདེབས་ལ་དགོས་ཆེད་བཅུང་ཟད་ཀོ་ལོ་ཀ་གཅིག་རྒྱས་བྱེ་ཁང་དགའ་ལྡན་ཕེག་ཆེན་གྲྭ་བ་ཐ་ཤལ་བཀའ་བཅུ་མིང་འཛིན་པ་འོད་ཁང་བར་ནས།

НАРО БАНЧЭН ГЭГЭЭНТНИЙ ӨЛМИЙГ БАТАТГАХ ЗАЛБИРАЛ ОРШВОЙ

Ум сайн амгалан болтугай

Хоосон чанар, их амгалан хослон цэнгэх номын лагшингаас
Хувьдаж тоолшгүй дүрст лагшингийн тольт буман бүжиг
Хувилан цацруулж дэлгэрүүлэн зохиогч нууцын эзэн Очирдарь
Хутагт дээд гэтэлгэгч багшийн өлмийд соёрхол талбин залбирмой.

Ялгуусан бүхний айлдал нигүүлсэхүй тунгалаг цогт саран
Есөн төрөлхтөний тус амгаланг бүтээхээр урган гийсэн
Тонилохыг хүсэгч гүмүдаан чуулганы цор ганц садан
Дээрхийн хувилгаан, амьтны итгэлт дор соёрхол талбимой.

Шашин амьтнаа туслахын бодийн сэтгэл үүсгэсний хүчээр
Шавь түмэн алинаа таацсан уран аргын явдлаар
Тийн дөрвөн үйлсээр амьтны тус хэргийг зохиогч
Татагч дээд, амьтны удирдагч дор соёрхол талбимой.

Хэлэн дор эрхшээн урвуулагч сайн оюун зөвшлийн
Хэлэлцэж номлох, туурвиж бүтээхийн номын
дуазыг сансрын үзүүрт
Ханьцашгүй гайхамшигт бодийн сэтгэлийн
өмгөөр барихдаа мэргэшсэн
Хосгүй ачит гурав төгөлдөр Очирыг баригч дор залбирмой.

Цөвүүн цагийн эцсийн эцэс энэхүү ахуй үест
Цог учралын гүүр болсон эгэл ёсны дүрст лагшин
Эх болсон амьтдыг орчлонгийн далайгаас гэтэлгэхийг хүртэл
Энэхүү муу гаслангаас үл нөгчин бат оршин соёрх.

Бурхан багшийн ёсыг баригчийн дээд
Бүтээлч Наробагийн олон төрлийн нэгэн
Дээрхийн гэгээнтнээс тодруулан нэр хайрласан
ДАНЗАНЛХҮНДҮВ гэгээнтний өлмий бат оршин соёрх.

Тийнхүү нэгэн үзүүрт сэтгэлээр залбирсны хүчээр
Төрөл төрлийн эрхсэнээ багш, дээд тэнгэр бээр
Энэрэн нигүүлсэхүйн хурц гохоороо сайтар бариад
Эцэсгүй энэ сансрын далайгаас гэтэлгэн зохиогтун.

Хуурмаггүй дээд багш чухаг гурвын адис жанлав хийгээд
Хүчин төгөлдөр идам, шашныг сахигч баатар дагинасын хүчээр
Даамай их амьтан бүхэн номын учрал, амгалан баяслаар амьдрахын
Далай шиг их сайн буян зүг бүхнээ түгэх болтугай

хэмээн бүтээлчийн Эрхт хувилгаан Наро Банчэн гэгээнтний өлмийг батадгах энэ адилын нэгэн залбирал хэрэгтэй хэмээн санч Гүржав, Цорж Дандар тэргүүтэн хар шар олноос сануулсны ялдамд тойн Лувсанлүндогжамц бээр найруулсан энэхүү залбирлыг хэргийн тухайд өчүүхэн нэг бадаг нэмсэн гандан хийдийн лам нарын адаг гавж нэрийг зүүгч Ц.Отгонбаяр.

།།། །ནཱ་ར་བཅུ་ཆེན་བསྟན་འཛིན་ལྷུན་གྲུབ་མཆོག་གིས་གནང་བའི་སྨོན་ལམ་བཞུགས་སོ། །

НАРО БАНЧЭН ХУТАГТ ДАНЗАНЛХҮНДҮВИЙН ЕРӨӨЛ

།།། །རྒྱལ་རབ་ཐམས་ཅད་འགྲོ་བ་སེམས་ཅན་ལ། །འབྲལ་མེད་བདེ་སྨོན་ཞུག་དགེ་བདེ་བས་པ་དང་

། །མགོན་མཆོག་གསུམ་གྱི་ཆོས་ཀྱི་ཆར་འབེབས་པས། །རི་བ་ཐམས་ཅད་ཡིད་བཞིན་འགྲུབ་པར་ཤོག

། །ནཱ་ར་བཅུ་ཆེན་བསྟན་འཛིན་ལྷུན་གྲུབ་ནས།

Төрөл тутамдаа хамаг амьтантай
Төөч холдолгүй амгаланг ерөөснөөр
Чухаг дээд гурвын номын хур бууж
Чин хүсэл бүгд сэтгэлчлэн бүтэх болтугай

Наро Банчэн хутагт ДАНЗАНЛХҮНДҮВ хутагтаас

ГЭГЭЭНТНИЙ МИНЬ ӨЛГИЙ НУТАГ ОТГОНТЭНГЭР.

Одтой тэнгэр баганадан сансарт тэмүүлсэн
Оройдоо мөнгөн дуулга духдуулж гангарсан
Харгиатсан боргиотсон цэнгэг рашааны ундрагатай
Хатан тунгалаг мөнхийн усны шуранхайтай.
Замба тивийн нарыг оргилдоо дээдэлсэн
Заяа тавилан тэгшилсэн Отгонтэнгэр хайрхан минь.
Есөн эрдэнээр биеэ чимж, гэрлээ цацруулсан
Ертөнцийг бишрүүлэм домог хайлан мөнхөрсөн
Зуун зууныг элээж огторгуйд сүмбэрлэсэн
Зулай цагаан оргилдоо хараа цуцаан дүнхийсэн.
Таван хошуу мал сүргээ билчээж сувдарсан
Тасын жигүүр эцээм Отгонтэнгэр хайрхан минь.
Лусын буултаар хур омогшин асгарсан
Луугийн ороолтоор будан татуулан зүмбэрлэсэн
Хийморь далласан Очирваанийн сахиустай
Хишиг өргүүлж идээ дээжилсэн хайрхантай.
Замын хүмүүсийн бишрэлийг татаж, залбирлыг хүртсэн
Завхан нутгийн үзэсгэлэн Отгонтэнгэр хайрхан минь.
Таван ухааны номонд боловсорч бошго хайрласан
Танхай билэгт хутагт хувилгаадаараа алдаршсан
Нар аргамждаг гэгээнтнүүдийг залгамжилж, өргөмжлөгдсөн
Долдугаар дүр ДАНЗАНЛХҮНДҮВ багшийн минь төрсөн нутаг.
Гэгээнтэн багшийн минь гэрийн буйрын тамгат газар
Гэгээн багшийн минь угааж, ундаалсан Буянт рашаан.
Аргал янгир ан араатан шивээлж,үзэсгэлэн нэмсэн
Арц ганга агь анхилж амьсгал тэтгэсэн
Сүсэгтэн олныхоо залбирлыг дааж зам мөрийг нь тэгшилсэн
Сүмбэрлэн цайрах оргилдоо болгоож ивээл буянаа хайрласан.
Оройн дээд шүтээн Очирваань бурхандаа мөргөн залбиръя.
Оройн дээд шүтээн Отгонтэнгэр хайрхнаа шүтэн залбиръя.

Л.Маам
МҮЭ-ийн “Хөдөлмөрийн хүний төлөө” шагналт ахмад багш
2014 оны 11-р сарын 16. Завхан аймаг Отгон сум..

ЭРТНИЙ ЭНЭТХЭГИЙН БАНДИД ДИЛОВА

Энэтхэгийн түүхийн сурвалжаас авч үзэхэд анхны Дилова нь анхны Гармапа нараас уг гарал нэгтэй 200 гаруй жилийн өмнө буй болсон гэж үздэг. Ихэвчлэн ном зохиол болон уламжлалт

модон зураг дээр зурагдаж олны хүртээл болон ирсэн байдаг. Зүүн энэтхэгийн нэгэн барахман Нагаржунай багштай анх удаа уулзаж шавь орсон хүн байв. Нагаржунай тэр бархман Диловаг энэтхэгийн нэгэн вант улсын захирагч болоход ихээхэн тус хүргэж ван болсон боловч орчлонгоос сэтгэл нь уйсаж Венгалийн

тарнийн Сумапура гэдэг газар байдаг хийдэд шавьлан суув. Тэр хийдийн тэргүүн гэлэнмаа ламаас гэгээрэлд хүрэхийн замыг заалгаж чакрасамбрагийн уламжлалыг заалган 12 жил бясалгалд суужээ. Гэвч хажуугаас харсан хүмүүс эмэгтэйчүүдтэй ойрхон суудаг хэмээн буруугаар харсанд хийдээн орхин энэтхэг даяар тэнүүчилж хүнгүй аглаг газар бясалгал хийн тэло цэцгийн

тосоор амьдарч байв. Тэгэхдээ махамутро болон бусад сургаалыг сурсан. Тэр хэдийгээр хүн байхгүй аглаг газар байдаг байсан ч нэр алдар нь олонд түгэж сүсэгтэн нар олноор шавь орон ном заалгаж байв. Түүний хамгийн итгэлтэй гол шавь нь Нарова байжээ.

ЭРТНИЙ ЭНЭТХЭГИЙН БАНДИДА НАРОВА

Венгалийн хаан Нарова (1016-1100) нь Самантавадра гэдэг газар төрсөн бөгөөд өөрсдийхөн хаадын сургалтын дүрэм журмыг дагахыг эсэргүүцсэн. Найман настай байхдаа Оюуны боловсрол олж авахын тулд хамгийн сайн багшид шавь орохоор Кашир явахыг хүссэн. Гурван жилийн дараа гэхэд зүй тогтлын шинжлэх ухаан, дүрэм, теори ба урлагын салбарт суралцаж эхэлсэн.

Түүнийг сурч байх хугацаанд түүний эцэг эх тэдний уламжлалт ёсны дагуу түүний гэрлэлтийн зохион байгуулж Вималидипийн Врахимтай гэрлүүлэхээр болсон. Гэрлэлтийн ёслолын үйл ажиллагаа нь түүнийг буцаж ирэхэд болсон гэвч найман жилийн дараа Нарова гэрлэлтээ цуцлахыг хүсээд Кашир луу хурдан эргэн очиж сахил аван сургалтаа цааш үргэжлүүлсэн.

Хэдэн жилийн дараа хорин найман настай түүний хүсэл түүнийг Наландирийн Их сургууль руу залсан. Пуллахарын ойролцоо байдаг энэ сургууль нь Буддын философоороо алдартай бөгөөд энэ салбарт суралцаад тэрээр хамба лам болсон.

Гэвч дараа нь Дакини гарч ирээд түүнд бясалгал бол Буддын филлософоос илүү чухал бөгөөд Тилопийн зааврыг судлахыг зөвлөсөн.

Түүний зөвлөгөөний дагуу Нарова Дорно зүг рүү явж бясалгалын багшийг олж суралцаад түүнийг тарнитай хослуулсан.

Тэр хэдийгээр Тилоротой уулзаагүй ч түүнийг танилгүй 12 удаа хатуу хүнд шалгалтыг өгсөн.

Тэр нөр их хөдөлмөрийнхөө үрээр Тилорын сургалтын мастер болж түүнийг залгамжлагч болсон.

НАРО БАНЧЭН ДАНЗАНЛХҮНДҮВ ГЭГЭЭНТНИЙ НАМТАРЫН ДАЛАЙГААС ӨЧҮҮХЭН ТӨДИЙ ДУРЬДВААСУУ

Гэгээнтэн XVII жарны мЦог нигуурт” хэмээх усан тахиа жилийн хаврын дунд сарын шинийн найман буюу 1993 оны 3 дугаар сарын 31-ний Балжиннямтай билэгт сайн өдөр Отгонтэнгэр хайрхны өвөрт орших Завхан аймгийн Отгон суманд эцэг Даарийжавын Баянмөнх, эх Ядамсүрэнгийн Содном нарын ууган хүү нь болон мэндэлжээ. Д.Баянмөнхийн гэр бүл ууган хүүдээ Б.Цэдэн-Иш хэмээх нэр хайрлажээ.

Цэдэн-Иш хүү аав, ээжийн хамт 1995 он

Б.Цэдэн-Иш хүү багадаа цочимхой хүүхэд байжээ. Хүүгийн зүсийг нуун буруу энгэртэй дээл өмсгөж, гэрийн үүдээр дээс татан хөл хорьж, ээж аав нь газар тавилгүй энхрийлэн тэвэрсээр 3 нас хүргэв. Хүүд зориулан нутгийн лам Адьяа болон хүүгийн өвөө нар нь өдөр бүр тусгайлан ном уншиж, рашаанаар ариулдаг байжээ. Мөн нутгийн хувилгаан Цэрэндондов /Мил богдын хувилгаан/ нэг ой хүрэх үед нь хүүгийн малгайн отог, өмсөх дээлийн өнгө зэргийг нь өөрийн гараар бэлдэн өгчээ.

Хүү дөрвөн настайдаа олон могой хормойлон тоглож хавь ойрын хүмүүсийг айлгадаг байсан байна. Таван нас хүрсэн хойноо гэрийнхээ бурхан тахил дээрх судрыг уншиж эхэлжээ. Үүнийг ажсан аав ээж нь Цэрэндондов хувилгааны зөвлөснийдагуу Заян гэгээн Лувсанданзанпүлжинжигмэдэддагуулан очиж шавь оруулсан байна. Зая гэгээн Лувсанданзанпүлжинжигмэд Итгэл судрыг уншихад нь хүү даган уншиж байсан гэдэг.

Гэгээнтэн Нийслэлийн 105 дугаар дунд сургууль болон ШУТИС-ийн КТМС-ийг тус тус онц дүнтэй төгссөн. Луу жилийн хаврын тэргүүн сарын шинийн 3-ны их ерөөлт өдөр буюу 2012 оны 2 дугаар сарын 24-нд ламтаны лагшинд эгэлгүй онцгой шинж тэмдэг ирнэ гэж Богд

Төрсөн дүү Б.Занабазарын хамт
2003 он

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ҮНЭМЛЭХ

БҮ 201132110

РД ИЙ 93033117

Баянмонх

эцэг /эх/-ийн нэр

Цоодол-Ш

нэр

Хэнтийн аймаг, Сонгинохайрхан

/Аймаг, нийслэл, сум, дүүрэг/

105 дугаар Бүрэн дунд

сургуулийн төгсөлтийн шалгалтын комиссын 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн шийдвэрийг үндэслэн бүрэн дунд боловсролын үнэмлэх олгов.

ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫН ДҮН, ХУВЬ

1. Монгол хэл, уран зохиол А 95,7
2. Математик А 100
3. Физик А 100

Төгсөлтийн шалгалтын комиссын дарга

Гэмтэй сарын

2011 оны 06 сарын 02-ны өдөр

СУРЛАГЫН ДҮН, ХУВЬ

1. Монгол хэл А 94,9
2. Уран зохиол А 94,7
3. Англи хэл Б 80,2
4. Математик А 89,9
5. Нийгмийн ухаан Б 87,8
6. Байгалийн ухаан А 90,6
7. Технологи Б 88,7
8. Эрүүл мэнд А 93,5
9. Биеийн тамир А 93,6
10. Мэдээлэл зүй А 90,8
11. Физик
12. Хими
13. Биологи
14. Газар зүй
15.

СОНГОН СУДАЛСАН ХИЧЭЭЛИЙН ДҮН, ХУВЬ

1. Физик А 92,4
2. Англи хэл Б 86,1
3.

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ГҮНЗГИЙРҮҮЛЭН СУДАЛСАН ХИЧЭЭЛИЙН ДҮН, ХУВЬ

1. Математик Б 105 87,9
2.

Сургуулийн захирал

Хичээлийн эрхлэгч

Ангийн багш

Бүрэн дунд боловсролын гэрчилгээ
2011 он

ШУТИС-ийн КТМС-ийг бакалавр
зэрэгтэй төгсөв, 2015 он

МОНГОЛ УЛС

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

БАКАЛАВРЫН ДИПЛОМ

Дугаар D 201530697

Монгол улсын иргэн **БАЯНМӨНХИЙН ЦЭДЭН-ИШ** нь

2015 онд БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН сургуульд

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ МЕНЕЖМЕНТ

мэргэжил /D340200/-ээр суралцан төгссөн тул

төгсөлтийн комиссын 2015 оны 06 сарын 23-ны өдрийн шийдвэрийг үндэслэн

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын 2015 оны 06 сарын 25-ны өдрийн тушаалаар

ТӨРИЙН УДИРДЛАГЫН

БАКАЛАВРЫН зэрэг олгов.

БД: 59109

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дарга **Ц.БУЯНЦОГТОО**

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал Профессор, доктор **Б.ОЧИРБАТ**

Төгсөлтийн комиссын дарга Профессор, доктор **Х.ЭНХЖАРГАЛ**

Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн захирал Профессор, доктор **Г.БАТХҮРЭЛ**

Аав, ээж,
дүүгийн хамт
2015 он

гэгээнтэн айлдсны дагуу Монголын Гандантэгчэнлин хийдийн их хурлын танхимд лам хуваргууд онцгойлон чуулж, хүндэтгэлтэйгээр лагшин гэрэлт биед нь сахиус залав.

Наро Банчэн гэгээний 6 дугаар дүр Жүгдэрнамжил лагшин гэрэлт биеэ хураахаасаа өмнө “Би сайн цаг ирэх үед Цагаан уул талдаа, голоо өгсөж дахин төрнө” гэж ерөөл тавьсныг нутгийн зон олон ярьдагчлан Наро Банчэн гэгээний VII дугаар дүр Отгонтэнгэр хайрхны өвөрт төрж, 7 нас хүртлээ өөрийн нутагтаа амьдарч байсан байна. Хувилгаан хүн өөрийн авьяас билэг, эрдэм чадлаараа өргөн олныг бишрүүлэн хүндлэл хүлээх нь ихэд ховор байдаг нь судар номонд тэмдэглэгджээ. Наро Банчэн Данзанлхүндүв гэгээнтэн төрсөн цагаасаа олноос онцгойрч, уулзаж золгосон бүхний сүжиг бишрэлийг төрүүлж түүний онцгой содон авьяас билиг, номын хүч чадлыг ам дамжин ярьдаг болов. Үүнээс улбаалан орон нутгийн засаг захиргаа, сүм хийд, ард олон нь урьдын хутагт хувилгаадын хойд дүр мөн эсэхийг тодруулахаар Дээрхийн гэгээн 14-р Далай ламд уламжилжээ. Дээрхийн гэгээн XIV Далай лам Данзанжамц эрхшээн соёрхож “Халхын 88 шидтэй Наро Банчэн хутагт эргэлзээгүй мөн” хэмээн батламжлав. Энэхүү соёрхол одоо цагт хувилгаадыг тодруулдгаас огт өөр ховор тохиолдол болсон юм.

Б.Цэдэн-Иш 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Наро Банчэн гэгээний долдугаар дүрээр тодорч, Дээрхийн гэгээн 14 дүгээр Далай лам Данзанжамцаас батламж, соёрхолоо гардав. Гэгээнтнээр тодорсон батламжийг нь гардуулахдаа долдугаар дүрийн гэгээнтэнд Далай багш Данзанлхүндүв хэмээх номын нэр

хайрлажээ. Мөн нэгэн цагт хамтдаа батламж, соёрхолоо гардсан Жамъянгарав хувилгааны хойд дүрийн гэгээнтэнд Данзанжигварал хэмээх номын нэр хайрлалаа. Шинжлэх ухаан төгс хөгжиж байгаа XXI дүгээр зуунд шинжлэх ухааны эрдэм боловсрол эзэмшиж байгаа Наро Банчэн гэгээнийг Далай лам сайшаан сургуулиа амжилттай дүүргэхийг ерөөж, үргэлжлүүлэн бурхны номд шамдах хэрэгтэйг онцгойлоод эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд агуу их үйлсийг бүтээгээрэй гэж захив.

Энэтхэг улс, Дарамсала хот. Дээрхийн Гэгээн XIV Далай ламын өргөөнөө. Монголын Бурхны шашинтны тэргүүн хамба лам Д.Чойжамц болон Жамъянгарав гэгээн Данзанжигваралын хамт. 2014 он

Улаанбаатар хотноо 2014 оны 11 сарын 2-ны өдөр Наро Банчэн Данзанлхүндүв хувилгааныг Монголын Бурхан Шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Буддын гүн ухааны Дашчойнпэл дацанд шашин номын дагуу ширээнд залах хүндэтгэлийн ёслол үйлдлээ. Хүндэтгэлийн арга хэмжээний үеэр дээдийн номын багш хуварга хийгээд Наро Банчэн хувилгааны унаган шавь тэргүүтнүүд, улс төр, урлаг спорт гээд нийгмийн бүхий л давхаргын сүсэгтнүүд хүрэлцэн ирж шашин номын дагуу хувилгаанаа ширээнд залж, номын үйлийг гүйцэтгэсэн юм.

Наро Банчэн Данзанлхүндүв хувилгааныг Монголын Бурхан Шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Буддын гүн ухааны Дашчойнпэл дацанд ширээнд залсаны дараа төрж өссөн Завхан аймгийн Отгон сумаас нь Морин жилдээ амжиж өөрийн төрсөн нутагтаа морилон ирнэ үү хэмээсэн гүн хүндэтгэлэлт заллага ирсэн юм. Тус сумын Засаг даргын Тамгын газар хийгээд нутгийн

Энэтхэг улс, Дарамсала хот. Монголын тамгатай хутагтуудын хамт. 2014 он

зон олны гүн сүсэгт хүслийн дагуу өөрийн төрсөн нутгийн зүг хүлгийн жолоо залав. Завхан аймгийн Отгон суманд морилох аянд зам нийлж Гандантэгчэнлин хийдийн гавж лам Ц.Отгонбаяр, лам Лхагва, Төрболд, Дашдорж тэргүүтэй лам нар, мөн хувилгааны аав ээж болон бусад шавь нар нь бараа болон дагалдлаа. Хувилгааныг төрсөн нутагтаа морилох зуур Монгол ёс заншлаар нутгийн удирдлага болоод төрөл төрөгсөд, шавь нар нь замд нь тосч угтан золгосон билээ. Хувилгаан өөрийн төрсөн сумандаа хоёр өдөр саатаж тус сумын Гэндэнпэлжээлэн дацанд шашин номын дагуу мөргөл үйлдэн тахил өргөж номын үйлийг бүтээв. Үүний дараагаар сумын соёлын төвд сумын нийт ард иргэдтэй уулзаж, ном хурж, сүсэгтнүүдэд адис өглөө. Энэ үеэр зургаадугаар Наро Банчэн Жүгдэрнамжил хувилгааны төрсөн нутаг Шилүүстэй сумын нутгийн удирдлагууд хүрэлцэн ирж номын багшдаа алд шар хадаг барин заллага айлтгасан юм. Заллагын дагуу Шилүүстэй суманд морилоход Шилүүстэй сумын ард иргэд сумынхаа нутгийн удирдлагын ордоны өмнө Монгол гэр барьж үүдэнд нь цагаан эсгий дэвсэн хүж уугиулж, ном уншсаар гүн хүндэтгэлтэйгээр угтлаа. Шилүүстэй сум байгуулагдсны 90 жилийн ой 2014 онд

тохиосон бөгөөд ойн хүрээнд зохион байгуулагдсан олон арван ажлын нэг нь сумынхаа төвд хийд барьж, ашиглалтанд оруулсан нь бэлэгшээлтэй сайхан ажил боллоо хэмээж байсан юм. Хувилгаан Шилүүстэй сумын дацанд тахил өргөж, ном хурж бүгдийг шашин номын дагуу гүн хүндэтгэлтэйгээр үйлдсэн юм. Харин дараа нь Шилүүстэй сумын нийт ард иргэдэд зориулан сумын соёлын төвд ном уншиж, урд дүрийн төрсөн нутгийн зон олондоо адис хүртээсэн буян номын сайхан үйл хөгжөөлөө. Нар баруун руу хэвийхийн алдад Зургадугаар Нар Банчэн Жүгдэрнамжил хувилгааны төрсөн газарт хүрч, гэрэлт хөшөөнд нь хүндэтгэл үзүүлж шашин номын дагуу буягы үйлийг цогцлоосон юм. Ариун дагшин хангай дэлхий тун чиг намуухан эргэж байсан даа. Харин маргаашийнх нь ургах нарнаар Цаст Очирваань Отгонтэнгэр хайрхан руу хүлгийн жолоо заллаа. Хувилгаан аяны багийнхантайгаа их хайрханы энгэрт үдэлж, хайрхандаа сүсэглэн мөргөж, цай сүүнийхээ дээжийг өргөж тухлан саатав. Отгонтэнгэр хайрхны энгэрээс мордож Богдын голд дүлцэн өргөснөөр энэ удаагийн Завхан аймгийн Отгон, Шилүүстэй сумдаар аялсан аялал, бурхан номын ажил өндөрлөж хүлгийн жолоог эргүүлсэн юм.

Ламын гэгээн Данзанжамбалчойжишинэн хувилгааны санаачлагаар 2014 оны 12 сарын 2-5-ны өдрүүдэд Хойд Энэтхэгийн Дарамсала хотод Дээрхийн гэгээн 14 дүгээр Далай лам Данзанжамц Монголчуудад зориулж Ханьцашгүй агуу Зонхов Богдын зохиосон

Завхан аймаг Шилүүстэй сум. 2014 он

Их Бодь мөрийн зэрэг номыг айлдах “Монгол сүнчой” айлдварт Наро Банчэн хувилгаан морилсон юм. Монгол сүнчойд Монгол улсаас хувилан тодорсон 16 батламжит хутагтаас Дилов хутагт Данзанламид, Заян гэгээн Лувсанданзанпүлжинжигмэд, Жонан Ханчэн Лувсанчойдог, Жалханз хутагт Данзанчойживанчүг, Ламын гэгээн Данзанжамбалчойжишинэн, Гүшри хувилгаан Данзанчойжиням, Манзушир хутагт Данзанжамъяндорж, Баригри хувилгаан Дэнзэнжамъянлодойнамжил, Банбар эрдэнэ хутагт Дүрданзанпэрэнлэйгүнчав, Ноён хутагт Данзанлувсантүдэв, Наро Банчэн хутагт Данзанлхүндүв нарын 12 хувилгаан морилсон байлаа. Монголоос төрсөн тамгатай хутагтууд маань өглөө нь Далай багшийн номын айлдварт сууж, үдээс хойш нь Монголоос зорьж очсон сүсэгтэн олон хийгээд Монгол түмнийхээ ашдын сайн сайхны төлөө Өмнөд Энэтхэгийн Гоман болон Сера дацан хийгээд Монгол улсаас зорьж очсон лам хуваргуудтай хамтдаа ном хурж буян номын үйл хэргийг бүтээсэн юм.

Монгол Түвд зэрэг Гэлүгбагийн шашин дэлгэрсэн улс оронд Богд Зонхавын таалал төгссөн их дүйчин өдрийг Гандан ачод, Зулын хоринтаван гэж эртнээс эрхэмлэн тэмдэглэж хурал ном хурж ирсэн уламжлалтай байдаг. Өвлийн эхэн сарын 25 буюу зулын хорин тавны өдөр Наро банчэн хувилгаан лам хуварга хийгээд шавь, сүсэгтэн олонтойгоо Гандантэгчэнлин хийдэд зул өргөж, номын үйл үйлдсэн юм аа.

Идга Чойлин дацанд Жадо Ренбүчи Гэгээнтнээс номын авшиг авахын өмнө мандал өргөв. 2015 он

Эртний Энэтхэгийн 84 шидтэний нэг, ар халхын 88 шидтэй, нар аргамждаг хэмээн олноо домогшин алдаршсан урд төрлүүдээсээ дамжигдан өвлөсөн авьяас билгээ сэргээн, Наро Банчэн гэгээн эрдэм номд шамдан суралцсаар шид үзүүлж эхэлснийг нь дүрс бичлэг, зураг хөргөөр баримтжуулсан тохиолдлууд нэлээдгүй байна. Түүнээс цөөн хэдийг дурдвал: Завхан аймгийн Богдын гол тасарч, ган гачиг болсон 2006 онд Гэгээнтэн 13 настай байв. Гэгээнтэн аав ээж, ах дүүсийн хамт Богд Очирваань Отгонтэнгэр хайрхнаа зорин очиж тайлга тахилга үйлдсэний дараа Богдын гол сэргэн урссаныг нутгийн зон олон Гэгээн багшийн минь эрдэм чадал хэмээн сүсэглэн залбирдаг билээ. Өнгөрсөн 2014 оны зун Богд Очирваанийн нутагтаа очих үеэр болсон байгалийн содон үзэгдлээс сийрүүлье. Гэгээнтэн шавь нарын хамт хайрхныхаа өвөрт очиж хоноод өглөө босоход Отгонтэнгэр хайрхны доод хормой хүртэл цас орсон байлаа. Монгол түмний их шүтээн нүүрээ угаасан мэт цээлшин тунгалагшиж, ариун дагшин эхэмсэг сүртэйгээр дүнхийж байсан юм. Харин орой нь нар шингэхгүй гойд удав. Нар шингэсний дараа хулгана цагийн үед солонго татаж, шөнийн солонгыг яг дэргэдээс нь харж, хөхүүн баяссанаа нэгэн шавь нь дурсан ярьсан юм.

Наробанчэн гэгээний хурал ном, тахилга тайлгын үйл ажиллагааны үеэр бороо мөндөр орох, солонго татах, чоно, хос буга зэрэг амьтан тааралдах, ер бусын сонин содон үзэгдлүүд болдог байна.

Хутагтын аав “Очирваань” овогт Даарийжавын Баянмөнх нь Завхан аймгийн Отгон суманд 1969 оны тахиа жилийн өвлийн дунд сарын шинийн 15-ны билэгт сайн өдөр малчин ард Даарийжавын 3 дахь хүү болон мэндэлсэн. Д.Баянмөнх нь бага насаа эцэг эхийн дэргэд өнгөрөөж, сумын дунд сургуулийг дүүргэн, 1987-1990 онд цэргийн албанд тэнцэн, Ардын цэргийн ... дугаар ангийн дарга, улс төрийн орлогчийн жолоочоор алба хаасан. Цэргийн албыг дуусгаад өөрийн төрсөн Отгон сумдаа Зил-130 машин хүлээн авч, сумын бүхий л ажилд дайчилагдан өдөр шөнө, нойр хоолыг мартан аадар бороо, цасан шуурга аагим халууныг үл огоорон нутгийн зон олонд хэрэглэгдэх ачаа бараа татах, айл нүүлгэх гээд бүхий л ажлыг амжуулан өгч байв. Тэр үед нутгийн хүмүүс Баянмөнх гарлаа л гэвэл төд удалгүй саадгүй хүрээд ирдэг олны итгэл найдварыг хүлээсэн жолооч гэдэг байв. Зах зээлийн хүнд үед нутгийн зон олондоо гурил

будаа, хэрэгцээт бараа таваарыг хүргэн өгдөг буянтай ажлыг хийдэг байжээ.

Ээж Ядамсүрэнгийн Содном нь Завхан аймгийн Отгон суманд 1971 оны 10 сарын 18-нд Ядамсүрэнгийн 7 дахь охин болж төрсөн. Бага насандаа ах, эгч нарынхаа хүүхдүүдийг харж өгдөг, хүүхдэд хайртай, хөдөлмөрч охин байжээ. 1979 онд сургуульд орж Шилүүстэй сумын сургуулийг 1989 онд төгсөөд 1991 он хүртэл Ангаах ухааны дунд сургуульд суралцаж төгссөөд сумынхаа эмийн санд ажиллаж байжээ. 1992 онд Баянмөнхтэй гэр болж 2 хүү төрүүлсэн. 2004 онд АУДуС-ийн эм найруулагчийн анги төгссөн. Ард иргэдийнхээ эрүүл мэндийн салбарт одоог хүртэл ажиллаж байна.

Аав Баянмөнхийн аав Дэлэгням

Эцэг Дэлэгням нь лам хүн байсан Дуутын хүрээ, Наро Банчэн гэгээний хийдэд суудаг байсан. Тэрээр Дилова хутагттай их ойр дотно байснаа дурсан ярьдаг байсан. Мөн зурхай зурдаг, чойрын ном үзсэн их номтой буурал байсныг нутгийн ард олон дурсан ярьдаг. Өөрийн ээж Даарийжав Завхан аймгийн Отгон суманд 1934 онд төрсөн. Даарийжав нь 3 хүү 2 охин төрүүлж өсгөсөн буянтан.

Баянмөнхийн өвөг эцэг Жамсран

Өвөг эцэг Жамсран нь Засагт хан, Сайн ноён хан аймгийн хошуунд хошуу тамгын бичээч, төр нийгмийн зүтгэлтэн хүн байсан. 1930-1932 оны Засгийн газрын шийдвэрийг эсрэг ташаа ойлгосон хүмүүст зөв ойлгуулан ухуулах, бичиг хэргийг зөв таниулах үйл хэрэгт хүчин зүтгэж явсан тухай Дилав хутагт Жамсранжав дурдатгалдаа бичсэн байдаг.

Баянмөнхийн эмэг эх Дуламсүрэн

Завхан аймгийн Отгон суманд төрсөн. Бурхан урлаач хүн байсан. Оёж хатгаж зүү ороож, оёсон бурхад нь одоо болтол хадлгалагдаж байгаа. 98 нас зооглож бурхан болсон.

Ээж Содномын аав Ядамсүрэн

Эцэг Дүгэржавын Ядамсүрэн нь 1924 онд Завхан аймгийн Отгон сумын малчин ард Дүгэржавын 3 дахь хүү болон төрсөн.

Бага насандаа Халтарын хүрээнд сууж ном үзсэн. 1942-1945 онд цэргийн алба хаасан. Эх Цэрэнпилтэй 1950 онд гэр бүл болсон. Аав минь номын их тусыг нутгийн түмэндээ хүргэсэн эрхэм лам хүн байлаа.

Ээж Содномын ээж Цэрэнпил

Эх Дагий овогтой Цэрэнпил нь 1933 онд Завхан аймгийн Отгон суманд төрсөн. Эх, ах нарын хамт мал маллаж байгаад 1950 онд эцэг Ядамсүрэнтэй гэр бүл болж 9 хүүхэд төрүүлж өсгөсөн. Үр хүүхдүүддээ ажил хөдөлмөр амьдралын ухаан сургасан ачит ээж байжээ.

Ээж Содномын өвөг эцэг Дүгэржав

Өвөг эцэг Дүгэржав нь 1886 он Завхан аймгийн Отгон суманд төрсөн. Бага насандаа эцэг эхийн хамт мал малладаг байсан. Эмэг эх Цэвэгмэд нь 1890 онд Завхан аймгийн Отгон суман малчин ардын гэр бүлд төрсөн.

ХУТАГТЫН УУГАН ШАВЬ Л.ЭНХСАЙХАНЫ ДУРСАМЖААС

Бид азтай юм. Сайн нөхдийн буянаар 2011 оны намар Олхонууд овогт Лувсандоржийн Энхсайхан миний бие, эхнэр Замч овогт Маамын Буянхишигийн хамт багштайгаа танилцаж, номын барилдлагат багш шавь болох хувь тохиосон юм. Тухайн үед би гэдэг хүн социализмийн үеийн хүмүүжлээр төлөвшсөн шашинд үл итгэгч байлаа. Бидний анхны уулзалт сэтгэлд их л дотно сайхан мэдрэмж төрүүлсэн цаг хугацаа байв. Тэр л өдрөөс хойш багшийнхаа буян номын төлөөх их үйлд даган баясаж, бишрэн шүтсэн хүн билээ.

Тэр үед багш маань ЕБС-иа дүүргээд, ШУТИС-ийн КТМС-ийн нэгдүгээр курссын оюутан, Эрдэнэ Зая-Бандида гэгээний хийдэд шавилан сууж ном үздэг лам байлаа.

Багшийг дагалдан явахад замын туршид сонин содон, мэлмий гийгүүлж, сонор мялаах гайхамшигтай үзэгдэл тохиолдлууд олон болдог нь багшийн минь эрдэм чадал, далд увидас, авьяас билэг хэмээн итгэж сүсэглэн залибарч явдаг нэгэн билээ, би.

Шавь Л.Энхсайханы хамт. 2015 он

Багшдаа бараа болон 2012 оны 7 сард улсын наадмын дараахан Завханы Отгон сум руу анх очив. Багш сумын төв дээр ах дүүстэйгээ уулзан хэд хоносны дараа нутгийн цөөн хэдэн хүнийг дагуулан Отгонтэнгэр Хайрхан руу өгсөж, тайлга тахилга хийсний дараа үүлгүй шахам тэнгэрт гэнэт үүл хуралдан бороо орж, шидийн гэмээр мөндөр оров. Маргааш өглөө нь харахад Цагаан уул маань олон жил ган гачиг халуунд хиртсэн нөмрөгөө угааж, цас нь цагааран гялалзаж харагдахад хотол олон баясан байсан нь тод санагдаж байна. Мөн тэр өдөр Шилүүстэй сумын төлөөллүүд хүрэлцэн ирж, заллага айлдсны дагуу хүрэлцэн очив. Шилүүстэйнхэн морь уралдуулан наадаж тоссон юм. Хүндэтгэлийн концертыг үзэн сонирхсны дараа Андиа Гэгээний суварга дээр очиж ном айлдав. Сумын сүсэгтэн олон өргөнөөр оролцсон тэрхүү өдөр багшийг машинаас буугаад суварга очих үест гэнэт салхилж, дээлийнх нь хормойг дэрвэлзүүлсэн шидийн гэмээр салхи яагаад хөдөлснийг гайхаад л өнгөрч билээ.

Харин дараа нь 2013 оны зун цөөн хэдэн шавийн хамт Булган, Хөвсгөлийн сайхан нутгаар дамжин, төрсөн нутаг Отгон сумын зүг хүлгийн жолоо заллаа. Хөвсгөл явах замд нэгэн жижиг нуурийн захад цувж явсан олон машин чонотой таарав. Машин замаас ердөө 5 метр орчмын зайд чоно хэлээ унжуулан өөдөөс харан зогссоор 10

орчим минут болсон юм. Таван метрийн цаана зогсоо чонын цоо ширтэж гайхан мэлэрсэн дөлгөөн харц одоо болтол миний санаанд тод байна. Илүү заяатайдаа олзлогдож, ижил заяатайдаа харагдаад л өнгөрдөг хийморьт чоныг цувж яваа тэр олон машинд ийм ойрхон, айдас хүйдсийг мартан гайхаж зогсохын чинээ бодоогүй хэрэг л дээ. Багш 2013 оны 8 сарын 18-ны билэгт сайн өдөр Цагаан уулаа тахих тайлга тахилга үйлдэв. Тахилга хийсэн өдрийн нар жаргахгүй удаж, харин шөнө нь солонго татаж зон олныг сүсэг бишрэлийг гүн төрүүлсэн юм.

Нэгэнтээ Халхын IX Богд Жавзандамба хутагт багшийг маань “Аль нэг хувилгааны хойд дүр болов уу, нэг л өөр байна. Надад их таалагдлаа.” хэмээгээд хойшид хичээл сургууль болон Далай багшид уламжлах асуудлыг шийдэхийг Одсэр Ринбүчид даалгаж билээ. Энэ үеэс нутгийн зон олон түүнийг хувилгаан хэмээх итгэл үнэмшлээр даган баясаж, Наро банчэн гэгээний зургаа дугаар дүр Жүгдэрнамжил хутагт айлдахдаа: “Миний дараа дүр Отгонтэнгэр хайрханы өвөрт голоо өгсөөд төрнө” (VI дүрийн Наро Банчэн хутагт Жүгдэрнамжил хутагтын авга дүү, Цагдаагийн хурандаа С.Цэвээнлхазал болон Шилүүстэй сум, Отгон сумын нутгийн хөгшчүүлийн ярьдагчлан) гэсний дагуу Наро банчэний гэгээнтний хойд дүр мөн хэмээн нутгийнхан сүсэглэн залбирсаар иржээ.

Үүний дагуу Наро банчэн хувилгааны урд дүрийн нутаг Завхан аймгийн Шилүүстэй сумын “Нутгийн зөвлөл”, мөн Отгон сумын “Нутгийн зөвлөл” санаачилж, Гандантэгчэнлин хийд дэмжин, түүний дэргэдэх “Эрдэм соёлын хүрээлэн”, Монголын Бурхан Шашны Дээд Сургууль хамтран зохион байгуулж “Наро банчэн хутагт судлал” эрдэм шинжилгээний хурлыг 2014 оны 1 сарын 16-ны Шинийн 15-ны бэлгэт сайн өдөр эрдэмтэн багш нар чуулж Наро Банчэн хутагттай холбоо бүхий судалгааны ажлуудаар итгэл тавьж байлаа. Тус эрдэм шинжилгээний хурлаар үеэр Наро Банчэн хувилгааны дараа дүрийг тодруулах санал гарч хэлцэгджээ. Гандантэгчэнлин хийдийн дэд хамба лам, гавж Н.Нанзаддорж, Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх “Эрдэм соёлын хүрээлэнгийн захирал, доктор гавж Ш.Сонинбаяр, Азийн буддистуудын энх тайвны бага хурлын нарийн бичгийн дарга, доктор гавж Т.Булган, Монголын бурхны шашины дээд сургуулийн захирал Х.Бямбажав болон бусад лам хуваргууд, ‘”Дилова” хутагт сангийн Гүйцэтгэх захирал

А.Батцэнгэл, VI Наро Банчэн Жүгдэрнамжил хутагтын авга дүү С.Цэвээнлхазал ах дүүстэйгээ, Завхан аймгийн Шилүүстэй сумын Нутгийн зөвлөлийн дарга Билиг-Өрнөх, мөн Отгон сумын Нутгийн зөвлөлийн дарга Л.Гаваасүрэн нар оройлон оролцов. Хурлын үеэр тавигдсан 11 эрдэмтдийн илтгэлийг эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл номонд дэлгэрэнгүй дурдсан болно. Тун удалгүй Завхан аймгийн Отгон болон Шилүүстэй сумын удирдлагууд болон нутгийн зөвлөлүүд Гандантэгчэнлин хийдэд хүсэлт гаргажээ. Хүсэлтийг үндэслэн 2014 оны 04 сарын 11-ний билэгт сайн өдөр МБШТөв, Гандантэгчэнлин хийдээс Дээрхийн гэгээнтэн XIV-р Далай багшид өргөх бичиг уламжилсан байдаг.

Өнгөрсөн жил олон сумдын 90 жилийн ой тохиосон билээ. Урилга заллагын дагуу Отгон сумын 90 жилийн ойн баяр наадамд багш маань лам хуварга, шавь нарынхаа хамт 10 гаруй машины цуваа үүсгэж Завхан нутгийг зорьсон юм. Уламжлал ёсоор нутгийн иргэд багшийг замд нь тосон хүндэтгэл үзүүлж, Отгон сумынхан хоймортоо залан наадав. Бидэнд багш маань аль хэдийн хутагт болон тодорсон мэт санагдсанд нууцхан залибарч суулаа. Цагаан уулаа тахьсаны дараа Улиастай орох замд Ганцын даваан дээр багшийн машины өмнүүр хос буга гарч одов. Мөн л содон сайхан, ихэд билэгшээлтэй харагдаж байж билээ.

Гайхалтай. 2014 оны 09 сарын 11 өдөр. Далай багшийн зарлигтай айлдвар ирсэн тухай баярт мэдээ амнаас ам дамжин бидэнд хүрсэн билээ. Далай багшийн айлдварыг сонсох тэр мөчид багшийнхаа буян заяанд даган баясаж, бид бүгд залбиран мөргөлөө. Тэрхүү лүндэнд НАРО БАНЧЭН-ийн хойд дүр мөн гэдэгт эргэлзэхгүйгээр батлан айлдсан нь бүх цаг үеийн туршид шууд хувилгаан тодруулсан онцгой тохиолдолын 2 дахь нь байжээ. Тун удалгүй 2014 оны 10 сарын 6 өдөр Багшийг даган аав ээж, лам хуврага, нутгийн зөвлөл, “Монголын Хутагт Хувилгаад” баримтат кино төслийн сэтгүүлч, зураглаач, сүсэгтэн олон хийгээд нийт 20 хүнтэй баг Буянт-Ухаа нисэх онгоцны буудлаас хөөрч БНХАУ-ын Бээжин хотоор дамжин 6-наас 7-нд шилжих шөнө Энэтхэгийн нийслэл Дели хотноо газардав. Айхтар бөгчим халуун ч, зөөлөн бороо шивэрсэн сайхан шөнө байлаа. Норовбадам лам маань түрүүлэн очиж, бүх бэлтгэл ажлаа базаасан тул бидэнд түүртэх шалтгаан гарсангүй. Цаг алдалгүй давхисаар хорь гаруй цагийн

дараа өндөр уулсын дундах суурин, Дээрхийн гэгээн XIV Далай ламын амьдран суудаг

Дарамсала хотод үдшийн бүрий тасарахын алдад хүрсэн юм. Бид Далай багшийн ордны дэргэдэх зочид буудалд байрлалаа. Тэр шөнө өндөр уулсын хотод хүчтэй аяга цахилгаантай ширүүн аадар бороо орж, тал нутгийн би гэдэг хүн айн түгшиж Далай багшийг бодон залибарч хонов.

МБШТөв, Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба Б.Чойжамц түрүүлэн очсон байлаа. Мөн шинээр тодорсон Жамьянгарав хувилгаан батламж соёрхлоо гардахаар хүрэлцэн ирсэн байлаа. Монгол хоёр хувилгаан Далай багшаас соёрхлоо хүртэхээр очоод уулзсан бас түүхэн тохиол байлаа. Хувилгаадын шадар хүмүүс уулзалдаж ярилцах, яг тэр үед бас нэг сонин зүйл тохиов. Гэнэт л цастай өндөр уулын хоёр талаас агшин зуурын дотор үүл хуйлран хуралдаж нийлэн, манан будан буулгаж зөөлөн бороо зүсэрч эхлэв. Бүгд л тагтан дээр гарч зураг хөрөг авч, дүрс бичлэг хийж байлаа.

Халхын IX Богдынхоо лаврингаар орж мөргөн, түүний туулж өнгөрүүлсэн амьдрал, нулимстай гашуун түүхийг сонсон Монголчуудынхаа сайн сайхны төлөө халхын X Богд маань монголдоо хурдан залрах болтугай гэж ерөөл тавин залбирч, Далай ламын ордонг гороолон сүсэглэсээр нэгэн өдрийг өнгөрүүлэв.

Намрын дунд сарын шинийн 17-ний билэгт сайн өдөр хоёр хутагтын маань даахийг Дээрхийн гэгээнтэнд үргээн сахил хүртээж, НАРО БАНЧЭН хутагт багшид маань ДАНЗАНЛХҮНДЭВ гэж номын нэр хайрласан билээ. Далай багш дээд сургуулиа амжилттай дүүргээд, Жагарын орноо эргэн ирж, бурхны номондоо шамдан суралцахыг хүссэн юм. Шинжлэх ухааны дээд боловсролтой хутагт хувилгаад цөөхөн байгааг онцлон дурьдаж байв.

Тайванчуудад зориулан Далай ламын айлдаж байсан номонд 3 хоног даган баясаад, орой бүр лаврин тойрон гороолоно. Буцах замд Жадо Ренбүчи багшийг маань хүлээн авч, өөрийн дацандаа 1000 ламаар ном айлдан, өөрийн өргөөнөө хүлээн авч уулзав. Энэ үеэр гэгээн багшийн маань аав Баянмөнхийн сэтгэл ихэд хөдлөн “Жадо Ренбүчид хадаг барин миний хүүгийн номын аав нь болоорой” гэж ерөөл тавьсан нь машид сайхан сонсогдож байв.

Делид Үндэсний музейгээр нь орж, Бурхан багшийн лагшинд залбирав. Агра хотод байх Монгол цусны хатанд зориулан босгосон ертөнцийн долоон гайхамшгийн нэг Таж махалыг үзэж сонирхлоо.

Жагарын орноос буцах замдаа, Бээжин хотод түр буудаллан хотын төвд байрлах Монголчуудын барьж байгуулсан хийдэд очин, өвөг дээдсийн маань урласан нарийн хийцтэй бурхад хийгээд бусад бүтээлийг бишрэн сонирхож явахдаа тус хийдийн Өвөрмонгол хамбатай таарав. Хамба багшийг өргөөндөө урьж уулзав.

Зорьсон хэргээ бүтээгээд 2014 оны 10 сарын 15 өдөр Буянт-Ухаа нисэх онгоцны буудалд буухад багшид лам хуврагууд болон сүсэгтэн олон мандал өргөв. Тэндээсээ Гандантэгчилэн хийддээ ирж Монгол түмний их шүтээн Мэгжид Жанрайсаг бурханд мандал өргөлөө.

2014 оны 11 сарын 2-ны билэгт сайн өдөр Гандангийн Дашчоймпил дацанд Наро Банчэн Данзанлхүндүв гэгээнийг сэнтийд залах үйл ажилгаанд Отгон сумын удирдлагууд оролцож, нутаг орондоо морилох заллага барив. Багш 2014 оны 11 сарын 10-ны алдад нутгийн зүг хөдөллөө. Нутгийн олон Буянт голын гүүрэн дээр тосон авч хүндэтгэл үзүүлэн маргааш өглөө нь сумын хийддээ мандал өргөв. Сумын соёлын төвд Наро Банчэн хутагтын долоодугаар дүрээр тодорсон Данзанлхүндэв Гэгээн багш маань мэгзим хөгжөөн даллага авхуулан, нутгийн олондоо Дарь эхийн болон Очирваанийн лүнгийн авшиг өглөө. Шилүүстэй сумын зочид төлөөлөгчид Гэгээнийг нутагтаа залахаар ирлээ. Багшийг морилоход Шар хөтөл дээрээ угтаж, захиргааныхаа өмнө гэр барин цагаан эсгий дэвсэн сүсэгтэн олон хүж асаан, ном уншсаар хүндлэл дүүрэн угтсан юм. Хийдэд мандал өргөж, соёлын төвд нь маань, мэгзэм хөгжөөн даллага авхуулав. Орой нь VI Наро Бачнэн Жүгдэрнамжил хутагтын гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлж, ном уншлаа. Харин маргааш өглөө нь Цагаан уулынхаа хормойд хүрэв. Бурхан номын дагуу ёслол үйлдээд буцахдаа Буянт голын харзанд дүлцэн өргөснөөр хотын зүг хөдөлсөн билээ.

2015 оны зун 06 сард Ховд аймагт, 07 сард Говь-Алтай аймагт Наро Банчэн Данзанлхүндэв Гэгээнтэн багшийг залан хүндэтгэл үзүүлж, сүсэгтэн олонд зориулсан ном хурах ёслолууд ээлж дараагаар болов. Сүсэгтэн олон шид үзүүлээч гэж уламжилсаны

дагуу хат суусан гантай сэлмийг хоромын дотор зангидаж харуулав. Сүсэгтэн олон залбиран шүтэж, багшаас адис хүртэн ерөөлөө хайрласан билээ. Урд дүрүүдийн шавилан сууж байсан Наро ванчин хутагтын сүмийн туурин дээр аймгийн удирдлагуудтай очиж ном хурав. Энэхүү туурийн урд том хэмжээний нуур үүссэнийг нутгийн олон “Гэгээн нуур” гэж нэр хайрласныг багшид дуулгав. Энэ нуурын эрэг дээр туурийн хажууд аймгийн удирлагууд аймгийн хийд оронд сэнтийдээ залах тухай заллага айлдахад гэгээн багш маань төрсөн аймагтаа 08 сард залагдах урилгатай, үүний дараа болох болов уу гэж айлдсан. Урьдын ерөөлтэй нутгаараа морилон саатаж, Гуулин тосгоны иргэдэд ном айлдав. Алтайн өндөр уулсын нэг Бурхан буудайд очин залбирал үйлдээд хотын зүг хүлгийн жолоо залсан юм. Энд хүрээд дурдатгалаа жаргаахын ялдамд Гэгээн багшийн маань эрдэм чадал, увидас чадвар нь улам нэмэгдэн батжиж, бурхны номондоо шамдан суралцаж, Монголын түмэн олон маань амар амгаланг олж, сайн сайхан жаргалыг эдлэх болтугай хэмээх ерөөлийг өргөж байна.

2015.07.20
Улаанбаатар хот
Л.Энхсайхан

ДЭЭРХИЙН ГЭГЭЭН XIV ДАЛАЙ БАГШ
ТАНАА

МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИНТНЫ ТӨВ
ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН
ЗАХИРГАА

Монголын Бурхан Шашинтны Төв,
Гандантэгчэнлин хийд, Улаанбаатар-38, Монгол улс
Утас: 976-11-360354/360337 Факс: 976-11-360354
И-мэйл: mbcgandan@magicnet.mn

Огноо 2014.06.24. № 209

ЭРХЭМ ДЭЭД АВРАЛЫН ОРОН
ДЭЭРХИЙН ГЭГЭЭН XIV ДАЛАЙ БАГШ ДАНЗАНЖАМЦ ТАНЫ
АМАР АМРГАЛАНГ АЙЛТГАЖ ӨЛМИЙД ТАНЬ СӨГДӨН МӨРГӨЖ
АЙЛТГАХЫН УЧИР:

Монгол Улсын Завхан аймаг болон Завхан аймгийн Отгон сумын иргэдийн Төлөөлөгчидийн хурал хийгээд тухайн орон нутгийн иргэд сүсэгтэн олон, Завхан аймгийн Отгон сумын харъяат Баянмөнхийн Цэдэн-Ишийг Монголын төрөл дамжсан Наро ванчин хутагтын хойд дүр хэмээн итгэж үнэмшиж үүнийг Дээрхийн Гэгээн XIV Далай багш танд айлтгаж мөн эсэхийг баталгаажуулж өгнө үү хэмээн удаа дараа бидэнд хүсэлт тавьж байна.

Иймийн учир Дээрхийн Гэгээн Далай багш Та үүнийг болгоон соёрхоно уу.

Авралт итгэлийн орон болсон багш таны өлмийн батжиж зуун галавт залрах болтугай.

Жич: Холбогдох бичиг баримтыг хавсаргав.

ТЭРГҮҮН ИХ ХАМБА ЛАМ, ГАВЖ Д.ЧОЙЖАМЦ

ЗАВХАН АЙМГИЙН
ОТГОН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 01 сарын 09 өдөр Дугаар 03. Отгон

Иргэдийн хүсэлт уламжлах тухай

Завхан аймгийн Отгон сумын харьяат ард иргэд, нутгийн уугуул Улаанбаатар хотын иргэд, тус сумын Нутгийн зөвлөлийн удирдлага болон бурханы шашинт сүсэгтэн олны санал, хүсэлтийн дагуу Отгон сумын ИТХ-р хэлэлцэн хуралдаж дараах үндэслэлийн дагуу /хавсралт1/, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 , 20.1.9 , 20.1.10 дахь заалтыг үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Отгон сумын уугуул иргэн ИЙ93033117 регистрийн дугаартай Монгол улсын иргэн Очирваань ургийн овогт Баянмөнх овогтой Цэдэн-Ишийн талаар хавсралт 1-ийн үндэслэлээр түүнийг дэмжигч, шүтэн залбирагч иргэдийн саналыг дэмжсүгэй.

2.Цэдэн-Ишийг дэмжигч иргэдийн гарын үсэг, бусад материалыг холбогдох газарт нь уламжлахыг сумын Засаг дарга /Ж. Амгаланбаяр/-т даалгасугай.

ДАРГА Д. ПҮРЭВДОРЖ

Завхан аймгийн Отгон сумын

ЗАВХАН АЙМГИЙН
ШИЛҮҮСТЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 03 өдөр Дугаар 8 Балгатай

Иргэдийн хүсэлт уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 4, 9, 10 дахь заалт, сумын иргэдээс ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Завхан аймгийн Отгон сумын харьяат Очирваань ургийн овогт Баянмөнх овогтой Цэдэн-Иш нь хувраг хүн бөгөөд эдүгээ нэр алдар нь олноо түгж, эгэлгүй нэгэн бодьгал болж, эрдэм, ид шидийг үзүүлж буйг харгалзан, албан ёсоор тодруулж, баталгаажуулах, түүнийг шүтэгч, дэмжигчид, шавь нар болон нутаг усны ард иргэдээс ирүүлсэн хүсэлтийг дэмжсүгэй.

2. Б.Цэдэн-Ишийг дэмжиж нутгийн иргэдээс ирүүлсэн хүсэлт, гарын үсэг болон бусад материалыг холбогдох газарт нь уламжлахыг сумын Засаг дарга \Я.Баасанхүү\-д даалгасугай.

ДАРГА Ш.УРАНЧИМЭГ

togtool

ЗАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 02 сарын 03 өдөр Дугаар 07 Улиастай

Иргэдийн хүсэлтийг уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Очирваань ургийн овогт Батмөнхийн Цэдэн-Иш нь эрдэм чадал, оюун ухаанаараа нэр алдар нь олноо түгэн, сүсэгтэн олон, ард иргэдэд ивээл буянаа хайрлаж, олон түмний хүндэтгэлийг хүлээснийг харгалзан түүний хувилгаан дүрийг тодруулж, баталгаажуулан сэнтийд нь залах тухай иргэдийн санал хүсэлтийг дэмжсүгэй.

2.Б.Цэдэн-Ишийг дэмжсэн баримт материалыг холбогдох газарт нь уламжлахыг аймгийн Засаг дарга /Ж.Жамъянтив/, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Балхярваа/ нарт даалгасугай.

ДАРГА Б.ОТГОНБААТАР

Тогтоол 2014

ЗАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ
212800 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-2211

МОНГОЛЫН БУРХАН ШАШИНТНЫ ТӨВ
ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН ТЭРГҮҮН,
ИХ ХАМБА ЛАМ, ГАВЖ Д.ЧОЙЖАМЦ ТАНАА

2014.04.11 № 63
танай_____-ны №_____т

Хүсэлт уламжлах тухай

Завхан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар Завхан аймгийн Отгон сумын харьяат Б.Цэдэн-Ишийн талаар хэлэлцэн 07 дугаар бүхий шийдвэр гарсныг Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн Хамба лам гавж Д.Чойжамц танаа хүргүүлж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газрын 2014 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн ТГ/179 дугаар бүхий албан бичгийг үндэслэн Монгол улсын "Төр, Сүм хийдийн харилцааны тухай" хуулийн хүрээнд аймгийн 69700 иргэдийн шашин шүтэх эрхийг хүндэтгэн Б. Цэдэн-Ишийг Наро Банчэн хутагтын хойд дүр мөн хэмээх Завхан нутгийн ард иргэдийн итгэл үнэмшил, даган баясах чин хүсэлтийг харгалзан үзэж таньд уламжилж байна.

Шашны дэг жаягийн дагуу та бүхэн шийдвэрээ гаргаж Дээрхийн гэгээнтэн XIV Далай ламд уламжлан танилцуулан, баталгаажуулж өгөхийг хичээнгүйлэн хүсье.

ДАРГА Б.ОТГОНБААТАР

Тоот 2014

150 052

ЗАВХАН АЙМГИЙН ОТГОН СУМЫН УЛААНБААТАР ХОТ ДАХЬ НУТГИЙН ЗӨВЛӨЛ

2019 оны 08 сар 24 өдөр Дугаар 1/29 Улаанбаатар хот

Баянмөнх овогтой Цэдэн-Ишийн тухай

Хувилгаанд тодруулах үндэслэл

Завхан аймгийн Отгон суманд 1993 оны 3 сарын 31-ны өдөр, тахиа жилийн хаврын дунд сарын шинийн 8-ны Балжиннямтай бэлгэ дэмбэрэлт өдрийн сайн цаг болох үхэр цагт Баянмөнхийн ууган хүү Цэдэн-Ишийг мэндлэхэд Завхан нутгийн Цэрэндондов хувилгаан маш сайн хүү төрлөө хэмээн ихэд баясч байжээ.Удалгүй эцэг Баянмөнхтэй уулзаж ноёны малгайн отго, дээлийн өнгө өгч, 2 настай байхад нь хүүг сахиус бурханы ивээлд ойрхон тул хайрлан хамгаалж, ариун байлгахыг сануулж байжээ.

Бага насандаа үеийн хүүхдүүдээс онцгой сэргэлэн, аливаа зүйлдих зөн билигтэй хандаж, хэн ч заагаагүй байхад маань тарни унших мэт залбиран суудаг байсанд гайхширсан эцэг, эх хүүгээ хожим Зая гэгээнд бараалхуулж багш шавийн барилдлагатай болгожээ.

Халхын Эрдэнэ Зая Бандида Лувсанданзанпүлжинжигмэд багш нь“Итгэл”номыг түвдээр уншихад хэнээр ч ном заалгаагүй байсан хүү уг номыг даган уншихад Зая гэгээн урьдын авьяас билиг нь тодорч байна хэмээн ихэд баясжээ.

2010 оны 1 сард Багшийн хамт Дармасалад IX Богд Жавзандамба хутагт Жамбалнамдолчойжижалцан (IX Bogd Jebtsundamba)-д бараалхахад ном сайн үзэхээр байна хэмээн ихэд олзуурхаж, сахиус бурханы ерөөл барилдлага байгааг хэлж Очирваань бурханы тарний тоо гүйцээхийг захижээ.

2010 оны зун Отгонтэнгэр Очирваань хайрхан нутагтаа очих үед хайрхан шинэ цасаар нүүрээ угааж, харуй бүрий болохын цагт нар шингэхгүй удан, харанхуй шөнийн хулгана цагт солонго татахад нутгийн олон Богд багшийн тааллаар Нар аргамждаг Наро банчэн гэгээн заларалаа хэмээн ихэд бэлгэшээн хүндэтгэж байв.

2012 оны 2 сарын 24-ны Цагаан сарын шинийн 3-ны их ерөөлт өдөр Монголын Гандантэгчэнлин хийдийн Лавранд Богд гэгээнтний айлдсанаар Цэдэн-Иш хүүд эгэлгүй онцгой шинж тэмдэг ирэх тул хүлээн авах ёслолыг Гандантэгчэнлин хийдийн хурлын зааланд зохион байгуулж, лам нар чуулж үйлдсэнд Зая гэгээн болон лам багш нар Одсэр Ринбүчи, Түгсрэй Ринбүчи нарын хамт байлцаж Богдод айлтгажээ.

1

Халхын IX Богд “Аль нэг хувилгааны хойд дүр болов уу, нэг л өөр байна. Надад их таалагдлаа. Хойшид хичээл сургууль болон Далай багшид уламжлах асуудлыг шийдэх”-ийг Одсэр Ринбүчид даалгасан.

Энэ үеэс нутгийн зон олон түүнийг хувилгаан хэмээх итгэл үнэмшлээр даган баясаж, Наро банчэн гэгээний урд дүр хэлэхдээ: “Миний дараа дүр бол Отгонтэнгэр хайрхандаа голоо өгсөөд төрнө” (VI дүрийн Наро Банчэн хутагт Жүгдэрнамжил хутагтын авга дүү, Цагдаагийн хурандаа С. Цэвээнлхазал болон Шилүүстэй сум, Отгон сумын нутгийн хөгшчүүлийн урд дүрийн захиасыг хэлсэнтэй давхцаж буй) гэсний дагуу Наро банчэний дүр мөн хэмээн нутгийнхан сүсэглэн залбирсаар ирлээ.

Үүний дагуу Наро банчэн хувилгааны урд дүрийн нутаг Завхан аймгийн Шилүүстэй сумын “Нутгийн зөвлөл”, тус аймгийн Отгон сумын “Нутгийн зөвлөл” санаачилж, Гандантэгчэнлин хийд дэмжин, түүний дэргэдэх “Эрдэм соёлын хүрээлэн”, Монголын Бурхан Шашны Дээд Сургууль хамтран зохион байгуулж “Наро банчэн хутагт судлал” эрдэм шинжилгээний хурлыг 2014 оны 1 сарын 16-ны Шинийн 15-ны бэлгэт сайн өдөр эрдэмтэн багш нар чуулж Наро банчэн хутагттай холбоо бүхий судалгааны ажлуудаар итгэл тавьж, энэхүү Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцэн, Наро банчэн хувилгааны дараа дүрийг тодруулах нь зүйтэй талаар нэгдсэн саналд хүрсэн билээ. Энэхүү шийдвэрийг гаргахад тус хуралд оролцсон Гандантэгчэнлин хийдийн Дэд хамба лам Н. Нанзаддорж гавж, Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх “Эрдэм соёлын хүрээлэнгийн захирал доктор гавж Ш. Сонинбаяр, Азийн буддистуудын энх тайвны бага хурлын нарийн бичгийн дарга, доктор гавж Т. Булган, Монголын бурханы шашины дээд сургуулийн захирал Х. Бямбажав болон бусад лам багш нар, ”“Дилова” хутагт сангийн Гүйцэтгэх захирал А. Батцэнгэл, VI Наро банчэн Жүгдэрнамжил хутагтын авга дүү С. Цэвээнлхазал болон түүний ойрын ах дүү хамаатан садангууд, Завхан аймгийн Шилүүстэй сумын “Нутгийн зөвлөл”-ийн дарга Билиг-Өрнөх, Завхан аймгийн Отгон сумын ”Нутгийн зөвлөл”-ийн дарга Л. Гаваасүрэн болон лам хуврагууд байлцсан юм. Мөн Илтгэл тавьсан 11 эрдэмтийн тухай танилцуулга мэдээлэл болон илтгэлийг эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл номонд дэлгэрэнгүй дурдсан болно.

2014 оны зун Отгонтэнгэр хайрханаа тахихуй үест урдийн бэлгэт зүйлс давтагдан хос вансэмбэрүү тааралдаж, хос 2 чоно угтаж, хосоороо ижилссэн буга, согоо үдсэнд нутгийн олон бэлгэшээн ховор сонин үзэгдэлд талархан, Далай багшаас хувилгаанаа хэмээсэн итгэл сүжгийг ёсоор болохыг сүсэглэн залбирсаар байна.

Ард түмний энэхүү итгэл үнэмшил дээр тулгуурлан Завхан аймгийн Отгон сумын “Нутгийн зөвлөл” хуралдан шийдвэрлэж, шат шатны байгууллагуудад хандсанаар нутгийн засаг захиргааны ИТХ болон Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын, сүсэгтнүүдийн итгэл үнэмшлийг даган баяссан албан бичиг зэрэгт үндэслэн Монголын бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн захиргаа хуралдан Баянмөнх овогтой Цэдэн-Ишийг Наро банчэн хувилгааны хойд дүр мөн эсэхэд тодруулга хийж өгнө үү хэмээн Далай багшид хандсан албан бичгийг Гандантэгчэнлин хийдийн зүгээс зөвхөн Баянмөнх овогтой Цэдэн-Ишд хийж өгснийг хавсралт баримтуудын хамтаар үйлдсэн болно.

Баянмөнх овогтой Цэдэн-Иш нь Улаанбаатар хотын арван жилийн 105-р сургуульд 1-10-р анги хүртлээ суралцан алтан медальтай төгсөөд Шинжлэх Ухаан Техникийн Их Сургуулийн харьяа, КТМС-ийн “Төрийн захиргааны менежмент”-ийн ангид элсэн одоо дүүргэх шатандаа суралцаж байна.

2

Цэдэн-Ишийн эцэг эхийн болон гурван үеийн намтрын товчлол

Аав Баянмөнх

Даарийжавын Баянмөнх нь Завхан аймгийн Отгон суманд 1969 оны 1 сарын 13-нд Даарийжавын 3 дахь хүү болон мэндэлсэн. Нутаг усандаа бага насаа өнгөрүүлж 8-р анги төгссөн. 1987-1990 онд цэргийн алба хааж төрсөн нутагтаа ажил амьдралаа эхлүүлсэн. 1992 онд эхнэр Содномтой гэр бүл болж 1993 онд том хүү Цэдэн-Иш нь мэндэлсэн. 1995 онд бага хүү Занабазар мэндэлж ам бүл 4-үүлээ амьдарч байна.

Ээж Содном

Ядамсүрэнгийн Содном нь Завхан аймгийн Отгон суманд 1971 оны 10 сарын 18-нд Ядамсүрэнгийн 7 дахь охин болж төрсөн. 1979 онд сургуульд орж 1989 онд 10-р анги төгсөөд 1989-1991 оны хооронд АУДунд сургуульд суралцаж төгссөн. 2004 он АУДуС-ийн эм найруулагчийн анги төгссөн. 1992 онд Баянмөнхтэй гэрлэж 2 хүү төрүүлсэн. Том хүү Цэдэн-Иш, бага хүү Занабазар нар юм.

Аав Баянмөнхийн аав Дэлэгням

Эцэг Дэлэгням нь лам хүн байсан Дуутын хүрээ, Наро банчэн гэгээний хийдэд суудаг байсан. Тэрээр Дилова хутагттай их ойр дотно байснаа дурсан ярьдаг байсан. Мөн зурхай зурдаг, чойрын ном үзсэн их номтой буурал байсныг нутгийн ард олон дурсан ярьдаг. Өөрийн ээж Даарийжав Завхан аймгийн Отгон суманд 1934 онд төрсөн. Даарийжав нь 3 хүү 2 охин төрүүлж өсгөсөн.

Баянмөнхийн өвөг эцэг Жамсран

Өвөг эцэг Жамсран нь Засагт хан, Сайн ноён хан аймгийн хошуунд хошуу тамгын бичээч, төр нийгмийн зүтгэлтэн хүн байсан. 1930-1932 оны Засгийн газрын шийдвэрийг эсрэг ташаа ойлгосон хүмүүст зөв ойлгуулан ухуулах, бичиг хэргийг зөв таниулах үйл хэрэгт хучин зүтгэж явсан тухай Дилав хутагт Жамсранжав дурдатгалдаа бичсэн байна.

Баянмөнхийн эмэг эх Дуламсүрэн

Завхан аймгийн Отгон суманд төрсөн. Бурхан урлаач хүн байсан. Оёж хатгаж зүү ороож оёсон бурхад нь одоо болтол хадлгалагдаж байгаа. 98 нас зооглож бурхан болсон.

Ээж Содномын аав Ядамсүрэн

Эцэг Дүгэржавын Ядамсүрэн нь 1924 онд Завхан аймгийн Отгон сумын малчин ард Дүгэржавын 3 дахь хүү болон төрсөн. Бага насандаа Халтарын хүрээнд сууж ном үзсэн. 1942-1945 онд цэргийн алба хаасан. Эх Цэрэнпилтэй 1950 онд гэр бүл болсон.Аав минь номын их тусыг нутгийн түмэндээ хүргэсэн эрхэм лам хүн байлаа.

Ээж Содномын ээж Цэрэнпил

Эх Дагий овогтой Цэрэнпил нь 1933 онд Завхан аймгийн Отгон суманд төрсөн. Эх, ах нарын хамт мал маллаж байгаад 1950 онд эцэг Ядамсүрэнтэй гэр бүл болж 9 хүүхэд төрүүлж өсгөсөн. Үр хүүхдүүддээ ажил хөдөлмөр амьдралын ухаан сургасан ачит ээж байжээ.

Ээж Содномын өвөг эцэг Дүгэржав

Өвөг эцэг Дүгэржав нь 1886 он Завхан аймгийн Отгон суманд төрсөн. Бага насандаа эцэг эхийн хамт мал малладаг байсан. Эмэг эх Цэвэгмэд нь 1890 онд Завхан аймгийн Отгон суман малчин ардын гэр бүлд төрсөн.

Хүндэтгэсэн:

Нутгийн зөвлөлийн дарга Л. Гаваасүрэн

НУТГИЙН ЗӨВЛӨЛ УБ30178

4

Завхан аймаг Отгон сумын хийдэд. 2014 он

Отгонтэнгэр хайрханы өвөрт. 2014 он



Завхан аймаг Отгон сумын соёлын төвд. 2014 он

ГУРАВДУГААР БҮЛЭГ

НАРО БАНЧЭН ХУТАГТЫН ТУХАЙ АРХИВЫН БОЛОН НОМ, БҮТЭЭЛ, ТУУРВИЛД ДУРДАГДСАН ИШЛЭЛҮҮД

Монгол улсын үндэсний төв номын сангийн архиваас

Наро Банчэн хутагтын тамга, түүн дээр хуучин монгол үсгээр “Наро Банчэн хутагтын шавь нарыг бүгдийг захирагч тамга” гэж бичжээ.



Үсгийг хөрвүүлбэл: Зарилгаар соёлыг бадруулагч сүм хэмээн шагначухай. Мөн онд эхэлж цогчин, хангал, ганжуур, хайлан, хурлуудыг хурж майдар бурхан эргэж дээдийн түмэн өлзий бататгахын хурал бүр хурж тогтчухай. Бүрэн засагчийн гуравдугаар онд тус шавийн 6. “Дилова”-гийн хувилгаан эрх Цорж 7. Рашпунцаг 8. Цанид хурал хуруулахаар хүсэж уламжлан Дээрхийн гэгээний айлтгасанд 9. Жамъяншадавын 10. Игча-аар Цанид хуруултугай хэмээн айлдсанд мөн онд Цанид дацан байгуулж мөн хурал хурж тогтчухай. Бадралт төр зургаа дугаар онд Нар-Банчин хутагт 12. Бирава мөн шавийн Дилова-ын хувилгаан эрх цоржи Рашпунцаг нар 13. Зод дацан байгуулж хурал номыг хуруулж тогтчухай. Олноо өргөгдсөний найм дугаар онд гэжээ.

НЭГДҮГЭЭР. “Монгол улсын шастир” номноос авсан ишлэл.

Сайн ноён хан аймгийн Наро Банчэн хутагт Жүгдэрнамжилын уг эхийг байцааваас Энэтхэгийн оронд Жанингаханда (?), Банчиннару, Соном-Одсэр, Бадамринчин, Дүгбааравжир хэмээн таван үе хувилгаан мэндэлжээ. Түүний хойно Төвдийн оронд Даржаачойжалбуу, Ламунгэджав, Дардуйчинбүрэлхү, Жанцаннямбо хэмээн дөрвөн үе хувилгаан мэндэлжээ. Түүний хойно АНХ удаагийн хувилгаан Бадамдорж Чин улсын Энх Амгалангийн 38-р онд Сайн ноён хан аймгийн гүн Гончигийн хошууны тайж Гүржавын гэрт хувилгаан мэндэлж 40 хоногийн хүнс олгуулан Наро Банчэн хутагтын цолыг өгчээ. Тэнгэрийн Тэтгэсний 2-р онд жанч халжээ. /84б/

ХОЁРДУГААР үеийн хувилгаан Наваанчойронданзанжамц Тэнгэрийн Тэтгэсний 3-р онд Ордосын бэйс Наваанбалданцэрэнгийн хошууны тайж Дашдэндэвийн гэрт хувилгаан мэндэлжээ. 37-р онд Наро Банчэн хутагтын шавь нарыг захирах манж, монгол, төвд гурван зүйлийн үсгийн мөнгөн тамга олгуулжээ. Шанзадба байгуулжээ. Дараа өөрийн харьяат ба Ордос бэйс Юндэндоржийн хошууны нутгуудад нижгээд сүм байгуулан Сайшаалт Ерөөлтийн 8-р онд соёлыг бадруулагч шашны ерөөлт хэмээх нэр олгуулжээ. 22-р онд жанч халжээ.

ГУРАВДУГААР үеийн хувилгаан Түгжжав Төр Гэрэлтийн 8-р онд Амду газрын Жүбса хийдийн шавь Галсаннамжилын гэрт /85а/

хувилгаан төржээ. 11-р онд харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. Түгээмэл Элбэгтийн 7-р онд Нийслэл хот орж түнлий ном уншсанд магнаг нэгэн зах, луут нэг, сажибуу нэг, цэмбэ нэгэн зах, мөнгө 25 лан, булганы арьс 24, шүрэн эрхи нэг, шил зэс бойпор нижгээд, хавтага 10, мөнгөн өлгий хоёр, алтат найман тахил нэг, шаазан 51, хөхүүр хутга нижгээд, тугалган савтай чин цай хоёр бүхэл, үсэг нэгийг олгуулжээ. 11-р онд жанч халжээ.

ДӨРӨВДҮГЭЭР үеийн хувилгаан Бирваа Бүрэнт Засагчийн тэргүүн онд Халхын Түшээ гүн Мипамсамбуугийн хошууны залан Чогсомын гэрт хувилгаан мэндэлжээ. 4-р онд харьяат шавь нарт нийлүүлэн суулгажээ. 5-р онд хувилгаан үсгийг хасуулжээ. 9-р онд жанч халжээ.

ТАВДУГААР үеийн хувилгаан Пүрэвжав Бадаргуулалт Төрийн 10-р онд харьяат шавийн ард Доржийн гэрт хувилгаан мэндэлжээ. 18-р онд уул шавь нарт нийлүүлэн суулгажээ. 27-р онд хувилгаан үсгийг хасуулжээ. 29-р онд жанч халжээ.

ЗУРГАДУГААР үеийн хувилгаан Жүгдэрнамжил Бадаргуулалт Төрийн 30-р онд харьяат шавийн ард Лувсанцэрэнгийн гэрт хувилгаан мэндэлжээ. Хэвт ёсны 2-р онд уул шавь нарт нийлүүлэн суулгажээ. Монгол улсын Олноо өргөгдсөний 8-р онд улсын санд мөнгө хариулан өргөсөн учир айлтгаад хамбын бүрэн ямба шагнан хүртээжээ. Мөн онд Дотоод яамнаас хишиг тархаах зарлигаас хоцрогдсон учир айлтгаад цоржийн ямба шагнан хүртээжээ. /87а/

ХОЁРДУГААР. “Хутагтуудын өлгий миний Шилүүстэй” номноос авсан ишлэл.

НАРОБАНЧЭН ХУТАГТЫН ХҮРЭЭ

Наробанчэн хутагтын сүмийн уг эх бичигт тэмдэглэхдээ: «Урьд үеийн байгуулсан сүм, хурал, сургууль, нутаглан суух зэргийг байцааваас анх сайшаалт Ерөөлтийн 7-р /1802/ онд Наробанчэн хутагт Агваанчойроданзанжамц дээдийн түмэн өлзий бататгахын ном уншуулахаар Завхан голын хойт дахь Чандмань уулын өвөрт сүм хийд байгуулсныг айлтгасанд зарлигаар «Соёлыг бадруулагч»

сүм хэмээн нэрлэжээ.

Мөн онд эхэлж Цогчин, Хангал, Ганжуур, Хайлан хурлуудыг хурж, Майдар бурхан эргэж, дээд түмэн өлзий бататгахын хурал өдөр бүр хурж байхаар тогтоожээ.

Бүринт Засагчийн 3-р /1864/ онд тус шавийн Дилав хувилгаан, эрх цорж Раашпунцаг Цанид хурал хуруулахаар хүсэж уламжлан Дээрхийн гэгээнээ (Богд Жавзандамба хутагт) айлтгасанд Жамъяншадавын игчаагаар цанидын дацан байгуулж, мөн хурлыг тогтоож болно» хэмээжээ.

Бадаргуулалт төрийн 6-р /1880/ онд Наробанчэн хутагт Бирваа, мөн шавийн Дилав хутагт, эрх цорж Раашпунцаг нар жүдийн дацан байгуулж, хурал номыг хуруулж байхаар тогтоожээ. Олноо өргөгдсөний 8-р /1918/ онд энэхүү 2 дацанд нэр гуйж уламжлан айлтгасанд Очирдарь эзэн гэгээний зарлигаар цанид дацанд Чоянжүрмэддэчинлин, жүд дацанд Дэвшинсүмбэрэллин хэмээн тус тус нэр шагнасныг хичээнгүйлэн дагаж хэвээр хурал ном хуруулж, бүхийгээс гадна 4 улирал дараалан олон дончид, найданчога, манла, нүгнээ эдгээр хурлуудыг хурж, ламрим, ложин, цанид эдгээр номын сургуулийг үйлджээ. Наробанчэн хутагт, Дилав хутагт нар суух газар Завхан голын зах, Чандмань уулын өвөрт, хийдийн дэргэд суудаг болно. Үүнээс дээш энэ хоёр ламын байгуулсан сүм дацан 3, хурал 10 анги, суусан газар 1 болой» гэхчлэн тодорхойлж мэдүүлсэн байна.

Наробанчэн хутагтын шавийн хүрээ бол дэлхийн шарын шашны хоёр томоохон төлөөлөгч болох Наробанчэн, Дилав нарын хувилгаан дүрүүд үе үеэр залран сууж байсан түүхтэй, Очирвааний орны ариун дагшин өлгий юм.

Энэ хүрээ нь сүм дуганын хийц, зохиомж, дээвэр, ганжирын чимэглэлээрээ хосгүй чамин хийцтэй, халхын 700 гаруй сүм хийдийн дундаас нэртэй байсан гэдэг юм.

Барааны газраас алтан ганжрууд нь туяаран шаргалтаж, түмэн зул асаасан мэт яралзан тунарч харагдах нь аргагүй л халхын хоёр том гэгээний ид шидэнд бишрэх жир хүмүүний сэтгэлийг улам ариусган цэлмүүлдэг бөлгөө.

Андуу гэгээн Бирваа жүдийн дацанг хятадуудаар бариулаад

мөнгө бэлэн, сайхан барь гэхэд зарим шавь нар нь - Энэ мангарт мөнгө байхгүй. Энэ их мөнгийг хаанаасаа олох юм бэ гэж байтал дуганаа бариулж дуусаад шавь ардуудыг явуулж, хойт Цагаан Цахирын чулуунаас авчруулан цэгнэж өгөхөд мөнгө болсон байж гэнэ. Энэ үед Андуу дүрийн хувилгааны ид шидэнд биширч манай мангар чинь тэр аяараа Лусын сантай хүн юм гэцгээж байсан гэдэг.

Ар Монголд Манжийн засгаас автономитийн үе хүртэл арван гуравхан тамгатай хутагт байсны хоёр нь нэгэн хүрээнд зэрэгцэн сууж байсан нь ховорхон тохиох учрал бөгөөд энэ хоёр хутагтын хүрээнд эргэл мөргөлөөр ирэх хүмүүс саатаж амьдрах нь элбэг байснаас уг шавийн нутагт олон газраас торгууд, өөлд, дүрвэд зэрэг янз бүрийн ястан үндэстэн суурьшин амьдарч байсан аж. Энэ хүрээнд Наробанчэн хутагтын Монголд тодорсон сүүлчийн 5 дүр, Дилав хутагтын сүүлчийн 3 дүр залагдан сууж түмэн шавь нартаа буян хишгээ хайрласаар байсан түүхтэй.

ГУРАВДУГААР. “Халхын тамга бүхий хутагтуудын товчис” номноос авсан ишлэл.

НАРОБАНЧЭН ХУТАГТ

Наро Банчэн хутагтын язгуур угсаа нь Энэтхэг оронд тав, Түвдэд дөрвөн удаа тус тус хувилан төржээ.

Халх Монголын хаад ноёд Манж чин улсын бүрэлдэхүүнд дагаар орж Ар Монголд цэрэг-феодлын засаг захиргааны зохион байгуулалт ид хийгдэж байсан үед Наро Банчэн хутагтын дүр Түшээт хан аймагт тодорсон байна. Халхын умар замын дундад дахь умарт буюу хожмын “Хошууч мэргэн” хошууны тайж Гүржавынд 1699 онд төрсөн хүүг хутагтад тодруулах үйл ажиллагаа хошуу, аймгаар өрнөж 1703 онд дүр нь мөн болохыг Далай лам айлтгаснаар Гүржавын Бадамдорж хутагт бага наснаасаа Түвдэд залагдаж, тэнд эрдэм номонд суралцсан байна. Түүнийг нутагтаа буцан ирэхэд нь өөрийн хүслээр, бусад хүмүүсийн өглөгөөр нилээд тооны шавьтай болжээ.

Хошуу нутгийн харьяалал нь өөрчлөгдөж Сайн ноёны аймгийн бүрэлдэхүүнд оржээ. Тэрбээр 1737 онд жанч халсан байна.

Халх дахь Наробанчэн хутагтын дараагийн дүрээр тодорсон нь Агваанчойдогданзанжанцан бөгөөд энэ нь сахилын нэр юм. Хутагт бараг хорин нас хүртлээ эрдэм номын мөр хөөсөн, өөрийн гэсэн сүм хийдтэй ч болжээ. Хошуу, аймгийн чуулганы тодорхойлолтоор Тэнгэрийг тэтгэгч-Говзун хаан 1772 онд зарлиг гарган Наробанчэнд хутагтын тамга олгожээ.

34 настай тасга бүхий Агваанчойдогданзанжанцан хутагт шавь, аж ахуйгаа эмхлэн зохион байгуулж, Цэцэрлэгийн чуулганд захирагдах болсон байна. Хутагтад Хошууч мэргэн хошууны урьд хэсгээс газар нутаг таслан олгож Завхан голын хойт захад Наробанчэн хутагтын Тамгын газрыг суурьшуулжээ.

Наробанчэн хутагтын нутаг нь хэмжээгээрээ төдийлөн их биш. Өмнөт тал нь Бор цонж, хойт тал нь Туулайт хүртэл 1.5 өртөө, баруун нь Номгоноос зүүн тийшээ Уушиг хэмээх газар хүртэл гурван өртөө. Эл нутаг л хутагтад ноогдсон байна. Улсын төв номын санд байгаа 1913 онд зохиогдсон газрын зурагт «Наробанчэн хутагтын нутаг зүүнээс баруун хүртэл бүгд 120 (69120 м) газар, өмнөөс хойд хүртэл бүгд 30 (17280 м) газар байжээ» (24) гэсэн байна.

Агваанчойдогданзанжанцан хутагт 80 насан дээрээ жанч халсан байна.

Наро Банчэн хутагтын гурав дахь дүүрээр Түгжжав (1818-1860), дөрөв дэх нь Бирваа (1862-1883), тав дахь нь Пүрэвжав нар тодрон залагдаж үйл ажиллагаагаа явуулж байв.

Пүрэвжав гэгээн нилээн шазруун зантай, шавь нарынхаа гэр орноор очиж ном айлдах, зарим айлын тоононд хадаг зүүж ёслох, бадарчин болоод явуулын хүмүүстэй уулзаж ярилцах дуртай ажээ. Тэгж явахдаа жороо морь унан, олон хүн дагуулж, уулзсан бүхэнтэй өндөр дуугаар харилцах, хүнийг басамжлах, хор шары нь маажсан үг хэллэг айлдах нь энүүхэнд.

Гэгээнтэн нэгэн явалтаараа онцгой хурдан гэгэгддэг Аюуш хэмээх хүнтэй дайралджээ. Тэр бол дөрвөн хөллөөд хурдлахаар морьтой хүнд гүйцэтгэгддэггүй сонин хүн байж.

Пүрэвжав хутагт Аюушид хандан чи их хурдан гэл үү? Надтай уралдаад түрүүлдэг юм бол би чамд азрага адуу өгье гэжээ. Ингээд хутагт жороо халиун морио унан тэр хүнтэй Бугатын голд уралдаад

гүйцээгүйд Пүрэвжав гэгээнтэн нилээдгүй догширч арга буюу түүнд адуугаа өгч байжээ.

Сайн ноёны аймгийн тамгатай хутагтуудын дотроос Наробанчэн хутагтын хүрээнд хоёр хутагт байсан онцлогтой. Нэг нь Наро Банчэн гэгээн, нөгөө нь Дилав хутагт юм.

Дилав хутагтын язгуур угсаа нь Готама Буддагийн хамтран зүтгэгч Мангала юм. Харин Монгол газар орноо анхлан тодорсон дүр нь Ордос нутгийн Дамбадорж. Дараагийн хувилсан дүр нь Эрх бөгөөд тэрбээр Ордост Ванчин-жогийн сүмийг барьж олон түмний итгэл хүндэтгэлийг хүлээж, өвөр, ар Халхаас хэдэн арван шавьтай болжээ. Наробанчэн хутагт Эрхийн шавь нь байгаад нутаг өөрийн сүмийг босгосон байна.

Дөрөв дэх Дилав хутагт Халхаас тодрон Алтайн нурууны уулсын агуйнуудад Нямба хийж байгаад буцах замдаа Наробанчэнгийн сүмийг дайрах зорилгоор Улиастайд түр буудлан тэндээ зуурдаар жанч халсан байна.

Дараагийн тав дахь Дилав хутагтыг тодруулах ажил өрнөж мэргэ төлгөөс эхлээд Чойчин дуудах, зүг чигийг гаргах, сунтаг үзэх мэтээр хэд хэдэн хүүхэд сонголтод орсноос Наробанчэн хийдээс 30 орчим км-ийн зайтай газарт ээжийгээ 48 настай байхад хачин гэрэл цацруулан мэндэлсэн Жамсранжавыг тодруулан Жургааны яамаар дамжуулан Бадаргуулалт төр Дэйзун хаан баталгаажуулжээ. Дилав хутагтыг халхад дахин тодроод арваад жил болсны дараа Наробанчэн хутагт түүнийг сүм хийддээ хамтран сууна уу? гэж (25;29) урьжээ.

Дилав хутагт Жамсранжавыг Наро Банчэн хийдэд аваачин мандал өргөх ёслол үйлдэн Түвд үсэг бичиг зааж, шашны дэг жаягт сургаж эхэлжээ. Хутагтын хүрээ нь шашны ёс жаягийг хатуу баримталсан ойролцоох хошуу нутгийн хүмүүс, шавь олныхоо итгэл, бишрэл хүндэтгэлийг хүлээсэн нэр хүндтэй газрын нэг байв. Бусад хутагтууд болон Түвдээс лам хуваргууд залагдан ирж ажилладаг, олныг хамарсан том том хурлыг үе үе хийдэг, шашны төрөл бүрийн сургалт явуулдаг хүрээ байжээ. Тус хүрээний “Соёлыг бадруулагч” сүм нь Халх Монголд төдийгүй Түвдэд үнэлэгдэн “Шашны ерөөлт” нэрээр шагнагдсан байна.

Халхад тодорсон Наробанчэн Пүрэвжав, Дилав Жамсранжав

хоёул чацуу, хоёр хутагтын тус тусын тав дахь дүр нь нэгэн зэрэг эрдэм номонд суралцсан ажээ. Тэдний суралцсан байдлаас ажиглахад Жамсранжав нь оюуны чадавхиар илүү байсан бололтой. Хоёр хутагт аймгийн чуулганд оролцож, Богд гэгээний дүрийг нүдээрээ үзэж, олон хошууны ноёд хийгээд лам хуварга нартай уулзан нэг ёсондоо «нүд тайлсан» байна. Дилав хутагт арван гурван настайдаа «цагаан бурхан» өвчнөөр өвчилж жил гаран болоод эдгэхдээ нүүр нь ов тов цоохор болжээ. Хоёр хутагт хүрээ болон шавь аж ахуйгаа удирдахдаа тэгш эрх мэдэлтэй, хоорондоо эв нэгдэлтэй, хамтын шийдвэр гаргаж чаддагт онцлог нь оршино. Дилав хутагт Жамсранжав 1902-1903 онд Ховд, Улиастайд ажлаар явж байсан хойгуур хүнд өвчтэй байсан Наробанчэн Пүрэвжав гэгээн таалал төгсжээ.

Наробанчэн хутагтын Халх дахь зургадугаар дүрээр тус шавийн харьяат Жүгдэрнамжилыг тодруулан залсан байна. Наробанчэн шинэ хутагтыг олж тодруулах, эрдэм ном сургахад Дилав Жамсранжав хутагт ихээхэн хувь нэмэр оруулжээ.

Хүрээндээ Наробанчэн гэгээн, Дилав хутагт тус тусдаа өргөөтэй. Хурал номын хийгээд алив нэгэн үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг хоёр хутагтын сангаас ижил хэмжээгээр гаргадаг байжээ. Асуудлыг тэгш эрхтэй хамтран шийдвэрлэдэг. Дилав хутагт арван тав, арван зургаан настайгаас сүм хийд, засаг захиргааны ажилд идэвхийлэн оролцох болжээ. Жамсранжав хутагтыг 18 нас хүрэхээр нь Манжийн хуулийн дагуу сүм хийд, иргэний хэрэг эрхлэх бие даасан үйл ажиллагаа явуулахыг нь баталгаажуулан өгчээ.

Хоёр хутагт хүрээ хийд, шавь аж ахуйгаа өөд татах янз бүрийн ажлыг санаачлан хийж, Цэцэрлэгийн чуулганд ажил төрлөө танилцуулан ихээхэн дэмжлэг авч байжээ. Шавь малчин айл өрхөө 16, 16-аар нь хэсэг болгон зохион байгуулж мал сүргээ өсгөх, ашиг шимийг нь ашиглахад илүү үр дүнд хүрсэн байна. Дилав хутагт Жамсранжав урьд өмнө хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулж залруулсан баримт байдаг. Хутагт хэдэн сараар даяанчилж, мацаг барьж, ном бясалгадаг байв.

Дилава хутагт 1990 онд Улиастайд гарсан Монгол цэргийн бослогыг нүдээр үзсэн бөгөөд Ховдод очиж хэд хэдэн газарт ном айлдсан байна. Энэ үеэс л хутагт Түгээмэл Амаржуулах хийд

хийгээд том сүм хурал номын газарт залран олон мөргөлчидтэй учран тэдний итгэл хүндэтгэлийг хүлээн нэр цуу нь түгж эхэлсэн.

Улиастайн ноёдуудад хэд хэдэн удаа бараалхан, хөрш зэргэлдээ хошуу, Жалханз хутагт, Наран хутагттай уулзан тэдний нутгаар олон сараар морилсон байна. 1910 онд Наробанчэн гэгээнд зориулсан Бат Оршил (түвдээр даншиг) хэмээх наадмыг Дилав хутагт биеэр зохион байгуулан удирдсан бөгөөд олон газрын өндөр албан тушаалтан, лам хуварга, гэгээнтнүүд заларсан ёслол гойд сайхан болжээ. Засагт хан аймгийн Ялгуусан гэгээн, Сайн ноён хан аймгийн Хамба номун хутагтуудтай уулзан шашин номын зузаан холбоог Дилав хутагт тогтоосон байна. Тэрбээр сайн ноён хан аймгийн Баатар бэйс, Далайчойнхор, эрдэнэ ван нартай ойр дотно харилцаатай байв.

1912 онд Богд хаанд Дилав хутагт Жамсранжав ирж мөргөсөн бөгөөд Богд түүнийг цорж ямбаар шагнажээ. (26;85)

1917 оны өвөл Хятад улсын Лю-Чэнхуй тэргүүтэй хагас мянга илүү дээрэмчин хулгайчид Халхын өмнө захын хошуудын ард түмнийг дээрэлхэн түйвээж эхэлжээ. Энэ үйл явдлыг зогсоолгохоор Богд хаан зарлиг гарган Магсаржаваар удирдуулсан түшмэдүүдийг цэргийн хамт явуулсан байна. Тэр бүрэлдэхүүнд Дилав хутагт Жамсранжав цэрэг хамгаалах номын ламаар болон хэд хэдэн үүрэг хүлээн оролцож, Мэргэн вангийн хошууны Мэнд хайрхан хэмээх өргөн уудам газар нутагт (эдүгээгийн Дорноговь аймгийн Сулинхээр, Хатанбулаг, Хөвсгөл сум) дөрвөн сар орчим ажиллажээ. Энэ хугацаанд хутагт нутгийн ард иргэдийн оюун санааг эзэмдэн, хил хязгаарын газар орныг судалж, даалгасан ажлуудыг чадмаг гүйцэтгэсэнд Богдоос хүрэн хамба ямба, номч мэргэн цол, хүрэн жолоо, ногоон тэрэг, шар торгон гангиу шагнал хүртсэн (27;135) байна.

Хутагтыг Наробанчэн хийддээ 1918 оны намар эргэн ирэхэд нь шавь нар, мөргөлчид нь ёс төртэй угтсан. Дилав хутагт Жамсранжавыг 1919 онд Богд хааны зарлигаар Хатанбаатарын орлогч жанжнаар томилон хэсэг хугацаанд ажиллуулжээ.

Улс орны байдал нэн хүндэрсэн 1919 оны сүүлчид Богд хаан Жалханз хутагт Дамдинбазар тэргүүтэй төлөөлөгчдийг бүрэлдэхүүнд Дилав хутагт орсон учир нийслэл хүрээнд тэр иржээ.

Төлөөлөгчдийн зорилго нь Хятадын болон гадаад орны албаны хүмүүстэй уулзаж, Монголын бие даасан эрхийн асуудлыг ярилцах явдал байв. Тэд Бээжинд очоод Хятад хүмүүсээс гадна Жалханз нутагт Америкийн элчинтэй, Дилав хутагт АНУ-ын цэргийн атташетэй тус тус уулзсан байна. Тэднийг нутагтаа эргэн ирсэний дараа Жамсранжав хутагтыг Баруун хязгаарын сайдаар томилон Улиастайд суулгажээ. Наробанчэн хийдийг сэлбэн засахад хандив болгон Богд хаан 50 лангийн хоёр ембүү (28) олгосон байдаг. 1921 онд хутагтыг Улиастайн сайдаар ажиллуулжээ.

Ардын засгийн үйл ажиллагааг Башлуугийн Жамсранжав хутагт талархан дэмжиж харилцан туслалцах хоршооны гишүүнээр элсчээ. Дилав хутагт 1923 онд албан тушаалаа хүлээлгэн өгөөд буян үйлдэн аялах, ном судар айлтгах, бясалгах ажлыг өргөн хүрээтэй хийхийн хамт сүм хийд, шавь аж ахуйн ажилд биечлэн оролцсоор байжээ.

1929-1930 онд Дилав хутагт хөрөнгөө хураалгасан байна (29:138). Дилав хутагт Жамсранжав Ванчин богдод бараалхахаар одох ажлаа хөөцөлдөж хүрээнд ирээд удалгүй учир битүүлгээр мөрдөгдөн, шоронд сууж тэнсэн ялаар шийтгүүлжээ.

1920-иод оны сүүлч гучаад оны эхээр олон тооны ард иргэд нутаг орноо орхин урд хөрш рүү дүрвэн гарсан билээ. Ийм нөхцөлд Ванчин богдын үзэл бодол, үйл ажиллагаанд нэвтрэх, дүрвэн гарагчдын байдлыг судлан тодруулах үүднээс 1931 оны II сард дотоодыг хамгаалах газар Дилав хутагт Жамсранжавыг тусгай үүрэг гүйцэтгэгчээр гадаад руу явуулжээ. Хутагт дотнын хүн Гэндэн лам Намжил, Халзан, Бүдүүн нарын хамт тэмээн хөсгөөр хуучин мэдэх Мэнд хайрханы орчмоор нутгийн хилээ алхсан байна. Жамсранжав хутагт Өвөр Монголын нэр хүнд бүхий ноён Дэмчигдонров, Тайваны ерөнхийлөгч, Чан Кай-ши, Далай ламын зөвлөх, номын багш зэргээр хамтран 1949 он хүртэл ажиллаж байгаад Америкийн эрдэмтэн доктор, профессор Оуэн Латтиморын туслалцаатайгаар АНУ-д шилжин суурьшжээ. Тэрбээр Америкт 1952 оноос цагаач халимагуудтай хамтран Буддын шашны сүм байгуулж тэргүүн хамбаар нь өргөмжлөгдсөн байна.

Дилав хутагт Жамсранжав нь 1964 оны IV сарын найманд Америкт 82 насандаа таалал төгссөн юм. Саахь хутагт гүн ухааны

бясалгалыг олсон, шашны болон иргэний өргөн боловсрол мэдлэгтэй, захирамжлах, засаглах ухаан, төр захиргааны арга барил эзэмшсэн, нигүүлсэн сэтгэлтэй лам байжээ.

Халхын нутагт хамгийн сүүлд тодорсон Дилав хутагт эх орондоо хилс хэргээр шүүгдэж, гадаадад цагаачилж, эцэст нь харийн газраас бурханы “өргөө рүүгээ” одсон байна.

Сайн ноёны аймгийн тамгатай хутагтууд дотроос Наробанчэн хутагтын шавь нь газар нутаг, мал хөрөнгөөр багавтарт орно. Уул шавийг 1925 онд Отгон хайрхан уулын хошуунд нийлүүлсэн бөгөөд 1931 оноос Завхан аймагт харъяалагджээ. Ингээд хутагтын хүрээ, шавь, хөрөнгө нь тарамдаж яван явсаар үгүй болсоор.

ДӨРӨВДҮГЭЭР. “Монголын сүм хийдийн түүхэн товчоон” номноос авсан ишлэл.

НАРО БАНЧЭН ХУТАГТ

Энэтхэгийг 84 шидтэний нэг Банчин Наровын хувилгаан дүрүүдийг Түвд, Монголд удаа дараалан залж байсан түүхтэй. Монголд хувилсан анхдугаар дүр Наро Банчэн хутагт Бадамдорж /1699-1737/

II дүр Наваанчойранданзанжамц /1738-1817/

III дүр Түгжжав /1818-1860/

IV дүр Бирваа /1861-1883/

V дүр Пүрэвжав /1884-1903/

VI дүр Жүгдэрнамжил /1904-?/

Наро Банчэн хутагтын V дүр Пүрэвжавын үед нутаг ойроос төрсөн Дилова хутагт Жамсранжавыг Наро Банчэнгийн хүрээнд мандал өргөж ширээнд залж байжээ. Энэ хоёр хутагт нь Наро Банчэнгийн V, Дилова хутагтын V дүр тус тус бөгөөд нас ойр эрдэм номд хамт суралцаж нууц тарнийн ид шидийг үзүүлдэг байсныг шавь нар нь дурсан ярьдаг байв. Наро Банчэн хутагтын VI дүр хувилгаан Жүгдэрнамжилыг бага наснаас нь ном эрдэмд тэтгэсэн багш нь Дилова хутагт Жамсранжав байжээ.

ТАВДУГААР. “Үндэсний Архивын газраас авсан материалаас ишлэв

1. Наро Банчэн хутагтыг Бээжинд оруулахад тогтоосон дэвсгэр тэргийг тушаалын ёсоор хэрэгжүүлж байв. 1861 онд жанч халжээ.

13-р төрлийн Бирваа нь 1862 онд Засагт хан аймгийн улсын түшээ гүн Мипимсамбуугийн хошууны залан Чогсомын гэрт хувилгаан мэндэлжээ. Түүнийг тодруулахдаа сурвалжлан олсон 2 хөвгүүдийн нэрийг шавгад бичиж, Найралт найрамдах ордонд тахигласан алтан бумбад оруулж бламын тамга барьсан тэргүүн блам Донхор хутагт нарт тушааж 3 өдөр ном уншиж, шавга татаж 1865 оны хаврын тэргүүн сард Бирвааг Наро Банчэн хутагтын хувилгаан болгожээ. 1883 онд жанч халжээ.

14-р төрлийн Пүрэвжав нь 1884 онд харьяат шавийн ард Доржийн гэрт хувилгаан мэндэлжээ. 1892 онд уул шавь нарт нийлүүлэн суулгасан бөгөөд 1901 онд хувилгааны үсгийг хасуулжээ. 1903 онд жанч халжээ.

15-р төрлийн Жүгдэрнамжил нь 1904 онд харьяат шавийн ард Лувсанцэрэнгийн гэрт хувилгаан мэндэлжээ. 1910 онд уул шавь нарт нийлүүлэн суулгажээ. 1918 онд Монгол улсын санд мөнгө өргөсөн учир хамбын ямба шагнан хүртээсэн бөгөөд мөн онд Дотоодын яамнаас хишиг тархаах зарлигаас хоцрогдсон учирыг айлтгаад цоржийн ямба шагнан хүртээжээ. Дашрамд тэмдэглэхэд Наро Банчэн хутагтын 10-15-р төрлийг Халхад тодорсноос эхлэн тоолж 1-6-р дүр хэмээн “Зарлигаар тогтоосон Монгол улсын шастирын хураангуй”-д бичсэн байна.

2. Наробанчэн хутагтын шавийн үүсэл. Халхад Наро Банчэн хутагтын дүр тодорсон тухайд дараах мэдээ анхаарал татна. Түшээт хан аймгийн хожмын Сайн ноён аймгийн гүн Гончигийн хошууны тайж Гүржавын хүү Бадамдорж нялх цагт ном унших, зан нь бусдаас өөр тул хувилгаан буйзаа хэмээн Далай блам, Банчин Эрдэнэ, лам Чойжунд айлтгасанд, Энэтхэг Төвдөд 9 удаа хувилж явсан хэмээгээд Халхын Наро Банчэн хутагт хэмээн нэрийджээ. 1725 оны зуны сүүл сарын 27-нд Дотоод сайд бөгөөд хошууг захирагч сайдаас Халхын Наро Банчэн хутагт-д бичиг илгээж Манж Чингийн хааны зарлигаар өвлийн тэргүүн сарын 15-наар Бээжинд

ирэхийг мэдэгджээ. Уг уулзалтын үеэр дээр дурдсанчлан Наро Банчэн хутагт цолыг дахин олгосон ажээ.

Наро Банчэн хутагтын шавь нар цөөн тоотой байсан ч улам олширсоор дараах дүрийн Наваанчойрогданзанжамцад Чингийн хаанаас Наро Банчэн хутагтын шавь нарыг захирах тамга олгожээ. Харин яагаад Наро Банчэн хутагт Бадамдоржид бус Наро Банчэн хутагт Наваанчойрогданзанжамцадад тамга олгосон талаар тодруулья.

1748 онд Ордос бэйс Намжилсэрэнгийн хошууны Эрх цоржид өгвөөс зохих Сундуй нарын 10 хүнийг өгч дансанд тэмдэглэн тамга дарсан бичиг өгчээ. 1754 онд Эрх цоржийн мэдүүлснийг үндэслэвэл, тэрбээр 1710 онд харьяат засагт айлтгаж Ганжуур номыг залаад сүм барьж, Наро Банчэн хутагтаар расан (дацан) засуулаад эзэнд айлтгасанд 20 дуутай шагнуулжээ. Тэр үед 3 цагийн бурхан ба 8 бодьсад сайн цагийн мянган бурхны бие бүтээсэн бөгөөд Найралт төвийн үед 25 жин торго ба Аюушийн сүм, Ямандагийн сүм, 4 махранзийн сүм бариад Данжуур залаад Данжуурт сүм барьжээ. Тэр үед Хонсимбодьсадын биеийг Дара эхийн бие мянга мянга бүтээв. Бодь суварга гурав гурван алд 108-ыг барив. Тэнгэрийн тэтгэсний үед Хонсимбодьсадын сүм, Дара эхийн сүм ба Намчин суварга 108 -ыг барив. Бас Майдарын биеийг 16 тохой бүтээж 25 жан сүм, 81 жин торго ба Оточийн сүм, Ганжуурын сүм, Ганжуурын сүм, 8 суварга ес есөн алд барив. Бас цагийн хүрднийг бэлгэ билгийн суварга 2, гурван бодьсадын суварга 2, хуврагыг зохилдуулагч суварга 108 барив. Нийт 11 сүмд тахиж байх бүх биеийн шүтээн бурхан түм илүү, зарлигийн шүтээн Данжуур нэг, Ганжуур хоёр, Хувраг хурах дуган гурав, их бага суварга 300 илүү болсон байна. Иймд Банчин эрдэнэ шүтээн өгч зарлиг болгосонд жил сар хуврагт барих манз зэдийн дээжийг хураасаар 300 хонь, 100 бодтой болжээ.

Наро Банчэн хутагт очиж дацан засаад 200 хонь, 50 бод жасаа байгуулсны дараа чуулганы тэргүүн да ноён, 50 адуу, 50 үхэр, дээд Дагпу шаврунгийн гэгээн маань бүтээж Гү шүг дацан засаад 30 адуу, 100 хонь жасаа талбив. Мөн Жанжаа гэгээн маань бүтээж Гү шүг дацан Яманчи шүтээн хайрлаад 60 адуу жасаанд талбижээ. Эдгээр бурхан шүтээн бөгөөд жас жив, харьяат шавь нар бүгдийг Эрх цоржоос Наро Банчэны хувилгаан тойн цорж Бадамдоржтанд тэтгэмжлэхүйг даалган өгсөн байна. Иймд ноёноос “шавь нар бүгд

албагүй, гагц Зуугийн харьяат хэргээн дагаж явтугай” хэмээн бичиг олгож байжээ. Тийнхүү Наро Банчэн хутагтын Ордос дахь шавь бий болжээ.

1758-1767 оны бичигт дурдсанаар Ордос бэйсээс сүмийн шавь нарыг цэсд бичихгүй хэмээн тогтоож байсанд Наро Банчэн хутагт-аас “манай харьяат шар хар шавь нар цөмийг тойн цоржийн бламын байгуулсан сүм хийдийн жас жив болон шавь нартай оролцсон байна” хэмээн гомдол мэдүүлсэн байна. Тэдгээр шавь нарыг язгуур

аймаг болгож анги зохиож тогтоосон байсан бөгөөд Наробанчэнд мэдүүлсэнд «язгуурын хэвээр нийцүүлэн хэрэг чирэгдэл гаргалгүй явахыг хичээн саная» хэмээжээ. Иймд «язгуурын тогтоосон анги зохиосныг эвдэлгүй хэв хэзээ санаа солихгүйгээр нийцүүлэн, хийд сүмийн аливаа хэрэгт шамдан хичээж, хэрэг чирэгдэл гаргалгүй эе найртайгаар явахыг мэдтүгэй» хэмээгээд тамга дарсан батлах бичиг олгожээ.

Наро Банчэн хутагт Бадамдоржийн бие өнгөрсний хойно шавь нар нь тайж агсан Гүржавын хөвгүүн Пандай нарын хамт гүн Гончигийн хошуунд байжээ. Хутагтын дараах дүр Ордост хувилж, Богд эзний амгаланг эрж явсныг мэдсэн боловч хаа ч гэсэн Богд эзний албат шавь байна хэмээн үзэж шавь нар нь цөөн тул хувилгаанаа нутагтаа залж чадаагүй байв. Гэвч 1765 онд Наро Банчэн хутагт “Миний урьд төрөл танай хошууны асан тул, бурхан ном шавь нар тэргүүтэн минь таны газар байдаг. Тэндэх ах минь над лугаа атаа барин өшлөхүйд хүрснээр би Ордосын газраа суушгүй болов. Миний мэт тойн хувраг хүнд аль ч орон болов цөм Богд эзний албат тул хаа суувч ном гэхээс өөр явдал үгүйгээр уг өглөгийн эзэн минь хэбэй жүн ван болон таны биес тул намайг шавь нар тэргүүлэнд минь нийлүүлэн энд суулгаж болму» хэмээжээ. Иймд «тойн хувраг улс хаа ч болов шашин номын үйл гэхээс бус учир байх биш. Бас

энэ хутагт хуучин шүтээн шавь нартаан нийлж сууя гэх нь болох мэт» тул Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, Цэцэрлэгийн чуулганы дарга, засгийн хошой чин ван Цэнгүнжаваас хэрхэн шийтгэхийг айлтган ГМТЗЯЯ-наа бичиг өргөжээ. Наро Банчэн хутагт болон түүний ах Бадамдорж, гүн Гончиг нар зөвшөөрсөн тул Наро Банчэн хутагтыг гүн Гончигийн хошуунд суулгаж, түүний хуучин шавь нарт нийлүүлэхийг зарлигаар зөвшөөрсөн байна.

Ийнхүү 1738-1767 онд Наро Банчэн хутагт Ордост, Халх дахь шавь нар нь хошуундаа байсан бол 1767 оноос Наро Банчэн хутагт Халх дахь хуучин шавьдаа нийлэн суужээ. 1772 онд гүн Гончиг “Манай хошууны Наро Банчэн хутагт хэмээгч урьд үе миний өвөг эцэг гүн агсан Норовжавын дүү тайж Гүржавт хувилсан тул Богд эзний амгаланг эрж бэлэг барив. Хойно Наробанчэн өнгөрч Ордосын бэйс агсан Лхаваанбалданцэрэнгийн хошууны тайж Дашдондовт хувилж түүний газраас айлтгасанд Богд эзэн хишиг хүртээж Наробанчэн цол шагнав. Хойно хутагтын урьд үеийн шавь нарын нийлүүлэн суулгах ажаамуу хэмээн өргөж мэдүүлсэний хувьд Их журганаас айлтгаж эдүгээ миний хошуунд суулгажээ... хутагт расан (дацан) байгуулж Богд эзний түмэн өлзийн тул гүрэм хийж чин үнэн сүсгээр ном уншмуй. Бас ч аливаа албанд оруулахын тулд гуйх нь Их Журган (ГМТЗЯЯ)-аа уламжлан айлтгаж Наробанчэн хутагтын шавь нарыг захирах тамга олгуулах ажаамуу» хэмээснийг аймаг бүхийгээр хэлэлцээд (ГМТЗЯЯ)-д өргөжээ. 1772 оны өвлийн тэргүүн сард ГМТЗЯЯ-наас Манж чин улсын хаанд “Халхын Наро Банчэн хутагтын шавь нар 100 илүү бөгөөд хар хүн 100 илүү өрх буй. Харьяат засаг гүн Гончиг захирахуйд бэрх, Наро Банчэн хутагт-д тамга шагнаж шавь нарыг хураамжлан захиргах ажаамуу” хэмээн айлтгасанд зөвшөөрчээ.

Уг хэргийг шийдэхдээ 1737 онд Жанжин агсан эфү Цэрэн “Эрдэнэ бандида хутагт, Зая бандида хутагтын шавь нар олон, хураамжлан захирахуйд бэрх, тамга нэг олгуулах ажаамуу” хэмээснийг хэлэлцэж айлтгаад “Эрдэнэ бандида хутагтын шавь нарыг бүгд захирах тамга” хэмээн манж, монгол тангууд гурван зүйлийн үсэг хавсарч бичээд ёслолын явдлын яаманд тушаал өгч цутгаад олгуулсан тэмдэглэл ба 1751 онд жанжин Цэнгүнжавын газраас “блам эрдэнэ ноён цорж Лувсанноровын шавь нар 100 илүү бөгөөд хар хүн 100 илүү өрх буй. Харьяат засаг Лувсандондов нэхэж захирахуйд бэрх. Эрдэнэ ноён цорж Лувсанноровт тамга шагнаж шавь нарыг хураамжлан захиргах ажаамуу” хэмээн хүргэж ирснийг хэлэлцэж айлтгаад тамга олгуулсан тухай дансны тэмдэглэлийг үндэслэжээ. Наробанчэн хутагтад Эрдэнэ ноён цорж Лувсанноровын ёсоор «Халхын Наробанчэн хутагтын шавь нарыг бүгд захиргах тамга» хэмээн манж Монгол тангууд гурван зүйлийн үсэг хавсарч бичиж цутган олгохоор болжээ.

1773 оны 2 сард Наро Банчэн хутагтын шавийн лам Ванжил,

Цорж нар ГМТЗЯЯ-аас тамга залж гараад нутагтаа хүрчээ. Энэ тухай 3-12 ны хариу бичигт “өчүүхэн лам Наваанданзанжамц эхний шагнасан тамгыг сөгдөж хичээнгүйлэн хүлээж авсан цагт даруй тэнгэрийн хишигт мөргөн мэхийн санахул өчүүхэн лам үе улиран Богд эзний хишгийг хүртсэн нь маш хүнд, гагц лам болсон хүн эзэндээ өчүүхэн ч хүчин өгч чадсангүй. Эдүгээ хэтэрхий хишиг хүртээж өчүүхэн бламд халхын Наро Банчэн хутагт-н шавь нарыг бүгд захирах тамгыг цутгаад шагнаж өгсөнийг өчүүхэн блам гагцхүү өдөр шөнөгүй аюуш номыг уншиж Богд эзний түмэн өлзий үүрд урт болохыг чин үнэнхүйгээр залбирч хичээсүгэй. Гуйх нь миний тэнгэрийн хишиг мөргөсөн явдлыг уламжлан айлтгах ажаамуу над өгсөнийг өчүүхэн лам гагцхүү өдөр шөнөгүй аюуш номыг уншиж Богд эзний түмэн өлзий үүрд урт болохыг чин үнэнхүйгээр залбирч хичээсүгэй. Гуйх нь миний тэнгэрийн хишиг мөргөсөн явдлыг уламжлан айлтгах ажаамуу” хэмээсэн нугалбарт улаан бийрээр цохолсон зарлиг мэдэв хэмээснийг ГМТЗЯЯ болон халхын Наро Банчэн хутагтад тушаан явуулжээ.

Шавийн захиргаатай холбогдон нутгийг нь хэрхэн тогтоосон тухай баримт бидэнд олдсонгүй харин 1803 оны бичигт тэмдэглэснээр урьд зарлигаар залсан Баарины ван халхын баруун гурван аймгийн нутгийн зах хязгаарыг савлаж овоо байгуулсан бөгөөд аймгийн нутгийн хязгаарын газар язгуурын хуучин тайзнаас өөр болсон тул дахин байцааж аль аймгийн хэний хошуутай зах нийлэх, бас аймгийн олон засгийн хошууд, хутагт нарын Шанзудба нар өөрсдийн суудаг нутгийн зах сав хил тогтоосон газрын нэрийг тодорхойлон баталж хүргэн ирүүлээд хуучин данстай нийлүүлж батлан тогтоохыг тушаажээ. Иймд 1772 оноос Наро Банчэн хутагтын шавийн нутаг, 1781 онд Наро Банчэн хутагтын шавийн нутгийн захыг тогтоосон гэж үзүүштэй юмаа.

1804 оны 7 сард цэцэрлэгийн чуулганы даргаас Наро Банчэн хутагтын шанзуд ба Наваандампил тушаан илгээсэн бичигт “Эдүгээ таны шавьд нэмж олгосон нутгийн сав баруун урд зах Дэлгэрбулаг, Номгон, Бэрх, Туулайт, Шилүүтийн гэзэг, Дөрөлж, балхудайн гол уруудсаар амны тус Завхан голын тэртээ ямаат Шинир, уушиг цонжийн зэргээр сав тогтоож тушаасныг мэдтүгэй” хэмээсэн Наро Банчэн хутагтын шавийн нутаг тэлж байсныг илтгэнэ. 1805

он 3 сард Цэцэрлэгийн чуулганы даргаас “ГМТЗЯЯ-аас тушаан хүрч ирсэн бичигт, байцааваас Халхын 4 аймгийн 84 хошууны нутаглах газрын зах, олон хошууны 4 этгээд 8 зүгт хүрэх газрын зурсан зургийг 1 хувь үйлдэж Журган(ГМТЗЯЯ)-д хүргүүлэн ирүүлж үйлдэхүйд тэмдэг болгоё хэмээн тушаасныг дагаж тус аймгаар чуулган нийлж томилон үлдээд явуулах тулд энэ жил 4 сарын шинийн 10-нд Энхийн давааны ар Ёлын булангийн газраа чуулган нийлээд шийтгэе. Үүнд Шанзудба чиний бие тамгаа аваад тус нутгийн зах хязгаарын зургийг аван нэг сайн зурагч хүн чадалтай сайн зайсангуудын хамтаар ирэх буцахын гадна 50 хоногийн хүнс хэрэглэлтэй мөнхүү өдөр газрын болзоонд хүрч иртүгэй» хэмээсэн шавийн нутгийн тухай чухал мэдээ байдаг юм.

1805 оны 5 сард Наро Банчэн хутагтын шанзудба Лувсанчүлтэмээс Цэцэрлэгийн чуулганы дарга нарт мэдүүлэхдээ “Урьд 1781 онд Зарлигаар зарсан Баарины ван, баруун 3 аймгийн нутгийн зах хязгаарыг тогтоож овоо байгуулахуйд Сайн ноён аймгийн гүний зэрэг засаг Сандзувдоржийн хошууны ард нутагламуй. Баруун өмнөд этгээдэд Засагт хан Цэвээнпалжайгийн хошууны ард нутагламуй хэмээн бичиж овоо байгуулжээ. Эдүгээ манай шавийн нутаг мөн Бор цонжоос Завхан голын эрэг барьсаар баруун өмнө зах Дэлгэр булан хүртэл голоор, мөн ханын хошуутай сав нийлмүй. Баруун бие Номгоны гэр, Баруун хойд зах Бэрхийн хяр, ойд зах Туулайтыг хярласаар мөн зүүн хойд зах Шүлэгтийн гэзэг дөрөлж, Балгастайн гол уруудсаар Амны тус Завхан голын тэртээ Бага Ямаатыг арлуулж, Шинирээр гүн Сономбалжурдоржийн хошуутай савлан суухыг мэдүүлж, үүний тул өргөв” хэмээжээ. Мөн савын 4 овоо байгуулахдаа нутгийн баруун зах Номгон уулын оройд нэг мод байгуулаад овооны зүүн этгээдэд шавь нар, баруун этгээдэд гүн Балжирын хошууны ард нутаглаж байв. Хойд этгээд туулайт уулын оройд нэг мод байгуулаад, өмнө этгээдэд шавь нар, хойд этгээдэд Балжирын хошуу нутаглаж байв. Зүүн этгээдэд уушгийн ууланд нэг овоо байгуулаад баруун этгээдэд нь шавь нар, зүүн этгээдэд нь гүн Цэвээнжавын хошуу нутаглаж байв. Өмнө этгээд Цонжийн толгойнд нэг овоо байгуулаад өмнө этгээдэд нь Засагт ханы хошуу, хойд этгээдэд нь шавийн ард нутаглаж байжээ. 1854 онд Наро Банчэн хутагтын шавь болон гүн Гүрсэдийн хошуу хооронд нутаг булаалдан тэмцсэн боловч нутгийн зургийг үзэж хошуу шавь нарыг тайж ард нарыг цуугин тэмцэлгүй нутаглуулахаар тохирон тогтоож байв.

Наро Банчэн хутагтын шавийн нутаг нь 1913 оны үед зүүнээс баруун хүртэл бүгд 120 газар(69 км орчим), өмнөөс хойд хүртэл бүгд 30 газар(17 км орчим) байжээ.

3. Наробанчэн хутагтын шавийн захиргаа. 1772 онд Наро Банчэн хутагтын шавийн захиргаа байгуулагдснаар аймаг, хошуудтай харилцах, хутагтад шавь өргөх болон харьяат сүм хийдь шавь нарыг захирах зэрэг болон бусад хэргийг шийдвэрлэх болжээ. 1776 онд Наро Банчэн хутагт Ховдын харьяат “Түгээмэл амаржуулагч сүм”-д суусан тухайд тодруулъя. Тухайн онд Жалханз хутагтаас бичиг өргөж 1766 оноос 10 жил илүү болов. Би өвчинд боогдож хурал хурж ном уншихуйд гүйцэтгэн чадахгүй. Би хоосон нэр хүлээж эзний сүмд суухуйд хэцүү тул намайг сүмээс тусгай байлгаж өвчинг засуулваас болох ажааму хэмээв. Иймд Ховдын амбанаас «Сайн ноён гүн Гончигийн хошуунд буй Нарбанчэн хэмээх хутагтын нутаг Ховдод ойр. Энэ хутагт нутагт хэрэггүй тул Жалханзын гуйсан ёсоор түүнд чөлөө олгож нутагт илгээж өвчин засуулж, илаарь болохын инагш дүр Наробанчэн хутагтыг энэ сүмд олон блам нарыг хураамжлан захирч ном уншуулан явуулж Жалханз хутагтын өвчин сайн болсон хойно хайш хэргээр энэ хоёр хутагтыг ээлжлэн сүмд явуулваас хэрэгт нэн тустай мэт» хэмээн айлтгасанд зарлиг буулгажээ. Иймд 1776-1791 онд Наро Банчэн хутагтын шавийн хэргийг шанзудба голлон эрхэлж байсан бөгөөд бусад хутагтуудын шавийн захиргаатай харьцуулан үзүүштэй юм.

Наро Банчэн хутагтын шавийн захиргааны хуулга данс дахь зарим хэргийн талаарх баримтыг дурдвал, 1772 онд Ордосын засаг бэйс Дамбадаржаагаас Наро Банчэн хутагт-д илгээсэн бичигт дурдсанаар 1757 онд хошууны занги Равжан сумны тайж Рашдондогоос 4 өрх хүнийг 2-р хүү Наро Банчэн хутагт-д өмч өгснийг дансанд тэмдэглэсэн тул 4 хүнийг бие хөвгүүн нартай нь Наро Банчэн хутагтын харьяат болгов. 1806 онд Ордосын засгийн хошууны бэйс Юндэндоржоос цорж Рагва нарыг Наро Банчэн хутагтын эцгийн өгсөн шавь нартай нэг адил үүрд алба улаагүй, гагцхүү “Шашны ерөөлт сүм”-ийг тахиж шажин хурлыг хичээнгүйлэн явуулахын тул батлах тамгат бичиг өгч байсныг хуулга дансанд тэмдэглэснээс үзэхэд Ордост Наро Банчэн хутагтын цөөн шавь нар байсан ажээ. Гэвч Ордос дахь шавь нарын хэргийг нутагт нь шийдвэрлэж байсан бололтой.

1773 онд гүн Гончигоос Наро Банчэн хутагтын урьд төрлийн ач дүү нар нь хуврага тул Наро Банчэн хутагтыг дагуулж Наро Банчэн хутагтыг тамганд харьяат болгосныг 1774 онд ГМТЗЯЯ-аас зөвшөөрсөн бөгөөд 1777 онд цорж Дорж, Найлан нараас хошуундаа буцах санал гаргаж байв. 1793 оны 5 сард Лувсанримпилээс Цэцэрлэгийн чуулганы даргаар уламжлуулан ГМТЗЯЯ-наа Наро Банчэн хутагтын уг эхийг өргөж байв. 1811 онд Наро Банчэн хутагтын шавь Наваандэчингээс Цэцэрлэгийн чуулганы даргад 1793 онд алтан бумба байгуулсан хойно гарсан шавь Эрх цорж ламын хувилгаан Дамчойяринпил 1809 онд Дээдийн 50 сүүдрийн их баярт одож дээдийн амгаланг эрж жасаалан хурал хуримд орж хишиг хүртсэн тул хэрхэхийг мэдүүлэн бичиг өргөжээ.

1867 онд Засагт хан аймгийн засгийн улсын түшээ гүнгээс “хуучин удааг журамлан хуулийг дагаж харьяат хамжилганы албатын өсвөр тул эр Мижид, Ёндон 2 ам хүнийг дуртайяа гаргаж бишрэхүйгээр” шавь болгон өргөж тамга дарсан бичиг илгээсэн бол 1868 онд засгийн улсад туслагч гүн Равдандоржоос шанзудба Гэлэг-Очирт илгээсэн бичигт “ манай урьд үеийн эцэг өвгөдөөс эдүгээ хүртэл Наро Банчэн хутагт танаа авралд шүтэж мөнч элдэв эвийн найрамдалтай явсан зэрэг учир гүн Равдандорж би өөрийн сүжгээр харьяат хошуун лам Ням, дүү хөвгүүн Гомбожав нэг өрх 9 амыг Наро Банчэн хутагт танаа шавь болгон барьсан үүнийг мэдэгдэн явуулья” хэмээв. Мөн 1868 онд Засагт хан аймгийн засаг Санжайцэсүрүнгийн хошууны гүн Гончигжав хувийн хамжилганы Ганжуур нэгэн өрх 5 ам хүнийг шавь болгон өргөсөн зэрэг нь хуулга дансанд тэмдэглэгджээ.

Эрх цоржийн хожмын дүр болох Дилав гэгээн Б.Жамсранжавтай Наро Банчэн хутагт Пүрэвжав нь багш шавийн барилдлагатай байсан бөгөөд Дилав хутагт Б.Жамсранжавын бичсэнээр аймгаас томилогдсон шавийн шанзудба нь шашны өндөр албан тушаалтныг захирах, лам нарыг иргэний хэрэгт ороцолдоход нь сахилгын шийтгэл хүлээлгэх ба хийдийн санхүүгийн байдлыг хянах эрх мэдэлтэй байв. Хар шавь нарын хувьд малын алба, улааны албатай бөгөөд 16 өрх бүрээс бүрдсэн 12 жижиг хэсэг нь тус бүрдээ даргатай байжээ. Шавь нарын өглөг барьц нь Наро Банчэн хутагтын болон Дилав гэгээний санд ордог тул тэндээс ядуу зүдүү шавь нарт мал хөрөнгө өгч тусалдаг. Тийнхүү сүмийн хөрөнгө, Наро Банчэн хутагт

болон Дилав гэгээний сан хөрөнгө, шавь нарын мал, эд хөрөнгө нь бие биесээ нөхөж байжээ. Тэдгээр санг 5 түшмэл бүхий хорооноос томилогдсон лам эрхэлж байв. Лам нар хийдийн гол барилгуудын хоёр талаар гудамжлан байрласан 15 эгнээ сууцанд амьдардаг байсан байна.

4. Наробанчэн хутагтын сүм хийд. Наро Банчэн хутагт нь 1776 онд Ховдын хэбэй амбаны газраас айлтгаснаар зарлигаар «Түгээмэл амаржуулагч сүм»-д 15 жил ном уншиж суугаад 1791 онд халагдаж гараад Сайн ноён аймгийн нутаг Завхан голын Тахилт хэмээх газраа «Богд эзний түмэн өлзий тул ном уншихыг хүсэж» нэгэн сүм барьж байгаа явдлыг мэдүүлж байв.

1802 он Наро Банчэн хутагтын бичигт дурдсанаар, Наро Банчэн хутагт Бадамдорж нь1720-иод оны үед Хархуна нэрт газарт олон бурхад бүхий нэгэн их агуйд мөргөхөөр очсон үед Ханги бэйсийн хошууны тайж Эрх цорж лам нар урьж сүм дацан засуулж ном уншуулжээ. 1725 онд Манж Чин улсын хаантай уулзахдаа «Хангин, Далад хоёр хошууны 2 дацанд 20-иод дуутай (тэмдэг бичиг) олгуулахыг гуйж олгуулжээ. Уг бичигт « Боол хутагт би Ордос Далад бэйсийн хошууны нутгийн баруун хойд этгээд Ханхтохой хэмээх газраа Богд эзний түмэн өлзий батдахын тулд 87 жан сүм барьж ном уншиж суугаад 1725 онд боол хутагт бараалхаж дээдийн амгалан олсон даруйд боолын барьсан сүмд Богд эзнээс хишиг хүртээж 20 дуутай шагнасан боловч сүмд нэр шагнасангүй бөлгөө. Эдүгээ боол хутагт надад хишиг хүртүүлэн энэ сүмд нэр олгохыг гуйхаас гадна басхүү боол хутагт би өөрийн нутаглан суух Завхан голын Чандмань хэмээх газар мөнхүү Богд эзний түмэн өлзий батдахын чин үнэнээр сүсэлж 120 жан сүм барьсан билээ. Олдвоос гуйх нь Их Журган (ГМТЗЯЯ)-ы газраас уламжлан боолд хишиг хүтээж мөнхүү энэ 2 сүмд нэр ба дуутай олгох ажаамуу хэмээн үүний тул гуйн сүсэлж өргөв.” хэмээснийг 1803 он намрын сүүл сарын 29-нөө айлтгасанд зарлигаар “Соёлыг бадруулагч сүм”, “Шашны ерөөлт сүм”-ийн нэр шагнажээ. Гэхдээ “Шашны ерөөлт сүм” нэрийг орон нутагт өмнө нь хэрэглэсээр байсан ажээ. 1758 онд “Шашны ерөөлт сүм”-ийн дуутай лам нарт зарлигтай эрхэм цэргийн албанаас бус албанд дарх олгосон Засгийн бэйс 2 зэрэг тэмдэглэсэн Намжилсэрэн бичиг олгож байв. Тухайн үед Эрх цоржоос мэдүүлэхдээ “өвгөн лам би 70 нас хүрэв. Шашин амьтны тусын тул сүм барьж шүтээн

бүртгэн номыг уншин тахиж суудаг бөлгөө. Үүнд сүжигтэн тайж нар ба өглөгийн эзэд сүм тахьтугай хэмээн гэрийн мэдэх боолыг дуртайяа өгсөн, худалдаж өгсөн, хулгайд холбогдоод хүнд ял оноож аллаганд тулгасан хүнийг амь зольж авсан, энэ зэргийн хүн олон тулд олдохул харьяат засгийн дансанд тэмдэглэж болох ажааму" хэмээснийг дагуу тэмдэглэсэн бөгөөд "шавь нар зарлигаар морь мал авах цэргийн тухайн эрхэм хэргээс бус бага сага учир жирчэм албанд явахыг байтугай. Зуу сүмийн үйл хэрэгт өөр өөрийн чадах чинээгээр зүтгэж явтугай" хэмээн тамга дарсан бичиг олгож байв.

"Соёлын бадруулагч сүм"-д дуутай хувраг 40 байсан бөгөөд "биеийг ариулан үнэн сайн явдлыг төгсгөвөөс зохимуй. Биеэн үл ариулан бурхныг үл тахин номыг үл уншин зоригоор банди болгон тэмдэг бичиг гүй зоригоор явагч лам банди нарыг агуулах хийгээд дарах ба эмсийг сүм хийдэд оруулах ба лам гэлэн гэцэл банди нар хүний гэрт одож хонох, ба бас үхсэн боссон ялын тул байлгасан лам бандийн тэмдэгт бичгийг өөр хүнд өгч лам банди болгохын зэрэг зүйлийн самуун явдлаар явбаас цаазны бичгийн ёсоор ялламуй." хэмээн "Соёлыг бадруулагч сүм"-ийн да лам гэлэн Ламжавд мэдэгдэж байв. Мөн 1803 онд хутагтаар жаяг зохиож чойрын хурал хуруулахаар завдсан боловч үүсгэсэнгүй байсаар Эрх цоржийн хувилгаан ламаас гүн Эрхэмжаргалан, шанзудба Гэлэг-Очир нарт хадаг барьж чойрын хурал хуруулахыг айлдсан тул 1866 оны зуны эхэн сараас эхэлж хурсан гэдэг. 1869 он цагаан сарын 15-нд 40 дуутайд явсан хуучин лам банди нараас орон гарсан эмгэглэсэн нас хөгширсөн зэргийг данснаас тайлж гараад шинэчлэн нөхөж бичсэн ажээ.

5. Наробанчэн хутагтын шавь нарын байдал. Наро Банчэн хутагтын шавийн албаны тухай мэдээ ховор юм. 1691 онд ГМТЗЯЯ-аас айлтгаад зарлигаар «Зая бандида хутагтын хар шавь нарыг сум зохиосонгүй шажны үйл хийж албагүй явтугай хэмээснийг дагаж Сайн ноён аймгийн хутагт нарын шавь нарыг албагүй явуулсаар байжээ. Харин 1808 оны бичигт "үүнээс хойш хутагт нарын шавийн отог дундуур улаа шүүс хэрэглэж өнгөрөн явах эрхэм тургэн албанд мөнхүү шавь нараас бэлтгүүлж явуулъя. Тэдний шавь нарын нутагт хамаагүй бус засаг хошууны нутгаар өнгөрөн явах албанд өртөө улаа гаргаж бэлтгэлцүүлэх явдлыг хуучин журмыг дагаж зогсоосугай» хэмээв.

1839 онд Цэцэрлэгийн чуулган нийтийн хэрэг шийтгэсэн гүн засаг туслагч түшмэдийн хэлэлцэн тогтсон хэргийн дотор аймгийн 24 засаг хошуудаас “нийгмээр үгээгүү болон аливаа чармайсан учир хутагт нарын шавийн нутаг тохиолдох суман өртөөг мөн шавь нараас гаргуулж аргацаагуулах ажааму” хэмээн хамт бичиг өргөжээ. Энэ тухайд Эрдэнэ бандида, Зая бандида хутагг нарын уул шавь нар бас ч ган зудад тохиолдон хурал номын зарлагад чармайж бүхий, язгуураас алба гаргуулсангүй, ГМТЗЯЯ-нм бичиг буй хэмээсэнд уг хэргийг хэлэлцэхгүй болсноо харьяат аймгийн олон засгууд, хутагт нарын шанзудба нарт мэдэгдэж байжээ.

1860 онд Манж Чингийн хаанд 9 цагаан өргөхөд Сайн ноён аймгаас барих бурхны үнэ зэргийг хуваан онуулахад Наро Банчэн хутагт-аас 4 лан, шанзудба Гэлэг-Очироос 3 лан гаргуулахаар заажээ.

Наро Банчэн хутагтын шавийн нэгэн чухал алба бол Наро Банчэн хутагтын шинэ дүрийн хувилгааныг сурвалжлан тодруулах, залахтай холбоотой гүйцэтгэх алба байв. Сайн ноён аймгийн ихээхэн хутагтын шинэ хувилгаан нь бусад аймаг шавийн газарт хувилгаан гарвал тухай бүрт аймгаас тусгайлан түшмэл зарж, бэлэг ёслол хүргүүлэн гүйцэтгүүлдэг байжээ. Ингэхдээ аймгаас хүргүүлэх бэлгийн 9 цагааны бие бүдүүн хүч тарган шүд залуу сайн цагаан морь 9-ийг харьяат хошуунаас сонгон гаргуулж, шанзудбагийн тамгын газраа хургүүлж харьяат шанзудбагийн хамт явж хувилгааны эцэг эх, жич харьяат засаг гүнд ёсолж залж аваачдаг байв. Жишээ нь, 1865 оид Наро Банчэн хутагтын шинэ хувилгааныг залж аймгаар даншог өргөхед харамжны эр эм шүдлэн хонь хийгээд наадмын элдэв хэрэгсэл зүйлийг цөм Эрдэнэ бандида хутагтын хувилгааныг ширээнд залсан даншогийн ёсоор гаргуулахаар боджээ. Мөн жасаас гаргуулах зэд манзны шар цай 2705-ыг урьд удаагаар онуулж хурдан морийг хүүхдийн хамт ойрын хошуу шавиас гаргуулахад танай шавиас гарах наадмын уралдах хүүхэдтэй их насны хурдан морь 40-ийг зарлан гаргуулж бэлтгүүлэхийг тушааж байв. 1895 оны үед Наро Банчэн хутагтын даншогт 500 хонь гаргах тооцоотой боловч түүнээс их хөрөнгө зардаг байв. 5 насны морь. азарга, жороо морь уралдах багөөд нас бүхний түрүү морь залуу атны шантай байв, Үзүүр түрүү бөхийн хэмээн аймаг бүрээс тэмээ ирдэг ба ёсыг бодож нутгийн бөхийг ямагт түрүүлүүлдэг байжээ.

1870 онд 5 сард Эрдэнэ бандида хутагтын хүрээнд дээрэмчид довтолсон тул хутагт нарын шавиас гаргаж тосон сэргийлж дайчлахад бэлтгэж идэр эрчүүдийн тоонд Наро Банчэн хутагтийн шавиас бүрэн зэвсэгтэй идэр эр 25-30, захирах зайсан түшмэл гаргахаар тушаажээ. Гзвч Сайн ноён хоёр аймгийн Ялгуулсан хутагт, Жалханз хутагт, Эрдэнэ бандида хутагт, Наробанчэн хутагт нарын шанзудбагийн газраас өөр өөрийн нутаг үндэс төвийг сэргийлүүлэхэд сум эр, хуяг өмсгөсөн цэрэг эр, зэр зэвсэг, боловсруулах эргүй бөгөөд суух бэрхтэй зэрэг учрыг мэдүүлжээ. Иймд тэдний шавь нарын эрсийг гадагш мордуулахыг зогсоож тушаасан тул тус тусын нутгийн чухал үндэс газруудыг орой тушаасан ёсоор бэхлэн сэргийлүүлье хэмээн тогтоосон байна. Мөн 1871 онд 5 хутагтын шанзудба нараас өргөсөн бичигт “5 хутагтын доторх ахмад Эрдэнэ бандида, Зая бандида хутагт нар Эеэр засагчийн онд Халхад хувилгаан гарснаас удаа дараа Чин сүсэгт номун хан, Наробанчэн. Эрдэнэ мэргэн ноён хутагт нар хувилгаан дүрийг удирдан тухай дахь шавь нар дагалдуулан авч тус бүрийн сум хүрээнд бурхан Зонховын ёсыг барьж Богд эзний түмэн өлзий батдах номыг уншин бүгд амьтны тусыг зохион суухуйд Энх-Амгалангийн 30-р (1691) онд Зарлигаар Эрдэнэ бандида, Зая бандида нарын хар шавь нарыг сум эс зохион их цэргийн хэрэг ба элдэв албан гаргуулсангүй ямагт харьяат хутагт нарын номын хэрэглэлд туслуулжээ. Нөгөө гурван хутагт нарт зарлиг адил буулгасангүй нь боловч ахмад хутагт нарын сайн журмаар хар шавь нарыг тус бүрийн хурал номын хэрэгт явуулсаар атал ойрх жилд муу хулгай олон удаа халдан ирж хэлмэгдүүлснээс Эрдэнэ бандида, Наро Банчэн хутагт нарын тус шавь нар цөм их төлөв хийд хүрээ орон хогшил хөрөнгө малыг алдаж бүгдээр ядууран сүмийн гэлэн банди нар тархаж шашин хурлыг тасалдуулан тэжээлийг эрж тэнэсээр буй. Зая бандида хутагтын шавь мар цөм уулаас сарлаг үхрийн шимд шүтэж аж төрөн бөгөөд их гамшиг тохиолдон бүхий үхрийг хохируулснаас уршиглаж маш ядууран 1000 илүү хүнийг аргацаан тэжээвч тэнхрэн амьдарсангүй. Ийнхүү ядуурсан манай 5 хутагтын шавь нарын байдал дүрс тодорхойлон олон удаа чуулганы дарга танаа мэдүүлвээс ер чингэж тэнхрэгтүн хэмээн заасан газарт дээр дотоод газраас олон анги давшсан их цэргийн өртөлгөнд нутаг тохиолдсон шавь нараас хавсрах улаа хэрэглэлийг тэгшлэн бэлтгүүлж манай бүгд шавиас цэргийн тухайд мал зүйлийг дайчлан

гаргуулсан нь дааанч их бөгөөд бид нар албаны сүрээс айж хүчин чинээ бартлаа дагаж явсаар буй.

Эдүгээ манай 5 шанзудбаг чуулганы газраа зарлан аваачиж да бэйл, бэйл Гэмпилдорж чуулган нийлсэн ноёд түшмэд нар манай нүүр чичиж тушаасан нь “харьяат аймаг нийгмээр ядуурсан тул таван хутагт шавь нараас ямар хичнээн өрх хавсаргын алба явдлыг мэдүүл” хэмээн шаардан тушаахуйд бид нар аймаг ...дотроо манай 5 хутагтын шавь маш хэлмэгдэн ядуурч харьяат аймгийн албанд хавсах чадал үнэхээр үгүй нь үзтэлээ илэрхий явдлыг учирлан гаргаж мэдүүлсэн боловч үл хэрэгсэн нэгэнтэйгүүр тушаасан бичигт хавсарга суман болвоос нутгийн харьяагаар гэх албан бөгөөд харьяат 5 хутагтын шавь нараас тус бүрийн нутагт дахь хавсарга суман өрхийн албыг гэвээс зохимуй хэмээн тоог тогтоож зайлсхийвээс хүндэд ял шийтгээр тушаасан тухайд хэрхэвч алба нэмэн хүлээх арга барагдсан явдлыг дахин мэдүүлсэн билээ. Боолчууд бодвоос аймаг ядуурав хэмээн алба түлхэх санаа сая агуулсан бус амар тайван бүхий цагт Төр гэрэлтийн 19-р(1839) онд ...хуучин хэвээр албагүй болгон тушаасан удаа буй бөгөөд мунхаглаваас манай 5 хутагт Сайн ноён аймагт нутагласан нь он маш удсан боловч нутаг тохиолдсон хавсарга суман албанд одоо хүртэл хамаарсан зүйлгүй аж. Эдүгээ хуучин хэвийг халж шилжүүлэн шийтгэхийг үзвээс зарлиг өршөөлд үүрд нийлэлцсэнгүй болов уу одоо ийм зэрэг их бага албанд тулгаваас манай хутагт шавь нар бурхан шашин үргэлжийг үл таслах арга мохсон” хэмээн мэдүүлж байснаас үзэхэд Наро Банчэн хутагтын шавь нь бусад шавийн хамт зарим албанд дайчлагдах тул байсан ажээ.

Дилав хутагт Б. Жамсранжавын үед Наро Банчэн хутагтын шавь нь 400 өрх, 1800 хүн амтай байсан бөгөөд шавийн харьяанд нэг ч ноёд, тайж угсаатай хүн байсангүй. Цөөн тооны хятад худалдаачид, гар урчууд байсан бөгөөд монголчууд мал маллаж цөөн өрх нь мал маллахын зэрэгцээ тариа ногоо тарьдаг байв. Мөн мужаан, элдүүрч, малын эмч, нядлагч, эх баригч зэрэг мэргэжлийн цөөн хүн байсны дээр чулуу, мод, төмөр зэрэг нарийн мэргэжил шаардах ажлыг хятад гар урчуудыг урьж хийлгэдэг байжээ. Мөн хүн амын 300 орчим нь лам байв.

1918 онд Наробанчэн хутагтыи шавь нь нийт 130 өрхийн 658 хүн амтай байсны 369 нь эрчүүд, хөвгүүд» 289 нь эмэгтэйчүүд, охид

байжээ. Эрчүүдийн 186 нь лам, 134 нь шавь, 49 нь чөлөөт хүмүүс байв. Наробанчэн хутагтын шавьд сүм хийд 4 байсан бөгөөд сүм хийдийн мэдэлд 54 адуу, 39 тэмээ, 84 үхэр, 2135 хонь ямаа байв. Мөн хутагт ламын мэдэлд 676 адуу, 131 тэмээ, 203 үхэр, 1800 хонь ямаа байв. Бусад мал нь адуу 1841,тэмээ 409, үхэр 396, хонь ямаа 10898 байжээ, Иймд 1918 онд ИХ-ын шавийн адуу 2511, тэмээ 579,үхэр 683, хонь ямаа 14833, нийт мал 18666 байв. 1924 онд Наро Банчэн хутагтын шавь нь нийт 232 өрхийн 1347 хүн амтай, мал нь адуу 3845, тэмээ 1248, үхэр 1542, хонь ямаа 20848, нийт мал 27483 болж өссөн юм. Тус шавийг 1925 онд Отгонхайрхан уулын хошуунд нийлүүлжээ.

Дээр дурдсан зарим баримтад тулгуурлан дараах саналыг дэвшүүлж болох юм.

Халхын нэгэн хошууны засаг ноёны төрөл тайжийн гэрт тодорсон хувилгаан Бадамдоржид Наробанчэн хутагт цолыг Далай лам, Банчин эрдэнэ нараас хүртээсэн бол 1725 онд Манж Чин улсын хаанаас уг цолыг дахин шагнажээ, Наро Банчэн хутагт нь 1772 он хүртэл хошууны хутагт байсан бол 1772 оноос бие даасан шавийн захиргаа бүхий томоохон хутагт болжээ. Тийнхүү Наро Банчэн хутагтын шавь нь XVIII зуунаас 1925 он болтол оршин тогтножээ.

Наро Банчэн хутагтын шавийн захиргаанд Ордосын Эрх цорж буюу хожмын Халхын Дилав гэгээний сүм, шавь нар багтаж байв. 1773 онд Наро Банчэн хутагтын шавь захирах тамга олгосноос хойш шавийн захиргааны хэргийг шанзудба голлон эрхэлж байв. XIX зууны үед Наро Банчэн хутагтын шавийн нутгийн зураг байсан бөгөөд Наро Банчэн хутагтын шавийн Ордос дахь 3 аймаг анги, Халх дахь тус бүр 16 өрхтэй 12 хэсэг бүхий зохион байгуулалт, хожмын Наро Банчэн хутагтын шавийн захиргаанд Дилав хутагтын оролцоо байсан зэрэг онцлог шинжтэй байв.

1772 оноос XIX зууны сүүлчээс XX зууны эхэн үед ИХ-ын шавийн хүн ам нилээд нэмэгдсэн бөгөөд 1918-1924 он хүн, малын тоо олширсон зэрэг иь Наро Банчэн хутагтын шавийн нийгмийн харилцаа, алба, бусад хошуудтай харилцаж байсан асуудлыг цаашид улам нягтлан судлууштайг илтгэнэ.

ЗУРГААДУГААР. “Их Монгол оронд уламжлагдсан ирээдүйг эш үзүүлсэн бошгууд” номноос ишлэв.

ТӨМӨР ХАЙРЦАГИЙН НОМ

Богд Жэвзүндамба хутагтын VIII дүрийн хувилгаан Агваанлувсан чойжиням данзинванчүг балсанбу бээр Монгол улсын шашин төрийг хослон баригч наран гэрэлт богд хаанаар өргөмжлөгдөн заларч байгаад аргын 1924 онд таалал төгсөв.

Орд, харш, эд хогшилыг нь хурааж дансаа тэмдэглэжээ. Гэтэл нэгэн жижиг төмөр хайрцагтай юм гарсныг задалж үзэх гэвэл түлхүүр нь үл олдсон тул нярав байсан Дамдинг баривчилж ял тулган байцааваас Дамдин булигаар гэртэй түлхүүрийг хүзүүнээсээ авч өгөв. Түүгээр уул хайрцгийг задлан үзвэл арван найман зүйл бүхий гэрээ бичиг байв. Энэхүү гэрээ бичгийн үндсэн зүйлүүдэд нь:

Ирээдүй цагт гадаад улстай нэг хоёр, гурав дугаар цуст дайн болох тухай хэлэлцэн тогтоосон байв.

Энэ гурав дугаар гэрээ бичгийг Бадаргуулалт төрийн арван найм дугаар оны үед Утай (таван үзүүрт) ууланд дэлхийн таван гүрний хаадууд болон богд хутагтуудын хамтаар хуран чуулж энэ гуравдугаар бичгийг баталжээ. Таван гүрний хаадын хамтаар богд Жавзүндамба хутагт, Далай лам, Банчин богд, Жанжаа богд, Саж богд, Дамбийжанцан богд эдгээр байжээ. Энэхүү гэрээ бичигт дурьдсан нь:

Төмөр хулгана жилээс усан бичин жил хүртэл (1900-1992)

Халх монголын хойд зүгээс

Хүмүүний дүрстэй, адгуусны байдалтай

Олон янзын шар нүүртэй

С, Е, Я, А, Н, хэнээх нэртэй хүмүүс ирж

Монголын цогт эрднийг булаан авна

Энэ үед эм хүн төрийн эрх барина

Лам хүн цэрэгт мордоно
Лам хүн хар хүний боол болно
Ноён хүн нохой мэт болно
Ядуу гуйлгачин хүн түшмэл болно
Худалдаачин хүн зарлага болно
Хууль байвч дагах хүнгүй
Ном байвч унших хүн цөөхөн
Тэр цагт хүрээ хийд байвч
Цэрэг түшмэд дайснуудын балгас болно
Энэ цагт монголын шашин, төр нэрийн төдий болно
гэсэн зарлиг бичгийг хаадын чуулганд өргөн мэдүүлэв.
Таван гүрний хаадын чуулганаас тэр цагт
“Эдүгээ богдуудын хамт арван найман гэгээн
Наян нэгэн шидтэний хамтаар дагалдуулан ирж
Ирээдүй цагт ямар ямар байдалтай болохыг
Тодорхой хэлэлцэхтүн” гэснийг
Ёсоор болгон хэлэлцэхэд
Наян нэгэн шидтэний хамтаар
Жагар, Бодлангийн орноос
Арван хоёр хэлмэрчинг залж ирээд
Тэдгээрийн хамтаар хэлэлцсэн нь:
“ Халх Монгол орны цогт эрднийг баруун хойт зүгээс
Тэрсүүд улсууд ирж булаан авсны дараа
Байдал ямар ямар болохыг дахин өгүүлснийг
Авч хэлэлцэгтүн” хэмээн зарлиг буулгасанд
Богд Жавзүндамба хутагт Халх Монгол орныг
Төмөр хулгана жилээс усан хулгана жил

(1900-1912) хүртэл даах
Дараа нь гал бар жилээс төмөр морин жил хүртэл
(1926-1930) Сахъяагийн гэгээн даах
Түүний дараа өмнө Хятад орны газарт
Төмөр морин жилээс эхлэн (1930)
Зан зүй лин, Ү пэ фугийн таван үед хямран байлдах
Тэр үед Жанжаа богд өөрийн биеэр эвсүүлнэ
Мөн түүний дараа Хятад орны чанадад буй
Япон хэмээх нэгэн хүчирхэг гүрэн
Хятад орныг боолчлон
Улмаар Монгол орны зүг хандана
Төмөр хонин жилийн намрын эхэн сарын (1931)
Арван ба арван таван
Мөн сүүл сарын хорин хоёр ба хорин тавны өдөр
Монгол улс Да шин улсын хавчлагаар
Хямран байлдах болно
Тэр үед Дамжандорлэг бурхан дармой
Энэ үеэр тэнгэрийн дуу, ба их салхи гарна
Газар хөдөлж, хүмүүний сэтгэл номхорно
Ингэж хэлэлцсэн бичгийг
Дэлхийн таван хаадын чуулганы
Зургаадугаар зүйлд өргөн мэдүүлжээ
Хутагт та нар Халх Монгол оронд
Ямар ямар бэрхшээл тохиолдох ба
Чухам аль аль орнуудад ямар болохыг
Дахин хэлэлцэгтүн хэмээн зарлиг айлдсаныг
Олон Богд хутагт, Дарь эх нарын

Чуулганаар хэлэлцэн тогтоосон нь: Хятад орны байлдааныг Япон ба Түвд улс тарина. Орос орны байлдааныг Англи, Америк улсууд тарина. Монгол орны байлдааныг Япон, Хятад, Түвд улс тарина. (зарим хувилбарт дарна гэж бий) гэжээ.

Жавзүндамба хутагт бээр

“Халх монгол орон чухам ямар болох вэ” гэсэнд

Богд гэгээнтэн, хутагт нар

Цөм дахин хэлэлцээд айлдсан нь

“Төмөр хонин жилийн (1931) эцэс

Усан бичин жилийн эхээр (1932)

Цуст байлдаан болно

Энэ байлдааныг өмнө зүгээс

Түг түмэн япон, хятад цэргүүдийг дагалдуулан

Түмэн настын хөвгүүн ба

Богд хутагт нар хамтаар ирнэ

Мөн тэр зүгээс том шарга морьтны хамт

Дээд монголын олон тооны цэрэг сэлт ирж

Буруу үзэлтэн бүгдийг махан овоо

Цусан далай болгоно

Тэр цагт монгол иргэд минь

Сүсэг бишрэлийг хичээ, хичээ

Юуны өмнө ма-ни мэгзэм

Дарь эхийн жинлов, самбалхүндүвийн сүн

Эдгээр номыг өдөр шөнөгүй уншиж

Бурханд мөргөж байгтун

Оточ бурханы лагшинг олноор бүтээ

Хоёр замын уулзварт ма-ни олныг босго

Димэд бурхны суваргыг олноор бүтээ
Энэ мэтээр буян үйлдвэл
Муу цагийн олон янзын аюулаас хэлтэрнэ.
Эдгээр буяныг эс үйлдвэл
Муу цагийн аюулд дайрагдана
Иймийн учир монгол иргэд минь
Сүсэг бишрэлийг хичээ
Үүний дотор Халх Монгол орны дотор
Баруун хоёр аймагт малын мөргүй болно
Зүүн хоёр аймагт хүмүүний мөргүй болно
Тэр цагт урьд нь байгуулагдсан
Эрдэнэ зуугийн хийдэд
Жавзүндамба хутагтыг зална
Тэр цагт Гүнгаа хэмээх хаантай болно
Түшээт нэртэй ууланд Энх-Амгалан хааны хөвгүүн
Далай амгалан гэгч хүмүүн
Усан тахиа жилд хаан сууна
Энэ үед монголчууд их амгалангаар жаргана
Гэсэн зарлиг бичгийг ертөнцийн дээд
Таван хаадын чуулганы
Арван наймдугаар зүйлд батлав
Өлзий хутаг орших болтугай
Ум ма ни бад мэ хум
Ловон Бадамжүнай бурхныг бодож
Ээ на хо ум ма пани пани суха гэж
Өдөр шөнөгүй олон олон уншиж яваарай

Тогтоолын хувилбарыг дэлхийн таван хаадын газраа
Бат бэхээр хадгалав хэмээчхүй

Бадаргуут төрийн 14/1889 он.
Шар хулгана жил.

Хавсралт

Богд эзэн хаан Монгол улсын олноо өргөгдсөний
Зургаадугаар онд цаг төрийн тухай учир шалтгаан
Цаг хэмжээ ямар болохыг тус тус тодорхойлсон нь:
Ховд хот дайны хөл болсон үед
Богд Жавзүндамба дарнатын гэгээнтнээ
Нууцаар дээд бошго зарлиг буулгасан нь:
Ар Халх Монголын олон амьтны
Зовлонг арилгах тусын тулд
Нийтээр зарлиг тараасан учир дамжиг бүү сана.
Богд Жэвзүндамба дарнатын гэгээн танаа:
Зүүн хойт зүгт муу дайсан хэмээх уулын
Зүүн үзүүрт газар хагарч цөмөрсөний дотор
Нэгэн зэс хаалга бий.
Түүний дотор арван настай нэгэн хөвгүүн бий.
Зүүн хаалганы гадна баруун биед
Лу овогт нэгэн хөвгүүн бий.
Бас нэгэн хаалганы дэргэд уулын дотор
Зэс могой бий.
Зүүн биед нь гуулин царцаа бий.
Үүдний хаалганы өмнө биед нь
Ван овогт нэгэн хөвгүүн бий.
Бас хаалганы дотор зэс хорхой бий.
Зүүн биед нь Му овогт нэгэн хөвгүүн бий.
Бас урд биенд нь гуулин үхэр бий
Баруун хяалганд Манзушри бий
Шар хаалганд нь Махгал бий

Хөх хаалганд нь Лхам тэнгэр бий

Эл бүгдийн дотор нэгэн хаалга бий

Түүний баруун биед гуулин хоншоортой нохой бий.

Хар хаалганд Авид бурхан бий

Цагаан хаалганд охин цагаан тэнгэр бий

Эдгээрийн баруун хаалганы дотор

Зэс хошуутай, гуулин хошуутай хоёр нохой бий.

Эдгээр бүгд хятадуудыг барьж идмүй.

Энэ бүгд өөрсдөө бүтсэн амьтад болой.

Богдын зарлиг нь:

Бурхны санваарыг хурдан авагтун. Хятад тоорцог, улаан бүрх малгай бүү өмс Хонь, бичин жилийн дөрвөн сарын Шинийн гурван, дөрөвнөөс эхлэн Хятадтай бүү хэлэлц

Олон үг хэлэлцэн тархваас барьж идэх вий. Тариа иддэг гуулин хорхой бий Тариа хишиг олонд тараа Монгол айл дарцаг хийсгэ

Дөрвөн сард бороо, цас мөс, таван сард хур элбэг Манай монгол хүмүүн уур хилэнгүй, амар жаргалаар Идээ будаагаа идэх, эд бараагаа эдлэх болно Ялангуяа хятад, орос хүмүүсийн Гашуун зовлон их болно

Хонь, бичин жилийн долоон сард их гамшиг болох

Хятад , орос лугаа дэмий бүү зөрөлдөгтүн

Монгол эр хүмүүн цагаан өмд,

Эм хүмүүн нь хар өмд өмсөх хэрэгтэй.

Гэнэт ханиад томуу тохиолдвол цагаан үзмийг

Адилсан буцалгаж ууваас өвчин илааршина

Миний хуврага шавь нарууд сайн сайн гэж бүү хэтэр

Муу муу хэмээн бүү доромжил

Цөм л нэгэн адил бурхны шавь болой.

Бичин жилийн дөрвөн сараас эхлэн

Хаан төр тогтож төвширмой.

Монгол хүмүүний есөн хүсэл ханах бий

Ламын гэгээн, ноён хутагтын гэгээн,

Богдын гэгээн, Номун хаан гэгээн,

Гүндэнсанбуугийн гэгээн, Арз богдын гэгээн,
Хонсим бодисадын гэгээн тэргүүнтэн
Энэ арван найман гэгээн Маналын сүмд заларч
Шар шувуун арслан мэт дөрвөн зүгт хандаж зогсоно.
Цаг хэмжээ болно.
Энэ зовлонт муу цагийн дашрамын
Гэмт цагийн байдал
Үйлийн үрийн авьяас хэзээ дуусах тэр үед
Арван зургаан зуун мянган манж нар
Хятад газрын сүмд заларч бүгдээр цугларaад
Бичин жилийн дөрвөн сард
Наян нэгэн шидтэн гарч ирж
Халхын олон амьтанд энэ зарлигийг тараана.
Хятад, Орос улсын элдэв тамхийг
Гурван зоос хүрэвч хямд гэж бүү авч тат
Янз бүрийн архи зуун зоос хүрэвч
Хямд хэмээн бүү ав. Ууж үл болмой.
Хэрэв авбал Хятад, Оросын хор хүрмүй
Монголчууд аа, үүднийхээ өмнө үнэн овоо босго
Монгол хүмүүний тэмдгийг түүгээр мэдмой.
Монгол эхнэр үсээ өндөр болгон бүү овоол
Самнаж байх хэрэгтэй
Толгойгоо алаг эрээн элдэв юмаар бүү боогтун
Үсээ нэг боож үл болмой.
Хуучин төрийн ёсоор сүлжих хэрэгтэй.
Оросыг дагаж болохгүй.
Ядрах хоосрохын зовлонг эдэлнэ.
Зургаан сард тахианы өндөгтэй хоол бүү ид
Идвээс орос, хятадын хор хүрмүй.
Оймс гутлаа гаднаа бүү босго
Монгол хүний тэнэгийг түүгээр мэдмүй
Аливаа хүмүүн эдгээрийг

Худал явдал хэмээн санаж хэлбэл
Хамар амнаас нь цус гарч үхмой
Өглөгийн эздэд их сүсэглэх хэрэгтэй.
Үүнд:
Алтангэрэлийн тарни, Билгийн зүрхний тарни,
Найман мянгын тарни эдгээрийг
Гэр , хүрээний дөрвөн зүгт хийсгэ.
Ирэх бичин жилд цэргийн морь, эмээл, хазаар бэлтгэ
Бичин жилийн дөрвөн сарын шинийн гурванд

АРВАН НАЙМАН ГЭГЭЭН, НАЯН НЭГЭН ШИДТЭН ГАРЧ

(Дээрх үгийн тайлбар нь: Үнэхээр энэ ишлэлээр есдүгээр богд монголд заларч 10 гаруй хутагт хувилгаадыг тодруулж, ширээнд залан мөн түүнчлэн эртний энэтхэгийн 81 шидтэний манлай Наро Банчэн хутагтын долдугаар дүр ДАНЗАНЛХҮНДҮВ гэгээнтэн тодорсон нь энэхүү ишлэлийг жинхэнэ утгаар нь биелэж байгааг харуулж байна)

Таван зуун цэрэгтэй, гурван мянган
Зэс, гуулин нохой цөм цуглармой.
Монголын сайн хувь заяатай хүмүүс
Сүсэг бишрэлээ нэн хичээвэл их хэрэгтэй.
Бурхны шашныг мандуулагч Түвд орноо
Дашлхүмбэ хийдийн хамгийг айлдагч
Богд Банчин эрдэнийн гэгээн,
Амьтны тусыг нигүүлсэгч Ламын гэгээн
Тэр хоёрын айлдсан зарлиг гарна.
Түнээс хойш барс жилээс
Долоон сарын арван таван хүртэл
Хятад, Орос орны амьтанд муу тул
Хойшид Монгол улсын эдлэх зовлон
Хуучирч нэлээд арилах болно.
Бас хонин жилийн долоон сарын арван нэгэнд
Баруун хойт зүгээс их гал одны гэрэл гарч байсан.
Түүний шалтгаанаар тэнгэрийн хилэн их болж

Хан хурмаст болон найман аймаг, лусын хаад,
Элдэв шашны сахиус, савдгууд ихэд хилэгнэн,
Орос, хятадуудад хөнөөл авчрах болно.
Тэр учир шалтгаанаар тэнгэрийн аюул
Лусын аюул, газар хөдлөхийн аюул
Түүнд хөнөөгдөн үхэхийн аюул
Цэрэг дайны аюул хийгээд
Мэдэх, мэдэхгүй хижиг өвчний аюул
Салхи шуурга тэргүүтэн гал, усны аюул
Эдгээр муу ёрууд биелэхийн өмнө
Алтангэрэл (сэр од), Бисман тэнгэрийг (Намсрай)
Сайн уншвал өлзий хутаг орших болно
Шашины олон тойн, хуврагууд минь ээ
Ма-ни, мэгзмийг амны уншлага болгон
Оточ, Дарь эх хийгээд Цагаан шүхэртийн
Хариулга уншлага хийх хэрэгтэй
Эргэл мөргөлийг цаг үргэлж хий
Ялангуяа бичин жилийн
Цагаан сарын шинийн нэгнээс эхлэн
Долоодугаар сар хүртэл шар, хар олон амьтан
Энэ номыг толилж айлдвал нэн сайн болой.
Муу явдлыг хариулах нь хөх даавуун дээр зурж
Гурвалжлан эвхэж, гар, хөлийн тарнийг бичиж
Гар, хөлдөө зүүх аваас муу ёрыг ариутган дарах бий.
Найман сараас эхлэн манай Монголын
Хамаг буян хишиг, цог хийморь цөм эргэн сэргэж
Аливаа санасан сайн үйл дэлгэрнэ
Дээдийн жаргалаар жаргах болно
Тиймийн тул лам гурван эрдэнэд сайн залбирахтун
Буян их хийхтүн
Ном их уншиж, эргэл хийвээс сайн болно.

ДИЛОВА НАРОБА ХОЁР ГЭГЭЭНТЭН БИЕ БИЕНЭЭ ТОДРУУЛЖ НЭГЭН ХИЙДЭД ШАВИЛАН СУУЖ БАЙСАН НОМЫН АХАН ДҮҮС БУЯНЫ САДАН УЧИР ДИЛОВ ХУТАГТ Б.ЖАМСРАНЖАВИЙН НАМТРЫГ ЦУХАС ДУРЬДВАЛ

ДИЛОВ ХУТАГТ Б.ЖАМСРАНЖАВ (1884-1965)

Намайг долоогоос есөн настай байх хооронд (1890-1892 он) шинэ Наро Банчэн гэгээнийг залах яриа гарч, хийдэд маань бөөн ажил боллоо. Хуучин Наро Банчэн гэгээний жасад нэн ядуу щавь ардын эхнэрээс шинэ гэгээн мэндэлжээ. Тэр бүсгүй нэг монгол хүнтэй ханилж байгаад хожим нь хятадын засгийн газрын албанд түшмэл агсан Тинг хэмээх хятадыг дагаж Ховд руу оджээ. Тинг гэгч нь түүний жинхэнэ нэр биш, тэрбээр Хонанд болсон үймээнд оролцож, тийм нэртэй болсон агаад тэндээс ирж Ховдод цөлөгдсөн хүн байжээ. Эрдэм боловсрол сайтай учир тэндэх хятад монгол түшмэл нарт нэр олжээ. Тинг эхнэрийнхээ өмнөх нөхөрт жаахан мөнгө өгч, хүүг үрчилж аваад Шинжааны Или нутагт оджээ. Тэр хүүг Наро Банчэн гэгээний дүр хэмээн тодруулмагц, түүнийг олж ирүүлэхээр Или нутагт элч илгээжээ. Үүний зэрэгцээгээр Хятадууд тэр хүүг 35000 лангийн барьцаанд авчээ. Хүүг залж ирэхээр морь, тэмээ бүхий 40-өөд хүнийг илгээжээ. Аз болоход манай Хүрээ, Алтайн Торгууд нартай сайн харилцаатай байсан тул тэд унаа залгуулж байв. Тэд 35000 лан мөнгийг төлөхөөс татгалзсан тул эгэн иржээ. Энэ зуур элчийг цааш нааш явуулсаар нэг жилийг өнгөрөөсөн бөгөөд мөнгө амласан авч түүнийг нь цаад тал хүлээн авахаас татгалзжээ. Тэгээд цөхрөнгөө барж, эргэж иртлээ зуныг нь Бор тал, өвлийг нь Илид өнгөрөөжээ. Дараахь намар нь хиа нарын хамт 12 хүрэхгүй хүнийг илгээсэн бөгөөд тэд нь Или хүрч удтал ярилцсаны эцэст хандиваар хуримтлуулсан 10000 лан мөнгийг өргөж, хүүг эгүүлэн авчирчээ. Тэр хүү насаар бараг над шиг байв. Элч нарын дотор хийдийн нэг хэлэмгий хүн, аймгийн яамны нэгэн дэндүү зөөлөн хүн байжээ. Хэрэв аймгийн төлөөлөгч тийнхүү уриалгахан байгаагүй бол манайхан тийм их мөнгө 10000 лан мөнгө төлөхөд хүрэхгүй байх байжээ.

Долоон настайдаа (1890 он) би Засагт ханы хошуунд очиж,

хошууны ноёнтой уулзав. Намайг угтахаар гэрээсээ гарч ирсэн хошуу ноёныг дагасан хавууд миний хормойн доогуур үсэрч орон, шагайнаас минь суун тустал хазсан тул би их эвгүй байдалд орж билээ. Наро Банчин гэгээнийг тодруулсан тэр зуныг би тэнд өнгөрөөсөн бөгөөд намайг ихэд хүндлэн ёс төртэй байлгасан юм. Засагт ханы хошуу нь манай хийдээс жар орчим бээрийн зайд байв.

Арван хоёр настай байхад минь (1895 он) Халх дөрвөн аймгийн их наадам болдог Эрдэнэзуугийн том хийдэд Ар богд (Хүрээний амьд бурхан) залран ирлээ. Төвдөөр Даншиг буюу монголоор Бат-оршил хэмээх наадам энэ удаа болсон юм. Энэхүү Бат-Оршил нь миний таван настай байхад Наро Банчэн хийдэд болсон Мандал өргөх ёслолтой төстэй байсан бөгөөд ялгаатай нь илүү сүрлэг том байлаа.

Богдын даншигт дөрвөн аймгаас жил бур 10000 лан өргөх ёстой бөгөөд аймаг бүр өөрсдөө хэмжээг хувааж тогтоох ёстой байдаг байв. Морь, бөх, сурын тэмцээн, асар майхан, айраг цагаа, идээ шүүс зэрэг асар их хөрөнгө гаргах түл орон нутагт сүрхий дарамттай байдаг бөлгөө.

Наро Банчэнгийн хүрээнд болдог манай Даншигийн хэрэгцээнд 500 хонь гаргах тооцоотой авч үүнээс их хөрөнгө зардаг байж билээ. Таван насны морь уралдахын зэрэгцээ азарга, жороо морь мөн уралддаг байв. Нас бүхний түрүү морь залуу атны шантай. Үзүүр түрүүний бөхийн шан хэмээн аймаг бүрээс тэмээ ирнэ. Ёсыг бодож нутгийн бөхийг ямагт түрүүлүүлнэ. Үнэнхүү ялагч болох ёстой байсан үзүүр бөхийн шанд жороо морь, дээлийн торго, цөөвтөр мөнгө барина.

Наро Банчэн гэгээн бид хоёр энэхүү чуулганд очлоо. Би хурдан морь үзэж, бусад үеэр тэндхийн нэгэн эрдэмтэн ламаас ном хүртэж, бөх, бусад наадам тоглоомд очдоггүй байв. Эрдэнэзуу руу би урд замаар очиж, хойд замаар эргэж ирж билээ. Замдаа дөрвөн хошуугаар орсон бөгөөд хошуу бүр найр наадам хийж, бэлэг сэлт харилцан барьж билээ.

Арван гуравтайдаа (1896 он) би цагаан бурхан (салхин цэцэг) өвчин тусч, намайг жил орчим тусгаарлан байлгав. Намайг арван нэгтэйд мөн тахал дэгдэж надад тарилга хийн ууланд байлгаж байсан юм. Тэгэхэд намайг нэгэн орос тарьсан агаад шанд нь

цоохор морь өгч байсан билээ. Гэвч түүний тарилга өвчнийг эдгээж чадаагүй тул сүүлд нэгэн монгол оточ ирж дахин тарьсан юм даг.

Арван дөрвөн настайдаа (1897 он) би хурал номын ажил, хятад манж түшмэдтэй нүүр учрахаар Улиастай явлаа. Тэр удаа би хоёр дахин явах хэрэгтэй болсон юм. Учир нь Наро Банчэн гэгээний шүд өвдсөн тул намайг замын дундаас буцаан дуудлаа. (Тэр цагт шүд сугална гэж үгүй, харин халуун зүүгээр цоолох, төөнөх, эсвэл буйлыг нь зүсдэг байлаа) Наро Банчэн хийдээс Улиастай 130 бээр орчим зайтай боловч би морь унах дуртай тул мориор нэг хоног яваад хүрчихдэг байсан юм. Энэ үед бид Наро Банчэн гэгээний шүдний өвчний зэрэгцээ түүний хойт эцгийн амь насны талаар санаа зовж байв. Хойт эцэг нь тэр жилдээ хавангийн улмаас нас нөгчсөн юм. Тэрээр нэг хэсэг Улиастайд 5 хятад зарцын хамт суудаг байв. Тэр эхнэрээсээ монгол хэл маш сайн сурсан бөгөөд Улиастайн манж ноёдод их нөлөөтэй учир монголчууд түүнээс цэрвэдэг байсан юм.

Мөн тэр жил их лам нарын үйлддэг өргөл мөргөлийн хэргээр би төрсөн хошуундаа очлоо. Энэ удаа бол «Уул овоондоо» өргөл өргөсөн юм. Зун нь хошуунаасаа эргэн ирээд мөнх цаст «Отгон цэнхэр» ууланд бараалхав. «Отгон» гэдэг нь хамгийн бага хүүхэд гэсэн үг. Энэ хайрхан Сайн ноён хан аймгийн нутагт байдаг байв. Тэгэхэд манжийн хааны өмнөөс манж жанжин≫ Ар Богд, уг уулын оршдог аймаг, хошууч Бэйсийн хошуу өргөл өргөлөө. Өргөл тахилга болж байсан үеэр би тэнд байлаа. Монгол бичгээр бичсэн шашны бус тахилгын шүлэг ч байв. Отгон Тэнгэр бол Японы Фужи уулнаас хавьгүй өндөр уул юм. Заншил ёсоор би хийдийн үйл хэргийг 18-тайгаасаа л эрхлэх ёстой байсан ч үнэндээ 11 наснаасаа уг ажлыг сонирхох болсон юм. Би 18 хүрч албан ёсоор хийдийг удирдах эрхтэй болох үедээ 15-тайгаасаа хийдийн ажилд идэвхтэй оролцож байсныхаа ачаар нэлээн туршлагатай болсон байлаа. Хийдийг удирдах албанд Наро Банчэн гэгээн бид хоёр тэгш эрх мэдэлтэй байсан бөгөөд аливаа шийдийг хамтран гаргаж байхдаа ам зөрж байсан нь үгүй.

Наро Банчэн гэгээн хийдэд анх есөн настайдаа залрахдаа зөвхөн хятадаар ярьдаг байсан ч хожим нь монгол хэлийг тун сайн сурсан юм. Гэхдээ Илид байхдаа тэр «Би гэртээ харимаар байна» гэж монголоор хэлж байсан, мөн овоо тахихад хэлдэг ерөөлийн үгс хэллэгийг монголоор хэлж овоонд хадаг өргөж байсан зэргээрээ

Наро Банчэн гэгээн мөн болохоо нотолсон гэдэг.

16 насандаа (1899 он) би урьд зунуудын адил хийдээс гарч явсангүй, харин гурван сар даяанчилж, мацаг барьж, судар бясалгасан билээ.

Миний 17 настай (1900 он) байхад хятадад нударган зодоочдын бослого гарсан боловч Монгол орон амгалан үлдсэн юм. Манж амбан Улиастайд монгол цэрэг татах тушаал буулгасан хэдий боловч харин Хятад руу ер хөдлөөгүй юм. Засагт ханы цэрэг үймсэн боловч Сайн ноён ханыхан хөдөлсөнгүй. Хэрэв хоёр хошууны цэрэг нэгдсэн бол Улиастайг эзэлж авч чадах байсан юм. (Халх хоёр аймгаас Улиастайд 2000 орчим цэрэг цугларсан юм. Тэд хөлс хүчээ аваагүй байсан учир Чин-гийн сөрөг хүчин тэднийг Улиастай дахь манжийн эрх баригчдын эсрэг үймээнд турхирсан билээ. Цэргүүд манжийн эрх баригчид байрлаж байсан хотын бага хэрмийг бүсэлж, манж түшмэлүүд уул руу зугатсан юм) Энэ жил би төрсөн гэрээрээ очсон билээ.

Арван найман настайдаа (1901 он) төрсөн хошуундаа залагдлаа. Энэ жилийн хавар Хошууч бээсийн хошуунд Түвд ном уншихаар очсон юм. Энэ үес хошууны ноёд хоорондоо түнжин хагарсан байсан бөлгөө. Миний айлдсан ном, ноёдын сэтгэлд шүглэсэн нүглийг арилгаж, хэрүүлийг эцэс болгоно хэмээн найдацгааж байжээ. Энэ нь ч ёсоор бүтэмжтэй болжээ. Зарим лам нарын ая дан сайн нийлэхгүй сандардаг боловч миний мэтийн төрөлхийн ая дантай нэгэн бол ажрах юмгүй. Нөгөөтэйгүүр энэ насанд багшийн заадаг судар номын хэвшмэл сургаалд эгдүүцдэг болсон байлаа. Чухамхүү энэ жил би нэг зүүд зүүдэлсэн юм. Би хийдийн доогуур урсдаг голд нүүр гараа угаахаар очоод нүүрээ угаасны дараа гараа усанд дүртэл амнаас минь сар гарч ирээд эргэлдэн хөвсөөр урсаж одов. Сүлд минь орхиж байгаа нь энэ юм. Би нойрноос сэрвэл бие сул, нэг л эвгүй байсан тул номын багшаа дуудаж, багш маань учрыг ойлгож, сүлдийг минь буцаан дуудлаа. Хэд хоноод сүлд минь наддаа эргэн оршиж бие маань сайжрав. Сүлд гэгч бол сэтгэлийн хийморь бөгөөд Түвдөөр “Ла”, хятадаар «Линг» хэмээн нэрлэнэ. Сэтгэлийн нөгөө нэг хэсэг нь сүнс бөгөөд Түвдөөр «нам ше», хятадаар «хун» гэнэ. Сүнс бол биеш талын зүйл. Сүнс ороод ирэхээр бие амьдарч, сүнс гарчихвал бие үхнэ. Сүлд бол биеэс гарч явж болно. Тэгвэл хүний бие амаргүй байх ба ухаан хоосрох авч бие амьд хэвээр байна. Сүлдээ алдах явдал олонтаа

тохиолдоно. Сүлдийг эргүүлэн дуудахдаа тухайн хүний хувцасыг сайтар дэнсэлж ном уншина. Сүлд эргэн ирэхэд хувцасны нь жин нэмэгддэг. Арван есөн насандаа (1902 он) өвөл, зун хоёр удаа Ховд орлоо. Ховд бол Улиастайгаас 14 өртөө буюу 300 гаруй бээр, 15 хоног мориор явна гэсэн үг. Тэр жил миний хувьд Ховд явсан учир бол Буянт голын хойт хөвөөнд нэг том хийд байсан бөгөөд тэр нь өөрийн гэсэн хувилгаангүй юмсанж. Энэ хийдийн нэр нь Түгээмэл Амаржуулах гэдэг байлаа. Уул нь Наро Банчэн, Жалханз гэгээн нар гурав гурван жилээр ээлжлэн энэ хийдэд Богдын (амьд бурхан) суудлыг эзэлж байх байсан юм. Миний өмнөх дүрүүдийн нэг нь уг хийдэд гурвантаа заларсан юм гэдэг. Тэрбээр далан нас зооглосон ажгуу. Энэ хийд бол зөвхөн Ховд төдийгүй баруун хойт хязгаарыг хамарсан хүрээ байлаа. Үүнийг Чиен Лун (Манжийн Тэнгэр тэтгэсэн хаан) үндэслэн байгуулсан гэж би боддог юм. Энэхүү том Хүрээ нь Ховдын хязгаарын хүрээ байсан бөгөөд аль ч хошуу аймагт хамаагүй, өөрийн газар, шавь, жасгүй байсан бөгөөд түүний харьцдаг нь Мянгад Дамбий өөлдийн хошууд байлаа.

Ховдын 20 хошууны алинд ч хувилгаан байсангүй. Зарим хошуу тухайлбал, Дамбий өөлдийн хошуунд Дарь эх нэртэй эмэгтэй хувилгаан байдаг байв. Дарь эх нь өөрийн сүмгүй, үе залгамжилсан хувилгаан дүргүй, хааяа энд тэнд тодордог байв. Дарь эх нар нөхөртэй бөгөөд анагаах увдистай хүмүүс байдаг байлаа. Чиен Лун-ийн үед (1736-1796) хамгийн алдартай Дарь эх тодорч урт нас зооглосон гэдэг. Алс баруун хойт Монголын ихэнх нь халх бус хүмүүс байсан бөгөөд миний бага байхынх тэндээс олон хүн мөргөлөөр ирдэг байсан тул тэдний хэл аялгыг би андахгүй мэддэг байсан сан. Мөн зунаа би Ховдод очсон юм. Би бас Захчин өөлдийн хоёр хошуугаар ороод Хар гол болон Булган голын дагуухи Шинжааны хийдээс холгүй байдаг Цэцэрлэгт болсон аймгийн их чуулганд оролцов. Тэнд би ард түмний аж амьдралыг улам бүр дороитуулж байсан элдэв татварыг бууруулахыг шаардан өргөх бичиг барьсан билээ. Уг чуулганд байнгын суудалтай манай хийдийн хоёр төлөөлөгч байсан авч би чуулганд оролцохоор ирсэн бусад аймаг, хошууны ноёд түшмэдүүдтэй уулзаж, танилцах зорилготой явсан юм. Чуулганд байсан манай хийдийн хоёр хүн бол Шанзав лам болон Зайсан лам нар байсан агаад Цэцэрлэгт тэдний зиндааны тав юмуу зургаан хүн л байлаа.

Зун, хорин насандаа (1903 он) шинээр томилогдсон монгол түшмэлтэй уулзахаар Улиастай оров. Мөн тэр жилийнхээ өвөл Ховд явсан юм. Намайг хорин настай байхад Орос-Японы дайн гарсан боловч манай нутаг тэр дайнд өртөөгүй юм. Наро Банчэн гэгээн энэ хэр маш хүнд өвчтэй байсан тул Ховдоос би маш их яарч ирсэн юм. Харамсалтай нь, миний буцаж ирэхээс хэдхэн цагийн өмнө тэрбээр таалал төгссөн байж билээ. Шинэ Наро Банчэн гэгээн тодортол зургаан жилийн хугацаа өнгөрөв. Амьд бурхныг таалал төгссөний дараа эхний нэг жилд гэгээний дүрийг эрж хайдаггүй, учир нь эхийн хэвлийд буй болж байгаа хэмээн үздэг. Засагт хан аймгийн хошуудын нэгэн хийдийн ширээт ламаар залагдаад байсан Дашлхүнбэ гэдэг, талийгаач Наро Банчэнгийн багш, эрдэмтэй Түвд ламаас, бас Жалханз хутагтаас тусламж гуйв. Тэд шинэ хувилгаан холгүй байна гэсэн юм. Нээрээ ч шинэ хувилгаан манай шавьд тодрон гарав. Эцэг нь надаас хоёрхон ах хүн байв.

Хорин нэгэн насандаа (1904 он) би хоёр ч удаа Улиастай орж ноёдод бараалхлаа. Учир нь манай хийдийн хүмүүсээс хятадын худалдаачдад төлөх өр давж даагдахаа болив. Монголчууд хятадаас тариа будаа, гэрийн эд хогшил, хувцас хунар худалдан авах бөгөөд хариуд нь тэр болгон мал өгөөд байх боломжгүй байдаг байсан тул хятадууд зуун хувь хүртэлх өндөр хүүгээр зээл олгодог байв. Үүний зэрэгцээ борчуул хошуу ноёдынхоо өрийг төлөхөд хүрдэг байсан юм. 1912 онд Ачит Бэйсийн хошуу хятадын худалдаачдад 1183 лан мөнгөний өртэй байсан бөгөөд 1916 онд уг өр 19000 лан болж өссөн байв. Би өр болон түүний хүүний учрыг олохоор явсан билээ. Өрийн ихэнх нь намайг алба хашихаас өмнө үүссэн байсан бөгөөд би тэдний нилээдийг залруулах гэж багагүй оролдлоо. Энэ ажил хэргийн дараа би төрсөн хошуундаа очиж зуслаа. Тэндээс буцах замдаа би дахин Улиастайд саатахаас аргагүйд хүрэв. Тэндхийн монгол амбаны хүүхэд нилээн хүнд өвчилсөн учир түүнд ном уншиж нэг сар гаруй боллоо. Тэгсээр нөгөө хүүхэд ч илааршиж би шашны ном судар уншин хийддээ өвөлжив. Дараа жилийнх нь хавар, хорин хоёр настайд минь (1905 он) Улиастайн нөгөө монгол ноёны хүүхэд дахин өвдсөн тул даруй ирэхийг хүссэн юм. Энэ тухай мэдээ харуй бүрий болж байхад ирсэн тул би үүрээр гарч Улиастайд нэг хоногийн дараа хүрэв. Өвлийн гурван сарын турш ном үзсээр ер морь унаагүй учраас би бас ч ядарсан боловч залуу

халуун насныхаа аагаар бараг маргааш нь л зүгээр болсон байлаа.

Харин зуны эхээр би өвчин тусч хоёр сар орчим хэвтсэн юм. Үүнээс хориод хоногт нь ихэд халуурч дэмийрсэн байв. Нэг сарын туршид аажим аажмаар тэнхэрч бүр эдгэхэд минь Хошууч Бэйс дахин хошуундаа урьж миний эдгэрснийг тохиолдуулан мандал өргөсөн билээ.

Хорин дөрвөн насандаа (1907 он) би монгол амбаныд дахин очихдоо Улиастайгаас зүүн хойно байдаг төмрийн дархадаараа алдартай хошуунд нь айлчлав. Би тэндээ хаваржаад зуны дундуур буцаж ирсэн юм. Эргэж ирснийхээ дараа надаас арван нэгэн насаар ах Жалханз гэгээний хийдэд байж байгаад хийддээ намар ирчихээд Засагг хан аймагт очиж мөргөл ном айлдлаа. Харин өвөл нь дахин Улиастайд очиж нэг сар болсон юм. Ер нь би өвөл нь шашин номд шамдахыг эрмэлздэг байв. Тэгэхэд Жалханз гэгээнтэй Ховд орчихоод Улиастай руу явж байх замд нь таарсан юм. Төрсөн нутагг нь олон хүнийг алж талсан явдал гарсан гээд надаар ном уншуулав. Дараа зун нь би Жалханз Гэгээнийд зусаад хийддээ намар нь ирлээ. Жалханз хутагтын хийд манайхаас 450 бээрийн зайтай бөгөөд Хөвсгөлөөс ачаатай тэмээгээр гурав хоног явж байж хүрдэг байв.

Намайг 25 настай байхад (1908 он) намрын эхээр миний 25-ны жилийг ёсолсон сүрхий том баяр болов.

26 насандаа (1909 он) зун Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу орлоо. Тэр хошуунд айхавтар халуун хавар болсон юм. Жалханз гэгээн мөн морилон ирж, бид халуун рашаанд хамт байлаа. Дараа нь бид хойно нь залгаа орших Баатар вангийн хошуунд залагдаж, нэг хэсэг амарч зугаацлаа. Тэгээд Жалханз гэгээний хүрээ орж, тэнд би гурван сар байгаад гэртээ эргэж ирэв. Мөн өвөл Далай Чойнхор ван Улиастайн захирагчаар томилогдож, түүнд би бараалхав.

27-ны жилд маань онцын явдал болсонгүй. Хавар нь би Хошууч Бэйсийн хошуу орж, дараа нь Улиастайд очив. Мөн жилийн зун, Төвдөөр Даншиг, монголоор бол Бат-Оршил хэмээх их наадам болж, энэ их наадмыг Наро Банчэн гэгээнд зориулсан юм. Бүх бэлтгэлийг би хариуцав. Энэ нь миний хорин таван насны баяртай төстэй болсон агаад гурван насны бус таван насны морь уралдаж, сүмийн мяндагт ушаалтан нар заларсан ёслол болов.

Хоёрдугаар бүлэг

(1911-1921 он)

Манжийн ноёрхолын сүүлчийн хавар 28 настайдаа (1911 он) би Наран хутагтынд хоёр удаа очсон юм. Түүний хүрээ манайхаас холгүй, зуны цагт бол мориор нэгэн өдөржийн газар байдаг бөлгөө. Тэрбээр өөрийн мэдлийн нутаг дэвсгэр, жастай амьд бурхан (хувилгаан) байж билээ. Зуны тэргүүн сард миний бие Жалханз хутагтын хамт Далай Чойнхор вангийн хошуунд байдаг Халуун рашаанд мөн очоод, зуны тэргүүн сард гэр гэртээ буцсан билээ.

Тэр жил Халх нутагт гойд их бороотой байлаа. Ийм их бороотой зуныг би санадаггүй юм. Настайчуул ч тийм их бороотой зун үзээгүй хэмээн ярьж байсан юм. Намар нь Чойнхор вангийн урилга заллагаар би түүнд бараалахлаа. Учир нь тэрбээр Гадаад монголын өөртөө засан тохинох асуудлаар яриа хэлэлцээнд оролцох төлөөний түшмэлээр томилогдох асуудлыг надтай зөвшихийг хүссэн байжээ. Хүрээ орж бусад түшмэл нартай зөвлөлдөхийн өмнө Далай Чойнхор ван надтай уулзаж, тийш очих уу, болих уу гэдгээ ярилцах гэсэн хэрэг байлаа. Хүрээнээс буцаж ирээд тэрбээр намайг дахин дуудуулж, Хятадаас Монгол улсыг зарлан тунхаглаж хүрээний Богдыг хаанаар ширээнд өргөмжлөн залсан тухай надад хүүрнэв. 1911-1912 оны өвлийн эхээр би Улиастай оров. Тэр үед гойд ширүүн хэрэг явдал гараагүй байсан боловч элдэв цуу яриа дэгдэж хүн бүр чих тавин байсан цаг. Ма нэртэй манж амбан байдаг байв. Тэрбээр гурван жилийн тэртээ томилогдсон боловч уг албанаа залрахаас цааргалж байгаад нэг хэсэг болоод тэр зун хүрэлцэн ирээд, өвөл нь зайлан одсон юм. Тэр жил хүрээний Богд, хаан ширээнд суусан билээ. Дараа жил нь буюу 29 настайдаа (1912 он) би Жа ламын тухай сонсч эхэлсэн бөгөөд энэ тухай дараа өгүүлсүү. Мөн оны намар би Богдод бараалхахаар Хүрээ оров. Ёслолын горимоор бол хутагтын зиндааны амьд бурхан цэнхэр бүрээстэй, хоёр дугуйтай сүйх тэргээр залрах ёстой ажээ. Богд, манжийн эзэн хаанд гурван удаа бараалахсны дараа цэнхэр бүрээсийн оронд ногоон бүрээстэй сүйх тэрэгний хишиг хүртжээ. Энэ удаа надад ногоон бүрээстэй сүйх тэрэг хайрлав. (Тусгаар тогтнолоо зарласны дараа Богд хаан Манжийн хааны мэдэлд байсан төрийн

хэргийг гардан барих болов) Тэрбээр надад бас улбар шар бүрээстэй хазаар хайрласан юм. Хаад дээдсийн хазаар нь тод алтан шаргал өнгөтэй байдаг ёстой. Харин арай доогуур зиндаанынханд гүн улбар шар өнгөтэйг хайрлаж байлаа.

1914 онд буюу намайг 31 настай байхад миний Ордос дахь сүмүүдийн нэгнээс нэг лам ирж, би түүнтэй бурхны ном бясалгав.

(Эх сурвалж: “Бидний Монголчууд” цуврал, “Ариун сэтгэл, Авралын үндэс” - “Дилав хутагт Б.Жамсранжав. Хэвлэлд бэлтгэсэн Л.Чойжилсүрэн. Цувралыг эрхэлсэн Ц.Гомбосүрэн. УБ, 2000 он. 145 - 232 тал.)

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХУТАГТЫГ ТОДРУУЛАХААС ЭМНӨ НАРО БАНЧЭН СУДЛАЛААР ХОЁРОНТОО ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН БА ТҮҮНД ИЛТГЭЛ ТАВЬСАН ЭРДЭМТЭН МЭРГЭДИЙН ИШЛЭЛ

НАРОБАНЧЭН ХУТАГТУУД

Б. Лааган
Монгол улсын гавьяат багш, доктор (Ph.D), профессор

Энэхүү илтгэлд би Наробанчэн хутагтын дүрүүдийг товч дурдаад Монголд төрсөн тав дахь дүр болох Пүрэвжав хутагтын талаар өгүүлье.

XVII зууны сүүл үеэс Энэтхэгт тав, Төвдөд дөрвөн удаа тодрон үйл ажиллагаа явуулж байсан Наробанчэн хутагт Монголд мэндлэх нөхцөл нь бүрдэж 1699 онд мэндэлсэн Түшээт ханн аймгийн баруун захын “Умар замын дундад дахь умарт буюу хожмын Хошууч мэргэн” хошууны тайж Гүржавын хүү Бадамдоржийг шинжээчдийн баг Наробанчэн хутагтын хойд дүр хэмээн тодруулсан байна. Далай лам Бадамдоржийг Наробанчэн хутагтын дүр мөн гэж айлдсанаар Халхад анхны Наробанчэн хутагтын дүр тодорчээ. Түүнд сүм дугана, шавь гэх зүйл байсангүй бөгөөд Түвдэд очиж ном эрдэмд суралцжээ. Хутагтыг хэдэн жилийн дараа нутагтаа ирэхэд хошуу нутгийн харьяалал нь өөрчлөгдөж Сайн ноён хан аймгийн чуулганд багтаж олон шавьтай болсон байна.

Халхын хоёр дахь Наробанчэн хутагт Наваанчойронданзанжамц тэр үеийн Ордос хошууны тайж Дашдэндэвийнд 1738 онд мэндэлсэн бөгөөд тав, зургаа насандаа хутагтаар тодорч 79 насандаа жанч халжээ.

Халхын гурав дахь үеийн Наробанчэн хутагтаар Амду газрын Цувдан хийдийн шавь Галсаннамжилынд 1818 онд мэндэлсэн.

Түгжжавын тодруулан цол олгож, шавьд нийлүүлэн суулгажээ. Тэрээр 1860 онд жанч тайлж Түшээ гүн Мягвасамбуугийн залан Чогсомынд хувилан мэндэлжээ.

Наробанчэн хутагтын дөрөв дэх үеийн Чогсомын хүү Бирваад Далай лам, Банчэн эрдэнэ нар 1865 онд Наробанчэн цол олгон шавьд нийлүүлэн суулгасан бөгөөд тэрээр идэр залуудаа жанч халж 1884 онд өөрийн шавь Доржийн гэрт хувилан төржээ.

Энэхүү хутагтыг Пүрэвжав гэх бөгөөд өмнөх хутагтуудаас зарим зүйлээр ялгаатай. Олон хүүхдүүдээс шигшигдсэний гол шалтгаан бол Пүрэвжав хүү Монгол хэл мэддэггүй мөртлөө Наробанчэн хутагтын уул ус тахиж байхдаа уншиж байсан тарнийн үг хэллэг, тэр нутаг дэвсгэрт байсан уул, усны нэрсийг монголоор, яг бичиж уншиж байгаа юм шиг хэлж байсан нь хутагтаар тодруулах нэгэн үндэс нь болсон. Энэ хутагтыг 9 настайд нь шавьд нь нийлүүлэн суулгасан бөгөөд 1903 онд таалал болж дараагийн дүрээр 1904 онд мэндэлсэн Лувсанцэрэнгийн Жүгдэрнамжил тодорсон байна.

Наробанчэн хутагтын дүрүүдээс тав дахь дүр Пүрэвжав бол шийдэмгий, хэл яриа нь нэлээн өвөрмөц хүн байсан. Тэрээр шавьд нийлсний дараагаар Дилова хутагтын шавь болжээ. Энэ хүн шавь нар болоод хүн ардынхаа эрүүл мэндэд онцгой анхаарч ирсэн хүн байгаа юм. Гэхдээ эрүүл мэндэд анхаарахдаа бусдаас ялгарах гол онцлог юу вэ гэхлээр шашин болоод лам хуваргуудын хэрэглэж байснаас арай өөр маягийн арга засал хэрэглэж, тэр нь амжилт олж байсан. Үүнийг хутагтын ид шид, шинжлэх ухаантай холбож тайлбарлаж болно. Тухайлбал, маш хүнд өвчин туссан хүнд малын мах өгч, махаар эдгээж байсан. Түүнээс гадна энэ хутагтын амьдарч байсан хугацаанд Монголд их тархсан цагаан бурхан хэмээх аюултай өвчин түгээмэл байжээ. Энэ өвчнөөр өвчлөгсдийн 80% нь хорогддог, эмчлэгдсэн тохиолдолд ч янз бүрийн эмгэгтэй үлддэг ийм хүнд өвчнийг эдгэрүүлж байжээ. Эдгэрүүлж, эмчилж байхдаа тэр хүний өвчинг хүйтэй нь холбож, ид шидийнхээ хүчээр хийдэг байсан бөгөөд үүгээрээ бусдаас ялгагддаг байсан бөгөөд хүйг нь долоох юм уу, ариутгаж энэ өвчинг эдгээдэг байсан баримтууд байдаг.

Энэ хутагт 15 настайдаа багшийгаа дагаж, Жавзундамба хутагттай биечлэн уулзсан байдаг бөгөөд ийм хутагт цөөхөн байдаг. Энэ хутагт Жавзундамба хутагтын санал зөвлөгөөнийг авч явдаг

байсан. Хутагтын шавийн газар нутгийн зохион байгуулалт бол тухайн үеийн засаг захиргааны зохион байгуулалтаар Сайн ноён хан аймгийн харьяанд байсан юм. Ийм учраас Сайн ноён хан аймгийнхаа нутаг дэвсгэрээр энд тэндгүй явж хүн ардад ном айлдах, зарим сонин өвөрмөц үйл ажилд оролцдог үүгээрээ их өөр хүн байсан. Хүмүүстэй бооцоо тавьж морь уралдуулах ч юм уу, тогтдоггүй хүүхдийн нэрийг сольж нэр өгөх ч юм уу ялангуяа Сайн ноён хан аймгаас тусгаарлагдсан Далай Чойнхор вангийн хошуунд нэлээд хэд хэдэн удаа олон хоногоор ажиллаж байсан баримт бий. Хоёр хүүхэд нь нас барчихаад гурав дахь хүүхдийг эхийнхээ гэдсэн байхад нь Пүрэвжав хутагт үзээд хүйг нь цэвэрлэхгүй бол гараад цагаан бурхан өвчин тусах хүүхэд байна гээд эмчилж байсан байдаг. Түүнээс гадна энэхүү хутагт нутаг усаа, язгуур гарлаа хэвээр нь хадгалах талаар, ёс суртахуун, уламжилж ирсэн зан заншлыг үлдээх талаар нэлээд анхаарсан үйл ажиллагаа явуулж байсан байна. Тийм ч учраас залагдаж явахдаа, шавь нарынхаараа морилохдоо заавал монгол дээлээ өмсөнө. Очоод тухайн шашны үйл ажиллагаан дээр номын хувцсаа өмсдөг байсан. Зан үйлийг ёсчлон хийж, дагадаг, зааж сургадаг үүнээс нь шавь нар болоод ард суралцдаг их үлгэр дууриалалтай хүн байсан ажээ. Мөн Наробанчэн хутагтын хийдээ, нутаг дэвсгэрээ хамгаалж өргөжүүлэхийн зээл авах, тусламж хандив авах ажлыг олон удаа зохион байгуулж байсан баримт бий. Тийм учраас өр зээлтэй болсон үед нь Дилова хутагт тусалж салгаж байсан удаа бий. Үүнээс үзвэл эдийн засаг, менежментийн асуудлыг тусгайлан авч үзэж байсан тал бүрийн мэдлэгтэй хүн байжээ. Пүрэвжав хутагтын амьдрал, үйл ажиллагаа нь хойчийн бидэнд ихээхэн үлгэр дууриалалтай гэж би бодож байгаа юм. Ингээд энэ бүгдээс дүгнэж хэлвэл Наробанчэн хутагт Пүрэвжав бол:

Заларч ирсэн төрөлхийн зохион байгуулах авьяас чадвартай хутагт юм. Тэрээр хаана ч явлаа гэсэн шавь нар, ард олныг биедээ татаж уулзаж учирч явдаг хүн байжээ.

Бурхан номын онол сургаалд хүндэтгэлтэй хандаж, хүмүүний оюуны чадавхийг маш богино хугацааны дотор дээд зэргээр хөгжүүлсэн, төрөлхийн ухаалаг хүн мөн.

Хутагтын амьдрал, үйл ажиллагааны уламжлалт хэв заншлыг шинэчилж өөрчлөхийг зорьсон.

Хутагт судлал сүүлийн хэдэн жилд нэлээд өргөжиж байна. Гэхдээ үүнийг шинжлэх ухаан талаас нь судлаасай гэж хүсэж байна. Жишээлбэл Пүрэвжав хутагт хатуу эдлэл, төмөр зүйлсийг зөөлөн дээс сур шиг хэрэглэдэг байсан хүн. Үүгээрээ их онцлог. Тэгэхлээр үүнийг яагаад ингэдэг байв гэж учир начрыг нь тодруулж судалвал их сонирхолтой.

САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ХОШУУЧ МЭРГЭН БЭЙСИЙН ХОШУУНЫ ЛАШИН ХУВИЛГААН АГВААНПРИНЛЭЙЖАМЦ

Ц. Лхагвасүрэн
Академич, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан

Лашин хувилгаан Агваанпринлэйжамц 1869 онд буюу шаргачин могой жил одоогийн Завхан аймгийн Отгон сумын нутаг Сүмбэр уулын “Нарийн” нэртэй аманд Цагаан гүртэнгийн 2-р хүү болон мэндэлжээ. Бага наснаасаа дуутын хүрээнд шавьлан сууж эрдэм номд боловсорчээ. 1909 онд XIII Далай ламаас “Хачинсамба” цол шагнагдсан. Тэрээр 1911 онд Шилүүстэй сумын мянган уулын энгэрт хоёр байшин 12 ламтай хурал хурж эхэлсэн бөгөөд 1916 онд Богд Жавзандамба хутагтад бараалхаж уг хийд “Дэчин Чойлон” хэмээн нэрлэгдэв. Улмаар 1917 онд Хайлан, Чоймприн, Нүннэй гэсэн 3 хурал нэмж байгуулж эдгээрийн дэгийг өөрөө удирдаж харуулсан байна. Лашин хувилгаан Агваанпринлэйжамц

Хан дөрвөн ууланд минь ертөнцийн наран саран өдөр бүр мандаг

Хатан туулын хөвөөнд хүжсийн үнэрт цэцэгс жил бүр дэлгэрэг

Гандирс бурхадын орон мэт энэ ариун газар

Гаслангуй суух жаргалыг хамаг амьтан эдлэн жаргах болтугай

хэмээн ерөөсөн Дөрвөн уулын сан, сэржим ерөөл, Отгон тэнгэр хайрхан буюу Богд Очирваанийн тахилгын судар болон тарнийн хураангуй, “Тод сарны гэрэл сургаалийн үгс” хэмээх төрт ёсны гурван боть ном, Монгол улсын олноо өргөгдсөн Богд Хааны түүх зэрэг

зохиол бүтээл туурвисан бөгөөд аман яриа, дурсамж зэрэгт таван боть номыг бүтээсэн хэмээн ярьдаг.

Архангай аймгийн Их Тамир сумын Хөх нуур багийн Шивэртийн голын эрэг дээр, Мандал уулын өвөрт Лашин хувилгаан бага дүү Цэмбэлийн хамт Шивэртийн дуганыг барьж байгуулсан бөгөөд энэ тухайд “Мандал уул нь отог жинстэй малгай шиг хэлбэртэй олон үеийн тахилгатай уул юм. Сорогзон модыг орлуулж хийсэн. Дуган нь Мандал уулын голыг гараад 400-500 метр газар “Мухар Шивэрт”-ийн дэнж дээр хоёр дуган байсан. Одоо хэдэн улаан чулуу байгаа. Энэ дуганыг Шивэртийн дуган хэмээн нэрлэдэг байсан. Хоёр унзад байдаг байсан нь нэг нь Цэмбэл ах, нөгөөх нь Жарантай ажаагийн хамаатны ах Гөлөгөө унзад хоёр. Дуган Хөх нуур багийн төвөөс жаахан өгсөөд хоёр гол нийлээд урд голын хөвөөнд Хөх нуур багийн төвөөс баруун урд 10 километрээс багагүй байх. Одоо улаан чулуугаар нь баримжаалж дуганыг нь төлөөлж болно. Өргөн нь 10 м, урт нь 15-20 м орчим хэмжээтэй. Дээвэр нь эр, эм модон ховилтой, модон өрөөтэй байсан. Хойт дуган нь арай бага байсан. Дүйнхорын ван хурдаг байсан. Унадаг ван гэдэг нь одоогийн Далай багшийн тавьдаг Дүйнхорын ван шүү дээ. Хуралд суусан хүн ном тарнийн хүчээр ухаан алдаж унадаг гэж ярьцгаадаг юм.”

Лашин хувилгаан цаг төрийн байдал эвгүйтсэний учир өөрийн нутаг усаа орхиж явах болсон байна. Энэ үеэс өмнөхөн нь нутаг усныхандаа нэгэн зүйлийг хэлж захижээ. Энэ нь дараах дөрвөн газрын нэрийг солих тухай юм байжээ. “Сэнжийн цохиог-Бунхан цохио гэе, Өргөн ширэгийг- Өргөн тохой, Сэрвэнгийн үзүүрийн нуурыг- Бадархундага, Доод түрүүн- Баян түрүү” хэмээж байгаарай хэмээн захижээ.

Шилүүстэй сумын харьяат Санж гэдэг хүний эхнэр 2011 онд 90 гаруй настайдаа бурхан болсон Маамаа /гуайлсан нэр/ нэгэн сонин түүхийг өгүүлсэн юм. Маамаа гуайг 1930-аад оны сүүлээр Өвөр голд зусаж байхад өглөө эрт зүүн хамар давж 3-4 үхэр тэрэгтэй, морь малтай нэлээд олон хүмүүс ирж мэнд усаа мэдэлцжээ. Тэд Архангай нутгаас явж байгаа хүмүүс ажээ. Ажиглаваас шарил ачиж яваа хүмүүс бололтой. Тэдгээр хүмүүс Маамаа гуайгаас “Бунхант-Цохио” гэж хаана вэ гэж асуужээ. Маамаа гуай тэднийг шарил ачиж явааг мэдээд аягүй бол энд хүн оршуулах нь гэж дотроо бодоод “Бунхант-Цохио” гэдэг уул бол Сэнжит цохио уулыг хэлж буй хэрэг хэмээн

бодож тэрхүү асуусан уулыг нь зааж өгөлгүй Мянган уулын өвөрт орших нэгэн уулыг чиглүүлж энэ бол “Бунхант-Цохио” хэмээн зааж өгчээ. Ингээд тэдгээр хүмүүс Маамаа гуайн зааж өгсөн уулын зүг үхэр тэрэг, ачаа бараагаа хөтөлсөөр хөдөлжээ. Удалгүй зааж өгсөн газарт нь бурхан болоочийг нутаглуулаад, ёс журмыг үйлдэн буцацгаажээ. Тэрхүү талийгаачийг нутаглуулсан газар нь “Их-Мянган”-ы өвөр буюу Андиа хувилгааны суварганаас баруут хойт талд нь ажээ. Талийгаачийг их ёс төртэйгөөр нутаглуулсан бололтой, хирэгсүүр маягийн чулуун тойрог бүхий тэмдэг тавьж ёсолсон нь одоо хирнээ уулын бэлээс нь харагддаг тухай Шилүүстэй нутгийн уугуул Төмөр гэдэг хүн ийнхүү өгүүлжээ.

Сайн ухаантан мэргэдийн хичээж бүтээсэн их хэргийг

Санаа муут хорон хүн нэгэн цагт эвдэх буй бүлгээ

Сар жил болтол шамдан хичээж ургуулсан тариаг

Салхит догшин мөндөр нэгэн агшинд товрог болгох мэт хэмээн шүлэглэсэн бичгийн их хүмүүн, Лашин хувилгаан Агваанпринлэйжамц 1936 оны үед буюу 67 орчим насныхаа сүүдэр зооглосон үед хилс хэргээр цаазлагджээ.

Монголчууд бид үүх түүх, удам угсаагаа тун тааруухан мэддэг юм байна. Хичээгээд долоон үеэ холбон бичиж эс чадсан болой. Нэгэн жишээг харуулбаас: 145 жилийн хоорондЛашин хувилгаан Агваанпринлэйжамцын удам угсааг үзүүлбэл:

Миний өндөр өвөө Ц. Агваанпринлэйжамц - 1869 онд төрсөн

Түүний хүү/ дүү С. Цэмбэл - 1899 онд төсөн

Түүний лхин Ц. Цэвэллхам -1938 онд төрсөн

Түүний хүү Ц. Лхагвасүрэн - 1954 онд төрсөн

Түүний хүүЛ. Мөнхтулга - 1976 онд төрсөн

Түүний охин М. Анужин - 2000 онд төрсөн бөгөөд удмын хэлхээг хавсралтад үзүүлэв.

САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ХОШУУЧ МЭРГЭН БЭЙСИЙН ХОШУУНЫ ЛАШИН ХУВИЛГААН АГВААНПРИНЛЭЙЖАМЦЫН СУДЛАГААНД

Ш. Сонинбаяр
Доктор (Ph.D), профессор, гавж

VIII Богдын дэлгэрэнгүй намтрыг зохиосон Лашин хувилгааны талаар эрдэм шинжилгээ судлагааны үүднээс анхлан мэдээлж бичсэн хүн бол хамба лам, номч мэргэн гавж С.Гомбожав юм. Номч мэргэн гавж С.Гомбожав 1959 онд нийтлүүлсэн "Сайн Ноён хан аймгийн Хошууч бэйсийн хошууны Лашин хувилгаан Агваанпринлэйжамц нь XX-р зууны үеийн хүн, зохиол нь таван боть, зан үйл намтрууд бичмэл" гэж мэдээлсэн байна. Үүнээс гадна түүхч Д.Дашбадрах "Монгол улсын олноо өргөгдсөн Богд хааны түүх" номынхоо оршилд Лашин хувилгааны намтар түүхэнд холбогдох архивын баримт сэлтийг эрэн сурвалжилж олсноо бичлээ.

Одоогоор Агваанпринлэйжамцын лавтай судласан мэдээ баримт хараахан гараагүй байна. Дуутын хүрээнд лам явсан Лувсансамбуу гуай 1986 онд Лашин хувилгааны тухай ярьсныг үндэслэн өгүүлье.

Лашин хувилгаан Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн бэйсийн хошууны нутаг Цагаан бургас гэдэг газар шаргачин могой жил (1869) мэндэлжээ. Энэ нь одоогийн Завхан аймгийн Отгон сумын нутаг юм^Ш Богд, Сайн ноён хан Намнансүрэн, Лашин хувилгаан нар чацуу могой жилтнүүд юм. Лашин хувилгааны эцэг нь Цагаан бөө гэдэг байсан бөгөөд ах нь Гончиг гүртэн гэж байв. Багад нь ном эрдэм зааж сургасан багш нь Осор хамба лам гэж байжээ. Бага наснаасаа лам болж Дуутын хүрээ буюу Сайн итгэмжит хийдэд сууж, сургуул ловнир хийгээд 20 орчим насандаа Дуутын хүрээний Дүйнхор дацангийн хамба лам болж байжээ. VIII Богдын номын багш ёнзин байсан Төвд лам Арибүрлгү Дуутын хүрээнд ирж уулзаад Төвдийн Радэн Доржчангийн хойд дүрийн Лашин хувилгаан гэж тодруулжээ. 1906 оны морин жил 13-р Далай лам Түвдэнжамцийг Заяын хүрээнд залрахад Лашин хувилгаан өөрийн бичсэн ном зохиолуудаа өргөсөнд ихэд таалж Ханчин ямба олгож хувилгаан болгож байжээ. Далай ламаас Мянган уулын энгэрт сүм барьж суу

гэсэн зарлигийн дагуу Отгонтэнгэр уулын өвөрт байх Мянган уулын энгэрт Дэчинчойлин буюу Мянганы хүрээг байгуулан тэнд суух болж Мянганы хувилгаан лам гэж нутаг хошуундаа алдаршсан байна. Лашин хувилгааны зохиосон таван боть номыг 13-р Далай лам аваад явсан гэдэг. 1911 онд VIII Богдыг хаан ширээнд залрах үед Лашин хувилгаан их хүрээнд ирж суун ном зохиол бичиж байжээ. Мөн 58 настайдаа Цэцэрлэг мандлын аймаг гэж байх үед Сайд вангийн хошуунд залагдан Их тамирын эхэнд сүм барин сууж байв. 61 настайдаа Шива ширээтийн хүрээт Дүйнхорын ван тавив. Лашин хувилгааныг 62 настай байхад нь 1930 онд баривчлан Заяын хүрээнд аваачин Ламзав гүн, Цэдэнбалжир маарамба нарын хамт цаазлан хороожээ.

Лашин хувилгаан Агваанпринлэйжамцын зохиосон 10-аад жижиг бичмэл номыг миний бие олж үзсэн билээ. Баянзүрх, Сонгинохайрхан уулын сан тахилга, Богдын хүрээний Дөрвөн уул гэж алдаршсан Баянзүрх, Богд хан уул, Сонгинохайрхан, Чингилтэй уулын сэржмийг зохиожээ. Чингилтэй уулын сэржмийн төгсгөлийн үгэнд “Далай ламын зарлигаар ханчен хэмээн дуудагдагч Раден Ян Гомбын хувилгааны нэрийг баригч их хамба Агваанпринлэйжамц” гэж нэрээ бичжээ. “Отгонтэнгэр ууланд сан тахилга өргөх ёс сайн буяны есөн хүслийн хурыг буулгагч” хэмээх зохиолын төгсгөлд Жид Шодын төрлийн хувилгаан нэрийг баригч их хамба Агваанпринлэйжамц” хэмээн бичсэн байна. “Шамбалын ерөөл”, “Ловон Бадамжунайн залбирал” зэрэг зохиолдоо Лигдэн Бадамгаравын хувилгаанд лүндэгнэсэн Жид Шодын дүрийн хувилгаан Мянганы нэрээр ихэд алдаршсан үйл ерөөлт, хамба хувилгаан Агваанпринлэйжамц, Тарнийг баригчдын адаг Бадамбазар буюу Мянган уулын Лашин Агваанпринлэйжамц гэх зэргээр нэр алдараа бичсэн байна.

Энд дурдсан зарим зохиолын төгсгөлийн үгнээс харахад Лашин хувилгаан нь Төвдийн Радэн хийдийн алдартай эрдэмтэн Ишдамбаравжаа ламын хойт дүр, Баруун Монголын эрдэмтэн лам Жид Шод Агваанданзанпринлэйн хойт дүр Мянганы лам болох нь тодорхой байна.

УЛИАСТАЙН САЙД ДИЛОВА ХУТАГТ ЖАМСРАНЖАВ

Г. Очирбат
Монгол улсын хөдөлмөрийн баатар,
философийн ухааны доктор (Ph.D)

Ар, Өвөр Монголд Диловын хувилгааны нийт таван дүр тодорсоны хамгийн сүүлчийн, хамгийн өндөр насалсан, нэн их бартаат бөгөөд түүхэн цадиг намтартай нь Жамсранжав хутагт юм.

Тэрбээр Буддагийн ухааныг нухацтай судлаж нэвтэрсэн, шарын шашны шүтлэг бишрэлдээ насан турш үнэнч байсан, жинхэнэ ариун хуврага хүн байжээ. Түүний амьдрал, үйл ажилпагааны ерөнхий зам мөрийг товч тоймлон өгүүлбээс: Дилова хутагт Жамсранжав бол Халхын арван гурван тамгатай хутагтуудын нэг Наробанчэнтай түшлэг зэрэгцэн тус шавийн хийдийн ширээт лам, Монголын өмнө болон Урианхайн хязгаарт Хатанбаатар Магсаржавын удирдсан цэргийг даасан лам, Улиастайн хамаарсан сайд, тус яамны туслах шийтгэх түшмэл, Өвөр Монголын Баруун Сөнөд хошуунд Халхаас дөрвөж очсон Монголчуудаар бүрдсэн шинэ хошууны засаг ноён , Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөний удирдагч Дэмчигдөнрөг ноёны зөвлөх, Чан Кай Шийн засгийн газрын Монгол-Төвдийн хорооны түшмэл, Америкийн индианы их сургуулийн Орон судлалын хөтөлбөрийн монгол хэл, нийгэм сулалын семинарын идэвхитэй гишүүн, Америк тив дэх Буддагийн анхны сүмийн тэргүүн лам тус тус байжээ.

Жамсранжав хутагт улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг сахин хамгаалахтай холбогдсон нэн их хариуцлага, нэн их хүнд хэцүү үүрэг даалгаврыг өвөрлөн 1931 оны эхээр нутгийнхаа хилийг давснаас хойш 18 жил орчим Өбfр Монгол, Хятад, Япон, Түвд, Энэтхэг зэрэр орноор хэрэн амьдарч, сүүлийн 16 жил орчмыг алс тэртээ Америкийн нэгдсэн Улсад өнгөрүүлж, 1965 онд тэндээ бие лагшин амрахын ёсыг үзүүлжээ.

1967 онд Гандан хийдийн хамба, ухаант хуврага Гомбожав гуай Дилова гэгээн Жамсранжавын чандарыг эх оронд нь залж авчраад өөрийн өргөөний бурханы дэргэд залсан байдаг.

1994 онд Жалханз хутагт Дамдинбазарыг мэндэлсний 120 жил, Дилова хутагт Жамсранжавын мэндэлсний 110 жилийн ойг анх удаагаа тэмдэглэх үед миний бие уг чандрыг Дилова хутагтын төрсөн нутаг хуучин хан-Тайшир уулын аймгийн Нөмрөг уулын хошууны Ойгон нуурын хойхно талд сүндэрлэх Баян-Айраг уулын өвөр энгэр, Түшлэгийн булаг хэмээх түүний эхийн хүйнээс тасарсан бууринд залж, хутагтын хол ойрын садан төрлүүд, нутгийн сүсэгтэн олон ёслол мөргөл үйлдсэн юм.

Дилова хутагт Жамсранжав 1921-1923 онуудад дундаа завсарлагатайгаар Улиастайд сайд, туслан шийтгэх түшмэлээр сонгогдон ажиллажээ. 1921 оны 8-р сард Жамсранжав хутагт Богдын зарлигаар Улиастайн сайдын яаманд туслан шийтгэх түшмэлээр томилогдож, Улиастайн сайд Цогтой Ван Дамдин-Абишатай хамтран хэрэг шийтгэж эхэлсэн байна.

Энэ үед Хатанбаатар Магсаржав цэрэгтэйгээ мөн Улиастай хотод ирж буудалласан байв. Энэ бол Засагт хан, Сайн ноён хан аймгийн хувьд үймээн самуунтай, улс орны амьдралд огцом өөрчлөлт гарч эхэлсэн цаг байв. Хятадын гамин цэргийн аюулаас дөнгөж ангижирсан боловч оросын цагаантны шинэ аюул нөмөрсөн тэднээс тус хязгаарын орныг цэвэрлэх тэмцэл эд өрнөж байлаа.

Ийм нөхцөлд яамны туслан шийтгэх түшмэлийн шинэ албанд томилогдсон Дилова хутагт Жамсранжав тус аймгийн бусад эрх баригчдын хамт засаг ханы хязгаарыг цагаан намынхнаас бүрэн цэвэрлэх, нутаг орныг амар түвшин болгох үйлсэд оролцож эхлэв. Улиастайн сайд бол Засагт хан, Сайн ноён хан хоёр аймгийн хэргийг эрхлэж, тэдгээрийн 47 хошуу шавьтай харилцдаг өргөн цар хүрээтэй ажил гүйцэтгэж байсан юм.

Төдийлөн удалгүй хамаарсан сайд Цогтой Ван Дамдин-Абиша өвчин сувилуулах чөлөө мэдүүлснийг Дээдэс ёсоор болгож, оронд нь Дилова хутагт Жамсранжавыг зарлигаар Улиастайн хамаарсан сайдаар томилжээ.

Дилова хутагт 1921 оны 10-р сарын 17-ноос тамга, хэргийг хүлээн авч, сайдын ажлаа эхлэв. Яг энэ үед Ардын засгийн газрын шийдвэрээр Хатанбаатар Магсаржав Ховд, Улаангомын хязгаарыг чөлөөлүүлэхээр мордуулах бүх цэргийг захирах их жанжны тушаалд томилогдон тамгыг хүлээн авсан байсан юм.

Засагт хан, Сайн ноён хан аймгуудын нутаг цагаантнаас үндсэндээ чөлөөлөгдсөн боловч зэргэлдээ Ховд, Дөрвөдийн хязгаарт үүрлэсэнцагаантныг зайлуулах шаардлага хурцаар тавигдсан байв.

Ховдын хязгаарыг чөлөөлөхөд сайд Дилова хутагтын үүрэг

Ингээд Упиастайн сайд, чуулган дарга нар Ховд, Упаангомын нутгаас цагаантныг үлдэн зайлуулах тэмцэлд туслах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах ажилд оржээ. Эхний ээлжинд өөрийн аймгаас цэрэг дайчилж тус хязгаар уруу мордуулах, тус аймгийг дайран Ховдын зүг явах Хатанбаатар Магсаржав, дэд жанжин Пунцаг нарын цэргүүдийн бүх бэлтгэлийг хангах талаар дараах ажлуудыг хийсэн байна.

1921 оны намрын адаг сараас Улиастайг дайрч явах 300 цэргийн хэрэгцээнд нэг удаа 40 гаруй гэр, гэр тутам хоёр галч, хүн бүрт 2 уяа мориор бодож 650 гаруй шилдэг агт морь, мах зэрэг хүнс, түлээ түлшийг хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэсэн байна. Баруун замын цэргүүдийн хэрэгцээнд нийлүүлсэн зүйлийг хошуудаар нь жагсааваас: Цэцэн сартуул хошуунаас ирэгхонь 100,12 хүн багтах гэр буюу их сайхан майхан 10. Үйзэн түшээ гүн Цэвэгжавын хошуунаас - ирэг хонь 50, мөн хэмжээний гэр буюу майхан 7, Дүүрэгч чин вангийн хошуунаас агт морь 78, ирэг хонь 400, Зоригт вангийн хошуунаас агт морь 50, монголын шар 7, Ачит вангийн хошуунаас агт морь 50, монголын шар 30, ирэг хонь 100, Ахай бэйл Цэдэндоржийн хошуунаас агт морь 60, монголын шар 20, Далай гүн Содномванчигийн хошуунаас агт морь 40, монголын шар 20, Ялгуусан хутагтын шавиас агт морь 20, монголын шар 8-ыг тус тус нийлүүлжээ. Тэдгээрийн гэр майхны ихэнхийг газрын ойрыг үзэж Дашпунцаглин хийдийн харьяат /одоогийн Алдархаан, Яруу сумын зарим хэсэг/ зургаан ангиас гаргасан байна (1).

Ингээд Хатанбаатар Магсаржав Улиастайд байгаа өөрийн харьяат цэргийн дотроос 500-г сонгон авч 1921 оны 10 сарын 27-нд Улиастайгаас Ховдын зүг дайлаар морджээ. Энэ үеэс Ховд, Улаангомын хязгаарт томилогдсон, их түшмэл Хасбаатар нар

Аптай давж ирсэн цагаан намын зэвсэглэсэн 2500 гаруй цэрэгг

хүч автагдаж өөрсдөө баривчлагдан онц хүнд байдалд орсон байсан учраас Хатанбаатар цэрэгтэйгээ ийнхүү яаралтай мордсон байна.

Төдийлөн удалгүй өвлийн дунд сарын аравдаар Ховдын хязгаар уруу явж буй дэд жанжин Пунцаг цэрэгтэйгээ Улиастайд ирээд гурав хоногийн дотор тэдний хэрэглэх уналга, хүнсний мал зэргийг бэлтгэж өг хэмээн шаарджээ. Сайд Дилова хутагт Пунцагтай уулзаж, түүнд учрыг тайлбарлан хэлсэн нь, Улиабтайн ойр орчмын хошуудаас бид өмнө их хэмжээгээр дайчилсан, гэтэл танай цэргүүд мөн тэр хошуудаас дур мэдэн аль олигтойг шууд хөөн авч дуусгасан тул холхон газраас зарлан авахад гурав байтугай арав хоногт ч амжуулахад бэрхшээлтэй гэж мэдэгдэхийн хамт, Хатанбаатар баруун хязгаарыг нэгэнц., төвшитгөж, цэрэг буцсаар арваад өдөр болж байна, иймд “Миний санах болбоос багаахан алгуурлаж, аажим болзоогоор зүй зохистойгоор аливааг бүтэмжтэй сайнаар бэлтгэвээс дутагдал гачигдалгүй болж, ард амьтан ч хилсдэж гаслахгүй мэт. Бид чухлыг саатуулахын учраар бус, зүйг бодож зөвлөж байна (2) гэхэд жанжин зөвшөөрч, Улиастайн сайдын яам түүнд Засагт ханы хошуу, Сайн ноён хан аймгийн далай Чойнхор вангийн хошуунаас нийт 800 агт морь зэрэг бусад шаардлагатай хүнсний зүйлийг бэлтгэн нийлүүлжээ.

Үүнээс гадна Ховд, Улаангомын хязгаар дахь Цагаантныг хүч хавсран устгах зорилгоор 1921 оны сүүлчээр орж ирэх Зөвлөлт Оросын 500-аад цэргийн хэрэгцээнд Засагт хан аймгаас агт морь 1000, амбан мар, сувай үнээ 300, тэдний орогнох майхан зэргийг бэлтгэх ажил эхэлжээ.

Ийнхүү хөрш Ховд, Дөрвөдийн хязгаар нутгийг цагаантны эзэрхэгчдээс ариутган цэвэрлэхэд Засагтхан, Сайн ноёнхан аймгийнхан бүх бололцоогоор тусалжээ. Эл эх оронч тэмцэлд идэвхтэй оролцож гавьяа байгуулсан Засагт хан аймгийн түшмэл цэрэг 40 гаруй хүнийг Богдын зарлигаар хөхүүлэн урамшуулсны дотор Засагт ханы хошууны Дамбасүрэнд дөтгөр зэрэг жинс, Дүүрэгч вангийн хошууны Тогтоход тогосын отго, Цогтой вангийн хошууны номч мэргэн Ари гэгээн Дамдинчогдонд цоржийн ямба тус тус шагнагджээ (3).

Ховд, Улаангомын хязгаарыг цагаантнаас чөлөөлөхтэй холбогдсон нөр их ажлын дараа улс орон, аймгийг сэргийлэн

хамгаалах шаардлага хэвээр байсан учраас цэрэг дайчлах, тэдний хэрэглээг хангах ажил үргэлжилсээр байв.

оны эцсээр Нийслэл хүрээний газарт цэргийн түлш, өвсний зэргийг зөөхөд тус аймгийн бараг бүх хошуу, шавиас бүрэн хэрэглэл бүхий 1000 тэмээг даамал хөтлийн хамт, мөн Дайчин ван Жалцангомбодоржийн зэрэг дөрвөн хошуунаас зуун агт морь тус тус дайчлан нийлүүлжээ.

оны эхээр Ардын засгийн газрын шийдвэрээр агт морь нэг бүрийг 15 лан мөнгөөр бодож 2000 агт худалдан авах ажлыг зохион байгуулсны дээр цэргийн хувцас хийхэд зориулсан 6000 ширхэг элдсэн нэхий, 8000 пүү мах бэлтгэн тушаажээ. 1921 оны намар Нийслэл хүрээний газраа хуралдуулан сурган боловсруулах цэргийн албанд 18-35 хүртэлх насны биед өвчингүй, эрүүл чийрэг сайныг сонгон 280 цэрэг татан илгээсний дотор Засагт ханы хошуунаас 40, Дүүрэгч вангийн хошуунаас 48 цэрэг тус тус оржээ.

Энэ бүхнийг эргэцүүлэн үзвээс, 1921 оны намар, өвлийн сард Упиастайн сайд Дилова хутагт, түүний толгойлсон яам, Засагт хан аймгийн чуулган гол анхаарлаа нутаг орноосоо цагааны үлдэгдлийг бүрмөсөн үлдэн зайлуулах, Ховдын хязгаарынхны цагаантай хийж байсан тэмцэлд цэрэг, түүний уналга, орон гэр майхан, хүнс хэрэглэлээр туслахад төвлөрүүлж, тэрхүү чухал үйл хэргийг сайн зохион байгуулж, амжилтгай гүйцэтгэсэн нь илт байгаа билээ.

Өртөөний албыг зохион байгуулсан нь

1921 оны сүүлч, 1922 оны эх гэхэд Ховд, Упаангомын хязгаарт үүрлэсэн цагаантныг арилган дуусгаж, нэгэнт амар тайван болсон учир ихэнх цэргүүдийг татан буулгаж буцахад тэднийг Засагт хан аймгийн нутгийг дайруулан хоёр чиглэлээр өртөөлөн буцаах болжээ. Үүний тул өртөөдийг зузаатгах, шинэ суман өртөө байгуулах их ажил гарсан байна.

Тэдгээр цэргийн нэг хэсгийг Хар ус-Улиастай-Байдрагийн чиглэлийн суурин өртөөдийг зузаатгал хийн өнгөрөөв. Нөгөө зүүн зүгийн хошуудын цэргийг Алдар, Хэрсэн, Байц, Нуурмаг, Ангирт, Шивэрт, Цагаан чулуут, бичгийн суман Цэнхэр болон цаашаа Хатгал

зүгийн гурван сумангаар Жалханз хутагтын хүрээ хүртэл явуулж, эдгээр өртөө сумангийн суурь тутам сул морь 80, морьтой улаач 20, шүүсхүнсний ирэгхонь 10-ыг Дашпунцаглин хийдийн зургаан анги, Сэцэн чин вангийн хошуу, Цогтой вангийн хошуу, Ялгуусан хутагтын шавь, Дүүрэгч вангийн хошуу, Жалханз хутагтын шавь, Сайн ноён хан аймгийн бэйс Бирваарагчаагийн хошуунаас тус тус дайчлан гаргасан байна. Энэ үед өртөөд, сумд нөр их ачаалал үүрч, өдөр шөнө, нойр хоолыг мэдэхгүй зүтгэн, онцгой ядарч сульдсан нь илэрхий билээ.

Тус аймгийн нутаг дундуур дайрсан төв замын суурин өртөөд, Улиастайн цоохор өртөө, Упиастай-хошуу, шавийн хоорондын суман өртөөд Цагаан цэргийн хөл үймээнд хохирч сүйрсэн учраас эдгээр өртөө, сумангийн албыг хэвийн залгуулахад нэмэлт бэрхшээл учирч, газар газраас өртөөний албыг дагнах буюу ацаглах хүч чадалгүй болсноо илтгэж, хөнгөлүүлэх санал шаардлага цөөнгүй гарах болжээ.

Сайд Дилова хутагт энэ тухайд улсын чухал албыг тасалдуулахгүй байлгахын тулд байгаа бололцоогоо шавхан өртөө, суманг зохих ёсоор ажиллуулах шийдвэр гаргасан байв. Үнэхээр аргагүйдсэн зарим нэг хошууны оногдсон өртөөний албыг арай дөнгүүр хошуунд нь тэгшитгэн шилжүүлэх замаар нэг удаа хөнгөлөх зэрэг арга хэмжээ авч байсан байна.

Өртөөний албыг саатуулсан тухай сайд Дилова хутагт Засагт хан аймгийн чуулган даргад 1921 оны 12 сард илгээсэн нэгэн бичигтээ “энэ мэт цэрэг хэрэглэж байлдан дайтаж бүхий түгшүүртэй тухайг цөм үзэж мэдсээр бөгөөд тушаасныг дагаж тасалдсан суман өрхүүдийг даруй дээр залгамжпан тавихгүй элдэв түргэн чухал цэргийн хэргийг саатуулахад хүргэсэн нь үнэхээр санаснаас ангид болжээ» (4) хэмээгээд харьяат хошуудаас холбогдох газрын өртөөдийн алба хаах өрхүүдийг яаралтай гаргаж нийлүүлэхийг тушаасан байна. Улиастайн сайдын яамнаас удирдан дайн самууны тэр хүнд үед өртөөний албыг ийнхүү цаг хугацаанд ямар ч саадгүй шуурхай залгуулж чадсан байна.

Цагаантны тарьсан гай гамшиг

1921 оны сүүлч, 1922 оны эхээр Упиастайн сайдын яамнаас цагаантны учруулсан хор хохирлын талаар Засагт хан аймгийн бүх хошуу, шавь бүрээр нарийн бүртгэл хийлгэжээ. Бароны цэргүүдийн уршгаар тус аймаг үлэмж хэмжээний зардал гаргасны дээр хүн ам нь тэдний дээрэмчдэд алагдаж таалагдан онц хүнд хэлмэгдсэн билээ. Ийм баримт олон. Энд зөвхөн нэг, хоёрыг дурдая.

1921 оны 8 сард 50 гаруй цагаан орос цэрэг Батар вангийн хүрээний хавь ойрын хүмүүс ба хүрээ хийдийн лам, жасааны түшмэл, бичээч нарыг хорин хашиж, дуган, гэр, хашаа байшинг эвдэж, элдэв юмы нь цөлбөн авсаар буйд мөн сарын 31-нд зүүн зүгээс зэвсэгтэй ба эм хөвгүүд нийлсэн 300 орчим оросууд ирж, улмаар халдан зовоож хашсан хүмүүсээс лам хар олныг анги хуваан мордуулж, нутгийн доторхи малыг цөлбөн авахуулж,тэднийг мал авчрахгүй буюу буцаж ирэхгүй бол дашсан хүмүүсийг цөмийг ална хэмээн айлгасаар зүйл бүрийн малыг дуусган аваад 9 сарын 5-6-нд хүрээ, хөдөө, энд тэнд ил далд алсан лам хар, эр эм хөвүүд 70 гаруй болжээ.

Тэдгээрийн дотор жасаанд сууж байсан мэйрэн Довчин, хурлын тушаалтай лам хэд хэд алагджээ. Одоо үхсэн амьдыг мэдэхгүй ойр хавиас зугтаасан хүн 40 гаруй, бас амь зайлж, гэр орноо орхиж, хаашаа явсан, үхсэн амьд нь мэдэгдэхгүй байгаагийн дээр “нутгийн уул ус эзэнгүй болж, олдсон цөөхөн хүн буй боловч хөрөнгө хогшилгүй болсон ба харьяат засгийн тамгыг хэдэн муу адууны ортой авч хаданд хоргодсоор буй билэз Одоо орон дацан ба шашны хурал ном тасарч яахин хүмүүжих аргагүй болов” хэмээн бүртгэгджээ.

Сайд Дилова хутагт хохирсон өөр нэг хошууны тухай Засгийн газарт 1922 оны 2-р сарын 10-нд илгээсэн бичигтээ: “Сайн Ноён хан аймгийн Хошууч мэргэн бэйл Дашзэвэгийн хошуунд 1921 онд цагаан самуун, цагаан цэргийн хэрэгт онц хэлмэгдэн хөрөнгө чинээ мохсон бөгөөд Упиастай хот хэмээгч угаас энэ хошууны нутагт нэн ойр нь түүний зүг бүрт чухал судал нэвтрээд эдүгээгийн элдэв самуун түргэн түүхий цагт албан, амин, алгуур түргэн аливаа зүйлээр хөдлөх бүр бусдаас хэтэрхий тохиолдож хэлмэгдэх, чирэгдэх, чармайх байдал дүрс үнэхээрийн үнэн, одоо ч тийнхүү үлэмжхэн мохож буй нь үнэнтэй хэмээвэл болно» гэж тус хошууны байдлыг тун нухацтай тодорхойлсон байна.

Цагаан самууны үед учруулсан хохирлыг хошуу, шавь бүрээр ийнхүү тодорхой бүртгэж тогтоосон нь аймгийн хэмжээний албан татвар, өртөө улаа зэрэг албыг цаашид зохион байгуулж зохицуулахад чухал үндэслэл баримжаа болжээ.

Хууль ёсыг сахиулах үйл ажиллагаа

Упиастайн сайдын яам цагийн самуунаас үүдэлтэй дээрэм, хулгай, өр авлагын хэргийг барагдуулах талаар ихээхэн анхаарал тавьж ажилласан байдаг юм. Хошуу, шавийн хэмжээнд шийдэх эрх мэдэл хүрэхгүй энэ төрлийн олон хэрэг Улиастайн сайд, аймгийн чуулган даргын газарт тасралтгүй ирж байсны заримаас дурдая. Жишээ нь, 1921 оны 11 сарын үед Цогтой вангийн хошууны нутаг Цоргын голд буй Оросын хашаа байшинг сахиж байсан Лут- Очирыг Хатгалын газраас гарсан хэмээх 200-аад цэрэг гэнэт хашгиралдан дайрч, оросын хашаа байшинг эвдэж, эд юмыг авч эвдэж үрэгдүүлсэн хэрэг гарсан байна. Уул цэргүүд сайд Хатанбаатарын харьяанд очихоор яваа учраас энэ тухай түүнд бичгээр мэдэгдэн, түүгээр байцаан шалгаж шийтгэхийг хүсчээ.

Мөн Улиастай болон харьяат хошуудад суурин байгаа хятадын худалдааны пүүсүүд ба монголчуудын хооронд өр авлагатай холбогдсон хэрэг цөөнгүй гарсан байдаг. Жишээ нь тэдгээр хятад худалдаачидтай гэрээ хэлцэл хийж, Улиастай-Нийслэл хүрээ болон Жанчхүү, Хаалган зэрэг газрын хооронд ачаа бараа тээхээр явсан Засагт хан, Сайн ноён хан, Түшээт хан аймгуудын зарим монгол хүмүүс тэр чигээрээ сураггүй алга болж, хятад худалдаачдыг хохироов, мөн тэднээс бараа юм зээлээр аваад тохирсон хугацаанд өгөхгүй байгаа хэмээсэн гомдол удаа дараа гарчээ. Энэ тухайд Упиастайн сайдаас холбогдох аймаг, хошуудын эрх баригчдад хэрэг явдлын учир холбогдлыг тайлбарлаж, хууль ёс сахихыг анхааруулсан бичиг явуулж гомдлыг барагдуулах арга хэмжээ авчээ.

Сайд эдгээр бичигтээ: “Цагийн самууныг далимдуулан завшин шингээхийг оролдож үл болно. Энэ бол эрхгүй гадаад улсын худалдааны хүмүүсийн ачаа жингийн хэдэн зуун түмэн лангийн юмын үлэмжид холбогдсон хэрэг, үнэхээр шудрагыг барьж чангалан

шаардаж шийтгэхгүй болбоос улсын ёсонд холбогдсон газар буй. Ийнхүү омтгойдон үзэж алгуурлан удааж, удтал хохируулахын туйлд хүрсэн нь үнэхээр үл нийлэлцэнэ” хэмээн цохон зааснаас үзэхэд сайд Дилова хутагт ямарваа үед монгол хүн хууль цаазыг сахиж, ёс журмыг баримтлан улсын нэр төрийг гутаахгүйг ямагт эрхэмлэх ёстойг нийтэд зарлан ухуулсан нь буй.

Оросын харьяат хүмүүстэй холбогдсон зарим нэг асуудал гарчээ. Упиастайд цагаан оросын үлдэгдэл мөн эсэхийг мэдэхэд төвөгтэй зарим оросууд энд тэндээс баригдах буюу өөрсдөө хүрч ирэх болсон байна. Харин тэдэнд болгоомжтой хандах шаардлагатай болсон байна. Энэ нь Баруун хязгаарыг илбэн тохижуулах сайд Жалханз хутагт Дамдинбазарын заавартай холбоотой байв.

Жалханз бээр Упиастайн сайд Дилова хутагтад энэ асуудлаар бичиг ирүүлсэнд: Хатгалд суугаа орос түшмэл Омидовоос “Монгол газарт хуучин суурин байсан ба цагаантнаас зугатсан оросуудыг бариад цагаан буюу зүгээрийг ялгаварлан мэдэхгүй шууд алж байна” гэсэн (8) мэдээлэл ирснийг тэмдэглээд “Одоо Монгол газраа суусан, эсвэл цагаантнаас явагчдын үнэн худпыг олж шүүхийн тулд Зөвлөлт Оросын цэргийн газарт (тухайн үед Зөвлөлт оросын цэргийн ангиХатгал ба Жалханзын хүрээнд байсныг хэлж байна. Г.О) тушааж байх, үүнээс хойш орос хүнийг зүй зохисгүй омтхойдон алж үл болохыг нийтэд ухуулан зарлахыг даалгажээ.

Ингээд Оросын харьяат нартай эл тушаалыг баримтлан харилцаж байх явцад тусгайлан анхаарч лавшруулан авч үзмээр явдал ажиглагдсан байна. 1921 оны намар өвлийн цаг Засагт хан, Сайн ноён хан, Ховдын хязгаараас цагаантанд дайчлагдан хэлмэгдсэн, нөхөр, эхнэрээ алуулсан, эд юмаа алдаж хохирсон гэх гомдол хэлсэн арав гаруй орос нэг, хоёроороо хүргэгдэн ирж тэдний дээрх тушаалын дагуу Хатгал болон Жалханзын хүрээний газарт тусгай элчид харгалзуулан хүргүүлж байх явцад тэдний зарим нь үнэхээр монголчуудад хорссон гомдсон үг яриа цухалзуулж байсан ажээ. Энэ байдлын талаар сайд Дилова хутагтаасЛ Төв засгийн газрын тэргүүн сайдуудад захидал бичиж өөрийн санал бодлоо толилуулжээ. Уг захидалд “Эдний уг явдал үнэн ташаа, санаа үзэл чухам юу атугай эчнээ учрыг барьж тэрхүү цагаан намын монгол газарт байсан үлдэгдэл этгээдийг ялгаж түр хэдэн жил Монголын хязгаарт эс оруулан тогтнуулбаас одоо цагийн бэрхэд ... аль ч

этгээдэд их л завшаан буян болох болов уу хэмээн санана”, “Ховдын орчим газарт үлдээж байцаан тушаахыг хүлээлгэсэн баахан орос буйг эрхтнээс элдвийг идэвхийлж уул нутагт буцааваас тэрхүү газар орон нь ариун амар болох төдийгүй, сэжиг таавар сүлбэлдэх нягших явдал ч шууд устна хэмээн дэмий санахаа саваагүй хамтаар илтгэн эрхэм сайдуудад тал дотуур яаран толилуулав. Үүнийг нэвтэрхийлэн толилоод хянан тогтоож хариу сургахыг” хүсчээ.

Сайд хутагт энэхүү захидалдаа цагаан цэргүүдийн хөлд хэлмэгдэж хохирсон зарим нутагт цагаан мөн эсэхийг ялгахгүйгээр орос хүнийг шууд алсан буюу эд юмыг нь тоножь дээрэмдэх явдал мэр сэр гарч, үүний улмаас монгол, орос хүмүүсийн хооронд үл итгэх, хардах сэрдэх байдал мэдэгдэх болсон учраас үлдэгдэл оросуудыг нутагт нь шууд буцааж, хэсэг хугацаанд тэднийг Монголд оруулахгүй байвал аль аль талдаа ач тус болно гэсэн санааг ийнхүү тавьжээ.

Энэ бол цаад утгаараа шинэ нөхцөлд дөнгөж эхлэл нь тавигдаж байсан Монгол, Зөвлөлт оросын харилцааны хувь заяаь, ирээдүйг давхар бодсон хутагт хүний ухаалаг байр суурь байжээ хэмээн бодогдном.

Сайд хутагт ба төрийн хүний ёс суртахуун, нийгмийн дэг журмын асуудал

Дилова хутагт Жамсранжав энэ асуудлаар ямар байр суурьтай байсныг харуулах хоёр баримт дурдая.

Нэгдүгээр баримт бол Улиастайн сайд Дилова хутагт Жамсранжаваас төв засгийн газарт өргөн барьсан бичиг юм. Түүнд өгүүлснээр Ховд, Улаангомын хязгаарт томилогдон ажилласан бүрэн эрхт төлөөний их түшмэл Дамбадорж дагалдагсдын хамт Ховдоос гарч 1921 оны 12 дугаар сарын эхээр Улиастайг дайран өнгөрөхдөө түүнд урьдчилан бэлтгүүлсэн Да- Шинкугийн пүүсний буудалд буухад нь хамаарсан сайд Дилова хутагтаас халх монголчуудын хоорондын ёсоор угтаж амрыг эрэн хадаг бариулахаар яамны түшмэл, гүнгийн зэрэг тайж Зэдбадар, дэд зэрэг түшмэл Цогтбазар, дүдгэр зэрэг түшмэл Намжилжав нарыг зарж илгээжээ.

Тэд шөнийн цаг эргэж ирж хэлэхдээ: тушаасан ёсоор бид Дамбадоржийн амрыг эрэн хадгийг барьтал тэрхүү түшмэл ихэд хилэгнэж хадгийг гэдрэг эргүүлэн хаяж, танай сайд түшмэл нар юун учирт миний гэр хэрэглэлийг бэлдэхгүй, орж ирэхэд аяга ч хар цайгүй болгов хэмээн агсархийлэн аашилж, түүнээс энэ Улиастайд ирсэн баруун хязгаарын газраа дайлж одох жанжин цэргүүдийн агт морь хэрэглэл зүйлийг нийлүүлж өгч явуулахгүй юунд саатуулав. Эвлэлийн үүр нээхээр ирсэн Өлзийханд нарын энэ гурван түшмэлийн үүр нээх хэргийг юун учир мөчөөрхөн саатуулав, та нар энэ Монгол ардын ёсонд нийлсэн хүн мөн үү, бус уу, буудаж алсугай хэмээн даруй бууг гарган чиглүүлж завдахад бидний өчүүхэн түшмэл нар даруй зүрх хагарах мэт болж, юуны урьд амьд хэлтрэхийг эрж айн чичирсээр уг учрыг гаргаж бүгдээр мөргөцгөөсөн боловч шууд бидний гурван түшмэлийн отгыг хураан, гэзгийг хайчлан авч орхиод мөнхүү пүүсний үүднээ дараалан хэвтүүлж түлээний модоор заримыг нь нэг, заримыг хоёр зуунд хүргүүлэн хүндээр занчиж, түүний хойно эднийг дараа арван хоёр цагт буудаж алья хэмээн харьяат дагалдсан орос цэргүүдэд тушаал өгч түр хадгалуулаад дагалдаагаар тавьж илгээв хэмээн бүгдээр цусыг цувруулан бөгцийн мөлхөж хэлж иржээ. Маргааш өглөө нь сайд Дилова хутагт бээр тэрхүү түшмэл Дамбадорж лугаа биеэр учирч тэр хэдэн зүйл хэргийн учир төлөвийг товчоор гаргаж хэлэхдээ:

Түшмэл Дамбадоржийн түүний гэр хэрэглэл, идэх уухыг бэлдсэнгүй хэмээсэн нэгэн зүйл болбоос харьяат яамнаа угаас бэлдсэн гэр хэрэглэл дутуу турхан, бас ч цагаан оросын муу хулгай нарт тохиолдож хотын дотор гадна орчим тойронгийн хятад, монгол бүгдээр албан амины орон гэр сав хэрэглэлийг алдагдаж сүйдсэн буснисан, хамаарсан дэд жанжны хэдэн зуун цэргийн гэр хэрэглэлийг дайчлан нийлүүлсээр нэгэнтдав дув олдох газаргүй болсны дээр хэдүйнээ жилээс янагш энэ мэт харьяат хотны газраар нааш цааш дайран ирэх их бага сайдууд түшмэд, ард нарын зэрэг аливаа албаны хүний гэр хэрэглэл шүүс хүнсний зүйлийг цөм энэхүү аймаг хошуудын албан түнш хэмээх Да-Шинхүү пүүснээс нийлүүлгэж үнэ хөлсийг жич шийтгэн олгуулсаар ирсэн хуучин удаа бүхий учир тийнхүү хэргийн ёсоор харьяат пүүснээ тушааж тухайд нэгэнт нийлүүлсэн нийлүүлгэсэн ийм хэрэг буюу.

Жанжин цэргүүдийн хэрэглэлийг саатуулав хэмээсэн нэгэн зүйл

болбоос түүний уг хэрэглэвээс зохих морь мал хэрэглэл зүйлийг манай сайдын газраас бичиг хүлээн авсаар харьяат баруун хоёр аймагт хуваан гаргаж өдөр хугацаж довтолгон тушаагаад бас дагалдангаар харьяат Чуулганы дарга нарт дахин давтан шаардаж, өдөр шөнөгүй бичиг довтолгон тушаасаар, мөн ойрыг үзэж шууд дайчлан хөөж нийлүүлсээр байсан нь эгнэгт манай сайдын газраа саатуулсан газар үгүй болой.

Гурван түшмэлийн үүр нээх хэргийг мөчөөрхөн саатуулав хэмээсэн нэгэн зүйл болбоос эдний уг барьж ирсэн бичгийн үг түшмэл Дамбадоржийн газраа одох нь бөгөөд тэрхүү түшмэл Өлзийханд нарын хэлсэн үг: баруун хязгаарт түгшүүртэй чимээ буй тул эдүгээ бид нар Дамбадоржийн газраа одохыг байвай, харин одоо энэхүү Улиастайд эвлэлийн үүр нээсүгэй хэмээн хэлсэн нь хэдүй харьяат түшмэл нарын үгийг баримтлах хэмээвч хойч өдөр омтхойдох, цүлийдэх /хэнэггүйтэх/ газар байх эсэхийг хянаж түшмэл Өлзийханд нар лугаа харилцан тайлбарлан хэлэлцэж байтал тавтайяа түшмэл Дамбадоржийн бие янагш өртөөлөн ирэхээр бичиг хүрч ирсэн учир, тэр харин ч бүрэн төгөлдөр эрхт түшмэл тул одоо түүн лүгээ зөвлөж нээж Щийтгэе хэмээн бүгдээр хэлэлцэж тэдний бие мөн Да-Шинхүү пүүснээ сууж түр хүлгэлзсэн төдий хэрэг бөгөөд дагалдаагаар түшмэл Дамбадоржийн бие ирсэн учир эдүгээ үүрийг нээсүгэй хэмээсэн болой хэмээн учирлан тайлбарлажээ. Хамаарсан сайд Дилова хутагт эл болсон явдал бол төрийн албаны ёс зүй дэг журамд холбогдох ноцтой зүйл хэмээн үзэж, Монгол ардын Засгийн газрын Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа өргөн толилуулж бичихдээ: Өлзийханд нараас түшмэл Дамбадорж лугаа хэлэлцэж энэ үүр нээхийг түдгэлзэж дараа ирж нээхээр тогтов хэмээн хуудас бичиг өгч мөнхүү түшмэл Дамбадоржийн хамт хойш буцсан явдал буюу. Эдүгээ, үүнд дээш эл гурван зүйл болбоос түшмэл Дамбадорж гагцхүү түүний биеийн учир бодож битүүгээр энэхэн тэрхэнд хилэн төрсөндөө ийнхүү манай хамаарсан сайд, харьяат яамны түшмэл нарыг дэмий зүйл зүйлээр өө сэв эрэлхийлэн хоосон их үгээр холбогдуулан алах жанчих сүрээр түүний дотроо санасан хорсголыг тайтгаруулсугай хэмээсэн хэрэг илэрхий болой. Эдүгээ үүн, хэдүй харьяат яамны хөгшин хөвөө олон түшмэл нарын бие арайхан хувь зохиолоор алдагдсангүй амьд төдий гарсан боловч гагцхүү Дамбадорж зүй нь

өөрөө өршөөл журмыг барьж харгис эзэрхгийг халж олны сэтгэлийг удирдан явсан эл газарт үлгэр дүр болговоос зохих түшмэл хүн бөгөөд жич харин энэ мэт харгис дүрсгүйгээр дарлан явж хязгаарын газраа олны сэтгэлийг хэртхийн цочруулахад хүргүүлсэн нь их л харамсалтай газар буй болов уу хэмээх бөгөөд энэ хэрэг хойч өдөр дэмий зүг зүгээр дуурайн явж ахин ахисаар үнэхээр юунд хүрэхийг даруй болзошгүй тул хэрхэн цаазыг тодорхойлж, хойчийг цээрлүүлэх явдлыг олдвоос Дотоод яамнаа мэдүүлэн явуулаад даруй нэвтэрхийлэн толилж заалхийлэн шийтгэж журамлан дагаж явуулахыг гуйв” гэсэн байна.

Дилова хутагт энэхүү бичигтээ, төрийн хүний ёс журмын асуудлыг цохон зааж, тэр үед цухалзаж байсан хувьсгалчирхан бардамнах явдлыг зориуд анхааруулан, тэр үзэгдэл бол харгис бурангуйг хална гэсэн Ардын нам, Засгийн зорилго бодлогод харш гэдгийг тэртээ 1921 онд ийнхүү шудрагаар шүүмжилсэн нь төлөөний их түшмэл Дамбадоржид төдийгүй, төрийн эрх мэдлийг дөнгөж аваад байсан нам, төрийн шинэ удирдагчдад зохих сургамж сануулга болсон байж болох юм.

Хоёр дахь баримт бол ёс журам сахихыг ухуулсан тухай юм.

Сайд Жамсранжав 1921 оны 11 дүгээр сарын 28-нд хүн ардын ёс, зөв ёс суртахууны тухай тусгайлан ухуулах бичиг гаргаж, Улиастайн гудамж, зах зээлийн газарт наалдуулсан нь буй. Тэрхүү бичигт, урьд одоо удаа дараа буулгасан дээд зарлигийг хүндэтгэж, хичээнгүйлэн дагаж, аливаа монголчууд үүнээс урагш золиг монид хэмээх зэрэг зүйл бүрийн муу хараал хараах, даалуу хөзрийн зэрэг өлзий бусын наадам наадах, архи ууж, хар тамхи татах, нуруу үүрэх ба энгийн лам нар эмс охид лугаа хольцолдон самуурах, жич харчууд ба эмс охид шард багтах өнгийн эд өмсөх хэрэглэх, бас толгойгоо ороох зэргийг цөм зогсоон, үүрд чангалан цаазалж нийтээр зарлан дагаж явуулахаар ухуулан тушаасан нь ер цөөнгүй бөлгөө. Ойрноос хааяа зарим нэгэн ухваргүй, үл өөдлөх түшмэл, ард нар эдгээр цаазалсан зүйлийг зөрчин ялангуяа дураар архи ууж, самууран явагчид үзэгдэж бүхий нь их төлөв олон харьяат захирагсдын осол сул захирч, омтгой хуумгайгаар өнгөрүүлснээс үүдэж, ийнхүү дахин цалгардан явахад хүрсэн болохын тулд одоо дахин чангалан ухуулах бичиг гаргаж зах зээлд өлгөж үзүүлэн тараав. Эдүгээ үүнээс урагш эдгээр цаазалсан зүйлүүдийг

эрхгүй тус тус даган нэн гүнээ тэвчин цээрлэж үүрд хичээнгүйлэн дагаж явагтун. Хэрэв зөрчин халдагчид байваас хэрхэвч уучлан хэлтрүүлэхгүй, харьяат захирагсдын хамтаар ялган салгаж маш чангалан залхаан, хэн тохиолдсон этгээд даруй байцаан шийтгэж цээрлэл үзүүлэн дагаж явуулья. Үүнийг басхүү харьяат хотын худалдааны иргэдийн хурлын дарга нарт ухуулан дэмий дураар ашгийг хичээн архи дамжуулан худалдан өгөхийг чанга цаазалья. Бүү зөрчин халдтугай” (12) гэжээ. Энэ мэтээр Дилова хутагтнаас үймээн самуун, амар тайван аль ч цагт монголчууд уламжпалт ёс заншлаа алдахгүй, ёс төрхтэй байх учиртайг ийнхүү дахин дахин сануулж сэнхрүүлж байсан нь сургамжтай хэвээр байгаа билээ.

Улиастай сайд Дилова хутагт Жамсранжавын олон талт үйл ажиллагааг тоймлон товч өгүүлэхэд ийм байна.

Зориуд тэмдэглэхэд, эл өгүүлэлд сайд Дилова хутагтын 1923 онд хоёрдахь удаагаа Упиастайн хамаарсан сайдаар томилогдон ажилласан тухай болон 1922 оны эцэс 1923 оны эхэнд Засагт хан аймгийн өмнөд хилээр байнга аюул занал учруулж байсан Жаа лам хэмээх Дамбийжанцанг устгах арга ухааныг сүвэгчилж хэрэгжүүлэхэд Упиастайн сайд Ламжавын төлөөний түшмэлээр томилогдон ажиллаж чухал үүрэг гүйцэтгэсэн тухай тус тус ороогүй бөгөөд тэдгээр нь жич яригдах сэдвүүд юм.

Дилова хутагт биеийн хууч өвчин хөдөлж чухал алба хашихад хүндрэл учирч буй зэрэг шалтгаан буйгаа дурьдаж хоёр удаа Засгийн газарт хамаарсан сайдын тушаалаас чөлөө гуйж бичиг өргөсөн бөгөөд түүний сүүлчийн хүсэлтийг ёсоор болгож оронд нь Улиастайн сайдаар гүн Ламжавыг томилжээ.

Төгсгөлд нь Монголын төр, шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт болон ардын шинэ төр засгаас Улиастайн сайд Дилова хутагт Жамсранжавын үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт дүгнэлтийг толилуулбаас: 1922 оны 9 сарын 17-нд Дотоод, Цэрэг хоёр яаман хамт нийлж, баруун хязгаарын сайд жанжин Хатанбаатар дархан ван Магсаржав нараас өргөн мэдүүлсний дагуу Богд хаан гэгээнтнээ нугалбар бичиж айлгасан бичигт: Улиастайн хамаарсан сайд Дилова хутагтан болбоос уржнан жилээс янагш улс төрийн тухай гүн номыг уншиж, өөрийн биеэр албан элдэвт гүн бодлого мэргэн онолыг илтгэн явсан бөгөөд ноднин жил зуны цагаас эхлэн

улс төрийн ба олон цэргийг даатгаж харгис дайсны омог зүрхийг шантруулан бууруулах авралын ном гүрмийг удаа дараа ихэд дөвлүүлэн, басхүү манай сайдын газраас цаг тухайд нийлүүлэн тушааснаар цэрэг ангийг татан дайчлан авч харгис дайсныг тосон сэргийлүүлж цэргүүдийг захируулан суулгаж газар орныг батлан хамгаалуулсны дээр дараа намар цаг Улиастайн сайдын тамга хэргийг хамааран хэрэг шийтгэснээс эхлэн эдүгээ хүртэл манай хязгаарын сайд жанжин нарын цэргийн элдэв хэрэглэхүүнийг чин үнэнхүүгээс чармайн зүтгэж зохих газруудаас удаа дараа шаардан нийлүүлсэн бөгөөд үүнд бидний сайд жанжин нар хянаваас энэхүү сайд хутагтын ийнхүү шашин төрийн хэрэгт хослон урьдаас одоо хүртэл ил далд хүчин тусалж зүтгэсэн нь үнэхээр хэтэрхий сайшаалтайн тул онц нэмэн хөхүүлж айлдах ажаамуу хэмээн толилуулж Богд хан бээр Улиастайн хамаарсан сайд Дилова хутагт Жамсранжавт Самади багш цол өргөмжпөх зарлиг гаргасан байна.

Дилова хутагт Жамсранжав бол хуучин төр шинэ төрөөр солигдох зааг мөчид монгол түмэн Бароны цагаантнаас ангижран улс орноо тусгаар тогтнуулан төвхнүүлэхийн төлөө ид тэмцэж байсан тэрхүү ороо бусгаа үед Засагт хан, Сайн ноён хан аймгуудыг дэвшлийн шинэ замд зөв хөтлөн оруулахад гарамгай гавьяа байгуулсан шашин төрийн мартагдашгүй зүтгэлтэн мөн буюу.

Улиастайн сайд Дилова хутагтын ухаалаг бодлого, өндөр нэр хүндийн ачаар эдгээр бүс нутагт шинэ төрийн үндэсний ардчилсан үзэл санааны дагуу дайн самууны шархаа илаашруулан, аж байдал, шашин соёлынхоо үйлсийг урагшлуулан хөгжүүлэх бодитой зөв суурь тавигдсан болно.

ДИЛОВА ХУТАГТ БОЛОН ӨРНӨДИЙНХӨН

С. Дулам
Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, доктор, профессор

Бусад хутагт хувилгаадын намтрыг бодвол Дилова хутагтын намтар илүү тодорхой, орчин үеийн хүнд ойлгомжтой байдаг нь түүний өөрийн бичсэн улс төрийн намтар, бусад гадаад, дотоодын хүмүүсийн олон арван дурсамжтай холбоотой. Дилова хутагтын намтрын нэг сонин содон тал нь эх орноосоо явахын өмнө ч гэсэн гадаадынхан, тэр дундаа өрнөдийн хүмүүстэй найрсаг сайхан харилцаа холбоотой байж, тэдний анхаарлыг татаж, сэтгэлд нь нийцсэн тохиолдол хэд хэд байна. Өрнөдийнхнөөс бараг анх удаа хутагттай уулзсан хүн бол Германы жуулчин Херманн Констен (Негтапп Сопз1еп 1878-1957) болно. Дашрамд дурдахад Херманн Констен бол 1878 онд Аахенд төрсөн, 1895 онд Аахений техникийн дээд сургуульд уран барилгын мэргэжпээр сурч байснаа Карлсруэгийн техникийн дээд сургуульд зурагзүйн мэргэжлээр шилжин суралцаж байсан хүн ажээ. Сургуулиа бүрэн дуусгалгүй 1900-1904 оны хооронд Германы колони Зүүн Африкийн (өнөөгийн Танзани) кофен тариалан дээр ажиллаж байжээ. 1905 онд Москвад очиж, Лазаревын институтэд дорно дахины хэл судалж байв. 1907 оноос Констен Монголд хэд дахин ирж Монгол орноор бүхэлд нь тойрон аялж, газарзүйн болон антропологийн судалгаагаар гараагаа эхэлсэн боловч үүнийгээ хойш тавьж монгол хэл сураад орос герман дипломатуудтай холбоо тогтоон, VIII Богд Жэбзүндамба тэргүүтэй гэгээн хутагтуудтай уулзан Монголын улс төрийн байдлын талаар Гадаад хэргийн яамандаа мэдээ дамжуулж байсан юм. Херманн Констен болон Дилова хутагт нарын харилцаа холбооны талаар дараах мэдээллүүд байна.

1. Херманн Констен Улиастайд байхдаа, энэ хотыг Хятадаас чөлөөлсний дараахан буюу 1912 онд анх удаа Дилова хутагт Жамсранжавтай танилцсан байна.

Энэ нь Ховдыг чөлөөлсний дараах 1912 оны 9-р сарын нэг өдөр бололтой. Энэ тухай түүний номоос ишилбэл: Delobin-Gegen – der erst am Abend eingertroffene lebende Buddha des Katschu-Schi-

Beese Chochun liegt etwa 45 Werst von Uljasutai. […] Delobin Gegen, dessen Bekanntschaft ich diesen Abend machte, ist ein duerst symphatischer, angenehmer Mensch. "…" [Consten I, 1919, 165] Үүнийг монголчилбол: „... өнөөдөр оройхон орж ирсэн Диловын гэгээн бол ... Хошууч бэйсийн хошууны амьд Будда. Энэ хошуу Улиастайгаас зүүн урагшаа 45 гаруй верст (1 верст нь 1.067 км) газар оршдог. Энэ орой би Диловын гэгээнтэй танилцсан ба маш нүдэнд дулаахан, сэтгэлд таатай хүн байна» гэж бичжээ.

2. Харин 1912 оны 9-р сарын 27-нд Дилова хутагт Х.Констентай дахин уулзсан тухайд: "27; September. Besuch des Delobin-Gegeen. Heute war fir mich und meine Leute groyer Waschtag. […] Mitten in der Wascharbeit [am der gute Delobin-Gegeen mit seinim Gefolge hineingeschneit …"[Consten 1919,I,173] гэхчлэн бичсэн байна.

Тэр өдөр манайханд болоод миний биеийн хувьд их угаалгын өдер байлаа. Нэгэн настай монгол авгай элдэв хувцас хунар, цэргийн өмсгөл зэргийг угаах юм болж би еерийн дотуур хувцсаа нэгэн хятадтай хамжин угаах болсон байлаа. Ид угаалгын ажил өрнеж байтал Дилав хутагт дэргэдийн шадар бараа бологсдын хамтаар гэнэт буужирдэг юм. Европын гэсэн юм бүхнийг сонирхох ажээ. Өмнө нь Африкаар болон Жагар орноор зорчижтатсан гэрэл зургуудыг бол бүр ихээр сонирхон үзэжэлдэв зүйлийг асуун байцаахад нь би амаа хаттал тайлбарлаж ярин нэлээд удсан юм. Өмнө нь Азиар зорчин явахдаа татсан орон хийд болон лам хуврагуудын зургийг бүр ч ихээр сонирхон тэр дор нь таньжбайх юм. Угаалгын ажил ид өрнөж байсан ч зоог баригтун хэмээн саатуулж дөнгөлөө. Зэхэн дайлсан хоол маань цэвэр европ хоол байснаас сонирхуулахад Магги үйлдвэрийн бэлэн хоол болох шарын сүүлний шөл, хонины шарсан мах, төмс, пүддинг болон хатаасан жимсээр чанасан компот, цагаан талх бяслаг хүртэл хүртэл байснаас хутагт амтархан зооглоод дэргэдийн хүмүүс нь ч амтархан идэж бас болоогүй ээ, заримыг нь онцлон хандаж аманд нь хүртэл амттан тэргүүтнээс хийж өгч байх юм. Шарсан махнаас харин хутагт дөнгеж ам хүрээд бусдад хуваан өгөхөд нь тэд нь их хүчилж хоолойгдороо давуулж байх юм. Хонины махыг чанаад голдуу зооглодог монголчууд шарсан маханд төдий л дурладаггүй бололтой юм. Өмнө нь Гадаад хийгээд Дотоод

Монголоор хөндлөн гулд он удаан жилээр аялан зорчиход шарсан махаар дайлуулснаа би огт санахгүй юм. Хоёр цаг хиртэй саатсаны хойно Дилова хутагт бараа бологсдын хамтаар өндөрлөж явах юм болов. Бараа бологсдыг нь Лининфа дайлж цайлсан юм. Дилова гэгээнтэн нуруу өндөр, мөрөөр өргөн, нүдэнд тун дулаахан мөртлөө цагаан бурхантсан зүс царай нь жаахан тиймхэн байв. Би хутагтыг үдэж өгөхөөр жингийн тэмээдээ буулгасан Лининфагийн том хашаанд гарч 16 дахин татдаг Цайссын дуранбайгаараа орчин тойрны бараа сонирхуулах юм болов. Тэр зуур монгол жинчдийн цуваа дагадаг айхтар зуумтгай нохой арслан бар мэт архиран дайрч ирэхэд тэд дээр дээрээс овооролдохоос наахнуур үүдээр чихцэлдэн гарахад нөгөө нохой ганцхан зүтгээд уяанаас алдууран дайрахад гэгээнтэн намайг амь аврах бамбай болгон миний араар гүйн ороход нь би нохойг хүнд ташуураар толгой түрүүгүй ороолгон жанчих зуур нэгэн хятад ажилчин маань гүйн ирж хоёулаа хамжин байж номхруулаад гэгээнтнийг үүдээр гаргаж амжлаа. Мань эр их л айж тэвдсэн бололтой царай хачин ихээр цонхийсон байх юм. Гэгээнтэн тэр дороо баяртай гэж яаруухан хэлээд яван одоход нь ойрмогтоо бараалхаж Цайссын дурангаа сонирхуулах болоод хоцров.

Хутагтын нэг өдрийн ерийн аж төрлийн тухай Германы жуулчин Херманн Констений 1912 оны 9-р сарын 27-ны өдрийн тэмдэглэлд ид хорин таван насны үе дээрээ яваа Дилова хутагтын гадаад дур байдлыг "Дилова гэгээнтэн нуруу өндөр, мөрөөр өргөн, нүдэнд тун дулаахан мөртлөө цагаан бурхантсан зүс царай нь жаахан тиймхэн байв" гэхчлэн тун оновчтой дүрсэлжээ. Хутагт мөн харь холын соёлыг цэрвэн жигшигч биш болохыг "Европын гэсэн юм бүхнийг сонирхож" байсан, тэр дундаа европ идээ ундааг амтархан таалж, арван зургаа дахин татдаг Цайссын дуранбайг сонирхож байсан гэдгээр тодруулжээ. Түүгээр ч барахгүй тэдний бэлтгэсэн европ зоогийг тун ч амтархан зооглосон атлаа хонины шарсан махнаас денгөж ам хүрээд бусаддаа өгөхөд тэдгээр бараа болоочид нь оас л их хүчилж хоолойгоор давуулж байсан тухай сонирхолтой ажиглалт энд гарч байна. Херманн Констен үүнийг басхүү гярхай ажиглаад, "хонины махыг чанаад голдуу зооглодог монголчууд шарсан маханд төдий л дурладаггүй бололтой юм" гэсэн нь тусгай нэгэн учир утгатай зүйл билээ.

Бидний судалснаар мах шарж иднэ гэдэг нь гэрийн нөхцөлд бараг хорио цээртэй бөгөөд харин хээрийн хоймор анчин гөрөөчин хүний хувьд бол анн гөрөөсний шарсан мах хамгийр чухал дуртай хоол билээ. Тэр тусмаа хонины махыг шарж идэх, шар тосонд хуурч идэхийг онцгой цээрлэдэг нь ийм зоогийг тэнгэрийн зоог хэмээн үзэх бөгөөд ийн хүнсэлбээс тэнгэртэй тэрсэлдсэн хэрэг болно хэмээн үздэг байжээ. Мэдээж яг энэ цээрийн утга нь тодорхой биш байсан байж болох авч ерөөс хонины шарсан мах идэх нь хуучин цагийн монголчуудын хувьд хэвийн бус зүйл байлаа. Мөн эзэн Чингис хаан хүүхэд байхаасаа зуудаг нохойноос их айдаг байсантай нэгэн адилаар Дилова хутагт ч бас ийм зан дадгаалтай байсан талаар сонирхолтой дүрсэлсэн байна.

3. Дараагийн өдөр нь буюу 1912 оны 9-р сарын 28-ны тэмдэглэлээс ишилбэл: "… Сеgеп Mittag erschien weiber mein Freund Delobin-Gegeen, der mir persunlich eine Einladung des Dsal-Chen-Sen-Gegen berbrachte…"[Consten 1919,I,175]

Тэр өдөр сэвэлзүүр салхитай цас жаахан бударсан дөрвөн хэм хэртэй хүйтэн өдөр байв. Арав гаран хоногийн тэртээгээс сураг нь дуулдсан казак цэргийн шуудан өнөөдөр л ирэх юм дуулдав. Орой тийш Дамдинсүрэн [Манлай ван С.Д.] морьд илгээж уулзахаар иртүгэй гэснийг нь би ёсоор болгож эс чадав. Тэр үдэш би-вээр оросын шинэ консул Вальтер болон гэргийд нь консулын шинэ байранд бараалхаж хүндэтгэл илэрхийлэх ёстой байлаа. Консулын шинэ байрыг хятадууд элдэв эрээн мяраан ваар сав, зураг хөрөг, цэцэг хуараар гоёж чимэх гэж их л хичээсэн байх юм. Энд би казакуудын тайж Ухтомскийтэй таарч гэрт нь оройн 11 цаг хүртэл элдвийг хуучлан саатав. Миний ийн эзгүй явах хооронд Хайсангийн бүлэг дээрэмчдийн хэсэг монголчууд Лининфагийн наймааны газарт хүч түрэмгийлэн хэдэн хятадыг минь гэзэгнээс нь гулд чирэн, хятад тогоочийг нь минь хүртэл барьж аваад Хүрээ рүү гаргах гэж байсан хулгайн барааг тэмээнд ачиж өгөхийг шаардсан гэнэ. Энэ тухай үгийн далим гарахад нь Сартуул бэйст сонордуулбал үүнээс хойш түүнээс цааш тэр наймааны газраар үзэгдэхийг ч хатуу хориглон үүний тул үүдэнд нь монгол бичгээр үйпдсэн сануулгатай туг хийсгэсэн юм. РЙ өглеөгүүр хотоор нэг дун бүрээ татан хангинуулж айж бэргэсэн хятадууд гэрийн

мухарт шигдэн арай зоригтой нэг нь үүдээрээ сэмхэн шагайж Дамдинсүрэн хэдэн баатар эрсийн хамтаар Улиастай хотоос баруунш таван өртөө газарт байх Гэсэр сүмийг чиглэн гол гудмаар одохыг хараад сая нэг санаа нь амарцгаав бололтой.

Үд хавьцаа Дилова гэгээн анд минь ахин морилон ирж Жалханз хутагтын урилга зааллагыг уламжлав. Ирэхийг нь угтуулаад өнөө зуудаг хэдэн нохдоо найдвартай уяж тогтоосон тул Дилова гэгээн нөгөө Цайссын дуранг минь харин ч тухтай сонирхон ид шидийг нь үзлээ.

Сартуул бэйс нутаг хошуундаа эгэн очиж тэндээ хэсэгтээ саатах юм байна гэжДилова гэгээнтэн надад дотночлон дуулгаад нарийн ширийнийг өөрөө дуулгана биз гэжхэлэв. Ховд, Улиастайн жанжин сайд энэ тунчиг хичээнгүй, ухаалаг залуу эрийг эзгүйд оросуудын башир заваан хуйвалдаан сүлбээ их л гай болох вий гэж би дотроо халаглаж суулаа.

Зуудаг нохойноос айдгийг нь эс тооцвол Дилав хутагт алс холын энэхүү герман хүнд "тунчиг хичээнгүй, ухаалаг залуу" санагдсан байна. Энэ бол ягшмал нямбай зан суртахуунтай герман хүний үнэнд их ойрхон үнэлэлт гэж бодогдоно. Негөөтэйгүүр Херманн Костений дээрх тэмдэглэл бол Манжаас чөлөөлөгдсөний дараахан цагийн Упиастай хотын аж байдал, хятад, монгол хүмүүсийн харилцааны талаар бодтой мэдээлэл өгч байна. Түүнчлэн Дилова хутагт түүнийг Жалханз хутагт болон Сартуул бэйс зэрэг тэр цагийн монгол ихэс дээдэстэй танилцуулж өгсөн бололтой байна. Ер нь Херманн Костений дээрх тэмдэглэл бол урьд өмнө монголчуудад, тэр дундаа эрдэм судалгааны хүрээнийхэнд төдийлөн танил биш учир ийнхүү дэлгэрэнгүй танилцууллаа. Мөн энэ тэмдэглэл хутагтын өдөр тутмын ерийн аж байдлынх нь нэгэн хэсэг зураглал гэдгээрээ сонин байж болох юм.

Хутагттай сайн холбоо харилцаатай байж, түүнийхээ хүчээр цагийн цавиргаан, төрийн төвөргөөн дундаас амьд мэнд нутаг орондоо харьсан өөр нэгэн хүн бол польш гаралтай, нийгэм-улс төрийн зүтгэлтэн, байгаль шинжээч Антони Фердинанд Оссендовски (1878-1945) болно. Түүнийг яагаад өрнөдийнхөн дунд оруулчихав гэвэл амьдралын эхний хэсэг нь Оростой холбоотой

байсан боловч сүүлийн хэсэг нь болон боловсрол, бүтээл туурвил нь Өрнөдтэй холбоотой болсон учир ийн үзсэн болно. Польш эмчийн гэр бүлд төрсөн тэрбээр хэрмэл гэр бүлийнхээ аж амьдралын улмаас Петербургийн гимназид суралцан төгссөөд тус их сургуулийн байгаль-математикийн ангид элссэн боловч оюутны үймээнд оролцсоны улмаас 1899 онд Оросоос хөөгдөн Францад очиж, Сорбоннын их сургуулийн химийн ангийг төгссөн байна. Орост оюутан байхдаа байгаль судлаач, профессор Степан Залевскийн шинжилгээний ангийн туслахаар орж Алтайн уулс, Кавказ, Днестр мөрний адаг, Енисей мөрөн, Байгал нуурын орчимд эрдэм шинжилгээний ажилд оролцож явжээ. Орост эргэн ирснийхээ дараа Томскийн техникийн дээд сургуульд багш, доцент, 1905 оны Оросын анхны хувьсгалын дараа байгуулагдсан Сибирийн Бүгд найрамдах Улсын хувьсгалт хороон даргаар сонгогдож байжээ. Үүнийхээ төлөө хаант засгаас шийтгэсэн зургаан сарын шоронгийн ялыг эдэлж дуусгаад 1917 он хүртэл Оросын алтны үйлдвэр, зэвсгийн үйлвэрүүдийн холбоонд зөвлөх, 1918 огд Сибирьт байгуулагдсан Колчакийн засгийн газрын Сангийн яамны сайдаар ажиллаж байжээ. Оссендовски бол байгаль шинжпэл, танин мэдэхүй, аялал жуулчлал, адал явдал, улс төрийн чиглэлээр олон арван нийтлэл, роман, тууж бичсэн бөгөөд 1921 оны тавдугаар сарын сүүлч хүртэл Монголд хагас жил байж, нүүдэлчдийн аж төрлийг нүдээр үзэж "Хүн, араатан, бурхад" ном бичсэн нь дэлхийн хорь гаруй хэлээр орчуулагдан хэвлэгдсэн билээ. Одоо энэ номд Дилова хутагтын тухай бичсэн хэсгээс нь Ж.Нэргүйн орчуулгаар толилуулъя. Энэ номын "Нууцпаг Түвдэд" хэмээх арванзургадугаар бүлэгт:

Дээрэмчид дахиад биднийг дайрахгүй гэж би нөхөд дээрээ ирж тайвшруулсан бөлгөө. Одоо Монгол руу бушуухан л эргэх хэрэгтэй байв. Морьдын маань хавирганы яс хэрзийж эцэж турах нь туйлдаа хүрсэн тул хоёр хоног бид хөдөлсөнгүй. Дайсныхаа толгойлогчийг хэдэн удаа очиж үзэхийн зэрэгцээ өөрсдийнхнийхөө үл ялиг шархыг ч илааршуулахаар бага зэрэг амсхийчихлээ. Ангийн хутганаас өөр мэс заслын багаж байхгүйн учир зүүн өгзгөнд орсон сумыг түүгээрээ авч, баруун өсгийгөө эмнээд орхилоо. Тэгээд дээрэмчдээсээ жинчдийн гол зам хаагуур явдгийг сайтар асууж аваад аяндаа гарч мөнөөхөн их зам хүрвээс харин

аз таарч Өргөөний Амьд Буддагийн захиаг Лхаст суугаа Далай ламд хүргээр яваа Монголын залуу хан Пунцагийн цуваатай таардаг байна шүү. Хан бээр морьд, тэмээ, хүнс олоход тусалсан агаад бүхий л зэр зэвсгээ тээврийн хэрэгслээр сольсон бид хэдэн хоногийн дараа Наро Банчэн хийдийн их хаалгыг нүдэж байлаа. Хутагт бээр биднийг их л дотноор хүлээн аваад:

- Та нарыг эргэж ирнэ гэдгийг би мэдэж байсан юм. Тэнгэр тэгж зөгнөөд байсан юм гэж билээ л. Зургаан хүнийхээ цогцсыг өмнө зүг рүү гэсэн галзуу тэмүүллийнхээ сургамж болгон Түвдэд орхиод хоёулхнаа л буцаж ирсэн юм даа. Хийдийн горломд айвуу тайвуу хоёр долоо хоногийг өнгөрөөж сэтгэлээ тогтворжуулсан хойноо амьдралын хар шуургыг дахиад л сөрж, аль нэг боомт руу Бурханы ивээлээр хүрчих мөрөөдлөө сэдрээж эхлэвэй, Большевикуудтай тулалдах зорилго агуулан Монголд байгуулагдаж эхэлсэн цагаан цэргийн хороонд манай офицерууд бүртгүүлж, харин би агрономич андтайгаа Монгол нутгаар хэсүүчлэн аюул багатай газар олохоос өөр зам байсангүй. Эдүгээ харин тэрхүү бэрхийн бэрх аян замыг санагалзан, ой дуртгалаас үл арчигдах тод зургуудыг улам сэргээн суухуй дор, бичээд өнгөрсөн эдгээр хуудсуудаа би бээр өөрийн итгэлт нөхөр, олон удаагийн шалгарсан анд агрономич нөхөртөө болон намайг дагалдаж явсан орос хүмүүст, нэн ялангуяа Түвдийн уулс дунд мөнхийн нойрондоо амирлах хурандаа Островский, ахмад Зубов, Туров, дэслэгч Писаревский, хасаг цэрэг Вернигор, татаар эр Мухамед Спиринд зориулму. Түүнчлэн өндөр угсаат Солжак хаан, Наро Банчэн хийдийн тэргүүн Дилав хутагт Жамсранжав нарт гүнзгий талархлаа илэрхийлэхийг хүсмү [Оссендовски 2000, 87-88]

Энэхүү хэсэглэлээс үзэхэд Төвдөөр дамжин гарах гэсэн хий мөрөөдөл нь үнс тоос болонгуут Монголд эргэн ирсэн гол түшиг тулгуур нь Наро Банчэн хийд, хийдийн тэргүүн Дилова хутагт байсан агаад хутагт ч бас нэн таалалтай дотносогоор хүлээн аваад амар тайван хэд хонож, бие, сэтгэлээ тэнхрүүлсэн ажгуу.

Тус номын “Жижиг сүмд болсон ер бусын явдал” хэмээх хорин долдугаар бүлэг нь хамгийн сонирхолтой.

Чүлтэм бэйл биднүүс Наро Банчэн. хийдээс явахаар зэхэж байв аа. Ерөөлийн сүмд сайдад зориулан хутагтыг ерөөл айлдаж

байх үед би гэлэн, гэцэл, равжамба, хойд нас судлаач маарамба, оточ гээд гэгээрлийн туйлд хүрсэн доктор, багш нарын өргөө, банди (санваартнуудын зэрэг дэвийн нэрийг бүгдийг монголоор бичжээ. Орч) хэмээх сурагч нарын гэр сууц, агуулах, номын сан, хөмрөгийн дуганууд шаваралдсан нарийхан гудамжаар холхиж хөлхөж ядарсаар хутагтын гэрт буцаж ирвээс хутагт бээр ч.мөн адил өргөөндөө морилсон ажгуу. Хутагт дахиад л надад хадаг өгөөд «Хийдийн ойролцоо бага зэрэг салхинд гарвал яана» гэж урилаа. Түүний царай нэг л бишийг хараад надтай ямар нэгэн зүйлийн талаар зөвлөлдөх нь дээ хэмээн тааварлаж даган гарваас бидэнтэй миний дагалт офицер, мөн дөнгөж барианаас суллагдсан орос худалдаачдын тэргүүн ч нийлвэй. Арын хананд нь тод шаргал өнгийн чулуу шигтгэсэн нэгэн жижиг дугана руу биднийг хутагт дагуулан хүрээд хэлсэн нь:

Далай лам ч, Богд хаан ч энд тухайн цагтаа заларсан бөлгөө. Ариун явдалт тэдбээрийн морилсон дуганыг бид шар өнгөөр хулддаг амой. Морилогтун!

Дуганы дотор гайхамшигтай зүйл нүднээ туслаа. Манз цаваа барьдаг бололтой нэгдүгээр давхарт нь хар зандангаар сийлэн урласан мэлхий ширээнүүд, алтадмал хийгээд шаазан сав суулга дүүрэн тавиастай, дээд давхарт нь бас хоёр ч өрөө ажгуу. Нойрсох өрөөнийх нь сийлбэртэй модон адраас үнэт эрдэнийн чулуугаар чимэглэсэн том хятад дэнг нарийхан хүрэл гинжээр дүүжилж, ханыг нь шар торгоор доторложухуй. Энд мөн торгон жинтүүнүүд хийгээд олбог, дэвсгэрүүд тавилсан томоо гэгчийн дөрвөлжин ор байлаа. Орыг мөнлхар зандангаар урлаж. майга дөрвөн хөлийг нь дорнын уламжлалт сийлбэр болох нарыг залгиж буй Раахын дүрсээр чимжүхүй. Басхүү шашны зан үйлийн сэдэвт уран сийлбэртэй модон авдар тэр өрөөнд тавиастай харагдмой. Хамгийн сүүлд бидний нүдэнд туссан юм гэвэл суухад эвтэйхэн дөрвөн зөөлөн сандайлга, дорно зүгийнхний хүндэтгэлийн намхан суудал авай.

Та энэ сэнтийг мэлмийдээн болгоогтун! Өвөл цагийн нэгэн үдшээр манай хийдийн хэрэмний хаалга нээгдэж, олон морьтой хүмүүс орж ирээд бүхлгэлэн, гэцлүүдийг хутагт, тойн, хамбатай нь энэ өрөөнд урин залсан болой. Тэгээд тэрхүү үл танихүмүүн нарын нэг нь тэргүүнээ ороосон орхимжоо буулгахуй дор бүх лам

нар газар сөгдөн унацгаасан бөлгөө. Ариун номын сургаалдаа Далай лам, Банчин лам, Богд хаануудын дурддаг асан. Тэрбээрийг лам нар танижухуй. Тэрбээр болбоос Шамбалын эзэн, Тэнгэрийн бүх нууцыг мэдэгч байваа. Тэрбээр түвдээр тарни уншаад цугларсан олонд өрөөл хайрласны дараагаар ойрын жаранд болох бүхий л үйл үртсийг ариун мэлмийдээн тунгаан тольдсан юм. Энэ явдал гучин жилийн өмнө тохиолдсон агаад айлдвар бцргон нь эдүгээг хүртэл биелсээр буй. Тэрбээр хажуугийн өрөөнд шүтээнай өмнө залбирч ахуйд яг энэ хаалга өөрөө алгуурхнаар нээгдээд, зулс нь бүгдээрээ өөрөө мандсан ба сангийн идээ үгүй атал бойпор уугиж, хавь орчинд арц хүжсийн үнэр түгэн дэлгэрвэй. Тэгээд ямар ч сануулга үгүйгээр Шамбалын эзэн бээр хийгээд түүний дагуулууд гэнэт алга болцгоосон юм даа. Зөвхөн Тэрбээрийн залраад боссон энэхүү сэнтийн торгон бүрээсний үл ялиг нугалаа л ирээд явсныг нь гэрчлэн түр зуур үрчгэр чигээр үлдсэнээ төд удалгүй арилсан болой [Оссендовски 2000,160-162].

Наро Банчэн хийдийн тухайн цагийн дүр байдлыг зурвасхан дүрсэлсэн сонирхолтой зураглалаас гадна нэгэн цап хийдийн горломд орж ирсэн үл таних морьтонгууд, тэднийг тэргүүлж ирсэн Шамбалын эзэн хаан Рэгдэндагва энэ хийдийн, энэ дуганд тэдний өмнөх ширээн дээр заларч байсан тухай үнэмшихүйеэ бэрх түүхийг Дилова хутагт Оссендовски болон ирсэн зочиддоо тайлбарлажээ. Шамбалын орон гэдэг нь юу вэ гэвэл, бурханы шашны очирт хөлгөний домогзүйд “Калачакра-тантра” болон цагийн хүрдний номын бусад сударт гардагаар Сита мөрнөөс (Сита мөрөн гэдэг нь Тарим хийгээд Амударья, Сырдарья мөрний аль нэгтэй адилтгадаг) умарш орших хийгээд лянхуан дэлбээ санагдуулам найман цаст уулсаар хүрээлүүлсэн байдаг. Төв дунд нь <Шамбалын нийслэл хүрээ, тэнд нь Калап хааны ордон сүндэрлэж байдаг. Шамбалын анхны тайлгач-хаан нь Сучандра (тө. Даваасамбуу) хаан бөгөөд анх ерэн зургаан нөхөр сэлт өчүүхэн хаадын хамт риди хувилгаанаар Бурхан багшийн оршин ахуй Цог төгөлдөр Врайбун суварганд ирж, Бурхан багшаас “Цагийн хүрдний язгуур үндэс” номын абшиг хүртэж, Цагийн хүрдний шашныг дэлгэрүүлсэн цагаас хойш Шамбал бол цагийн хүрдний номлолын төв, дагшин даван орны нэг нь болжээ. Сучандра хааны ордны цэцэрлэгт хүрээлэнд цагийн хүрдний үлэмж

их хот мандлыг босгожээ, Сучандра хааны дараагаар Шамбалын орныг зургаан тайлгач- хаан дараалан захирсан бөгөөд тус бүр нь нэг зуун жил болдог хорин таван хаан залгамжлан захирсан буюу одоо ч захирсаар байгаа гэж үздэг. Николай Рерихийн “Улаан морьтон” зурагт гардаг тэр Рэгдэндагвын тухай өгүүлж байгаа бололтой, Энэ бол нөгөө талаасаа барууны соёлтой байгаль шинжлэлийн эрдэмтэн хүний хувьд хутагтын ид шидийн талаар бичсэн хамгийн бодтой мэдээлэл хэмээн үзэхээс өөр аргагүй. Гэвч Оссендовскийн дурсамжийн хамгийн сонин зүйл нь дараахь болой.

Хутагт ын айлдаад шүтээний өрөө рүү орж сөхрөн суугаад хоёр алгаа нүүрэн тушаагаа авчран залбирал үйлдэж эхэлвэй. Өмнө нь мандах зулын чичигнэсэн гэрэл амгалан нүүрэн дээр нь агшин зуурын сүүдэр бүжиглүүлсэн алтадмал Буддагийн дүрийг ажиглан зогстол хоёр алаг нүдэндээ үл итгэм гайхамшигт зүйл үзэгдэх нь тэр.

Хүндэтгэлийн суудал дээр бор царайтай бадриун эр хүн сууж байх агаад хоёр уруулынх нь хүйтэн жимийлтийг гал цогтой нүднийх нь бүлээн туяа зөөлрүүлэх ажаам. Цагаан нөмрөгтэй маханбод нь тув тунгалаг үзэгдэж, хүндэтгэлийн суудлын түшлэг дээрх түвд үсгийн ерөөл нэвт шувт, тов тодхон харагдмой. Нүдээ хурдхан шиг чангаар аниад буцаан нээтэл суудал дээр одоо хэн ч үгүй атал, торгон бүрээс нь таталдан хөдлөх шиг санагдвай.

«Мэдрэл минь л ингэж байгаа юм. Жирийн бус хэт хүчтэй сэтгэгдэл, хэвийн бус нөхцөл байдлаас үүссэн мэдрэлийн гүн ядаргааных» гэж бодтол хутагт над руу эргэн:

- Хадгаа нааш өгтүгэй! Төрөл садангийнхаа төлөө ихэд санаа зовж явааг тань би мэдмүй. Тэднийг тань бурханд даатган мөргөсү. Та ч гэсэн залбирал үйлдэж, гэр орныхондоо туслахыг бурханаас гуйсугай! Нэгэн цагт энд ирж, энэ газрыг ариулсан Ертөнцийг эзэгнэн захирагчид дотоод сэтгэлийнхээ буй бүхий бодлоо чиглүүлтүгэй! гэвэй.

Тэгээд хутагт маань Будда бурханы мөрөн дээр хадгийг минь тавиад шүтээний өмнө сунан мөргөж, амандаа юм уншиж эхлэв.

Дараа нь толгойгоо өргөн намайг сулхнаар дуудаад:

Бурханы арын сүүдэр лүү сайн харж бай. Тэнд гэр орныхон

тань үзэгдмой гэлээ. Би ч лүндэнг нь даган бурханы арын хөндийн сүүдэр лүүхамаг анхаарлаа чиглүүллээ. Асар удалгүй тув тунгалаг утас лугаа ижил нарийн утаа тэндээс мөлхөн гарч ирвэй. Утаан цагирагууд нийлэн нийлсээр, олширон олширсоор, улам өтгөрөн нягтарч, хүмүүс хийгээд эд юмсын дүрсийг үүсгэхийг харсаар байлаа. Тэг тэгсээр, урьд нь миний огоот үзээгүй нэгэн өрөөнд гэр орныхныгоо, басхүү хэдэн үл таних хүмүүсийг харлаа. Заримыг нь мэдэх ч юм шиг. Эхнэрийн минь өмссөн даашинз надад дэндүү танил байнаа. Сэтгэлд дотно царай, нүүрнийх нь зураас үрчлээ бүхэн ч тод харагднам заа. Тэгснээ аажим аажмаар дүрсүүд бүдгэрсээр, хувирсаар ор тас үзэгдэхээ болив.

Будда бурханы ард зөвхөн сүүдэр нь л үлджүхүй. Хутагт өвдгөө тэнийлгэн босож ирээд хадгийг эргүүлэн надад өгч:

Таныг болон танай гэр орныхныг хийморь лундаа дагалдан явах болно. Бурхан таныг нигүүлсэлдээ багтаалаа хэмээвэй.

Нэгэн цагт Шамбалын эзэн бээр морилон ирж, хүмүүн төрөлхтөний төлөө залбирал үйлдэн, улс гүрнүүд, ард түмнүүдийн хувь зохиолыг айлдсанаар ариуссан тэр дуганаас бид гарцгаалаа. Гайхалтай юм. Миний дагуулууд ч надад үзэгдсэн тэр бүх дүрсийг харсан агаад, хэн нь ямар хувцастай байсныг сүүлд нь маш дэлгэрэнгүйгээр дурдан ярьцгааж билээ. Эх орны заяаг дэнслүүлсэн энэ хүнд өдрүүдэд өөрийг нь бас ямар тавилан хүлээж буйг хутагтаас Чүлтэм бэйл хичээнгүйлэн лавласанд хутагт хариу хэлэхээс эрс татгалзсан гэж монгол цэргийн дарга надад сүүлд нь хэлсэн болой.

Яагаад тэгснийг нь хутагтаас намайг асуухад тэр эрхэм бээр хөмсгөө зангидан:

- Болохгүй ээ. Бэйлтэн санаагаар унаж гүйцэх байсан. Түүнийг хар хувь заяа тосож байна лээ. Өчигдөр би зам мөрийг нь үзүүлэхийг гуйж тэнгэрт гурвантаа мөргөн хонины далны яс, гэдэс дотроор (Орч) мэргэлж үзэхэд дандаа л муу юм гараад байна лээ гэснээ гүн эмгэнэлтэйгээр хоёр алгаараа нүүрээ илж байсан юм даа. Түүний үзсэнээр бол, Чүлтэм бэйлийн хувь заяа саргүй шөнө мэт тас харанхуй байсан буй за. Нэг цагийн дараа гэхэд Наро Банчэн хийд бидний ард, уулсын тэртээд үлдсэн болой [Оссендовски 163-165]

Энэ гайхамшигт үйл явдлын үргэлжлэл нь Оссендовски болон бусад хүний нүдэнд ч үзэгдсэн агаад хамгийн сонирхолтой нь түүний ар гэрийнхэн болон эхнэрийнх нь дүрийг үргэлж өмсдөг танил дотно даашинзтай нь харуулсан явдал байлаа. Өрнөдийн боловсролтой байгаль шинжээч хүний ерийн сэтгэхүйгээр ойлгож үл болох ийм нэгэн үзэгдлийг Дилова хутагт түүнд болон хамт бараа бологсдод нь харуулжээ. Бурхан шашинтны хэлээр бол үүнийг риди хувилгаан гэдэг. Эрт нэгэн цагт Энэтхэгт наян дөрвөн их шидтэн гарч, элдэв риди хувилгааныг үзүүлэн хамаг амьтны тусыг цаглашгүй зохиосон цадиг буй бөгөөд чухам энэхүү арван нэгдүгээр равжүнгийн үед байсан наян дөрвөн шидтэний нэг нь Дилова, нөгөөх нь түүний гарын шавь Нароба (па>а-го-ра) билээ. Тэгээд энэ хоёр их шидтэний Монгол орноо хувилсан дүрүүд нь өнөөгийн бидний ойг нь тэмдэглээд байгаа Дилова хутагт, Наробанчин хутагт хоёр болно. Бидний өчүүхэн мэдлэгийн хэрээр төсөөлж байгаагаар аг дандрын номын үүсгэлийн зэргийн бүдүүн, нарийн хоёр ёсыг бясалган чинад хязгаарт хүрсэн (тарчигнасан) хүссэн зүйлээ юнгар будааны ширхэгт багтаан үзэж чадах увдис бүхүй, дээр өгүүлсэн Энэтхэгийн их бандида Наробагаас уламжилж ирсэн зургаан номын хоёрдахь Тэгээн гэрлийн йог» хэмээх увдисыг олсон бодгалийн бүтээн чадах зүйл билээ. Очирт хөлгөнөө суралцагч энэ йогын тусламжтай юм үзэгдлийн өвөр төрхтэй тулгарч, цэнгэлийг эдэлдэг гэлцдэг. Энэ увдис нь мэдээжээр Наробагийн нэрээр алдаршсан болохоос биш, Дилова багшийнхаа эрдмээс суралцсан хэрэг гээд хэлчихэд нэг их хилсдэхгүй болов уу. Тэгээд ч монголчууд “наян найман шидтэй Наробанчин гэгээн” гэж цоллодог нь оргүй биш.

Дилова хутагтын нас намтарт онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн хүн бол Америкийн монголч эрдэмтэн Оуэн Латтимор болно. О.Латтимор гуай бичихдээ “1930-1931 оны өвөл би Бээжин хотноо Дилув хутагттай анхлан нүүр учирч, тэр цагаас хойш 1964 онд Нью-Йорк хотноо насан өөд болтол нь нөхөрлөж явсан бөлгөө. Тавь гаруй жилийн турш намайг Монгол улс, монголын ард түмэн, түүний түүх соёл, эрх чөлөөний төлөө мятрашгүй тэмцэл, өрнүүн хувьсгал болон өнөөгийн аж амьдралтай нь гүн гүнзгий холбож байсан бүхий л үйл явдалд энэ хүн гол гүүр нь болж байсан билээ. Тийм ч учраас энэ хүн насан хутгийг олоод олон жил удаж байгаа ч гэсэн түүний тухай эрдэмтэн хүний хувиар биш, зөвхөн сэтгэлийн дуудлагаар

бичиж чадах хүн нь би мөнөөс мөн”[ТПе йНиу Кпи1ад1 МопдоИа 2009, 4; Дилав Хутагт 2000, 6]3 гэжээ. Чухам энэ хоёр их хүний нөхөрлөлөөс Хутагтын аж амьдралын сүүлийн хэдэн жил хамаарах бөгөөд Оуэн Латтимор абугай Балтимор дахь Жон Хопкинсийн их сургуулийн Олон улсын харилцааны Уолтер Пейтскул хэмээх сургуулийн захирал байхдаа монгол судлалын төсөл дээр хамтран ажиллахаар урьсан ажээ. Дилова хутагт Жон Хопкинсын их сургууль дахь гэртээ дотны анд Оуэн Латтиморын төлөө, түүнийг хамгаалан “хатуу ном” буюу уншиж байгаа гэх бидний бодлоор бол гүрэм хийсэн зураг хүртэл байдаг, Тэр үед Оуэн Лашиморыг АНУ-ын сенатч МкКарти “Зөвлөлтийн тагнуул, коммунист үзэлтэн” хэмээн буруутгаад байсан үе юм байна. Эх зургийг дагалдуулж сонин дээр гарсан мэдээг хавсаргасан нь бас их сонирхолтой бегөөд Дилова хутагт Сиэттлд айлчилж, нэрт монголч эрдэмтэн Николас Поппетой уулзсан тухай мэдээ ажгуу.

1950 онд орон гэргүй болсон халимагууд Америкт ирээд өөрсдийнх нь шүтдэг шашны томоохон зиндааны лам энд амьдарч байгааг сонсоод маш их баярлажээ. 1952 онд Нью-Жерсийн Фривуд Эйкрес гэдэг газар шарын шашны анхны дуган нээгдэхэд Дилова хутагтыг оюун ухааныхаа удирдагчаар залж аваачсан юм. Тэр үеэс эхлэн Дилова хутагт бүх цагаа шашны хэрэгт зориулсан юм. Америк орноор олонтаа аялж, шинэ хуучин андуудаараа зочилдог байлаа. Гүргэм алимны өнгөт лам хувцас, найрсаг инээмсэглэсэн түүний царайг олон их сургуулийн хотхонд таньдаг болсон юм. Янз янзын номын санд байгаа төвд, монгол номын цуглуулгыг уншиж судлан сүмдээ зориулан хуулан бичиж авдаг байв Дилав Хутагт 2000, 6].

Дилова хутагт ийнхүү Өрнөдийн ертөнцөд балрашгүй ул мөрөө үлдээж, тэдний эрхэмлэн хүндэтгэдэг бахархалт хүмүүн, түгшүүрт үеийн түшиг тулгуур угсаа гарвал нэгтнийхээ оюун санааны удирдагч болсон юм.

ДИЛОВА ХУТАГТЫН ДУРТГАЛД БУЙ ЗАРИМ МЭДЭЭ

Харнууд З.Лонжид
МУИС-ийн зөвлөх профессор, ботор(Ph.D)

Эхлэл

Нэрт хүмүүсийн бичсэн, ярьсан дуртгал дурсамж болон тэмдэглэл, захидал бол хувийн гаралтай сурвалж хэмээх ангилалд багтаж, судлаачдын анхаарлыг татаж байдаг. Хувийн гаралтай сурвалжийг бусад баримттай жишин харьцуулж, нягтлан боловсруулсныг аман түүх гэдэг. Аман түүхийн үндсэн эх сурвалж нь хүмүүсийн яриа, ярилцлага байдаг. Бичгийн сурвалжид огт тэмдэглээгүй буюу зориуд тойрч өнгөрсөн, эсвэл санамсаргүй орхисон янз бүрийн сэдэв асуудлыг аман түүхээс тодруулан нягтлаад, түүхийн судалгаанд ашигладаг. Энэ үүднээс авч үзвэл Дилова хутагт бээр 1949 онд 65 сүүдэртэй байхдаа өөрийн санаачилга ба эрдэмтэн О.Латтиморын дэмжин хөхүүлснээр бичиж дуусгасан түүний дуртгалд байгаа мэдээ нь 1860-аад оноос 1931 он хүртэлх Монголын эх түүхийн бүдэг бүрхэг олон асуудлыг шинжлэн боловсруулж, гаргалгаа дүгнэлт хийх боломжтой тун чамбай бүтээл юм.

Дилова хутагтын дуртгал хэмжээний хувьд төдий л их биш боловч манай эх түүхийн судалгаанд шууд ба дам холбогдох хэд хэдэн сэдвийг тусгаснаараа онцлог. Ялангуяа XX зууны Монголын түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсэн VIII Богдын тухай, Монголын хутагт хувилгаадын тухай, түүний дотор Жалханз гэгээний тухай, өөрийнхөө өмнөх дүрүүдийн тухай, цэргийн нэрт зүтгэлтэн Хатанбаатар Магсаржав, Баргын Манлайбаатар Дамдинсүрэн, ноён хутагт, Номун хаан Дамбийжанцан зэрэг олон хүний тухай сонин мэдээ өгүүлжээ.

Богд хутагт Монголын тусгаар тогтнолыг сэргээх, бэхжүүлэх, Хятадын түрэмгийллийг эсэргүүцэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэжээ. Дилова хутагт өөрийнхөө тухай хэд хэдэн удаа өгүүлэхдээ болсон үйл явдлыг дурдахын сацуу зарим зүйл дээр

алдсан байж болзошгүй хэмээн гэмшиж буйгаа илэрхийлжээ. Тухайлбал “Миний зан төрөлхийн зөөлөн бөгөөд бусдад зовлон төвөг багатай байхыг санасаар явдаг боловч залуу бага насны омог буюу түргэн уурын эрх ба албаны учир бусдыг засаж залруулах хэмээх зэргийн битүүлэг суртлаар хандаж, ширүүн үгээр аашилж зандарсам, хөнгөнөөр занчсан мэтийн зохисгүй явдал эрхгүй нилээд болсон” хэмээн туулж өнгөрүүлсэн зам мөрөө эргэн нягталж, алдсан зүйлдээ харамсаж буйгаа илэрхийлжээ. Янз бүрийн хүмүүсийн бичсэн дуртгал дурсамжинд Дилова хутагтын адил өөрийнхөө эндэгдлийг ийнхүү ил тод өгүүлсэн нь ховор билээ. Ингээд Дилова хутагтын дуртгалд хөндсөн олон сэдвийн заримаас нь товч өгүүлж гаргалгаа хийснээ та бүхэнд сонордуулж, санал бодлоо хуваалцъя.

Далай лам, Банчин-Эрдэнэ нарын тухай

Бурханы шашны хамгийн дээд буюу цогт эрдэнийн хувилгаад бол Далай лам, Банчин-Эрдэнэ нар юм. Монголчууд Түвд орныг манай шашны өлгий гэж үздэг ба Далай лам Банчин лам хоёрыг гэгээн хувилгаадын оройн дээд нь гэж сүслэн биширдэг юм. Иймээс ч тэднийг алс холоос зорьж очиж, мөргөл үйлдэж, өргөл өргөх нь сүсэгтэн олны сэтгэлийн хэрэг байсан юм гэжээ.

VIII Богд Жавзандамбын тухай

Монголчууд Манжийн эрхшээлээс ангижирахад VIII Богд бээр тэргүүлэх үүрэг гүйцэтгэснийг болон 1911-1924 онд тэр бээр Монголын төрийг тэргүүлж байсан тухай Дилова хутагт нилээд тогтож өгүүлжээ. Тухайлбал Богд хутагт 1895 онд буюу Чин улс Японтой дайтсан хөх морин жил Их шавийн Да лам Бадамдоржийг Орос руу нууцаар илгээж, Баатар цагаан хаанд захидал бэлэг хүргүүлж, таван зүйлийг хичээнгүйлэн хүсжээ. Үүнд 1) Монголыг Чин гүрний эрхшээлээс ангижирахад дэмжпэг үзүүлнэ үү. 2) Хэрэв ийнхүү Чингийн эсрэг тэмцэхэд Монголын хүчин мөхөсдвөл Орос улс цэрэг зэвсгээр тусална уу. 3) Монгол тусгай улс болох нь зөв гэдгийг Чин гүрэнд хэлж зөвшөөрүүлнэ үү. 4) Монгол улсын нутгийн хил хязгаарыг их* цагаан хэрмээр зааг болгож, уугуул нутгаа бүрэн

бүтнээр нь эзлэн суухад тусална уу. 5) Монголын Их хүрээнд сууж буй консул Шишмарёвыг энэ хэвээр удаан хугацаагаар суулгана уу гэжээ. Орос улс уул бичгийг хүлээн авч танилдаад хариу өгөхдөө Монгол улсад буруу явдал төдий л үгүй тул хэдэн жил азнаж, ямар нэгэн шалтаг гарахыг хүлээж Чин гийн эсрэг босох тэмцэлдээ “маш нууцаар яаралгүйгээр бэлтгэх хэрэгтэй” тэгэхдээ монголчууд цөм нэгдмэл саналтай байх нь чухал хэмээн сануулаад, танай сэдсэн энэ хэрэг зүйтэй учир консул Шишмарёвыг удаан хугацаагаар монголд суулгаж туслуулъя хэмээн мэдэгджээ. Дилова хутагтын энэ мэдээ бол Монголын улс төрийн түүхэнд тун чухал ач холбогдолтой сурвалж боловч 1990 оноос өмнө төдийлөн ашиглаагүй байлаа.

1911 онд Богд Жавзандамбыг Монголын төрийн тэргүүнээр өргөмжилсний учрыг Дилова хутагт тодорхой өгүүлснийг түүхчид ашигласаар байна. Богд хутагтын хойд дүрийг олон жилийн турш тодруулсаар ирсэн уламжпалтай боловч 1924 онд түүнийг таалал төгссөний дараа Оросын талыг баримтлагч коммунист удирдлагатай шинэ засгийн газар Богдыг дахин тодруулахыг хориглосон гэжээ. 1990 оноос хойш манай түүхчид энэ талаар судалгааны бүтээлдээ дурдаж, гаргалгаа хийсэн байдаг билээ. Үүнтэй холбогдуулж хэлэхэд 1921 оны хувьсгалыг үүсгэн сэдэгчид төрөөс шашны тухайд баримтлах бодлого боловсруулахдаа өргөн түмний олон жилийн уламжлалыг чанд харгалзаж, 1924 оны эх хүртэл үргэлжпүүлсээр байлаа. Гэвч коммунист оросууд мөн оны 3-р сараас эхлэн уул бодлогыг эрс хязгаарлах болсон төдийгүй лам хувраг, хутагт хувилгаад бол улс орны дайсан, харийн тагнуул туршуул болохоос үл буцах сэжигтэй хүмүүс хэмээн ил ба эчнээ байдлаар ухуулж, сүсэгтэн олны уламжлалт зан үйлийг хориглож, улмаар хүрээ, хийдүүдийг эдийн засгийн албадлагаар өмч, хөрөнгөнөөс нь хагацуулж, сөхрүүлэх болсон тухай 1924-1939 онд хэдэн мянган хуврагийн амь насыг егүүтгэж шорон гянданд хорьж, Оросын хүйтэн сэрүүн, цас мөсөөр бүрхмэл аглаг хөвч далай тэнгисийн хөвөө хязгаарт цөлж, Монгол хүний итгэл бишрэлийг хүчээр хориглон оюун санааны хувьд өрөөсгөл байдалд оруулсан билээ.

1918-1919 онд ДИУ Монголын автономит эрхийг устгаж, өөртөө нэгтгэхээр шимтэн хичээх болсон үед манай ихэс дээдэс, ноёд лам нар улс орныхоо хэтийн хувь заяаг нааштайгаар шийдвэрлэхэд

Богд хутагт голлох үүрэгтэй хэмээн итгэж байсныг Дилова хутагт тун тодорхой өгүүлжээ. Үүнийг бага зэрэг тодруулж ярья. 1919 оны зун Богдод бат оршил өргөх үед халх 4, ховд 2 аймгийн хамтарсан чуулганд засгийн газрын 5 яамны сайдууд оролцож, зөвлөлдөөд “Орос улс хаан эзнээ мөхөөж, хөрөнгө тэгшлэх нам босож самуурч байна манай Монголд халдан ирэх нь лав тул түүний аюулыг яахин хамгаалахыг хэлэлцье» хэмээснийг улсын хуралд уламжилсанд Доод хурал энэ тухай хэлэлцээд, биднийг зүгээр байхад улаан орос ирэх нь юу бол, харин Хятадыг түшиглэх хэмээвэл тэд Монголд ирээд хүчирхэх явдал болох болов уу... ер нь Хятад манай Монголд хорсол өвөрлөж байдаг тул итгэж болохгүй, Богдодоо залбираад суувал тогтооно биз дээ гэжээ. Улсын дээд хурал уул асуудлыг хэлэлцэж, Доод хурлын саналыг эсэргүүцээд “манай Монгол хүн цөөхөн бөгөөд цэрэг зэвсэг хүрэлцэхгүй тул тулж хамгаалах бэрх учир Дундад улсаас хамгаалах тусламж эрэхээс өөр аргагүй учир Нийслэл хүрээнд суугаа хятад сайд Чен И-тэй зөвлөлдвөөс ямар” хэмээсэнд Засагт хан Цэрэнгомбожав бээр “улаантан ирэхийг энэ хир тодорхой мэдсэн зүйлгүй, дэмий таамаглах хэрэггүй. Хятад цэрэг тусална гэж ирчихээд манай Монголыг хүчирхэн эзэлбэл яах юм бэ? Иймээс би хятад цэрэг ирүүлэхийг зөвшөөрөхгүй гагцхүү Богд юу хэмээн айлдахыг дагаваас зохино “ гэжээ.

Ийнхүү улаан Оросоос хэрхэн сэргийлах тухай бүх аймгийн ноёдын өргөтгөсөн чуулган ба улсын хоёр хурлаар хэлэлцээд нэгдсэн саналтай болж чадаагүй байна. Гэтэл Хятадад нааштай ханддаг ноёд олонхи болсон. Дээд хурлаас бид улаан Орос Монголд халдваас хамгаалахыг Хятадаас хүсэхээр шийдвэрлэсэн тул хүрээнд суугаа хятад сайдаас асуухаар боллоо хэмээн Богдод айлтгажээ. Тэрбээр үүнийг сонсоод бид энэ хэвээр зүгээр сууж байхад гэмгүй биздээ, гэхдээ та нар хятад түшмэлээс асууж, юу хэлэхийг нь сонсож болно гэжээ. Үүний дараахан дээд хурлын зарим хүмүүс Чин И-тэй уулзахад тэрбээр улаан Орос Монголд халдах санаа байгаа эсэхийг би лавлаж мэдье, үүнд би санаа их зовж байна, манай улсаас өөр та нарт туслах улс байхгүй шүү, би ерөнхийлөгчөөс асууж өгье гэжээ. Үүний маргааш Богд бээр улсын дээд хурлынханд хандаж та нар Чин И-тэй уулзах хэрэггүй гэсэнд тэд бид аль хэдийн-Чин И-тэй уулзсан харин тэрбээр Бээжинд утсаар мэдэгдээгүй бол хэлж зогсоолгоё гэжээ. Дээд хурлынхан

Чин И-тэй уулзаж асуухад би аль хэдийнээ ерөнхийлөгчид цахилгаан илпээсэн гэж хэлжээ. Хэд хоногийн дараа Чин И дээд хурлынхантай уулзаж, манай ерөнхийлөгч Монголд тусалж болно, гагцхүү та нар автономио устгах хэрэгтэй, Монголын юу хүссэнийг ёсоор болгож тэтгэнэ гэж хариу ирүүллээ хэмээн мэдэгджээ. Энэ үеэс эхлэн Чин И бээр Монголын автономитыг устгахад бэлтгэж, Монголыг амаржуулан товхинуулах 64 зүйл бүхий бичиг хэмээхийг боловсруулж өгчээ. Уул бичгийг улсын хоёр хурлаар хэлэлцүүлсэнд доод хурлынхан бүгдээрээ эсэргүүцэж, Хятадад нэгдэхгүй гэжээ. Дээд хурлынханаас Засагт хан Цэрэнгомбожав, тус аймгийн Дайчин засгй|н хошуууы засаг ноён Жалчингомбодорж, Сэцэнхамсаймгйин. Дайчин засаг Дашцэрэн нар хэрхэвч Хятадад орж болохгүй гэжээ. Гэвч тус хурлын бусад хүмүүс тэр гурвын саналыг огт дэмжээгүй байна. Улсын Дээд хурлын шийдвэрийг 6 Богдод айлтгахад тэр бээр хариу болгож би санавал бусдаас тусламж эрэх хэрэггүй. Ер нь Дундад улсын Засгийн газраас бидэнд ямар ч үг хэлээгүй байхад ганц Чин И -гийн үгэнд итгэж болохгүй, дахин нарийвчлан хэлэлцэж тогтоо гэжээ. Гэтэл мөнөөх ноёд бид Хятадын ерөнхийлөгчөөс асуувал болох уу хэмээн Богдод айлтгасан боловч эс зөвшөөрч “та нар олондоо тустай явдал хийвээс би хориглохгүй, гагцхүү сайн нарийвчлах хэрэгтэй” хэмээн зарлиг буулгажээ. Үүний маргааш нь Богд бээр зүүдэлсэн тухайгаа яриад “Хятадад нийлбээс сайн бус харин энэ хэвээр суухад огт гэмгүй тэр явдлыг Хятадын ерөнхийлөгчөөс асуухыг байваас зохино” хэмээн айлтгажээ. Гэвч дээд хурлын ноёд бид өчигдөр Бээжинд цахилгаан явуулсан одоо ямар хариу ирэхийг л хүлээе гээд улсын хурлыг тараажээ. Ингэж 1919 оны зун даншогт ирсэн ноёд маш цөөхнөөс гадна дээд хуралд суудаг яамдын сайд нар шадар сайдуудын олонхи нь Хятадад тун дотно хандах сэтгэл нь шулуудсан учир Монголын автономит эрх устгагдсан юм гэж Дилова хутагт бичжээ.

Монголын гадаад байдал ноцтой хурцадсан тэр үед төрийн өндөр албан тушаалтнуудын зарим нь эх орныхоо эрх ашгийг төдий л хайхрахгүй байсныг Дилова хутагт нэр заан дурджээ. Тухайлбал ерөнхий сайд Бадамдорж, Гадаад яамны сайд Цэрэндорж, Түшээтхан аймгийн засаг ноён Ананд-Очир, Цэрэнбаавай нар Хятадад дотнолон хандах болсон гэжээ. Гэвч түүхчид эдгээр хүмүүсийн тухай нэхэж судлах талаар хойргодуухан байдгийг энэ дашрамд тэмдэглэе.

Монголын автономитыг устгасны дараа Богд тэргүүтэй манай ихэс дээдэс улс орныхоо бүрэн эрхт тусгаар байдлыг дахин сэргээхийн төлөө хэрхэн чармайсныг Дилова хутагт тун тодорхой өгүүлсэн нь эх түүх судлаачдын анхаарлыг татаж байдаг. Тухайлбал дурдан буй үед Монголын нэр нөлөө бүхий хүмүүс Япон, Америк, ЗОУ-д хандаж, тусламж хүссэн тухай зарим нэгэн мэдээ байдаг боловч нилээд бүдэг, бүрхэг байдгийг Диловын дурдатгалаар тодруулах боломжтой байна. Түүний бичсэнээр бол 1920 оны өвөл Данзан, Сүхбаатар хоёр Орос руу одоод Хиагтаас цааш явж чадалгүй буцаж ирсний дараа Америкийн нэгэн албаны хүн Нийслэл хүрээнд ирж манай монголд тусалж болох мэт үг хэлсэнд Богдоос Жалханз хутагтыг тэр хүнтэй уулзаж хэлэлц хэмээсэнд Жалханз гэгээн түүнтэй уулзаж ярилцахад тэр бээр “туслахаар хэлж бичиг авч явах болсонд нэгэн шөнө” Засагт хан аймгийн Дайчин засаг Жалчингомбодорж, мөн тэдний хошууны захирагч Түвшин, Хатанбаатар ван, Дилова хутагт 4 нийлж, тусламж гуйсан бичиг үйлдсэнийг бэлгийн хамтаар Жалханз хутагт биеэр аваачиж өгсөн гэжээ. Энэ мэдээ судлаачдын анхаарлыг зүй ёсоор татахаас гадна энэ талаар ултай судлах зайлшгүй шаардлагатайг бид анхаарах ёстой.

Үүнээс гадна 1919 оны өвөл Цогтбадамжав зэрэг хэдэн буриад хүн Япон улсаас тусламж эрвэл амар түргэн бүтнэ, харин Америк бол алс хол орших тул туслахад бэрхтэй хэмээн ятгаж байсан боловч Японыг харгис, дарламтгай хэмээн сонссон монголчууд Японд дургүй байсан гэж Диловын дуртгалд бичжээ. Гэвч зарим номд тэмдэглэснээр бол монголчууд Японоос тусламж гуйж, Сэцэнхан аймгийн гүн Гүррагчааг Японд илгээж байсан тухай мэдээ байдгийг судлаачид мэдэх билээ.

Богд бээр Монголын бурханы шашны хамгийн өндөр эрх мэдэлтэн боловч бусад хутагт, хувилгаад, лам нарын хүрээ хийдийг шууд удирдаж байгаагүйг Дилова хутагт цохон тэмдэглэсэн нь Богд хутагт бүх зүйлд хэмжээ, хязгааргүй эрх эдэлж байгаагүйг ухаарч ойлгоход дөхөм болж байна.

Хүрээ хийдүүдийн тухай

Монголын хүрээ хийдүүдийн тухай Дилова хутагтын дуртгалд анхаарч үзүүштэй сонин мэдээ бий. Жишээ нь бүх хүрээ хийд харьцангуй бие даасан байдалтайгаас гадна шашны болон засаг захиргааны хосломол шинжтэй бөгөөд санхүүгийн гол эх үүсвэр нь сүсэгтний өргөл барьц байлаа гэж Дилова хутагт бичсэнийг мэргэжпийн түүхчид гүнзгийрүүлэн тайлбарлаж, гаргалгаа хийх нь чухал байна. Тодруулж хэлбэл 1990 оноос өмнөх манай түүх бичлэгт хүрээ хийдүүд их хэмжээний зүйлийг ард олноос албадан татварлаж авдаг байсан хэмээн бичдэг байсан бол ардчиллаас хойш хүрээ хийдийн аж ахуйн түшиг тулгуур нь чухам юу байсныг тусгайлан судлаагүй учир чив чимээгүй байдаг. Бидний ажигласнаар бол жас жав нь сүсэгтний өргөл барьцыг үржүүлэн хүрээ хийдийн бүх хэрэгцээг хангадаг байжээ. Жасууд олон зууны турш аж ахуйгаа маш өвөрмөц аргаар буюу жасад ч, жасын мал сүргийг адгуулж тариа тарьдаг айл өрхөд ч буюу аль алиндаа ашигтай байх болзолтойгоор аж ахуйгаа эрхэлдэг байсан юм билээ. Улс орон зах зээлийн тогтолцоонд шилжсэн өнөөгийн нөхцөлд манай хүрээ хийдүүд жас буюу өөрийн аж ахуйтай байхыг төр засаг эрх зүйн хувьд баталгаажуулбал тун хэрэгтэй мэт санагддагийг энэ дашрамд хэлье.

Төгсгөл

Монголын түүхэнд нэр нь мөнхөрсөн Дилова хутагтын дуртгалд өгүүлсэн олон зүйлээс ганц нэгийг нь цохон авч ярьсныхаа эцэст зарим санал хэлье гэж бодлоо. Тухайлбал Богдыг 22 сүүдэртэй байхад Сэцэнхан аймгийн жүн ван Доржпалам бээр хэд хэдэн зүйлээр Богдыг буруутгаж хүрээний манж сайдад зарга мэдүүлснийг Бадруулт хаанд уламжлан айлтгасанд төдий л тоогоогүйгээр үл барам “би хутагтад хүнд итгэмүй” гэж зарлиг буулгаад Доржпаламын жүн вангийн хэргэмийг эвдсэн гэж Дилова хутагт бичжээ. Үүнийг нэхэн тодруулбал VIII Богдын тухай судалгаанд тун хэрэгтэйг тэмдэглэе.

Дилова хутагтын бичгийн болон эдийн өвийг эрж олох, цуглуулах, судлах талаар цаашид хийх ажил нилээд байна. Жишээ нь тэр бээр 1931 оноос хойш Өвөрмонгол, Түвд, Хятад, АНУ-д байхдаа бичсэн

бүтээл туурвил, шашин номынх нь үйл ажиллагааг тодруулах, ялангуяа тэрбээр олон орны янз бүрийн хүнтэй уулзаж, ярилцаж, санал бодлоо солилцож байсныг судлах шаардлагатай байна.

Дилова хутагт бээр хэсэг хугацаанд 13-р Далай ламтны дэргэд байсан тухай тодруулан судлах хэрэгтэй. Хэрэв Далай ламтнаас Дилова хутагтын тухай асууж ярилцвал тодорхой зүйл айлдах нь мэдээж.

Чан Кай Ши, Дилова хутагт нар танилууд байсан гэдэг. Энэ талаар тодорхой зүйл тун хомсхон байдгийг хэн хүнгүй мэдэх боловч судлан тодруулах талаар хийсэн зүйл ховрыг цаашид анзаарууштай.

Дилова хутагттай уулзаж явсан хүмүүсээс эдүгээ сэрүүн тунгалаг байгааг нь сураглан олж, дуртгап дурсамжийг нь авах талаар сэдэж хийх зүйл нилээд байгааг судлаачид хэрэгжүүлэх биз.

1951 онд японы монголч эрдэмтэн Широ Хаттори бээр Калифорны их сургууль дээр хоёр удаа Диловатай уулзаж ярилцахдаа сүнсний тухай ярьсаныг нь соронзон хальсанд бичиж авсан хэмээн Хангины Гомбожав, Онон-Өргөнгөө нар бичжээ.Тэр бичлэг буюу Дилова хутагтын дуу хоолой Японд байж тун магадгүй.

Өвөр монголын шилийн голын чуулганы баруун Сөнидэд Дилова хутагтын хошуу гэж байсан бөгөөд тэдний олонхи нь цөвүүн цагт халхаас дүрвэж очсон хүмүүс байсан тухай мэдээ байх боловч нарийвчилсан судалгаа ховор бололтой.

Үүнээс гадна Дилова хутагтаас бусад хүмүүстэй харилцан захидал, өөр бусад сурвалж баримт бичиг манай улсын зарим архивын сан хөмрөгт байдгийг олж, эмхтгэн хэвлүүлж судалгааны эргэлтэнд оруулбал олон талын учир холбогдолтойг тайлбарлах шаардлагагүй билээ.

САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ХОШУУЧ МЭРГЭН БЭЙСИЙН ХОШУУНЫ ЦОРЖ АГРАМБА БАДАМДОРИГИЙН ДАРАМЫН ТУХАЙ

Н. Пүрэвжав
Монгол улсын гавьяат эмч, доктор (Ph.D), профессор

Б.Дарам нь 1865 онд Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн бэйсийн хошуу буюу одоогийн Завхан аймгийн Шилүүстэй сумын нутаг Чандмань хайрханы өвөр, Уртын голд Шар Халзан Жинжээ овогтой Бадамдоригийн анхдугаар хүү болон мэндэлжээ. Тэрээр таван настайдаа Отгонтэнгэрийн өврийн хүрээнд шавилан сууж төвд хэлийг гойд сурч, бурханы номын шидийг төгс эзэмшин 34 насандаа аграмбын цол хамгаалж Отгонтэнгэрийн өврийн хүрээний хамба ламаар өргөмжлөгдөж улмаар Мянган дуутын хүрээний Цоржийн мяндагийг 54 насандаа хүртэж эрдэм чадал, авьяас билиг, оюун ухаанаараа хошуундаа төдийгүй халх даяар алдаршсан эмч, гүрэмч, тарнич хувилгаан байжээ.

Рэдэн Ян Гомбын хувилгаан Агваанпринлэйжамц (1869-1930) Ямандаг бурханы хувилгаан Аграмба цорж Бадамдоригийн Дарам нар нь Цэрэндондов гэгээнтний номын багш байсан тухай ном хэвлэлд дурдаж үлдээжээ.

Дарам цорж нь Шамбалын орны тухай ном туурвиж Дээрхийн гэгээнтэнд өргөн барьсан бөгөөд Төвдийн Бүдэн Тамжид гэдэг эрдэмт ламын үндэслэн байгуулсан хүрээнд уг номыг хүргүүлсэн. Мөн Бүрэлбаа Нэршиг гэдэг номыг (орчуулсан юм уу бичсэн юм уу) туурвисан тухай шавь нарынх нь аман яриа үлджээ.

Мөн тэрээр Отгонтэнгэр уулын Тайлга тахилгын жаяг дэгийг боловсруулж, тахилгыг хошууны ноёд, ихэс дээдсүүдтэй хамтран олон удаа хийж байжээ.

Энэ эрдэмтэй лам нь Жигжидийн Нинчинг 4 удаа хийж Дээрхийн гэгээнтэнд бараалхахад Дээрхийн гэгээнтэн ийнхүү айлджээ:

- Цаана чинь Хошууч бэйсийн Ямандагийн хувилгаан морилж

ирээд байна гээд дааман хаалганы гадаа эсгий дэвсүүлж дааман хаалгыг хоёр тийш нь томоор нээж оруулахгүй бол орж багтахгүй байна хэмээн хэлж шавь нараараа бэлдүүлэн оруулж байжээ.

Жигжидын Нинчинг 4 удаа хийсний дараа духны цохноос 1 ширхэг улаан үс ургаж энэ үс нь орчин тойрон тайван үед шашраглаж, харин тайван бус сөрөг уур амьсгалтай үед эгц боссон байдаг байжээ. Мөн Зод тавьж Жанцан жарзыг 3 удаа хийсэн.

Хүн ардад тусалж эрдэм чадлаа үзүүлж байсан баримт

Энэ эрдэмт ламын тухай бидний өвөг дээдсийн өв дамжуулж ярьж үлдээсэн олон баримтын дотроос заримыг дурдвал:

1. Аграмба, цорж Дарам нь сүүлийн жилүүдэд Отгонтэнгэр Богд Очирваань уулаа байнга тахиж байсан ба уул тахих үед бороо маш ихээр зүсрэн орж наадам хийж чадахгүй байхад шавь Махшир хадаг барин ороход ном уншин уулаа аргадсаны дараа бороо зогсон Отгонтэнгэр уулын орой мэлтийн гарч ирээд нар гаран нойтон газраас уур савсаж ард түмэн наадамлаж байсан тухай шавь Дончин, Махшир, Мятавдорж нар ярьж байсан.
2. Дуутын хүрээнийхэн нэг удаа сор залах болоод сорын балинг хэнээр ширээний голд өргүүлэх вэ гэсэн яриа гарахад хүрээний хамба лам цорж Дарамаар өргүүлж түүний ид шидийг үзье гэж шийдээд дууджээ. Олон лам нар ярьж шийдээд уг сорын голыг их шуургатай өдөр шуурганы урдаас залахаар тааруулж бага гэрийн дайны гал түлж үүдэн хойморын дайтай хийсэн байгаа гал ын өөдөөс залахаар болжээ. Энэ сорыг балин барьж явсан Цорж лам галыг үзүүрт зогсон галын урдаас нэг удаа явахад галын дөл буцан эргэж тэр зуур сороо гал руу хийгээд буцаад зогсож байсан газраа ирэхэд гал араас нь нөмөрч байсан гэдэг. Үүнээс хойш Цоржийн эрдмийг давах аргагүй болжээ гэж олон лам нар ярьж байжээ.
3. Мөн шар Хадын хуудасны дэргэд байдаг ханан хадны Хошуунаас өвөл ус гарган өвөлжин малаа усалж байсныг олон хүн мэднэ.

Ямандаг бурханы хувилгаан Аграмба цорж Бадамдоригийн Дарамын амьдралын сүүлийн цаг мөчүүд

1938 оны 6-р сарын 21-нд баривчлагдсан. (Дилав хутагт Жамсранжав, Ёнзонхамбалувсанхаймчиг нарын хам хэргээр)

1938 оны 6-р сарын 21, 23-нд байцаагдсан. Байцаалтанд: Шилүүстэй сумын хоршооны Үржин гэгч хар хүн намайг баривчлахаар ирэхэд миний бие туйлын хүнд өвчтэй, ямар нэгэн хийсэн гэм үгүй тул явж чадахгүй. Хэрэв намайг аваачих хэрэг тохиосон бол манай гэрт буудаж алчихаад яв хэмээн эсэргүүцэл тавьсан. Ингэж нэг удаа баригдахаас үлдсэн гэж өчжээ.

Энэ байцаалтыг тэмдэглэсэн байцаагч Данзан-Очир.

1938 оны 6 сарын 23-нд ялын төлөвлөгөө гарсан.

1938 оны 7 сарын 1-нд 73 насандаа ялын дээд хэмжээ буудаж хороох ялаар шийтгэгдсэн.

Хавсралт 1

1. Хөрөнгө хураасан акт 1936.04-18

1. Цоохор хонх, очирын хамт 1
2. Жижиг зэс мандаа 4
3. Жижиг гуулин дийз 6
4. Цан (хос) 1, хэнгэрэг 1
5. Цоохор хонх, дамрын хайрцаг 1
6. Жижиг зэс таваг 1, модон таваг нэг (Ном судар битүүмжилсэн нэг авдар)
7. Хуучин манж орхимж 2

8. Шар торгон хүрэм 1
9. Цас чавир 1
10. Орхимжны манцуй 2
11. Хурган дотортой, халиу нударгатай шар торгон дээл-1
12. Улаан торгон тэрлэг 1
13. Айргийн шаазан 1
14. Шар цоохор олбог 1
15. Дархан хүний багаж ууттай 1
16. Будгийн шаазан хэрэглэл хайрцгийн хамт 1
17. Лүйжингийн том дамар 1
    - Хүрэн модон дамар 1
    - Цагаан хонх 1
    - Гандан 1
18. Манхагтай эм 1
19. Мөнгөн гүц, тулгын хамт, биеийн хамт явсан.
20. Цагаан баранзад
    - хадаг 1
    - Аюуш 4
    - Сайр 1
21. Мөнгөлсөн хэрэглэлтэй зэс гандан хосоор 1
22. Мөнгөн хэрэтэлтэй эмээл 1.
23. 6 ханатай бүрэн хэрэглэлтэй гэр 1
24. 4 ханатай эсгий гэр 1

2. Биеийн хамт хураасан зүйл

1. Улаан бажгар дурдан бүс 1

2. Зулын мөнгөн цөгц 3
3. Усны мөнгөн цөгц 1 ‹
4. Жижиг мөнгөн тойг і
5. :Мөнгөн толгойтой цоохор хонх 1
6. Мөнгөн хонхны гууре 1
7. Нүдний шил 1
8. Мөнгөн хэрэглэлтэй хазаар 1
9. Бие төгрөг 230

Нэгжиж үзсэн: Данзан-Очир

Жамьянмижид

Сумын дарга: Дандар

Нэгжүүлсэн: Дарам

Дээрх зүйлийг гэр орны хамт битүүмжилж үлдээсэн.

НАЦАГШУГАРЫН ЦЭРЭНДОНДОВ БУЮУ АНДИА ХУВИЛГААНЫ НАМТАР

Ч.Хулан
Хэл бичгийн ухааны доктор (Ph.D), ХААИС-ийн багш

Энэхүү илтгэлдээ ард түмний дунд Андиа хувилгаан, Агент хувилгаан нэрээр апдаршсан Завхан аймгийн Шилүүстэй сумын уугуул Нацагшугарын Цэрэндондовын намтрыг тодруулж, Монголын бурханы шашны хутагт хувилгаадын түүхэнд түүний эзлэх байр суурийг тодорхойлохыг зорьсон болно.

Андиа хувилгаан билгийн тооллын XV жарны шарагчин хонин жилийн -найрын дунд сарын 15-ны өдөр буюу 1919 онд Цэцэрлэг мандал аймгийн Отгон хайрхан уулын хошуу буюу одоогийн Завхан аймгийн Шилүүстэй сумын нутаг Хүрэн толгойн Өвөр булаг хэмээх газар ард Нацагшугарын хүү болон мэндэлжээ. Тэрээр 1924 онд 5 настайдаа Номч ламын жувилгаан Тойн ламын хойд дүрээр тодорч Агваанчинравданзансамбуу хэмээх сахилын нэртэйгээр Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн бэйсийн хошууны Гэндүнпэл даланд ширээт ламаар өргөмжлөгджээ.

Бидэнд “Номч хувилгаан Агваанчинравданзансамбуу богдын өлмийг багтатгах ерөөлийн үгс хэмээх нэрт оршвой” нэртэй Самади багш Дилова хутагтын, Ханчен Агваанпринлэйжамц буюу Мянганы хувилгаан 5 хэмээн олонд алдаршсан Лашин хувилгааны зохиосон хоёр солдив уламжлагдан ирсэн байна. Солдив бидэнд Андиа хувилгааныг Номч ламын хувилгаан болохыг баталж өгч байна.

“Шар морин жилийн зуны дунд сарын 15-ны их мацаг өдөр Улаан үст гамын хойд дүр Тойн хувилгаан бараа бологчдынхоо хамт Агвааншарав ламтныхыг Өргөн ширэгт зусаж байхад морилон иржээ. Гэгээнтэн залуу сайхан дүртэй, хурц ширүүн яриатай, омог бардам, өндөр сайхан нуруутай, яралзсан цагаан шүдтэй догшин дүртэй хүмүүн байсан ба сүсэгтэн олонд өршөөл айлтгал хүртээж байх зуураа “энд чинь ирж хэдэн жил айраг ууж амаръя” гэж хэлжээ. Манайхан ихэд бэлгэшээж энэ их хутагт маань жил болгон ирж айраг зоогпож байх юм байна гэж ойлгоод явахад нь “буцаж морилоорой” гээд цай сүүнийхээ дээжийг өргөн

цагаан хурганы арьс, самбай хадгаар даллан үлдсэн юм гэдэг. “Тэр намартаа Тойн хувилгаан хөдөөлж, Дамбийжанцан гэдэг ламыг дагуулж Цагаан бургасны голын айлуудаар хэсэж архи, айраг ууж явж “Хөхөө шувуу” гэдэг дууг байнга дуулдаг болж гэнэ. Настайчууд энэ хүн “явах нь ээ” “Хөхөө шувуу”-г байнга дуупах боллоо гэж ярьдаг байжээ. Өвөл нь Отгон сумд томуу дэгдэж олон хүн нас баржээ. Энэ үед Тойн хувилгаан лам гэрийнхээ баруун талын хамар дээр гарч шагайн дэвжээ засчихаад шагай тоглож байсан гэдэг. Удалгүй тэрээр нас барсан бөгөөд шарилыг нь Сүмбэрийн давааны өвөрт хайлахад баагисан хар утаа явсаар Уушигийн ар хавцал руу орохыг хонь хариулж явсан хүн харсан байна. Тэр жил Уушигийн ар хавцалд Шилүүстэй сумын харьяат Нацагшугарынх өвөлжиж байсан байна.»[1]

Хутагт, хувилгаадууд хэзээ явах, хаана дараа төрлөө олох зэргээ эндүүрэлгүй мэддэг бөгөөд мөн ийм түүх Номч ламын үе үеийн лагшин эрхэт тохиолдож төрөл төрөлдөө залагдан тодорсон учир шалтгаантай ажээ.

Андиа хувилгаан Гэндүнпэл хийдэд 4 жил орчим шавилан суусны дараа цаг төрийн байдал шашин номын эсрэг хандахад, хийдээ орхин, хар болж мал маллан, улаа хийх зэргээр, эгэл амьдарлаар амьдарч эхэлжээ. Тэрээр 1939-1945 онд Өмнөговь аймагт цэргийн алба хааж, сум нутагтаа буцаж ирээд мал маллах, тосны тасгийн эрхлэгч, бригадын намын хэсгийн зохион байгуулагч, сумын худалдаа бэлтгэлийн ангид агент зэрэг ажил албыг нэр төртэйгээр хашиж “Бид ялав” медаль, Халх голын ойн медаль, 5, 6, 7-р таван жилийн гавшгайч, Ардын хувьсгалын 40, 50, 60, 70 жилийн ойн медаль, Засгийн газрын хүндэт жуух, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас одонгоор шагнагджээ. Мөн ажиллаж байх хугацаандаа сум, аймгийн депутатаар удаа дарааллан сонгогдож, Аймгийн аварга агентаар гурван удаа шалгарч байсан байна.

Тэрээр улс орондоо 40 гаруй жил бүтээлчээр хөдөлмөрлөж 1979 он гавъяаныхаа амралтанд гарсан бөгөөд үр хүүхэд, ах дүүс, хамаатан садан, нутаг нугынхан, Монгол түмэндээ ач буян, ивээлээ хайрласаар 1996 онд бурханы хутгийг олсон билээ.

---

[1] *Ш.Сонинбаяр, Лашин хувилгаан Агваанпэрэнлэйжамцын намтрын тодруулга, Хутагтуудын өлгий миний Шилүүстэй, 2004, 54-55*

Андиа хувилгааны намтар цадиг, үе үеийн лагшин эрихсийн талаар тодруулахад дээр дурдсан төвд хэлээр зохиогдсон солдив чухал ач холбогдолтой билээ. Иймээс солдивын орчуулгыг түвд эхтэй нь тулгаж зарим зүйлд тайлбар тодруулга хийлээ. Монгол хэлээр хэвлэгдэн олны хүртээл болсон уг солдивын төгсгөлийн үгэнд *“Гэндүнпэл дацангийн лам, номч хувилгаан Агваанчинравданзансамбуугийн өлмийг бататгах энэхүү ерөөлийг Чойжи-Одсэр тэргүүтэн нийт иргэдээс сануулсны ялдамд Самади багш Дилова хутагт бээр бичсэний сайн буян арвижиг”* гэж гарч байгаа бөгөөд энэ төгсгөлийн үгийн Чойжи-Одсэр гэдэг нь Цорж лам Осор гэж монгол руу орчуулагдахыг олж тогтоолоо. Энд гарч буй цорж лам Осор нь Лашин хувилгаанд ном эхлэн заасан Осор хамба лам байж болох юм.

Лашин хувилгааны зохиосон солдивын төгсгөлийн үгийг “авга ах Агвааншарав бээр сэдэлт гаргасан ба үүнээс өмнө хувилгаан Арь гэгээнтнээс зарлигийн эш буусанчлан Радэн хийдийн Янгомбо Очирдарийн хувилгаан нэрийг баригч ханчен Агваанпринлэйжамц бээр найруулсны бичээч нь унзад, аяга тахимлаг Агваансамбуу болой” гэж “Цагаан суваргын эзэд”, “Очирваанийн хутагтууд”-д хэвлэгдсэн солдивт нагац ах Агвааншарав гэж мадагтай орчуулсан байна. Агвааншарав нь номтой лам байсан бөгөөд хувилгааны ээжийн төрсөн ах буюу нагац ах юм. Түвд эхтэй гавж Ш.Сонинбаяр багштаны тусламжтайгаар тулгаж үзэхэд нагац ах Агвааншарав гэж байлаа. Гавж Ш.Сонинбаяр бидэнд хувилгаан Ари гэгээнтэн гэдгийг Ари бүрлүгү буюу 8-р Богдын ёнзон хэмээн тодруулж өгөв. “8-р Богдын номын багш ёнзин Ари бүрлүгү Дуутын хүрээнд Агваанпринлэйжамцтай ирж уулзаад Төвдийн Радэн Доржчангийн хойд дүрийн Лашин хувилгаан гэж тодруулжээ. 1911 онд 8-р Богдыг хаан ширээнд залрах үед Лашин хувилгаан Их хүрээнд ирж суун ном зохиол бичиж байжээ” гэснээс үндэслэвэл Лашин хувилгаан 8-р Богдын ёнзин Ари бүрлүгүгийн хүсэлтээр энэхүү солдивыг зохиосон болох нь тодорхой байна.

“Төвдийн Ари гэгээн миний багш хэмээн Андиа хувилгаан дурсан ярьж, багшийнхаа хойд дүрийг хаана төрснийг мэдэх хүсэл өвөрлөж байсан бөгөөд “Ари гэгээн танаа сахил талбиху дагаан хайрласан хадаг энэ буй” хэмээх монгол бичиг бүхий цаас хавчуулаастай хадаг Андиа хувилгаанд хадгалагдаж байсан бөгөөд эндээс дүгнэж үзвэл

Андиахувилгааны сахилын багш нь Түвд лам 8-р Богдын ёнзин Ари бүрлүгү Данзанхайдав болж байна. Арь бүрлүгү Данзанхайдавыг Арь гэгээн Чанравтай андуурч бичигдсэн зүйл Андиа хувилгааны хэвлэгдсэн хэд хэдэн намтар, танилцуулга зэрэгт тохиолдож байгааг цаашид залруулах нь зүйтэй санагдана. Мөн нэг зүйлийг нэмж хэлэхэд хувилгаан тодруулах эрхтэй 8-р Богдын номын багш ёнзин Ари бүрлүгү Андиа хувилгааныг Номч лам Тойн хувилгааны хойд дүрээр тодруулсан байх боломжтой байна.

Солдивын төгсгөлийн үгэнд Гэндүнпэл дацангийн ширээт, Гэндүнпэл дацангийн лам, номч хувилгаан гэж гарч байгаа нь энэ хийдэд хувилгаанаар тодорч залагдсан гэдгийг гэрчилнэ. Харин зарим ном товхимолд Гэндүнпэл, Халтарын хүрээ хоёрыг нэг хүрээ мэтээр, эсвэл Халтарын хүрээнд хувилгаанаар залагдсан гэж бичиж тэмдэглэж байгаа нь ташаа зүйл болно. Үүнийг Завхан аймгийн Отгон сумын Улаанбаатар хотод амьдарч буй өндөр настангууд, нутгийн түүхийг сонирхон судлагчдаас асууж тодруулан энэ хоёр нь нэг хийд биш болохыг тогтоосон. Тэндүнпэл дацан нь гурав нүүсэн бөгөөд анхлан Отгон сумын Хуягтын аманд байгуулагдсан. Эхний удаад шатаж, хоёр дахь удаад дацан үерт автаж гурав дахь удаад Хүрээний ам хэмээн нэрлэгдэх газарт шилжин бууж Донхор Шавран гэдэг хүнээр дуганаа бариулж байсан”»[2] түүхтэй ажээ. Монголын урлагийн зөвлөлийн “Сүм хийдийн түүхэн товчоо» төслийн хүрээнд судалгааны эргэлтэнд орсон Тагнуулын төв газрын архивт буй 1934-1938 оны хооронд хийгдсэн сүм хийдийн бүртгэлд Тэндүнпэл хийд сумын төвөөс зүүн хойд зүгт 30 км, баруун талд нь Халтарын хийд 5 км-т орших бөгөөд , Тэнгэр тэтгэгч хааны үе буюу Монголын 2-р богд Жавзанлувсандамбийдомой гэгчийн үед 1700-аад онд Гэндэн гэгч тойн байгуулжээ. 1928 онд эзгүйрч 2234 тоот ёсоор хаасан. Хийдэд нийт найман байгууламж байсан бөгөөд үүнээс сүм дуган долоо, байшин нэгтэй байжээ. Хаагдах үед хийд 59 ламтай байсан бөгөөд тэдний 30 орчим нь хийддээ тогтмол хурж байсан» гэдэг мэдээ байна.

Эндээс үзвэл хувилгаан Н.Цэрэндондов уг хийдэд 5 настайдаа залагдаж 1928 он хүртэл дөрвөн жил ширээт ламаар суусан бөгөөд Гэндүнпил хийдийн сүүлчийн ширээт, сүүлчийн хувилгаан нь байжээ.

[2] *Ч.Юнрэндорж, Завхан аймгийн Отгон сумын уугууп, 1934 онд төрсөн өндөр настан*

Энд бидний сонирхлыг татаж буй бас нэг зүйл нь Дилова хутагт, Лашин хувилгаан хоёул түүнд солдив зохиосон явдал юм. Ард олны дунд домог мэт дэлгэрсэн олон хууч байдгаас нэгийг энд жишээ татвал “Түүнийг гурван настай байхад Лашин хувилгаан Дэчинчойлин буюу Өргөн ширэгийн хүрээнд залах гэж байх үест Дилова багштан морилон таарчээ. Дилова багштан Лашин хувилгаанд цаг нь болоогүй зүйл. Чиний хийх хэрэг энэ биш гээд хүүгээ дүүрч хүрээнд ирсэн Нацагшугарт авчир гэсний зоргоор авч явж байдаг нь гэж ихэд дургүйцэн гэр өөд нь буцаасан байна. Дилова жутагт 1924 онд хүүг таван нас хүрэхэд нь Отгон сумын Гэндүнпэл дацанд «цаг нь боллоо гээд хувилгааны сэнтийд нь залж мандал өргөжээ.»

Бидний дээр дурдсан хоёр солдивын тухайд энэ аман хуучтай холбогдож болох учир шалтгаан тодрон гарч ирж байгаа бөгөөд 1922 онд Лашин хувилгаан Дэчинчойлин хийдэд залах гэж байхдаа нэгэн солдив, 1924 онд “Дилова хутагт Гэндүнпэл дацанд залахдаа нэгэн солдив тус тус зохиосон гэж үзэж болохоор байна.

Мөн нөгөө талаар түүнд хоёр их хувилгаан тус тусдаа ерөөл билиг талбисан учрыг дараах байдлаар тайлбарлаж болно. Тус хошууны Наробанчэн хийдийн мяндагган, Монголын бурханы шашны томоохон зүтгэлтэн, нөлөө бүхий хутагт болох Дилова хутагт Жамсранжав өөрийн шашин номын хийд орон оршсон хошуу нутагт тодорч буй Цэрэндондов хувилгааны цаашдын хувь тавиланг тольдон хараад өөрийн биеэр хувилгааны ширээнд залж, мандал өргүүлсэн нь ирэх цагийн гай барцдыг зайлуулж холдуулсан төдийгүй дараа төрөлдөө эргэн учрахын ерөөл билиг тавьсан үйл хэрэг болжээ.

13-р Далай лам Түвдэнжамцаас Ханчин ямба олгогдсон, Төвдийн Радэн Доржчангийн хойд дүр Лашин хувилгааны хувьд Баянзүрх, Сонгино уулын сан тахилга, Хүрээ дөрвөн уулын сэржим, “Отгонтэнгэр ууланд сан тахилга өргөх ёс сайн буяны есөн хүслийн хурыг буулгагч “ зохиол, Шамбалын ерөөл”, “Ловон Бадамжунайн залбирал” зэрэг олон арван ном бүтээл туурвисан бичгийн хүний хувьд хошуу нутагтаа төрж буй хувилгаан, тэр дундаа хатуу цагийг туулан шашны алтан аргамжийг хойч үеийнхэнд ззлгуулах Цэрэндондовт зориулж түүний цаашдын зам мөрийг засан, аврал

одуулсан солдив нэгийг зохиох хүсэл төрж, үүрэг, хариуцлага тохоогдсон нь мэдээж хэрэг болох билээ.

Ийнхүү Андиа хувилгаан нь шашны элч төлөөлөгчийн соён гэгээрүүлэх үүргээ нэр төртэйгээр биелүүлсэн Монголын хувилгаадын нэг бөгөөд цаашид бидэнд түүний илэрхий тодорхой мэт боловч бүдэг бүрхэг намтар, үе үеийн лагшин эрихсийн түүхийг сурвалжлан судлах шаардлага тулгарч байна. Дээр өгүүлсэн зүйлээс үндэслэн дүгнэвэл Андиа хувилгаан нь

1. 8-р Богдын ёнзин, төвдийн Арибүрлгү Данзанхайдав хувилгаанаас сахил хүртсэн, Дилова хутагт, Лашин хувилгаан нараар солдивоо зохиолгосон, Номч ламын хувилгаан болно.
2. Андиа хувилгааны сахилын багш нь 8-р Богдын ёнзин, түвд лам Ари бүрүлгү байсан байна.
3. Андиа хувилгаан нь Завхан аймгийн Отгон сумын нутагт байсан Гэндүнпэлийн хүрээнд 1924 онд ширээтээр залагдаад 1928 он буюу хүрээ хаагдах хүртэл дөрвөн жил орчим шавилан суусан тус хүрээний сүүлчийн хувилгаан, сүүлчийн ширээт байжээ.
4. Андиа хувилгаан нь автономит-засгийн үед төрж, хувьсгалт засгийн эхэнд шашин сахиусаа нууцалж, ардчилалын эхэнд дахин дэлгэрсэн шажин сургаалаа хойч үедээ өвлүүлж чадсан гавъяатан билээ.
5. Андиа хувилгаан нь шашин бурхан ном шүтэх дээдлэх үзэл санаа хаагдмал байсан социалист нийгэмд ард түмэндээ сургаал хүргэж, олон түмнээ бурханы шашнаар хүмүүжүүлж чадсаныхаа төлөө Монголын бурханы шашны түүхэнд, Монголын хутагт хувилгаадын түүхэнд өөрийн гэсэн орон зайг хүндтэйгээр эзлэх элч хувилгаан билээ.

Энэхүү илтгэлээрээ бид Андиа хувилгааны намтар, түүх, лагшин эрихсийн судалгаа, дараа төрлийн эрлийн эхлэлийг тавьж буй бөгөөд цаашид социалист нийгмийн үед нууцлагдан амьдарч байсан ч ард түмэндээ ивээл буянаа хайрлаж шашны элч төлөөлөгчийн соён гэгээрүүлэх үүргээ нэр төртэйгээр биелүүлсэн хутагт хувилгаадыг судлан сурвалжпах нь Монголын бурханы шашны түүх, үзэл санаанд нэн шаардлагатай судалгаа болно гэж үзэж байна.

Хавсралт 1

Номч хувилгаан Агваанчинравданзансамбуу богдын өлмийг бататгах ерөөлийн үгс хэмээх нэрт оршвой

Ум амгалан болтугай

Еолор цагаан сүмбэр уулнаа Хан хурмастын нуман солонго
Бүчин хүрээлсний гоо үзэмж мэт хараад хараад ханашгүй лагшинт
Хэтэрхий үлэмжийн охин тэнгэр цагаан дарь эх та
Хор нөхдийн хамтаар хишиг буянаа хайрла.

Хэлний эрхэт, эрхэм айлдалт, зөөлөн итгэлт багш та
Ханьцашгүй дээд эш оноолтын шашныг баригчдын эрхэм
Суу мэргэн, шударга ёс сайн сэтгэлийн цогийг эрхшээгч
Цог төгөлдөр багшийн өлмий зуун галбад батжих болтугай.

Багш гурван эрдэнийн адис жанлавын хүчээр
Бидний үл хүсэх хөнөөлийг хоцроолгүй амирлуулж
Алин зохилдох сайн чуулганг далай мэт арвитгаад
Амгалан жаргалангийн цог дор цэнгэхийн өлзийг хайрла

хэмээх Гэчдүнпэл дацангийн лам, номч хувилгаан Агваанчинравданзансамбуугийн өлмийг бататгах энэхүү ерөөлийг Цорж лам Осор тэргүүтэн нийт иргэдээс сануулсны ялдамд Самади багш Дилова хутагт бээр бичсэний сайн буян арвижиг.

Амгалан болтугай

Хотол чуулсан буман буяны цог эрдэмт
Хуурмаггүй арвин ялгуулсны эрхэт Богд лам
Ялж төгссөн Аюуш сэлт үлэмжийн тэнгэр
Ямагт үүнээ буяны цэцгэн хурыг буулган соёрх.

Үнэн гайхамшигт үлэш үгүй бэрх хатуужлаар
Үл суралцахуйн бурханы хутгийг илэрхий олсон
Мила Тойвгаа тэргүүтэн хутагт хувилгаадын
Мэндэлсэн цадиг улиран залрагсдад мөргөн залбирмой.

Хэлний эрхэт эрхэм айлдлын болор хот мандлаас
Ивээн цацрагч эш онолын шашны гэгээн гэрэл
Мэргэн, шударга, сайн сэтгэлийн лянхуа цэцэгсийг
мөшөөлгөн дэлгэрүүл.
Гэтэлгэгч богд, амьтныг ивээгч наран танаа залбирмой

Итгэлт та олон галбын өмнө шимнусын өмгийг
Илт даран зохиож бурханы хутгийг илэрхий болгосон ч
Орон үүнээ хувилгааны дүрст лагшинг таалаараа болгоож
Олон галбыг хүртэл залран, батжиж оршин соёрх.

Хуурмаггүй дээд чухал гурвын адитстэд хийгээд
Хүчин төгөлдөр номыг тэтгэгч сахиуснуудын үйлсээр
Цог төгөлдөр багшийн лагшин сүүдэр, үйлс зохионгуй
Саад тотгор үгүй еэ ая зөндөө бүтэх болтугай.

хэмээн номын их хүрээлэн Гэндүнпэл дацангийн ширээт, номч ламын хувилгаан Агваанчинравданзансамбуугийн өлмийг бататгах энэ адил нэгэн хэрэгтэй байна хэмээн нагац ах Агвааншарав бээр сэдэлт гаргасан ба үүнээс өмнө хувилгаан Арибүрлгү гэгээнтнээс зарлигийн эш буусанчлан Радэн хийдийн Янгомбо Очирдарийн хувилгаан нэрийг баригч ханчен Агваанпринлэйжамц бээр найруулсны бичээч нь унзад, аяга тахимлаг Агваансамбуу болой.

БОГД ОЧИРВААНЬ УУЛ ХИЙГЭЭД ТҮҮНИЙГ ТОЙРОН ТӨРСӨН БУРХАД ХУВИЛГААДЫН ТУХАЙ

Н.Пүрэвжав
Монгол улсын гавьяат эмч ,доктор (Ph.D), профессор

Эрт дээр үеэс өдгөөг хүртэл Отгонтэнгэр уулыг Очирваань бурханы увидас аравнай шингэсэн ариун дагшин орон хэмээн шүтсээр ирсэн билээ. Энэ дагшин оронд өөр хаана ч үл байх таван өнгийн арц, таван өнгийн чулуун эрэл гэх мэт ховор нандин анагаах шидтэй ургамал чулуу элбэг бий. Эдгээр увидаст ургамал, шороо, чулуудын шим шингэсэн ариун рашаан ар өвөөс нь ундран байдаг бөгөөд энэхүү рашааныг бишрэн шүтэж хэрэглэсээр ирсэн.

Богд Очирваань уулыг дээр үеэс тахиж шүтэж ирсэн хүндтэй уул юм. Мэлхий чулуунаас дээш эмэгтэй хүн гардаггүй бөгөөд тахидаг овоон дээр нь лам нар болон ихэс дээдэс очдог байна. Овоогоо тахихдаа хошууны ноён халх түмэн болон олныг даатгаж баранзад хадганд гулууз мөнгө ороож өргөж байсан гэдэг. Мөн энэ уулын эргэн тойронд Монголын хутагт, хувилгаадын бараг тэн хагас нь төрсөн бөгөөд зарим нь хэд дахин энэ л нутагтаа эргэж төрсөн байдаг.

Хуучнаар Сайн Ноён хан аймгийн Хошууч мэргэн бэйсийн хошуу, Завхан аймгийн Шилүүстэй сумын нутагт хувилж төрсөн хутагт хувилгаадын тухай товч дурдъя.

Андиа хувилгаан нь энэ уулын өвөрт 4 удаа хувилж төрсөн юм. Хамгийн анхны дүр нь Номч лам алдартай. Богд Очирвааны зүүн өвөрт төрсөн бөгөөд Буянт голын эхэнд Гэндэнпилын хүрээг байгуулж тэндээ шавилан сууж байжээ. Хошууны анхны хүрээ учраас Хошууч бэйсийн хошууны бүх хүрээ цагаан сар гараад ууган хүрээний мэндийг илч явуулж мэддэг байсан гэдэг.

Хоёр дахь дүр нь Богд Очирваань уулынхаа өвөрт төрсөн Улаан үст хувилгаан гэж хүн байсан. Хөгшидийн ярих нь Гэндэнпилын хүрээнд залардаг их сонин улаан үстэй, маш сайхан хүн байж.

Гурав дахь дүр нь Богд Очирвааний зүүн урд төрсөн Тойн хувилгаан гэж байсан бөгөөд 1917 оны морин жил таалал төгссөн

гэдэг. Энэ гурван дүр нь бүгд тайж угсааны хүмүүст хувилж байсан.

Дөрөв дэхь дүр Андиа хувилгаан нь 1918 оны намрын дунд сарын 17-ны сайн өдөр Шарав гэлэн хэмээх ламын зээ болон төрсөн. Төрсөн газар нь буюу Хүрэн толгойн Өвөр булагт овоо босгосныг өдгөө ч жил бүрийн намрын дунд сарын 17-нд тахисаар байгаа билээ. Түүнийг 5 настай байхад нь тодруулж Гэндэнпилийн хүрээнд залж байх үед нь гэнэт бөөн хар үүл гарч бороо дусалж эхлэхэд нагац лам нь “Энэ бороо орох нь цугалсан олны дээл хувцсыг норгох нь, Та энэ бороог аргал гэж хадаг барихад тэрбээр хадгийг хуруундаа өргөж даллан гүйхэд үүл таран бороо онгойж байсан гэдэг.

Андиа гэгээнтэний биеийг үзэж байсан минь

Андиа намайг очих тоолонд биеэ үзүүлнэ. Би анагаахын сургуулийг тэр үедээ онцгойлж байсан үнэлгээгээр “Улаан диплом” алтан медальтай төгссөн 1979 оны цөөхөн төгсөгчийн нэг нь болж өөрийгөө тоож, бүх зүйлийг мэдэж сурч болмоор юм шиг санагдсан залуугийн өөдрөг сайхан сэтгэлд хөтлөгдсөн үе юм.

Сургуулиа төгсөөд Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг, Баянхайрхан сумын хүний их эмчийн салбарын эрхлэгч зэрэг ажлыг хийж, хүн үзэх овоо дөртэй болж байсан үе. Андиагийн биеийг үзэхдээ бүх биеийг үзнэ. Биеийг нь анх үзээд би хэд хэдэн зүйл дээр үнэхээр гайхаж билээ.

Гарын хурууны хумс нь хүнийхээс өөр бөмбөгөр гялтгар тунгалаг

Гарын хуруу нь яг савх шиг шув шулуун үзүүр нь нарийхан, үенүүд нь бараг мэдэгдэхгүй, үе нь хонхор

Биеийн арьс нь маш зөөлөн, яг торго шиг нимгэн

Бие нь зүрх судас, уушиг, хоол боловсруулах, толгой, тархи, бөөр, давсаг гээд ер нь эв эрүүл нялх хүүхдийнх шиг байдагсан.

Тэгээд би таны гар хуруу, арьс, хумс ямар сонин юм бэ? Хүнийхээс өөр гэхээр урдаас олон юм ярихгүй харин тийм хачин байгаа биз гэж хэлнэ. Тэгээд таны бие сайн байна, зүгээр байна гэхээр өө тийм үү хэдэн жил амьд явах нь дээ л гэнэ.

Андиа гэгээнтнээ тэнгэрт үдэж, ариун дагшин Отгонтэнгэрийн орноо ирэхийг хүлээж буй он жилүүд

1996 оны 6-р сарын 5-ны өглөө

Ж.Дашдорж (дээд шүүхээс) над руу ярьж Андиагийн бие муу байгааг дуулгаж билээ. Ингээд би Шилүүстэйн холбоо руу ярьж Андиагийн бие ямар байгааг тодорхой мэдэж, ухаан санаа даралт, зүрх судас, давсаг бөөрний үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл авч, Эрүүлийг хамгаалах яамны дэд сайд Г.Дашзэвгэ багш дээр очиж, үнэн байдлыг хэлж 3-р эмнэлгийн зүрх судас тасагийн эмч, доктор Баяртогтох , 1-р эмнэлгийн Урологийн тасгийн эрхлэгч Нарантуяа нарын бүрэлдхүүнтэй баг байгуулж, тушаал гаргуулаад эндээс авч явах эм бодис, бүх юмаа базааж аваад 6-р сарын 12-ны өглөө Завхан руу онгоцоор гарлаа. Онгоц 12.30-д буух ёстой байтал буудаггүй. Би босож очоод үйлчлэгчээс асуутал, Завханы агаар муу хүлээн авах боломжгүй болоод буцаж Говь-Алтай буухаар боллоо гэв. Тэгээд удалгүй 12 цаг өнгөрөөд Говь-Алтайд буугаад онгоцны буудлаас холбоо орж Шилүүстэй рүү яривал Говь-Алтай руу Дашдаваа жолооч та нарыг авахаар явсан гэлээ. Бид сумаар дайралгүй шууд Өвөр цэцэрлэгт 19.15-д Андиагийнд иртэл хүмүүс цугларчихсан бөөн уйлаан болж байв. Юу болов, яав гэтэл 15 минутын өмнө бурхан болчихлоо гэж хэлэв.

Маргааш нь Ичиноров ах, Сандагдарж бид гурав Цагаанхайрхан сумын төв орж Номч мэргэн, хамба ламтан Чойжин гуайд бараалхаж болсон явдлыг айлтгав. Тэгээд Андиагийн алтан савыг нээж байгаад бурхан хүн өөрийгөө яах тухай та нарт маш тодорхой шинжүүдийг 3 дахь, 5 дахь, 7 дахь өдрүүдэд үзүүлнэ. Түүнийг нь хүлээх шаардлагатай тэр шинжүүд мэдэгдтэл маань номын бүх үйлийг үргэлжлүүлэхийг захисан билээ.

1 дэх шинж:

Удалгүй хав харанхуй болж, гадаа хүмүүс маань унших, гэрүүдийн ойр орчинд адуу мал тургилах чимээнээс өөр юу ч үгүй түнэр харанхуй байтал Андиагийн байгаа гэрийн тооноор бөөрөнхий цагаан гэрэл гарч ирж эгц дээшээ хөөрч, улам гайхамшигтай гэрэлтэй болж, өдөр шиг болоод, асгамжаатай морины зүс, үхэр малын зүс бүр тодорхой үзэгдэж эхлэхэд мөргөн залбирч, уйлан хайлав аа.

Ийм онцгой өвөрмөц цаг үед бид залбирч, мөргөх, маань уншихаас өөр юу хийж чадах билээ дээ. Тэгээд тэр бөөрөнхий цагаан гэрэл Дааган дэлийн модтой уулыг гэрэлтүүлэн байж цаагуур нь орж баруун урд зүг рүү шингэн одсон бөлгөө.

2 дахь шинж:

Хурдас үүсэх шинж нь бурхан болооч биеэ хураасныхаа дараа дух, магнай хавиар нь бүр тодруулбал хоёр хөмсөг, духны цохны хэсэгт шүүрч тодорхой хурдас үүсэх бөгөөд энэ хурдасыг маш нарийн нямбай авах байв. Энэ хурдас 3, 5дахь өдөр тохиох байлаа.

3 дахь шинж:

Бурхан болоочийн өөд болсон сар бол зуны эхэн сар учраас ерөнхийдөө хүйтэвтэр байсан бөгөөд манай нутагт бүр сэрүүн бүгд л хөвөнтэй дээлтэй байцгаав. Тэнгэр хангай заримдаа цас бороо холилдон шивэрч, заримдаа тэнгэр тунгалаг нартай болж байсан билээ. Андиа бурханы оронд залраад 5 дахь өдрөө болж байтал Их мянганы өврийн хуучин хүрээний буурины ойролцоо үүлс газар бууж, тэрүүхэн орчинд босоо цагаан багана босов, энэ босоо цагаан багана ойролцоогоор 1 цаг 3О минут үргэлжилж улмаар тэнгэрт солонго татаж бид бүгдийг бишрүүлэв. Бид зүүн талын гүвээ рүү нэг хэсэг нь Өвөр нарийны гол руу явж босоо цагаан багананы буусан газрын товыг тогтоов. Тэгээд бид зургийг нь авч байтал тэнгэрт солонго татаж солонгын хоёр зах нь мянганы өвөр, нөгөө зах нь хүрээний бууринаас доохно тусав.

Бид тэр газрыг маш сайн товлож, босоо цагаан багана, солонго арилсны дараа үзээд энэ бол Андиагийн намайг энд нутаглуул гэсэн шинж тэмдэг мөн гэж үзээд Андиагийн цагаан суваргыг босгож аравнайлан залсан билээ.

ХУТАГТ СУДЛАЛ XX ЗУУНД

М.Гантуяа
МУИС-ийн Философи, Шашин судлалын тэнхимийн доктор (PhD), профөссор

Би энэхүү илтгэлдээ XX зуунд Монголын хутагт хувилгаадын талаар судалгаа хийж, дүгнэлт тайлбар өгсөн манай түүхч, гүн ухаан, утга зохиол, шашин судлаач нэрт эрдэмтдийн судалгааны тоймыг товч өгүүлэх болно.

18-р зуунаас эдүгээ хүртэл Буддын шарын шашин нь Монголын нийгэм соёлын амьдралд голлох шашин болж ирсэн билээ. Сүүлийн үед Монголын Бурханы- шашины түүх, эх сурвалж, ялангуяа лам хуврагууд, хутагт хувилгаад, сэтгэгч мэргэдүүдийн талаар шинэ сонирхолтой мэдээ мэдээлэл, судалгаа шинжилгээний үр дүн улам ихээр гарсаар байна.

Монголд бурхан шашин XVIII зуунаас уг шашин урьд үзэгдээгүйгээр дэлгэрч, түүний үзэл санаагаар монголчууд гэр бүл, нийгмийн хүмүүжлийг авч, зан үйл, дэг жаягийнх нь тусгал нөлөө хүмүүсийн амьдралын салбар бүхэнд гүн нэвтэрч, буддын мэдлэг боловсрол, гүн билигуханд нь сонирхон татагдах явдал улам хүчтэй болсон байна.

ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор Ч.Жүгдэр багшийн тэмдэглэн бичсэнээр, сүм хийдүүд нь зөвхөн хурал номын газар төдийгүй, гүн ухаан, анагаах, тэжээхүй ухаан, зурхай, урлахуй ухааны зэрэг их бага таван ухааныг судалдаг дацан сургуулиуд болсон юм. Их Хүрээний буддын гүн ухааны сүүлчийн сургууль 1739 онд, бусад нь 18 дугаар XIX зууны сүүлээр байгуулагдсан бөгөөд сүүлдээ Гандангийн шашны их сургуульд нэгджээ. Тус сургуулийн Дашчоймбол, Гунгаачойлин, Идгаачойлин дацангууд буддын шашин гүн ухааны үндсэн таван төрлийн хичээл буюу чойрын таван боть үздэг болжээ. Хөдөөгийн хийдүүдэд ч мөн чойрын дацан байгуулагдаж лам нар олноороо буддын гүн ухааныг гүнзгий судлах болсон байна.

XIX зууны сүүлчээр буддын сүм хийдүүд зохион байгуулалт, дотоод дэг ёс, үзэл онолын хувьд өмнөх үеэсээ доройтон буурч,

шашин, сүм хийд, лам нарын тухай буддын анхан эртний сургаал, ёс дэглэм орхигдож эхэлсэн үест үндэсний тусгаар тогтнол, шашин шүтээнээ эрхэмлэн хүндэлдэг, эх оронч, чин шударга эрдэм боловсролтой Агваанхайдав хамба, ноён хутагт Данзанравжаа, Жалханз хутагт Дамдинбазар, Заяын гэгээн Жамбацэрэн, Ламын гэгээн Чулуун, Егүзэр хутагт Галсандаш, Манзушир хутагт Цэрэндорж, Дилов хутагт Жамсранжав зэрэг буддын хутагт хувилгаад, сэтгэгч мэргэдүүд төрөн гарсан билээ. Тэдний үйл хэрэг, уран бүтээлд үндэсний эрх чөлөөг эрхэмлэсэн, шашныг ариусган шинэчлэх үзэл санаа үеэс илүүтэйгээр туссан байдаг.

1639 онд суурь нь тавигдсан Их Хүрээ л гэхэд 1903 он гэхэд 10 дацантай, Зүүн Хүрээ нь 12 аймаг, Баруун Хүрээ нь 18 аймаг, нийт 30 аймагтай болж асар их хөрөнгө малтай, жасын саИтай болсон байв. Заяын г.сзэ. Вангийн хүрээ, Сан Бэйсийн хүрээ, Сэцэн хан, Засагт хан, Сайн ноёны хүрээ, Ламын гэгээний хийд, Улаангомын хүрээ зэрэг томоохон гозэ хийдүүд хөдөө нутаг дахь соёл иргэншлийн төв болж нийгмийн оюун са-ааны амьдралд чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Хүрээ хийдүүд суурьшиж, шашин номын сургууль дацангууд үүсч эхэлснээр монголчууд буддын төрөл бурийн ухаанд суралцах болж, монголын буддын шашин-соёлын уламжлал тогтсон байна.

XX зууны эхнээс 1990-ээд оныг хүртэл Бурханы шашинд ч тэр, бусад аливаа шашин шүтлэгт хандах Монголын төрийн хандлага марксист шашингүйн үзлийн далбаан дор явагдаж байсан учраас Бурханы шашины талаар явуулсан судалгаа, шинжпэх ухааны бүтээлүүд нь шашныг бурангуй, мунхруулагч хэмээн тал бүрээс шүүмжлэн няцаахыг гол болгож байсныг эс тооцвол энэ үеийн шашны талаархи эрдэмтдийн судалгаанд эдүгээ ч анхаарлаа хандуулбал зохих олон чухал мэдээ баримт, дүн шинжилгээ байдгийг эргэн саналтай.

Америкийн нэрт Монголч эрдэмтэр Оуэн Латтимор: “Дэлхийд зургаан сая гаруй Монгол байна, бүгдийг нэгтгэн нийлүүлвэл хүчтэй улс болно доо... хэмээн ярьж Америкийн зөвлөхийг болон Чан Кайшиг цочоодог байсан..., Гоминданы засгийн газар Монголыг хүлээн зөвшөөрөхөд Дилова их хувь нэмэр оруулсан хүн” хэмээсэн нь манай хутагт хувилгаадын талаархи үнэн зөв дүгнэлт судалгаа хийсэн гадаад дотоодын олон эрдэмтдийн нэгэн жишээ билээ.

Монголын эрдэмтдээс доктор Д.Дашжамц, шинжлэх ухааны сурвалжлагч гишүүн Ч.Жүгдэр нарын бүтээлд Монголын Буддын хутагт мэргэдүүд монголчуудын үндэсний ухамсар тэмцлийг өсөн нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байсныг тэдний зохиол бүтээлийнх нь үзэл санаагаар илэрхийлэн гаргасан билээ.

Академич Ш.Нацагдорж, доктор С.Пүрэвжав зэрэг Монголын нэрт түүхчид шарын шашин хүчтэй дэлгэрсэн учир шалтгаан, шашин сүм хийдийн боловсрол, соёл болон санхүү эдийн засгийн өсөлтийг архивын нарийн мэдээ баримт дээр тулгуурлан гаргаж ирсэн байдаг.

Монгол газраа шарын шашин дэлгэрч эхэлснээс хойш Манжийн зүгээс монголчуудыг хойд хязгаараа хамгаалуулах цэргийн хүчин болгох зорилгоор 18-60 насны хүмүүсийг лам болохыг хуулиар чандлан цаазалж зөвхөн насанд хүрээгүй буюу эсвэл цэргийн наснаас хэтэрсэн хүмүүсийг лам болохыг зөвшөөрч байв. Алтан ханы үед лам нарыг албан татвараас хэлтрүүлэх, тэднийг цэргийн албанд явуулахгүй, ав аянд дайчлахгүй байх, лам нарыг доромжилсон, тэдэнд гар халдсан хүнийг чанга шийтгэх хууль байсан ч манжийн албан ёсны хууль дүрэмд лам нарын эдпэх онцгой эрх ямбын тухай тусгайлан заасан зүйлгүй ажээ. Гэхдээ лам хүнийг цэргийн болон харуулын албанд дайчилдаггүй байв. Лам болсноор хамжлагат байдлаас чөлөөлөгдөж, бурханы шавь хэмээн олонд хүндлэгдэж, мэргэ төлөг тавьж, ном уншиж, эм залж тодорхой орлого олдог, лам хүний эд хөрөнгийг нь шууд албан татвар болгон хураахыг нүгэл хэмээн үздэг байжээ. Олон хутагт, номун хан лам, энгийн хувилгаан нар, тамга бүхий хутагтын шавь нарыг захиран засах шанзудва нарын хөрөнгө малаас алба гаргуулахгүй байх, харин малыг нь гурван хувь бодож түүнээс хоёр хувийг харъяат шавийн сүм хурлын зардал хэрэгслийг нийлүүлэн, үлдсэн нэг хувийг аймгийн доторхи албанд томилж байхаар болжээ. Шавь нарын аливаа хэргийг таслан шийдэхдээ хүрээ хийдийн жаяг, “Халх журам” гэх мэтийн монгол хуучин хуулийг баримталдаг байжээ.

Академич, түүхч эрдэмтэн Ш.Бира “Монголчууд нийтдээ Буддын шашинтан болсноор тэд эцсийн бүлэгт Буддын шашин, соёлын их ертөнцөд хамаарагдах болж, Хятадад уусан ижилссэн манж захирагчдаасаа оюун санаа, зан заншлын хувьд улам бүр хөндийрөн холдоход хүрчээ. Манжийн хаадаас олон жилийн туршид

Монгол дахь шашны талаар явуулж байсан бодлого ялангуяа эхний үедээ тэдэнд тус дөхөм болж байсан нь үнэн боловч яваандаа манж захирагчид өөрсдөө ч урьдчилан харахын аргагүй, огт өөр үр дагавартай болсон нь тодорхой” хэмээн нэн оновчтой тэмдэглэн хэлсэн буй.

XIX зуунд Монголд хутагт хувилгаад олноороо бий болж шашин төрийн дээд эрхийг барих болсон ба хутагтуудын шавь нарын тоо нь он жил ирэх тутам олширч тэдний мал сүрэг нь уул хошууны нутагт багтахгүй болж, аяндаа тусгаарлан шавь нар захирах “тамга” (эрх) авах хэрэгтэй болсон нь Живзундамба хутагтаас гадна Засагт хан аймагт Жалханз, Ялгуугсан ,(Бэгэрийн) Номун хан, Сэцэн хан аймагт Егүзэр, Ялгуугсан, Сайн ноён хан аймагт Зая бандида, Эрдэнэ бандида (Ламын гэгээн), Чин сүзэгт Номун хан. Наро Банчэн, Эрдэнэ мэргэн ноён хутагт, Шива ширээт, Наран хутагт, Хамба хутагт гэсэн халх дөрвөн аймгийн нийт өрхийн 20 орчим хувь, мал сүргийн 10 гаруй хувийг захирах эрх бүхий 13 тамгатай хутагт бий болох үндэс болсон юм. XIX зууны сүүлээр Живзундамба хутагтын мал сүрэг л гэхэд 90000 гаруй толгойд хүрч байв.

Тамгатай хутагтууд нь шууд Живзундамба хутагтад биш, харин засаг ноёдын адил аймгийн чуулганд захирагддаг, улсын албанаас чөлөөлөгдсөн байна. Хутагт нарын шавь нар нь цэрэг, харуул, өртөөний зэрэг гол албанаас чөлөөлөгдөж өөр өөрийн харъяат хутагт нар, хүрээ хийд, хурал ном, бурхан тахил, шавийн ба орон нутгийн засаг захиргааны алба залгуулж байжээ. Тамгат хутагтын газар эзэмшлийг үе улиран захируулах эрхийг уул хутагтын хойд дүрийг тодруулах замаар гүйцэтгэж байв. Харин тамгагүй, хошууны хувилгаан бол хөрөнгө мал ихтэй, сүсэгтэн олонд хүндлэгдэх боловч, засаг ноёндоо харъяатын хувьд сум хамжлагын данснаа бүртгэгдсэн, хамжлага шавьгүй байжээ.

Үүний сацуу, академич Ш.Нацагдорж, доктор С.Пүрэвжав, дэд доктор Л.Дашжамц зэрэг түүхч эрдэмтдийн бүтээлд тэмдэглэснээр, XIX зууны сүүлээр дэлхийн хүчирхэг орнуудын санхүү-эдийн засгийн үйл ажиллагаа «харилцан хэлхэлдэж, гадаад харилцаа өсч, дэлхийг хоорондоо хуваарилах тэмцэл өрнөсөн бөгөөд Герман, Япон, Орос, Англи, Франц улсууд Хятадыг хуваан эзлэх бодлого явуулсан нь Манж Чин улсын хүчийг мөхөсдүүлж, улмаар Монгол улс биеэ даасан тусгаар байдлаа эргэн олж авах нөхцлийг бүрдүүлжээ.

Энэ үеэр Монголд төр шашныг хослон баригч Богд хаант улс байгуулагдаж, төрийн толгойд Монголын шарын шашны тэргүүн наймдугаар Богд гэгээн Живзундамба хутагт (1870-1924) заларсан билээ. VIII Богд Живзундамбыг сэргэн мандсан Монгол Улсын хаанаар өргөмжилсөн явдал Монголд шашны нэр хүнд, байр суурь, хүчин чадал тэр үед хичнээн их болсныг харуулав. Гадаад соёлт ертөнцөөс тусгаарлагдмал түгжигдмэл байдалд оршиж байсан Монголд тусгаар тогтнолоо сэргээхэд манжийн дарангуйллын үед дарлагдсан цөөнх үндэстний шашин болон хувирсан Буддын шашинд түшиглэхээс өөр улс төр, эдийн засаг, үзэл суртлын илүү нэр хүндтэй хүчин зүйл байсангүй. Монголын үндэсний тусгаар тогтолыг сэргээх үйлсэд “Дээр тэнгэрээс заяат” Чингис хааны алтан ургийнхнаас илүү шашны тэргүүн Богд Живзундамба тэргүүтэй ихэс лам нар, хутагт хувилгаад тухайн үедээ чухал үүрэг гүйцэтгэснийг манай түүхч эрдэмтэд нотлон өгүүлсэн байдаг.

Манай түүхчдийн үзсэнээр, шашны тэргүүн төрийн эрхийг хослон барих ёс дэлхий дахины түүхнээ ховор тохиолддог үзэгдэл бөгөөд нийгмийн амьдралд шарын шашин хуваарьгүй ноёрхсон Монгол орны хувьд төрийн хэргийг шашин бурханы нэрийн өмнөөс явуулах нь гадаадын ноёрхол, дотоодын хямрал мөргөлдөөнийг даван туулах нэгэн арга байсан байна. Богд гэгээн шавь нарын хэрэг эрхлэх Эрдэнэ шанзудбын Яам байгуулж, түүний харъяаны дөрвөн аймгийн нутагт таран суусан өөрийн бүх шавь нарыг зүг зүгээр товчлон захирах бүгдийн дарга, дэд дарга бий болгож, тус тус тамга олгуулжээ. Богд гэгээний засгийн газарт зөвхөн Халхын хан, вангууд төдийгүй хутагт хувилгаад ч орж төрийн хэрэгт хүчин зүтгэж байв.

Тэр үеийн Монголын тэргүүний дээд хан язгуурт ноёд тайж нар хэлэлцэн Монголын шашны тэргүүнийг тодруулсан үйл хэрэг нь өөрөө Чингисийн алтан ургийн үйл хэргийг тасралтгүй үргэлжлүүлж, нэгэн үзэл санаа, нэгэн зүрх сэтгэлийн дор Монголын ард түмнийг нэгтгэж монгол үндэс угсаа, улс төрөө бадруулан мандуулах гэсэн их зорилт, их үйл хэрэг байсан юм. Энэ үйл хэргийн үзэл санааг хойч үедээ тасралтгүй уламжлуулах арга болгож бурханы гэгээрсэн хутагт дээд лам бодьсадва нарын хувилгаан хойд дүрийг тодруулах бурханы шашны уламжпалыг Монголчууд эзэн богд Чингисийн үеэс уламжлалтай өөрсдийн дээд тэнгэр язгуурыг таслахгүй байх гэсэн

үзэл санаан дор хүлээн авч монгол хөрсөнд хэрэгжүүлсэн байна.

Эрт цагт Алун гуа эх дээд тэнгэр язгуурыг хүндэтгэн шүтэж байх шашин сүсэг бишрэлээр үр хөвгүүдээ хүмүүжүүлэн, нийгэм-амьдралын зам харгуйд үзэл санааны зүг чигтэй, баримталж байх ёс жаягтай болгон сургахын зэрэгцээ өөр хоорондоо эвсэн нэгдэж туурга тусгаар улс орноо бат тогтвортой байлгах үндсийг айлдаж байсан түүхтэй.

Энэ сургаал нь XVII зуунд алтан ургийн залгамжлалыг эзэнт гүрний үетэй адил хаан удмаас удамд бус, харин их нигүүлсэнгүй бодь сэтгэлийн үйлээс үйлийн үрд буюу хувилгаан дүрүүдийн үйл хэргээр уламжлах бурханы шашны сургаал номлолын аргаар хэрэгжих болсон нь тухайн үеийн Монголчуудын оюун санааны ертөнцөд бий болсон шинэ зүйл байлаа. Чухам энэхүү үзэл санаан дор 1650 онд Чингисийн алтан ургийн хэлхээт Өндөр гэгээн Жавзандамба хутагтыг Монголын бурханы шашны тэргүүнээр тодруулжээ. Энэ үйл хэргийн үр дагавар XX зууны эхэн хүртэл үргэлжилж оргил цэгтээ хүрсний илрэл нь ҮШ Богд Жавзандамба хутагт болой. Монгол орон Манжийн захиргаанд орж эхлэх үест Манжийн захиргаанаас гарч үндэсний тусгаар тогтнол, үндэсний соёл, ухамсар, оюун санааны эрх чөлөөг олох үндсийг Монгол хөрсөнд Анхдугаар богд суулгаж тэрхүү ор үндэс 200 жилийн дараагаар соёолон хөрснөө ил гарсан үр жимсийг нь VIII Богд тордон дэлгэрүүлэх боломжит бүхнийг хийсэн гэж хэлж болно.

Өндөр гэгээнээс хойш түүний хувилгаан дүрүүд, найман удаа Монгол газраа залж Монголын бурханы шашныг хөгжүүлэх, улмаар монгол сэтгэлгээ, монгол оюун санаа, монгол соёлын үйл хэргийг тэргүүлж ирсэн түүхтэй. Тэдгээрийн дотроос VIII Богд Жавзандамба хутагт зөвхөн Монголын төдийгүй хүн төрөлхтний түүх, нийгмийн нэгэн том хувьсгал, эргэлтийн үед үйл ажиллагаагаа явуулж, орчин цагийн Монгол орны улс төрийн байр суурь, нийгэм-соёлын хөгжлийн суурийг тавьснаараа түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Түүнээс хойш, 1921 онд ялсан Ардын засаг ч эхэн үедээ ерөнхий сайд Жалханз хутагт Дамдинбазар тэргүүтэй Монголын хутагт хувилгаадын мэдлэг чадвар, хүчин зүтгэлийг төрийн хэрэгт оролцуулж байсан юм. Гагцхүү Монголын шарын шашны дээд лам, хутагт хувилгаад Октябрийн хувьсгалын үзэп санаа, Зөвлөлт Орос

улсаас болгоомжилж байв.

Энэ үед монголчуудын дунд өргөн тархсан “Чулууны бичиг” хэмээх шашны зохиолд: “Эдүгээ цөвүүн цаг ирж, бурхан тэнгэрийг хүндэтгэн сүсэглэхгүй байгаа явдалд тэнгэр хилэгнэж, галын сахиусыг ирүүлэн, тэрх тэрсүүд үзэлтнүүдийг залхаан цээрлүүлнэ. Тариа будаа байвч идэх хүнгүй болж, хулгайн аюул, галын аюул, усны аюул, мэсийн аюул, цэрэг дайны аюул, зудын аюул: дайсны аюул, аянгын аюул, цаг бусын үхлийн аюул, газар хөдлөх аюул, огторгуйд нисэгчийн аюул, хилэнт араатны аюул, ад чөтгөрийн аюул тохиолдож нийт хүмүүс усан нохойгоос усан гахай жил үхэж дуусна. Хэрэв бурхан шашинд залбиран буян үйлдэж, муу хорт нүгэл сэтгэлээ тэвчиж чадвал дээрх аюулаас гэтэлж болно” гэх зэргээр бичжээ.

“Гай зовлон бүхнээс гэтэлгэгч авралт бурхан” хэмээн шүтдэг хутагт хувилгаадын хэлсэн үг бүрийг амилсан бурханы зарлиг хэмээн итгэдэг сүсэгтэн олон түмэнд Жалханз хутагт Дамдинбазар Ардын засгийн газрын тэргүүн болсон явдлыг “нэгэнт гэгээн багш ардын төрийн III сайд болсон болохоор тэр төр лав оршин тогтох түүх тавилантай сайн төр байх ёстой хэмээн итгэх болжээ.

Хувьсгалын эхний үед 100 гаруй мянган лам, 140-150 орчим хутагт хувилгаад, 2960 дуган сүм, 800 орчим сүм хийд оршиж байв. Тэдний эзэмшилд 2 сая гаруй толгой мал, 57 сая алтан рублийн үл хөдлөх хөрөнгө байжээ. XX зууны эхэн үед сүм хийдээ нураалгаж, цан хэнгэргээ хураалган, бурхан шүтээнээ шатаалгасан лам хуваргууд Ардын засгийн зүгээс сүм хийд, лам хуваргуудтай явуулж байсан бодлогыг, үйлдлийг талархан хүлээж аваагүй нь мэдээж. 1925 онд Зая Бандид Засгийн газарт хандан бичсэн өргөдөлдөө: “ Жилээс жилд цагийн аяс муудан, хутагт хувилгаадыг хялайн хавчих нь улам бүр газар авч буй нь цөвүүн цаг хаалга тогших дохио гэмээр намайгамар жимэр суулгасангүй. 1924-1924 оны өвөл баривчилж дотоодыг хамгаалахын шоронд хоёр дахь удаагаа өнгөрөөв. Хавар нутагтаа буцаж ирээд зунтай золгоюу гэтэл дахин дуудаж дотоодыг хамгаалахын шоронд “нууцыг задруулсан” хэмээх хэргээр зургаан сар суулгав” гэсэн байдаг. Дахин дахин баривчилж, тагнаж цагдах учир Заяа Бандид арга буюу төрийн албанаас хөндийрөхөөр шийдэн 1922 онд залгамжилж ирсэн отго жинсээ халж, ноён хэргэмээсээ татгалзсан боловч “до” яамны мөрдlөгөөс салсангүй.

XX зууны 20-оод оноос эхлэн Монголын төрөөс хүлээн зөвшөөрсөн цорын ганц үзэл онол нь марксист-ленинист сургаал хэмээн тунхагласнаар марксист шашингүйн үзлээр шашны асуудлыг шийдвэрлэх болж, хамгийн түрүүнд эрдмийн дээд зэрэг цолтой, бурханы номын оргилд хүрсэн их мэргэдүүд, хутагт хувилгаадыг үй олноор нь баривчлан гэсгээж, шид хүч ном эрдмээрээ хуримтлуулсан эд хөрөнгө, мал сүргийг нь хураах гашуун түүх эхэлсэн билээ. 1922 оны наймдугаар сарын 30-нд ерөнхий сайд Д.Бодоо нарын хүмүүсийг буудан хороож хэлмэгдүүлэхэд саж лам Жамъянданзанг егүүтгэсэн нь лам нарын хэлмэгдүүлэлтийн эхлэл байв.

1930 онд тайж Б.Эрэгдэндагва нарын 38-ын хэрэг гэгчийг үүсгэж Монголын баруун, зүүн, төвийн ард олны дунд нэр хүнд өндөртэй Дилов хутагт Жамсранжав, Егүзэр хутагт Ж.Галсандаш, Манзушир хутагт С.Цэрэндорж нарыг оруулж, харгалзах ялыг ногдуулж хэлмэгдүүлсэн байдаг. 1937 оны есдүгээр сарын 6-ны өдөр Гандан, Зүүн хүрээний их хамба, ёнзон Ц.Лувсанхаймчиг, дэд хамба Б.Дамдин нарыг Дотоод Явдlын Яамнаас баривчилж, ёнзон хамба тэргүүтэй 19 ламыг цаазалсан юм. Эдгээр лам нарын дотор Манзушир хутагт С.Цэрэндорж, дэд хамба Б.Дамдин, Богд хааны цорж нараас Б.Чойнзон, мөн цорж Жанцан, Чүлтэмийн Сандаг, Ж.Ёндонжамц, Д.Вандан, Хасбазар, Д.Дашдаваа нарын зэрэг Гандан, Зүүн хүрээний ихэс лам нарыг бүлэглэж шийтгэсэн ажээ.

Төвд, Монголд өргөн дэлгэрсэн Буддизмын хөгжпийн дээд шат болох Очирт хөлгөний ёсонд сүм хийдийн нарийн дэг сургуулиар хүмүүжсэн хувраг хүн Буддын шашин-соёлыг уламжлуулан хөгжүүлэх цорын ганц зорилгод бие сэтгэлээ зориулбал түүний үйл хэрэг төрөл дамжин хутагтуудын буяны үйлээр тасралтгүй үргэлжлэнэ. Буддизмд “эргэн төрөх” гэсэн ойлголт нь “сүнс” гэсэн утга илэрхийлдэг бус, харин “үйл” гэсэн утгаар хэрэглэгддэг болохыг энд цохон тэмдэглэе.

Тухайлбал, XVI зуунд Төвдөд үүссэн Гелүгба (шарын шашны) ёсыг үндэслэгч Богд Зонхавын гутгаар дүр Содномжамц багшид Түмэдийн Алтан ханаас өргөсөн “Далай лам” нэрээр энэ шашны тэргүүний 14 хойд дүр эдүгээг хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлж байна. Мөн Монголын шарын шашны тэргүүн анхдугаар Богд өндөр гэгээн Занабазарын хувилгаан дүрийг тодруулсаар ирсэн нь Буддын шашин-соёлыг Монгол соёлын хөрсөнд тасралтгүй

үргэлжлүүлнэ гэсэн гол зорилгыг агуулж байдаг. Иймээс аль нэг хувилгааныг тодруулах нь тухайн “бие хүнийг” онцгойлж байгаа хэрэг бус, Буддын шашин-соёлыг тухайн орон газар, ард түмний дотор уламжлан хадгалж, дэлгэрүүлэн хөгжүүлж байгаа үйл хэрэг болно.

Манай түүхчид, утга зохиол судлаач, эх бичиг, шашинсудлаачдаас Буддын хутагт хувилгаадын байгуулсан сүм хийдийн түүх, тэдний намтар, Монголын нийгэм-соёлын амьдралд оруулсан хувь нэмэр, үүрэг, байр суурь, бүтээл туурвилын талаархи мэдээллийг үнэн мөнөөр нь олон түмэнд хүргэх, 1930-аад оны хэлмэгдэлд өртсөн сүм хийд, хутагт хувилгаад, лам хуврагуудын нэр алдрыг сэргээх зэрэг ажлуудыг өргөнөөр зохион байгуулж байна.

1970-аад оноос ШУА-ийн Философи.социологи, эрхийн хүрээлэнд доктор Ч.Жүгдэрийн бичсэн “XY-XYIII зууны монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний түүх” (УБ. 1984), “З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл” (УБ. 1978), “XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил” (УБ. 1972) зэрэг нэгэн сэдэвт цуврал судалгааны бүтээлүүд, мөн хүрээлэнгийн Буддын философийн салбараас гаргасан “Буддын философийн урсгалууд”(УБ. 1985), “Монголын философийн түүхийн зарим асуудал” (УБ. 1987), Г.Лувсанцэрэн “Нагаржунагийн философи үзэл” (УБ. 1978), Т.Содномдаргиа “Агваандандарын зарим зохиол дахь философи- логикийн үзэл” (УБ. 1978), Г.Лхагвасүрэн “Данзанравжаагийн гүн ухааны үзэл” (УБ. 1988) зэрэг судалгааны зохиол, өгүүлэл, эрдэм-шинжилгээний илтгэлүүд нь буддизмыг бүх талаас шүүмжлэн няцааж, хориглон саатуулж байсан үзэл суртал-улс төрийн нөхцөлд монголын буддын сэтгэлгэгчдийн нэр алдрыг хадгалан мөнхжүүлэх, тэдний бүтээл туурвил, үйл хэрэг, үзэл баримтлал, философи сэтгэлгээг нь уламжлан хөгжүүлэх, судлан суралцах сонирхол төрүүлэхэд чухал хувь нэмэр болсон юм.

Буддын сургаалыг баримталсан Монголын анхны том сэтгэгч Чойжи- Одсэрийн талаар 1990-ээд оноос өмнө гол төлөв монголын утга зохиолын түүх судлалын хүрээнд академич эрдэмтэн Д.Цэрэнсодном “Монголын Бурханы шашны уран зохиол” хэмээх бүтээлдээ авч үзсэн юм. Мөн доктор Л.Хүрэлбаатар 1995 онд хэвлүүлсэн “Монгол орчуулгын товчоон” хэмээх бүтээлдээ Чойжи-

Одсэрийн бүтээлд хэл шинжлэлийн (лингвистиканализын) задлан шинжилгээ хийсэн байна. 1990-ээд оноос хойш Чойжи-Одсэрийг философийн түүхийн хүрээнд судлах ажил нэлээд өрнөж "Монголын философийн түүх"-ийн II дэвтэрт судлаач эрдэмтэн Г.Лхагвасүрэн Чойжи- Одсэрийн "Бодичарьяавадарагийн тайлбар"-ыг "дан ганц өөрийн үзэл бодлоор хандаагүй, харин буддын маш олон судар номуудыг харьцуулан хөөж тодруулан тайлсан" 12 хэмээн монголын буддизмд уламжлал холбоог баримталдаг арга зүйг тодруулжээ. Энэхүү Бодичарьяаватараг одоо ч судалсаар байгаагийн жишээнд доктор, профессор Т.Булган ламтаны бүтээлүүд зүй ёсоор орно13.

Монголын түвд хэлт утга зохиолын судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн Л.Хүрэлбаатар 1996 онд хэвлүүлсэн "Огторгуйн цагаан гарди" номондоо Өндөр гэгээн Занабазар, Зая бандид Лувсанпэрэнлэй, Хамбо номун хан Агваанхайдав, Эрдэнэ мэргэн бандид Ишсамбуу, Догшин ноён хутагт Данзанравжаа, Их сударч, тайж Инжиннаши, Лу жанжин гүн, Ханчин хамба Жамъянгарав, Цанид ловон Шагдар, Жалханз хутагт Дамдинбазар нарын намтар, уран бүтээл, үзэл санааны товчоог гаргасан билээ.

Доктор Ш.Сонинбаяр ламтан, төвдөч Д.Цэдэв, И.Дэмбэрэл нар Өндөр гэгээний намтруудыг түвд хэлнээс хөрвүүлж хэвлүүлснээс гадна академич Ш.Бира Өндөр гэгээний "Цаг лугаа зохилдуулсан залбирал адистадын дээдийг хайрлагч оршивой» "Жинлавчогзол" зохиолыг нь монгол хэлнээ хөрвүүлж анх удаа хэвлүүлсэн нь Занабазар судпалд оруулсан томоохон хувь нэмэр мөн.

Эрдэмтэн профессор Д.Дагвадорж "Монголын бурханы шашны соён гэгээрүүлэгчид" номондоо монголын бурхны шашны нэрт зүтгэлтэн соён гэгээрүүлэгчдийн намтар, шашин номын үйл үйлдвэрийн тухай өгүүлж, Монголын бурханы шашны нэрт төлөөлөгч Нэйж Тойн, IV далай лам Ёндонжамц, Зая бандида Намхайжамц, Өндөр гэгээн Занабазар, Зая бандида Лувсанпэрэнлэй, V ноён хутагт Данзанравжаа, эрдэмтэн зохиолч В.Инжинаш, бичээч цорж Агваандорж, анги Шагдар нарын зохиол бүтээлүүдийн тайлбарыг оруулжээ. 1998 онд доктор Д.Дагвадорж "Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг"-оо хэвлүүлсэн ба энд эртний Энэтхэгийн "чимгийн мэргэд" хэмээн алдаршсан хутагт Нагаржунай, Аръяндэв, Аръяа Асанга, Васубанду нарын үзэл санаанаас түвдийн буюу цастын мэргэд Төгс цогт Атиша, Богд Зонхов, Тууган гэгээн

Лувсанчойжиням нарыг уламжлуулан толилуулж, тэр нь Монголын мэргэдийн үйл ажиллагааны үндэс болсныг харуулж, Сүмбэ хамба Ишбалжираас эхпүүлээд Зава Дамдин хүртэлх Монголын нийт есөн том сэтгэгчээр төлөөлүүлэн Монголын буддын гүн ухаантнуудын үзэл санааг тоймлосон байна. 2001 онд хэвлэгдсэн "Монголын философийн түүхийн" IV дэвтэрт Д.Дагвадорж багшийн номонд авч үзсэн мэргэдээс гадна ламын гэгээн Лувсанданзанжанцан, Зая бандид Лувсанпэрэнлэй, Бичээч цорж Агваандорж, Оргиочийн лам Лувсанбалдан, Агваантүвдэн равжамба, Ноён хутагт Данзанравжаа нарын талаархи гүн ухааны түүхийн судалгааг нэмэн оруулсан билээ.

VIII Богд Агваанлувсан Жавзандамба хутагтын намтар бүтээл, үйл хэргийн талаар 1990-ээд оноос хойш арвин их материал хэвлэгдэх боллоо. Тухайлбал, Д.Чойжамц хамбын "VIII Богд Жавзандамба хутагтын товч намтар", С.Идшинноровын "Жавзандамба Агваанлувсан-чойжинямданзан-ваанчигбал-самбуу", Л.Жамсрангийн "Шашин төрийг хослон баригч Богд Жавзандамба хутагт хаан", Т.Төмөрхуягийн "Наймдугаар Жавзандамба хутагт ямар хүн байв", З.Лонжидын "Богд гэгээнтэн Орос улсаас хэдэн удаа тусламж хүссэн бэ" зэрэг манай судлаач эрдэмтдийн бичиж нийтлүүлсэн өгүүлэл илтгэлүүдээс гадна О.Батсайханы "Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт" зохиол хамгийн дорвитой том судалгаа боллоо. Ер нь VIII Богд Агваанлувсан Жавзандамба хутагтын судалгааг XX зууны эхэн үеийн Монголын түүх-нийгэм, улс төр-эдийн засаг, шашин-соёлын судалгаанаас салгах аргагүй. Энэ чиглэлээр С.Пүрэвжав, Ж.Самбуу, Ш.Нацагдорж, Ч.Жүгдэр зэрэг 1990-ээд оноос өмнөх үеийн манай нэрт түүхч, эрдэмтэн судлаачид тухайн үеийн төрийн үзэл суртлын хараа хяналтан дор боловч түүх, эх сурвалж, архивын мэдээ, арвин их баримт материалд тулгуурласан шинжлэх ухааны задлан шинжилгээг явуулж дорвитой бүтээлүүдийг туурвисан байдаг. Өндөр гэгээнээс хойш түүний хувилгаан дүрийг найман удаа Монгол газраа залж Монголын бурханы шашныг хөгжүүлэх, улмаар монгол сэтгэлгээ, монгол оюун санаа, монгол соёлын үйл хэргийг тэргүүлж ирсэн түүхтэй.

XX зууны эхэнд Богд хаант Монгол Улсын засгийн газар, дөрвөн аймгийнхаа чуулган дарга нараар ахлуулж хутагт хувилгаадын

судалгаа явуулах үүрэг бүхий орон тооны бус түр алба байгуулж, хэдэн жилийн туршид судалгаа хийж байжээ. Үүний үр дүнд гаргасан айлтгалыг Эрдэнэ шанзэвын яам товчоолон эмхтгэж баталгаажуулан “Зарлигаар тогтсон олон аймгийн тамга бүхий ба үгүй хутагт, хувилгаадын, шаштир” хэмээх хоёр дэвтрийг 1918 онд гаргасан байна. Бас “Хутагт, хувилгаадын данс бүртгэл” гэсэн нэг дэвтэр бүтээл эх сурвалж ч бий. Энэ бүтээлүүд Улсын үндэсний түүхийн төв архивт хадгалагдаж байна. Монгол оронд тодорсон том, жижиг 80 гаруй хутагтын дотор Монголын төрийн тамгатай 13 хутаггын судалгаа өнөө цагт улам хүчтэй явагдаж байна.

XVII зуунд алтан ургийн залгамжлалыг эзэнт гүрний үетэй адил хаан удмаас удамд бус, харин их нигүүлсэнгүй бодь сэтгэлийн үйлээс үйлийн үрд буюу хувилгаан дүрүүдийн үйл хэргээр уламжлах бурханы шашны сургаал номлолын аргаар хэрэгжих болсон нь Монголчуудын оюун санааны ертөнцөд бий болсон нэгэн шинэ онцлог зүйл байлаа. Монголын хутагт хувилгаадын талаархи түүх, соёл, шашин, урлаг, утга зохиол зэрэг тал бүрийн судалгаа шинжилгээ, тэдний үйл хэргийн талаархи үнэлэлт дүгнэлт нь зөвхөн тухайн бие хүний талаархи судалгаа төдийгүй, ерөөс Монголын төр ёс, нийгэм-улс төр, шашин-соёлын хөгжлийн онцлог байдлыг тогтооход зайлшгүй чухал судалгаа мөн. Монголын хутагт хувилгаад нь зүгээр нэг шашны номонд нэвтэрсэн лам төдий байсангүй, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, монгол зоныхоо сайн сайхан амьдралын төлөө хоёргүй сэтгэлээр сэтгэж, энэ бие, нэг насны амьдралаа золионд гаргасан эх оронч, улс төрийн нэртэй зүтгэлтнүүд байсныг сүүлийн үеийн судалгаанууд улам бүр батлан харуулсаар байна.

Наро Банчэн хутагт судлалын талаар эрдэм шинжилгээний хурлыг даргалсан Т. Булган гавж Доктор (Ph.D), профессор АБЭТБХурлын нарийн бичгийн дарга МБШДС, ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙД

Эрдэм шинжилгээний бага хурлын удирдагч Т. Булган гавжийн хурлыг нээж хэлсэн үг



Өнөөдөр өлзий дэмбэрэлтэй сайн өдөр монголын шашин соёл, түүх монголын хөгжилд хувь нэмрээ оруулсан олон сайхан эрдэмтэн мэргэдийн нэг болсон Наро Банчэн хутагтын намтар судлалд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг Гандантэгчэнлин хийд, мөн дэргэдэх Эрдэм соёлын хүрээлэн, Завхан аймгийн Отгон сумын нутгийн зөвлөл, Завхан аймгийн Шилүүстэй сумын нутгийн зөвлөл болон бусад эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран өнөөдрийн хурлыг зохион байгуулж байна.

Наро Банчэн гэгээн гэх агуу их хүн эртний Энэтхэгээс анх мэндэлж тэр оронд гэгээрч, бясалгаж, улмаар түүний хойд дүрүүд эрдэм боловсролтой хүмүүс олон газар хувилан төрж олон амьтны тусыг хүртээж байсны нэг нь бол монголд хувилан төрсөн ийм түүхтэй билээ. Наро Банчэн хутагтын тухай ард түмний дунд нар аргамждаг Наро Банчэн гэх ийм түүх домог явдаг. Нар аргамждаг хүн гэдэг бол одоо ч гэсэн шинжлэх ухаанд оньсого хэвээрээ бас тайлах ёстой, судлах ёстой нэг судлагдахуун явж байдаг.

Яахаараа хүн нар аргамждаг юм бэ гэдгийг одоо ч магадгүй өнөөдрийн эрдэм шинжилгээний хурал маань энд бас нэг хариулт өгөх байх гэж бодож байна.

Эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөрийн дагуу хурлын эхний илтгэл бол Зая гэгээн морилж бидэнд соёрхлоо айлдах байсан. Өнөөдөр хүндэтгэх шалтгааны улмаас ирэх боломжгүй болсноо бидэнд хэлсэн байна. Гэхдээ Зая гэгээний айлдварыг Отгонбаяр гавж бидэнд айлдаж хурлыг нээнэ.

Эрдэнэ Зая Бандида гэгээн Лувсанданзанпүлжинжигмэд

ГҮШИГ ДАЦАН

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт эрдэмтэн мэргэд зочид төлөөлөгч номын нөхдийн энэ өдрийн түмэн амгаланг айлтгая.

Нар аргамждагаараа алдаршсан Наро Банчэн гэгээнтний төрөл тутмын алдрыг дурьдваас хутагтын оронд Захимгаржадаас эхлэн Дүхэнгаржад хүртэл таван хувилгаан, цастны оронд Дэрчинчойжижалбуугаас Жанчивнянбуу хүртэл дөрвөн хувилгаан мэндлэн, улмаар монгол нутагт монгол угсааны усны гурван түмдийн нэгээс улбаалан Чин гүрнийг байгуулсан Их хаадын нэг Энх-Амгалангийн 38-р он буюу 1699 онд Сайн ноён хан аймгийн гүн Гончигийн хошууны тайж Гүржавын гэрт Наро Банчэн хутагт Бадамдорж мэлмий гийн өсөн тодорч, ид шидээр манж ноёдыг нар жаргаахгүй байлгаж хэлэлцээртээ тулган, Бээжинг хүртэл хазайлгаж байсан гэх намтар цадигаар дамжигдсаны дараа төрөл нь 1738 онд Ордосын тайж Дашдэндэвийн гэрт Наро Банчэн Агваан Чойдонданзанжанцан тэргүүн, 1818 онд Түвд газар Амду нутагт Галсаннамжилийн гэрт Наро Банчэн Түгжжав тэргүүн, 1862 онд Халхийн түшээ гүн Мягваасамбуугийн гэрт Наро Банчэн хутагт Бирваа тэргүүн, 1884 онд харъяат шавь Даржаагийн гэрт Наро Банчэнгийн дошгин дүр хэмээх Пүрэвжав тэргүүн, 1904 онд мөнхүү шавийн ард Лувсанцэрэнгийн гэрт Наро Банчэн Жүгдэрнамжил гэх тэргүүд мэндлэн шашин төрийн үйлэнд оройлон тэргүүлж байсан намтар туурвилыг олны хүртээл болгон түмэнд тайлагнаж байгааг би хувьдаа сайшаан магтаж байна. Миний урьд дүрийн Хүндлүн Цохүр ноён Түмэнхэн нартай ураг төрлийн холбоотой гэгддэг ба сүүлийн дүрүүд нь номын барилдлагатай болж өргөжсөн байдаг. Сүүлийн дүр Жүгдэрнамжил хувилгаан Заяын хүрээнд морилон Далай лам Түвдэнжамцаас сахил залж шавь орсон ба миний урьд дүр Зая Лувсанчойжиням гэгээнтэй номын барилдлага тогтоон, хоёр хийд хоорондоо тохомтой болж, одоогийн Архангай аймгийн

Батцэнгэл сумын Даага багийн нутагт буй Наравтүнба хэмээх Хайрханыг хамтран тахиж байсан баримтууд байдаг учраас энэхүү хуралд оролцож даган баясаж байгаа минь энэ билээ. Энэхүү морин жилд монгол түмний хийморь сэргэм үйл явдал болох Наро Банчэн хутагтын монголд хувилсан анхны дүр Хутагт Бадамдоржийн мэлмий гийсний 315 жил, тавдугаар дүр Дошгин хэмээх Пүрэвжав хутагтын мэлмий гийсний 130 жил, зургаадугаар дүр Жүгдэрнамжил хутагтын мэлмий гийсний 110 жилийн тэгш сайхан ой тохиож байгаа явдалд би бэлгэшээж байгаагаа илэрхийлэхийн ялдамд нийт хуралд оролцож байгаа эрдэмтэн мэргэдийн оюуны мэлмий тунгалаг гэрэлтэн нар шиг мандан бадарч, Наро Банчэн хутагтуудын маань агуу явдал нарны цацраг мэт түгж, үргэлжлэл нь үл тасран, мандан бадрахыг ерөөе.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Хурлын илтгэгч Завхан аймгийн уугуул Г.Очирбат
Доктор (Ph.D) МУ-ын Хөдөлмөрийн
баатар Улс төр, нийгмийн ахмад
зүтгэлтэн

НАРО БАНЧЭН, ДИЛОВА ХУТАГТ НАРЫН НОМЫН БАРИЛДЛАГА

Ар Монголд шавь захирсан тамга бүхий арван гурван хутагт байсны нэг нь Наро Банчэн хутагтын шавь юм. Тус шавийн бусад арван хоёроосоо ялгарах содон зүйл бол тэнд Монгол даяар нэрд гарсан Наро Банчэн, Дилова хэмээх хоёр том хутагт хамт шавилж байсан явдал юм.

Үүнтэй уялдан яагаад, ямар учир шалтгаанаар энэ хоёр хутагт нэгэн шавьд түшлэг ижилсэн ширээлэх болов гэсэн асуулт гарч байгаа юм. Энэ хоёр хутагтын нэгний нь тухай ярихад нөгөөгийн нь тухай зайлшгүй ярих болдог. Өнөөдрийн эрдэм шинжилгээний бага хурал бол Наро Банчэн хутагтад зориулагдаж байгаа. Гэвч нөгөө Дилова хутагтын тухай бас ямар нэг хэмжээгээр ярих шаардлага гарч байна.

Эдгээр асуултад бүрэн бус боловч ямар нэг хэмжээгээр хариулахад миний ярих зүйлийн агуулга оршино.

Нэг. Хоёр хутагтын Монголд тодорсон нутаг орны тухай. Наро Банчэн гэгээний хоёрдугаар үеийн хувилгаан Наваанчойрогданзанжамц /1738/ Ордосын бэйс Наваанбалданцэрэнгийн хошууны нутагт мэндлэн тодорч ширээнд залагдаад хэд хэдэн сүм байгуулсны дотор 1803 онд тус Ордосын нутагт “Шашины Ерөөлт” нэртэй нэгэн сүм бүтээсэн байна. Гэтэл Дилова хутагтын дөрөв дэх дүр Раашпунцаг энэхүү сүмийн харьяат ард Балдан-Очирын гэрээс тодорсон байдаг. Тус Ордос нутагт Дилова хутагтын Монгол дахь анхны болон хоёрдугаар дүрүүд хувилсныг нэмж хэлэх нь зүйтэй.

Ингээд бодоход Наро Банчэн, Дилова нар унасан газар, угаасан усаараа барилдлагатай байжээ. Нэг шавийн энэхүү хоёр хутагт

бол Ар, Өвөр Монголын аль алинд нь хувилж шүтэгдэн, тэдний ах дүүгийн хэлхээ холбооны төлөө номын буян түгээсэн хувилгаад байжээ гэж бодогдож байна.

Хоёр. Монгол дах Дилова хутагтын анхны дүр 1600-аад оны сүүлч, 1700-аад оны эхэн үед Наро Банчэн хутагтынх 1699 онд тус тус тодорчээ. Үүнээс үзэхэд энэ хоёр хутагтын Монголд анх ирж хувилсан цаг хугацаа тун ойролцоо, тэд шил шилээ даран мэндэлжээ гэж үзэхээр байгаа юм. Үүний хамт Наро Банчэн хутагтын шавьд гуравдах үеийн Дилова гэгээн Дамчаа-Яринпилийн нийлэн суусны /1763/ дараа Наро Банчэн Наваанчойрогданзанжамцад шавь захирах мөнгөн тамга олгожээ. Хоёр хутагтын Монгол газар анх мэндэлж тодорсон болон нэг шавьд хамтран шавилсан цаг хугацааны тойрог ийм байгаа нь бас нэг ёсны барилдлага юм даа.

Гурав. Наро Банчэн, Дилова хутагтын Монголд хувилсан нийт дүр арван нэг. Тэдгээрээс Диловын дөрөв дэх үеийн хувилгаан Раашпунцаг, Наро Банчэны гурав дахь үеийн Түгжжав, тавдугаар үеийн Пүрэвжав нар бол сахил санваарыг үл ойшоосон, “ердийн нүгэлт амьдралаас” буцдаггүй байжээ. Дилова хутагтын дурсан ярьснаар, гуравдахь үеийн Наро Банчэн Түгжжав бол арван зургаан орчим наснаасаа сахил санваараасаа няцаж, жирийн хар хүн шиг авгай хүүхэдтэй болж, түүгээр ч үл барам ан гөрөө хийж эхлэхэд нь түүнийг сахилаа сахидаг лам хуврагийн амьдралд эргүүлэн оруулахын тулд Түвдийн Амодугийн Гүмбэн мэтийн шашины сайн хийдэд очиж суух нь зүйтэй хэмээн зөвлөсөн байна. Нэгэнт тэрээр Дилова хутагттай багш шавийн барилдлагатай байсан тул энэхүү зөвлөлгөөг зөрчих эрх Наро Банчэн Түгжжавт байсангүй. Иймээс Дилова гэгээн шийдвэрээ батлах зорилгоор хэд хоногийн турш ном хурахаар болж байтал тэр нутагт халдварт тахал дэгджээ. Харин тэрхүү тахлыг Наро Банчэн хутагт үхэр нядлуулж өвдсөн хүмүүст өгөхөд тэр махнаас идсэн хүн бүр эдгэж, тахал дарагдсан байна. Дилова хутагт нотлон өгүүлэхдээ, “өөрийг нь Амоду руу явуулах гэсэн Дилова хутагтын шийдвэрийг Наро Банчэн гэгээн л үл тоож, Дилова хутагтыг ном хурж байх үед дэгдсэн тахлыг тэр л дарсан нь түүхэн баримт билээ” гэжээ.

Дилова хутагтын гуравдах үеийн хувилгаан Дамчаа-Яринпил, Наро Банчэн хутагтын хоёрдах үеийн хувилгаан Наваанчойрогданзанжамц нар бол “эрдэм номд шамдангуй, зөв

явдалт амьдралыг эрэлхийлэгч биед хувилсан” хутагтууд байжээ. Өөрөөр өгүүлбээс, хоёр хутагтын аль алины нь дүрүүд чин сүсэгт ламын биед ч хувилж байж, сахилаа сахидаггүй боловч ид шидийг үзүүлэгч биед ч хувилж байжээ. Энэ бол Наро Банчэн, Дилова нар хувилгааны мөн чанараараа барилдлагатай болохыг харуулж байна.

Дөрөв. Наро Банчэн хутагтын хоёрдугаар үеийн хувилгаан Наваанчойрогданзанжамц 1776 оноос эхлэн арван тав орчим жил Ховдын “Түгээмэл амаржуулагч сүм”-ийн ширээтээр сууж баруун монголчуудын дунд буддагийн шашины сургаалийг номлон дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж нэрд гарсан байдаг. Энэхүү “Түгээмэл амаржуулагч” буюу олны нэрлэж заншсанаар Ховдын Шар сүм бол Манжийн хааны зарлиг, хөрөнгө мөнгөөр 1750-иад онд байгуулагджээ. Тэр цаг бол баруун болон халх монголд манжийн ноёрхолыг эсэргүүцсэн Амарсанаа, Чингүнжав нарын удирдсан зэвсэгт тэмцэл гарсан үе байв. Харийн эзэрхийлэл дарамтанд уур хилэн нь бадарсан баруун монголчуудын сэтгэл санааг тайвшруулж номхотгох зорилгоор байгуулсан энэхүү сүмийн тэргүүн ламаар Халхын Засагт хан, Сайн ноён хан аймгийн нэр хүндтэй, ном эрдэмтэй хутагт хувилгаадаас зарлигаар томилж суулгадаг уламжлалтай байжээ. Тухайлбал, Наро Банчэн Наваанчойрогданзанжамцын өмнө тус сүмийн захирагч ламаар Жалханзын гуравдахь үеийн хутагт Галсандамбий-Яринпил 1766-1776 онд суусан байдаг юм.

Наро Банчэн хутагтууд болон Ховд, Дөрвөдийн хязгаарын шашин номын харилцаа Наваанчойрогданзанжамцын Ховдын Шар сүмийг тэргүүлж байсан үеэс хойш ч үргэлжилсээр байжээ. Энэ тухай сонирхолтой баримт гадаадын нэгэн эрдэмтний судалгаанд байдаг юм. Оросын эрдэмтэн-монгол судлаач А.Позднеев 1800-аад оны сүүлчийн 20 гаруй жилд удаа дараа манай орноор аялж, олон талын ажиглалт судалгаа хийж, монголын тухай хэд хэдэн дорвитой бүтээл туурвин хэвлүүлжээ. Тэдгээрийн нэг нь түүний 1887 онд Санкт-Петрбург хотноо хэвлүүлсэн “Очерки быта буддийстких монастырей и буддисткого духовенства в Монголии” /Монгол дахь буддын сүм хийдүүд болон буддист лам нарын байдлын тухай тойм/ хэмээх томоохон бүтээл юм. Тэрээр энэхүү бүтээлдээ Монголын сүм хийдүүдийн үүсэл хөгжил, дуган сүмийн дотоод байдал, тэдгээрт болдог шашины төрөл бүрийн зан үйл, лам хуврагуудын эрдэм боловсрол, зэрэг дэв, цол хэргэм,

шашины сургууль зэрэг ер нь манай хүрээ хийд, лам нарын тухай дэлгэрэнгүй өгүүлэхийн хамт Монголын хутагт, хувилгаадын тухай ч нилээд тодорхой бичжээ. Судлаач энэ хэсэгтээ Наро Банчэн хутагт болон Дөрвөдийн хязгаарын шашины харилцааны асуудлыг тусгасан байгаа юм. Түүний ажигласнаар, 19-р зуунаас Дөрвөдийн нутагт буддагийн шашин нилээд түргэн хөгжиж, шинэ сүм хийдүүд барьж, улмаар 1860-аад оны эхэнд өөрийн хутагт, хувилгаантай болох тухай яригдах болжээ. Тэгээд Дөрвөдийн лам нар санаачлан Наро Банчэн хутагт руу тусгай элч төлөөлөгч зарж, Дөрвөдийн нутагт орныг даасан хувилгаан тодруулж өгөхийг хүссэн гэнэ. Хүмүүсийн ярьж байгаагаар, Наро Банчэн хутагт тэдний элч нарыг хүлээн аваад хүсэлтийн нь талаар хэлэхдээ, эдүгээ хутагт, гэгээний аль аль нь үгүй байна. Харин тэнгэрийн охид цагаан, ногоон дарь эх тийм айлд хувилаад та бүхнийг ивээж байна гэжээ. Элч нар нутагтаа буцаж очоод Дөрвөд вангийн хошуунаас тэр дарь эхийг олоод, ийнхүү тус хязгаар өөрийн хувилгаан Дарь Эхтэй болсон юм гэнэ. Гэтэл тодруулсан Ногоон Дарь эх хэдэн сарын дараа нас баржээ. Тэгээд лам нар Наро Банчэн хутагт руу дахин элч илгээж, шинэ хувилгаан тодруулж өгөхийг хүсэхдээ тэр шинэ хувилгаан нь эрэгтэй байхыг тусгайлан гуйсан ажээ. Тэгэхэд Наро Банчэн тэдэнд:

1. Дарь эх бол гагцхүү сэтгэлийн хувилгаанаар л хувилдаг. Түүний биеийн хувилгаан нь зөвхөн эмэгтэй биед хувилдаг юм. 2.Энэхүү биеийн хувилгаан нь Дөрвөд вангийн нэгэн зарц Ноост гэдэг айлд төрсөн охин мөн. 3.Ногоон дарь эх эрэгтэй биед хувилаагүй байна гэсэн хариу өгсөн тухай яригддаг.

1877 онд Позднеевийг Монголд байх үед Дөрвөдийн лам нар гуравдахь элчээ Наро Банчэн хутагт руу илгээж, түүний тодруулсан Ногоон дарь эх нь эрэгтэй биед хувилсан 6 настай хүү байсан гэнэ.

Диловын хувилгаад ч баруун монголтой шашин номын барилдлагатай байжээ. Тухайлбал, Дилова хутагт Жамсранжав 1900-1903 онд Ховдын хязгаарт удаа дараа зочилж, Шар сүмд хурал хурж, зарим хошуудаар явж буяны ном айлдсан байдаг. Ингээд үзэхэд Наро Банчэн, Дилова хутагтууд халх болон баруун монголыг бурхан шашины үйлсээр холбож байсан гэгээнтнүүд юм. Нэг үгээр тодотгон хэлэхэд, Наро Банчэны шавийн энэхүү хоёр хутагт бол ар, өвөр, баруун монголчуудынхаа эв нэгдлийн тусын тулд хамтран буян үйлдэх барилдлагатай байжээ.

Тав. Дилова болон Наро Банчэн хутагт нарын багш шавийн барилдлага бол 1800-аад оны эхэн үеэс буюу Наро Банчэн хутагтын шавьд Диловын гуравдах үеийн хувилгаан Дамчаа-Яринпил нийлэн суусан үеэс эхэлжээ. Дилова хутагт Жамсранжавын өөрийн намтарт бичсэнээр, Дамчаа-Яринпил бол тэр үеийн Наро Банчэн Түгжжавын багш нь байсан байна. Дилова хутагт Жамсранжав болон тав дахь, зургаа дахь Наро Банчэн Пүрэвжав, Жүгдэрнамжил нар багш шавь хутагтууд юм. Тэдний хоорондын харилцаа бол багшийгаа хүндлэн дээдлэх, шавийгаа халамжлан хайрлах уламжлалт ёсонд суурилаж байсан байна. 1910 онд Наро Банчэн Жүгдэрнамжилд зориулсан даншиг наадмыг түүний багш Дилова хутагт Жамсранжав өөрөө удирдан зохион байгуулсан байх жишээтэй.

Өөр нэгэн зүйлийг тэмдэглэхэд, Наро Банчэны шавийн хоёр хутагтын үйл ажиллагаанд өөр өөрийн өвөрмөгц талууд бас байсан. Бидэнд мэдэгдэж байгаагаар, Наро Банчэн хутагтын дүрүүд шавийнхаа үйл хэргийг голлодог байж. Тухайлбал, Дилова хутагт Жамсранжав нь төр, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чухал үүрэг, байр суурьтай байсныг бид мэдэх билээ. Энэ бол биеэ даасан сэдэв учир дэлгэрэнгүй ярих шаардлагагүй. Эцэст нь товч дүгнэхэд, Наро Банчэны шавийн энэ хоёр хутагт бол төрсөн нутаг ус, тодорч залагдсан цаг хугацааны тойрог, хувилгаадын мөн чанар, нийт монгол түмнийхээ төлөө буян үйлдэж байсан зэргээрээ номын барилдлагатай бат хэлхээ холбоо бүхий гэгээнтнүүд байсан болно.

Ийм олон талын барилдлага бүхий хоёр их хутагт Наро Банчэн, Дилова нар нэгэн шавьд мөр зэрэгцэн ширээнд сууж байсан явдал бол яах аргагүй номын ёсны үзэгдэл мөн буюу.

Ашигласан ном, архивын материал:

- Зарлигаар тогтоосон олон аймгийн тамга бүхий, үгүй хутагт хувилгаан нарын шасдир. 1918. 1, 2-р дэвтэр. Улсын төв номын сан
- ҮТА, Ф-151, Д 1, ХН 48
- ҮТА, Ф-12, Д 1, ХН 82
- ҮТА, ФА-204, Д 1, ХН 2
- ҮТА, ФМ-77, Д 1, ХН 1
- Дилова хутагт Жамсранжав. Ариун сэтгэл авралын үндэс.
- УБ, 2000.
- Б.Лааган. Халхын тамга бүхий хутагтуудын товчис. УБ, 2004.
- А.Позднеев. Очерки быта буддийстких монастырей и буддисткого духовенства в Монголии. Спб. 1887.
- Майский. Орчин үеийн Монгол, УБ, 2001.

Хурлын илтгэгч Ш. Сонинбаяр гавж
Доктор (Ph.D), профессор
Эрдэм Соёлын Хүрээлэнгийн захирал
МБШТөв ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙД

ТҮВДИЙН ГАРЖҮДВИЙН ЁСНЫ УЛАМЖЛАЛТ ШАШИН, НОМЫН ЁС МОНГОЛД ДЭЛГЭРСЭН ТУХАЙ



Эртний энэтхэг, түвд, монгол гурван орны шашин номын харилцааны түүхийг үзэхэд эрт дээр үеэс эхэлсэн байдаг юм. Жишээлбэл, Эртний Энэтхэгийн наян дөрвөн шидтэн гэж алдаршсаны доторх тарнийн гүн ухааны үүсгэлийн зэрэг, төгсгөлийн зэрэг хэмээх хоёр зэргийг бясалгалын туйлд хүрсэн их дүвчин Дилова Шийравсамбуу, Банчэн Нараво, Ишидүва нарын хувилгаан дүрүүд монгол оронд заларч олон амьтны тусыг зохиож байсан баримт байдаг юм. Одоогоос 1000 гаруй жилийн өмнө Эртний Энэтхэгийн их бүтээлчин Дилова, Банчэн Нараво нар нь тарнийн гүн ухааны бясалгал бүтээлийг эзэмшиж олон түмэнд тустай үйл хийж байсан нь энэтхэгийн наян дөрвөн шидтэний намтарт тодорхой байдаг билээ. Их бүтээлчин Дилова нь Энэтхэгийн Сахор (Бангладеш) орны их дүвчин бөгөөд Энэтхэгийн Хачийн Бандидаа Банчэн Наравод нууц тарнийн ёсны увдисуудыг хайрлаж байсан байна. Гаржүдвийн ёс нь дотроо Шамбаа гаржүд, Дагво гаржүд, Гарма гаржүд, Бүрүгво гаржүд зэрэг долоо, найман биеэ даасан гүн ухаан, тарний ёсны салбар болон хөгжиж ирсэн байна.

XIII зууны үед Монголын хаан Мөнх, Хубилай нар Түвдээс Гарма гаржүдвийн салбарын их ламтан Гарма багш Чойжилодойг урин залж Гармавын ёсны номлол сургаалыг монгол оронд дэлгэрүүлсэн түүхтэй байна.

Монголын түүхч гүн ухаантан Зава Дамдин (1867-1837) гавжийн туурвисан Монголын шашины түүхийн гол сурвалж бичиг “Хор чойнжүн” номонд Мөнх хаан Буман хандын үсээр сүлжиж хийсэн хар малгайг Гарма багшид өргөсөн гэж тэмдэглэсэн байдаг.

Үүнээс хойш Гаржүдвийн ёсныхныг Шанаг Гармава гэж алдарших болжээ. Энэ түүхэн уламжлал яван явсаар 16-р Гармавыг хүртэл хэрэглэгдэж байсан байна.

Түүнээс хойш Монголын хаан Тогоон төмөр Гарма гаржүдвийн тэргүүн ламтан Гарма Ролбийдоржийг урин залж байсан байна. Энэ мэтчилэн Монголын Их хаадууд түвдийн эртний шашин Гаржүдва, Сажавын ёсны их дээдэс лам нарыг урин залж Жидор бурхан, Дэмчог бурханы ван, авшгийг хааны ордонд хатан, хөвгүүд, нөхөр сэлттэйгээр хүртэж авч байсан байна. Эртний Энэтхэгийн наян дөрвөн их шидтэний үүсгэн дамжуулсан нууц тарнийн ёсны Их хөлгөний шашин монголд дэлгэрч байжээ. Ялангуяа монголын анхдугаар Богд Жэвзүндамба Өндөр гэгээн Занабазараас хойш монголын шашины дахин сэргэн мандлын үед Монголын хутагт хувилгаад нар тодрон төрж байсны дотор Наро Банчэн хутагтын олон дүрүүд Дилова хутагтын удаа дараагийн дүрүүд тодрон гарч шашин амьтны тусыг агуу их үйлдэж байсан байна. Ялангуяа Наймдугаар Богд Жэвзүндамба Хутагтын үед монгол орны олон аймаг хошуудад ид шид эзэмшсэн тарнийн ёсны олон мэргэд төрж гарсныг VIII Богд Жэвзүндамба хутагтын үйлс ерөөлийн эрхээр Энэтхэгийн наян дөрвөн шидтэнгүүд монгол оронд дахин хувилан төрж байсан гэж дээдэс багш нар олонтой айлдаж байсан байдаг. Түвдэд дэлгэрсэн Гаржүдвийн ёсны Мил Богдын тухай мэдлэг Монголын ард түмний дотор өргөн дэлгэр домог болон тархсан байдаг. Үүнийг лавшруулан судлахад түүхчдийн Хар бухын балгаснаас олдсон судалгааны материалууд чухал үнэтэй баримт болж байна. Архангай аймгийн Өгий нуур сумын нутагт оршиж байсан Оромбын хүрээний хавь газар Оромбын гэгээний дэргэд амьдарч байсан хэд хэдэн түвд хүмүүс тэд нарын удам угсааны монгол хүмүүсийн дотор Мил богдын намтарт холбогдох Бэд Гонжид, Зэйс зэрэг нэртэй хүмүүс хорьдугаар зууны эхээр амьдарч байсан байна. Мөн үүнээс гадна Булган аймгийн Дашинчилэнгийн нутагт Милангийн гол гэдэг нэртэй гол нь урсан Хар бухын голд нийлдэг. Энэ нутгуудад цааш нь судалбал Гаржүдвийн ёсны Мил богдтой холбогдох Гаржүдвийн ёсны судалгааг лавшруулан судалбал их сонирхолтой байна.

Гаржүдвийн ёсыг түвд оронд дэлгэрүүлэгчдийн нэг болох Түвдийн их бүтээлчин Хайдав Чүнбоналжор (909-1139) түүнийг

төрөх үед нь Энэтхэгийн их бүтээлчин Амуга Базар заларч “Энэ бяцхан хөвгүүн шашин амьтны тусыг агуу ихээр үйлдэх болно” гэж эш бошго үзүүлсэн байна. Арван наснаасаа эхлэн үсэг бичигт суралцан одон зурхай зэрэг ухаанд мэргэжсэн байна. Залуудаа Балбын Пантэнбагаас Дэмчог бурханы авшигийг хүртэж Энэтхэгийн Рахула Базарыг шүтэж олон үндэс номлолуудыг сонссон байна. Энэтхэгийн их дүвчин Мидрэвааг шүтэж Гомбын чойгорыг бүрэн гүйцэд сонссон. Мөн Банчэн Наровын дүү охин Ишижи Хандома Нигүматай учран “Илбийн бие зүүдний авшиг”, “Наровын Зургаан ном”, “Илбийн мөрийн зэрэг” нийтийн бус увдисуудыг бүрэн гүйцэд хүртсэн байна. Эртний энэтхэгийн хандома Гандара зэрэг зуун тавь гаруй ихэс лам нарыг шүтэж нууц тарнийн номын аймгуудыг хязгааргүй их сонссон. Ном сонсохдоо түүний хариу болгож тоолшгүй их алтыг өргөж байв аа.

Гаржүдвийн ёсыг түвдэд дэлгэрүүлэгчдийн нэг Марав лозова Чойжилодой (1012-1097) Марав лам нь Өмнөд түвдийн Ловраг хэмээх газар мэндэлсэн. 15 наснаасаа Борогми лозова Шагжаан-Ишээс Санскрит хэл болон дуун ухаанд суралцсан байна. Арван таван лан алт аваад Энэтхэг Балба руу увдис номлолуудыг сурахаар явжээ. Энэтхэгийн Хачийн Бандида Нарова Банчэнгийн дэргэд заларч Сандуй, Махамаяа бурханы увдисыг сонсоод Банчэн Наравотай дахин уулзахаар очиход Банчэн Нараво бясалгалд суусан байжээ. Банчэн Нараво уулзахаар очихдоо тоолошгүй хэцүү бэрх олон явдлыг даван туулсны эцэст увдис номлолоо хайрласан байдаг. Энэ нь Банчэн Нараво Энэтхэгт байхдаа Их бүтээлчин Диловаыг шүтэхээр очиход нь арван хоёр бэрх зүйлийг даван туулсны эцэст увдис номлолоо бүрэн хайрласан байдаг юм. Энэ дамжлага ёс нь Марав ламыг шүтэж Мил Богд нэгэн нас, нэгэн биеэрээ бурханы хутгийг олсон байдаг. Дөчин хоёр сүүдэртэйдээ Түвдрүү дахин морилж юм Дагмэдматай хамт амьдрах болжээ. Зарим үед алтыг цуглуулж Жагарт морилохдоо лам Мидриватай уулзаж алтаа өргөж нууц тарнийн номыг олонтой сонсож байв. Түвдэдээ ирсэн хойноо нууц тарнийн олон номуудыг түвд хэлэнд орчуулсан байна. Наян зургаан насандаа таалал төгссөн юм. Марав лам нь Сандуй бурханы увдис номлолуудыг голлон эрхшээснээр Маравын ёс хэмээн алдаршжээ.

Марав Лозовагийн дөрвөн багана гэж алдаршсан Шүнгийн Огдон

Чойдор, Должийн Цүрдон Вангий Дорж, Зангийн Мэдон Содном Жалцан, Гүнтангийн Милрава Дорж Жалцан нар нь Гаржүдвийн ёсны дээдэс лам нар байжээ.

Гүнтангийн Милрава Доржжалцан (1040-1123) гийн намтар нь Монгол, Түвд хэлээр Монголын ард түмний дунд нэлээд эрт үеэс тархан дэлгэрч түвд, монгол хоёр орны шашин соёлын харилцааны түүхэнд зүй ёсоор орсон байдаг. Саяхан болтол Гандан хийдийн цорж багш Донжий ладү цанай мойдэ Ёндонжамц багшаар Милийн намтрыг уламжлалт аман орчуулгаар олон лам нар заалгаж байсан билээ. Түүнээс гадна Мил Богдын намтрыг цээжээр мэддэг хүмүүс олон байсан байна. Милрайв нь залуу насандаа нүгэл хилэнцдээ гэмшиж Марав ламтанд анхлан шавь ороход түүний буцашгүй үнэн чин зоригт, сүжиг бишрэлийг болгоож Хотын үйлийг үйлдүүлж нурууг нь цоортол олон жил залхаан дахин дахин зарж зовоосонд огтхонч сүжиг бууралгүй зүтгэсээр нэгэн нас, нэгэн биеэрээ Бурханы хутгийг олсон гайхамшигт чин зориг үзүүлсэн нь даган орогч шавь нарт үлгэр дуурайлал болж “Түвдийн ард түмний гайхамшигт хүү” хэмээн нэгэн дуугаар бишрэн сүжиглэсээр ирсэн билээ.

Мил Богдын наран адил шавь, саран адил шавь гэж алдаршсан Да-од шонүү, Райчүн Дорждагва нар нь Гаржүдвийн салбарын Мил богдын увдис дамжлагыг хүртсэн шавь нар байв.

Мил богдын наран адил шавь Дагволхажэ нь залуу наснаасаа эмийн номонд суралцаж мэргэн болсноор “Лхажэ” хэмээн алдаршжээ. Нэгэн эмэгтэйтэй ханилаад хорин таван насныхаа үед тэр нь өнгөрсөнд сэтгэлд нь уйтгар төрөөд Гаадамбын ёсны гэвш Шива Линбагаас гэлэн санваар хүртэж Жаеүлба, Нүгрэмба зэрэг газруудад Гаадамбын ёсны номыг олонтой сонссон байна. Мил богдын яруу алдрыг сонссоноор сэтгэл булаагдан учран уулзаж баясгалантайгаар түүнийг даган увдис номлолуудыг бүрэн гүйцэд хайрласныг бясалгаснаар ялгамжаат таалал эрдмүүд төрж Гаадамбын ёсны Ламрим хийгээд Мил богдын Маха мутрын увдисыг судалсан байна. Тэнсэлгүй Дагво Лхажээг дагагч нарыг Дагво Гаржүд хэмээдэг болсон.

Мил богдын саран адил шавь Райчүн Дорждагва нь Энэтхэгт хоёр удаа залрах үед Лам Бала зандрагаас “Чагдор дүмбовийн” увдисуудыг сонсож хожим нь Мил богдын зарлигаар “Лүймэд

хандоон чойгор”-ыг хүртэж бясалгасан байна. Райчүн Жагарт хүрээд Банчэн Нараво, Мидрэва хоёрын бодот шавь Дипүваад айлтгаж увдис номлолуудыг олонтой сонсоод Түвдэд Мил богдод өргөж байсан юм. Мил богдын энэ хоёр шавь нь Гаржүдвийн ёсны номын мэргэд байв.

Түвдийн Бүрүгва Гаржүдийн ёсны Бүрүгва ламтан 1980-аад оны дундуур Азийн Буддистудын Энх Тайвны төлөө Бага хуралд ирж оролцож байсан байна. Энэ нь саяхан болтол Гаржүдвийн салбарын ихэс дээдэс лам нар монголд морилж ирж байсны баримт юм.

Наро Банчэн хутагт, Дилова хутагт нар нь монгол оронд хэд хэдэн удаа хувилан төрж Энэтхэг, Түвдийн Гаржүдвийн ёсны мэргэн шидтэн нарын адилаар ид шидийг үзүүлж байсан олон баримт түүхийг тэдгээр хувилгаадын шавь нар дурсан ярьдаг. Ялангуяа Дилова хутагт Жамсранжавын аг тарнийн номонд мэргэжсэн тарнийн бясалгалын хүчээр ид шид үзүүлж байсан тухай Гандан хийдэд 1980-аад оны үед Балдан засгийн хошуунаас Гандан хийдэд хурж байсан нэр бүхий лам нар шагшран гайхацгааж байсан гэдэг. Мөн үүнтэй нэгэн адил Наро Банчэн хутагтуудын зарим дүрийн ид шидийн тухай одоо хүртэл дурсан яригдсаар байгаа юм. Эртний Энэтхэгийн их дүвчин Дилова, Нараво нарын үүсэл улбаатай Гаржүдвийн ёсны нууц тарнийн ёс нь Түвд оронд ихээхэн дэлгэрч бие даасан Гаржүдвийн ёс болтлоо хөгжиж ирсэн байна. Монголын Мөнх хаан Хубилай хааны үеэс Монгол оронд увдис номлол нь дэлгэрч XVIII, XIX зууны үед монгол оронд Дүвчин Диловын хувилгаан, Банчэн Наровын хувилаан дүрүүд удаа дараалан заларч, Монголын шашины түүхэнд тодорхой байр эзлэх хувилгаан хутагт нар олноороо төрж байсан нь Монголын шашины түүхийг судлахад чухал сэдэв болох нь дамжиггүй буй заа.

Хурлын илтгэгч Б.Лааган
Доктор (Ph.D), профессор, Монгол Улсын Гавьяат багш

НАРО БАНЧЭН ХУТАГТЫН УГСАА ГАРАЛ, ТУСГАЙ ТАМГА ЭЗЭМШСЭН ТҮҮХЭН ХУРААНГУЙ

Хувилгаан, хутагт тодруулдаг ёс жаяг, зан үйлээс тоймлон өгүүлэх нь

Нэрт эрдэмтэн Я. Цэвэл гуай “Хувилгаан нь хувирах, хувилах, шашин юманд хувилж чаддаг чадал бүхий зүйл” гээд “Хутагт шашины ёсны сайны хутаг олсон хувилгаадад ! олгох цол” гэсэн байна. (Монгол хэлний товч тайлбар толь. 721,736 дахь тал)

Үүнээс үзвэл хутагт гэдэг нь бурханы шашинд хувирах, хувьсах чадварыг гойд эзэмшсэн хүнд олгодог цол болох нь. Шашины тайлбар толинд: Эрдэм хийгээд нигүүлсэхүй сэтгэлээр хоосон чанарыг онон барьж, билгийн чинад хязгаарт хүрч, хүний сэтгэж танин мэдэхүйн төгс хөгжилд хүрч, эгэл хүнээс машид холдож хэтийдэн, ухаан билгээрээ зовлонгоос гэтлэж нирваанд хүрэгсдийг хутагт гэнэ” хэмээн тэмдэглэжээ. Иймээс сод билгүүн тунамал ухаан, авьяасаар эрдэм номонд нэвтэрч, хүн ёсны дээдийг олон мөнхөрсөн хүн нь хувилгаан, хутагт болдог байна. Бага ахуйд нь хувилгаан, цолтой болохоор нь хутагт гэнэ. Өөрөөр тодорхойлбол хүний зургаа дахь мэдрэмжийн эрхтэнийг эзэмших хэмжээнд хүрч чадсан хүмүүн Хутагт цолонд хүрдэг ажээ.

Хутагт цол хүртсэн хүн үрэгдэж үгүй болно гэсэн ойлголт бурханы онол сургаалд байхгүй. Тиймээс хутагтын бие, махбодь оюуны үйл ажиллагаа нь түр хугацаанд саатаад тодорхой үе шат дуусахаар бие цогцос нь дараагийнхаа дүрээр хувилан хэвийн амьдралаа үргэлжлүүлдэг байна. Иймээс өмнөх хутагтыг “жанч халав”, “жанч тайлав” гэхчлэнгээр нэрлэж, бичнэ. Харин хувилан залгаж буй хутагтыг хойд дүр нь тодров, шавьд нь нийлүүлэн суулгав гэдэг байна.

Хутагт цол хүртээдэг шашины онол, сургаал, арга зүйг тодорхойлсон тусгай судар ном байдаг бөгөөд түүнийг хутагтын сунтаг хэмээн нэрлэнэ. Хутагтыг жанч тайлсны дараа өндөр мэргэжлийн, дадлага туршлага бүхий лам, урьдчилан тогтоосон сайн өдөр, цагт нь Сунтагийг нээн уншина. Сунтаг номонд уул хутагтын мэндэлсэн газар орон, он, сар, өдөр, гариг, мэнгэ,суудал зэргийг нь жанч тайлсан цаг хугацаа, мөчлөгтэй харьцуулан дүгнэлт гаргах боломжийг зааж өгсөн байдаг ажээ. Түүнчлэн хутагт жанч тайлах үедээ хэлсэн үг, дохисон дохио, аль зүг рүү харж байсан мэтийг дүгнэлт гаргахдаа заавал авч үзнэ гэнэ.

Сунтагт хутагтын хойд дүрийг хайж олох, газар нутгийн зүг чигийг заахын хамт 3-4 настангуудыг онцгойлон дурьдаад, тэр насны хүүхдүүд өмнөх хутагтынхаа ном зохиол, дээл хувцас, хэрэглэж байсан эд өлгийн зүйл, тэрч байтугай дуртай хоол, унд, юуг илүү сонирхдог, сүм, дуганаас нь ямар нэг юм мэддэг байх ёстой хэмээн заажээ.

Хутагтын хойд хувирсан дүрд заавал хүүхэд гэхгүй, залуус байхыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэхдээ хүүхэд, залуучууд нь эрүүл саруул, оюуны өндөр чадамжтайгаас гадна тэдэнд ид шидийн эх сурвалж, шинж тэмдэг бусдаас илүү илэрхийлэгдсэн байх ёстой ажээ.

Шинээр хувилсан хутагтыг тантан хайхад эцэг, эхийн удам угсаа, байгаль дэлхийн байршил, шашин хүчтэй дэлгэрсэн газар чухал нөлөөтэйг сунтагт дурьдсан төдийгүй, Энэтхэгийн үзэсгэлэнт мөнхийн ногоон нутаг, Ганга мөрний сав, Түвдийн өндөрлөг уулс зэрэг нь Бурхадын сүнс, хувилах хутагтуудын байрлах орчин хэмээн заажээ.

Хувилгаан, хутагтын дүрийг тантан олоод шүүлтүүр давсан хүмүүнийг шашины ёс жаягаар Далай лам, Банчэн эрдэнэнарт уламжлан айлтгах ёстой. Тэд л эцсийн шийдвэр гаргадаг журам, ёс заншил эдүгээ хүртэл үргэлжилсээр ирсэн юм.

Ер нь хувилгаан, хутагтын асуудал зөвхөн Бурханы шашинаас гадна өөр шашин дэлгэрсэн улс оронд байдаг бололтой юм билээ. Оросын нэрт эрдэмтэн Ф.Щербетский, С.Ольденбург нар Бурханы шашины хувилгаан. Хутагтуудыг дагнан судалж хэд хэдэн ном хэвлүүлсэн байна. Тэдний номонд Христын шашины зарим урсгалын лам хувраг нарт Хутагт цол олгосон төдийгүй хойд дүрийг

нь өвөрмөц байдлаар тодруулдгийг харьцуулан дурьдсан зүйл бий.

Англид Йоркийн тамгатай хутагтын сургууль нилээн дээр үед ажиллаж байжээ. Тус сургуулийг төгссөн Алкуйн хэмээх ид шидтэй хутагт “Хүнийг танин мэдэх арга ухааныг тодорхойлох нь” гэсэн ном бичиж хэвлүүлсэн нь Лениний нэрэмжит Москвагийн номын санд байсныг миний бие гүйлгэн уншиж байсан билээ.

Бурханы шашины гол төв Түвдэд ХҮШ зууны эхэн үед 12О орчим хутагт тодорсон байсныг нэр устай нь, сүм хийдтэй нь тодруулан бичсэн судар байдаг. Сударт дурьдагдсан хувилгаан, хутагт нарын намтар, цадигаас харвал ер бусын ид шид бүхий бишрэн гайхмаар, бас итгэн үнэмшихэд бэрх гойд сонирхолтой үйл явдлууд бий. Хутагтуудын эрдэм чадал, билэг оюуныг шүтлэгтэй хүмүүсээс гадна жирийн иргэд, судлаачид,сонирхогчид ч хүндэтгэн, цаад учир начрыг нь мэдэхийг хүсэмжилсээр байна. Эрдэмтэн мэргэд шинжлэх ухааны талаас судалж, зарим хэсэгт нь бодит гаргалгаа хийж чадаж байна.

Наро Банчэн Хутагтын удам угсаа, түүний дүр Халхад хувилсан үйл ажиллагаа Монгол нутагт бурханы шашин миний ойлголтоор хэд хэдэн үе шат буюу удаа дараалалтай дэлгэрсэн байдаг. Бурханы шашины шинэтгэлийг оройлон хийсэн Богд Зонхабын онол сургаал, ХҮ! зууны дундаас Түмэдийн Алтан, Түвдийн Содномжамц нарын идэвхтэй оролцоотойгоор Халх нутагт хүчтэй орж ирэх зам тавигдсан билээ.

Монголын феодал ноёд, бөө мөргөлийг орхин, шарын шашиныг хүлээн авах ёслол дээр дээрх Содномжамцад “Далай лам” гэсэн цолыг хүртээсэн нь гойд түүхэн үйл явдал байлаа. 1577 онд Чингис хааны ойрын удмын, нэр нөлөө бүхий ноён Абтай далай лам Содномжамцтай биечлэн учирч Халхад шарын шашиныг удирдан дэлгэрүүлэх болсноор Эрдэнэ зуугаас эхлэн шашины олон сүм дугана, хурал номын газрууд байгуулагдаж, нүүдэлчдийн анхаарлыг гоёд татаж, шашин шүтэгчид олширч, лам хуврага нар ч төрөх болсон түүхтэй.

Шашин дэлгэрэхийн хирээр бурханы орон Түвдээс эрхэм чадал бүхий оюуны өндөр чадамжтай лам хуврагууд, ид шидтэн хутагтууд залагдан ирж ажилласнаар хүрээ хийд бэхжин өргөжиж, монголчууд ч лам, хутагтуудыг сайтар мэдрэх болсон байна.

Монгол хүн бурханы шашиныг мэдрэн шүтэн биширч, хүндэтгэн тахихын хамт хувилгаан, хутагтыг ойлгодог болсноор өөрсдийн доторх оюунлаг, эрдэм ном сурах авьяас, чадвар бүхий хүүхэд, залуучуудыг сонгон хүрээ хийдэд суулган, цааш нь Түвдэд суралцуулж, бас хутагтад тодруулах боломжийг хайн илэрхийлэх болжээ.

1630-аад оны дунд үест Түвдийн Хүдэн гэгээний хувилгаан Балжууржамцын хойд дүр болох Жалханз хутагтад Халх монголын Лувсанданзанжамцыг тодруулсан бол төдөлгүй Зая Бандидаа, Ламын гэгээн гэзд хэд хэдэн хутагт тодрон үйл ажиллагаагаа амжилттай явуулсан байна. Ингэзд л Энэтхэг, Түвдийн ном эрдэмтэй, алдар хүндтэй, ид шидтэй хутагтууд Халх монголд хувилан мэндлэх нь өргөжжээ. Хутагт тодорсон аймаг, хошуу, хүрээ хийдийн нэр хүнд ч өсөн нэмэгдсэн байна.

XY11 зууны сүүлчид Энэтхэгт тав, Түвдэд дөрвөн удаа тодрон үйл ажиллагаа явуулж байсан Наро Банчэн хутагт Халх нутагт хувилан мэндлэх нөхцөл боломж бүрджээ. Тухайн үеийн Түшээт хан аймгийн баруун захын “Умар замын дундад дахь умарт буюу хожмын Хошууч мэргэн” хошууны тайж Гүржавын хүү Бадамдоржийг шинжээчдийн баг Наро Банчэнгийн хойд дүр хэмээн нэрийг нь тодруулан гаргаж ирсэн байна. Бадамдорж 1699 онд эхээс мэндэлж, хүйг нь боосон үеэс хоёр гараа бурханд заливарч буй байдалтай болгоод өлгийдүүлэлгүй уйлж эхэлжээ. Хүйг нь боосон “ээж” арга ядаад гэрийн хоймор дахь залаастай бурханы өмнө хүүг тавьтал уйлахаа болж өлгийдүүлсэн гэх бас Бадамдоржийн үндсэн хошууны засаг ноён Гончигсүрэн Эрдэнэ-зуу болон бусад хийдээс нэр хүнд бүхий лам хуврага залан хутагт тодруулах хүмүүстэй уулзуулж байсан гэсэн ам дамжсан яриа бий. Бадамдорж хэлд орохдоо мааний үг хэлж, Түвдэд жанч тайлсан Наро Банчэн Жанцаннямбо хутагтын хэрэглэж байсан зүйлээс нэрлэсэн гэх буюу төмөр мэт хатуу зүйлийг дээс, сур шиг эвхэж тоглодог байжээ.

Далай лам Бадамдоржийг Наро Банчэн хутагтын дүр мөн гэж айлдсанаар Халхад анхны Наро Банчэн хутагт албан ёсоор тодорсон ч түүнд зориулсан сүм дугана, шавь гэхээр юм байсангүй.

Бадамдорж хутагт Түвд оронд залагдаж, эрдэм номонд суралцжээ. Хутагт хэдэн жилийн дараа нутагтаа ирэхэд олон хүн түүний шавь

болж, хошуу нутгийн харъяалал нь ч өөрчлөгдөж, Сайн ноён хан аймгийн чуулганд багтсан байна. Тэрээр 1737 онд 38 насан дээрээ жанч тайлжээ.

Халхын хоёр дахь Наро Банчэн хутагтын нэрийг судлаачид ялигүйхэн зөрөөтэй бичсэн, нэрлэсэн байгаа. Хутагт нарт сахилын, үндсэн, багшийн нь өгсөн нэр гээд өөр, өөр нэр байх явдал бий. Тэр үеийн Ордос хошууны тайж Дашдэндэвийн гэрт 1738 онд мэндэлсэн хүү Наваанчойронданзанжамцыг тав, зургаан насны заагт нь Халх дахь Наро Банчэн хутагтаар тодруулжээ. Тэр хутагт 79-ний сүүдэр дээрээ жанч тайлсан байна.

Халхын гурав дахь үеийн Наро Банчэн хутагтаар Амду газрын Цувдан хийдийн шавь Галсаннамжилын гэрт 1818 онд төрсөн Түгжжавыг тодруулан хутагт цол олгож, шавьд нь нийлүүлэн суулгажээ. Энэ хутагт 1860 онд жанч тайлаад Түшээ гүн Мягвасамбуугийн хошууны залан Чогсомынд хувилан мэндэлжээ.

Наро Банчэнгийн дөрөв дэх үеийн Чогсомын хүү Бирваад Далай лам, Банчэн эрдэнэнар 1865 онд Наро Банчэн цол олгон шавьд нь нийлүүлэн суулгасан байна. Бирваа хутагт идэр залуудаа жанч тайлж, өөрийн шавийнхаа Доржийн гэрт 1884 онд хувилжээ.

Энэхүү хувилсан гэгээнийг Пүрэвжав гэх бөгөөд өмнөх хутагт нараасаа зарим нэг зүйлээр ялгаатай. Тэрээр шашины ёс жаяганд тэр бүр баригдахгүй, чөлөөтэй байхыг эрмэлзэнэ. Шазруун зантай, шавь болон бусад айлын гэр орноор очиж, ном айлдах, явуулын тэр тусмаа бадарчин хүмүүстэй уулзаж, яриа хөөрөө өдөх сонирхолтой. Тэгж явахдаа жороо морь унан, олон хүн дагуулж, уулзсан бүхэнтэй өндөр дуугаар харилцдаг байжээ. Пүрэвжав хутагттай холбогдол бүхий яриа, хөөрөө, домог үе улиран яригдаж ирсэн зүйл нилээд байдаг.

Нутгийнхны нэгэн яриаг дэлгэвэл, Улиастай орчимд явганаар морьтой хүнтэй уралдаад гүйцэгддэггүй хурдан Аюуш гэж байж гэнэ. Хутагт Аюуштай уулзаад чи их хурдан гэл үү? Та надтай уралдаад түрүүлбэл би чамд азарга адуу өгье гэснээр тохиролцоо хийжээ. Хутагт жороо халиун морио унаж, Бугатын голд Аюуштай уралдаад гүйцээгүйд гэгээнтэн чамгүй бухимдаж, чи жинхэнэ хурдан биш, чамд ямар нэгэн ид шид байх шиг байна гэхдээ тохиролцсон ёсоор азарга адуугаа өгч байжээ.

Түүнчлэн Пүрэвжав хутагт шавь нутагтаа гарсан аймшигт тахал өвчнийг өөрийн биеэр малын махаар эмчлэн богино хугацаанд эдгэрүүлсэн яриа ч бий.

Пүрэвжав Дилова хутагтын унаган шавь нь, багштайгаа хамт Богд Жэвзүндамбатай биечлэн уулзаж байжээ. Тэр гэгээнтэн 1903 онд гэнэт жанч тайлжээ.

Халхад тодорсон зургаа дахь Наро Банчэн нь Лувсанцэрэнгийн Жүгдэрнамжил юм. Энэ гэгээнтэн 1904 онд мэндэлж, тав орчим насанд нь шавьд нийлүүлэн суулгасан байна.

Наро Банчэн Жүгдэрнамжил шашины эрдэм номонд шамдан суралцаж, сахил санваарын ёс жаягийг хатуу сахидаг, шашин, төрд үнэнчээр зүтгэдэг байжээ. Хутагт Олноо өргөгдсөн Богд хаант улсын үед Хамбын бүрэн эрх, цоржийн ямбаар тус тус шагнагдсан байна. Хутагт 1931 оны орчим жанч тайлсан ч хойд дүр нь тодроогүй явна.

Түүхэн сурвалж бичиг, баримт, эрдэмтдийн бүтээл, архивын сан хөмрөг болон бидний хийсэн судалгаанаас нэгтгэн үзвэл Халхад Наро Банчэн хутагтаар монгол хүн анх тодорсны 315 жил, хутагт Пүрэвжавын мэндэлсний 130 жил, хувилан хараахан тодроогүй яваа хутагт Жүгдэрнамжилын төрсний 110 жилийн ойнууд энэ 2014 онд тохиож байгааг та бүхэнд дуулгахад таатай байна.

Халхын Наро Банчэн хутагтууд тусгай тамга эзэмшиж, эрх үүрэг нэмэгдсэн нь Халхын нутагт бурханы шашин нийтийг хамран өргөн хүрээнд дэлгэрч, хангай, хээр тал, говь газарт сүм хийд сүндэрлэн босож, нүүдэлчдийн сэтгэл зүй шарын шашинд хүчтэй татагдаж байсан үед Манж улс Монголчуудыг хэрхэн мэдэлдээ оруулах төрийн бодлогоо боловсруулсан нь тохиолдлын зүйл биш байв.

Манж улсын хаад нэр хүндээ өргөх, монголыг эзэгнэх төрийн бодлогодоо бурханы шашины нөлөөг ашиглах, шашинаар дамжуулж, монголчуудыг өөртөө татах зэргийн ажлуудыг дэс дараатай хэрэгжүүлсэн түүхэн баримт элбэг.

Тухайлбал 1691 онд Халх монголыг Манж чин улс мэдэлдээ оруулаад Халхын шарын шашины тэргүүнээр 1639 онд өргөмжлөгдсөн Жэвзүндамба Занабазар хутагтыг хэвээр нь үлдээж, сүсэгтэн монгол хүмүүс зориулж, “Буяныг цугларуулагч” хэмээх сүм байгуулж өгчээ.

1736 онд II Жэвзүндамба хутагтыг Бээжинд очиход Тэнгэрийг тэтгэсэн хаан хутагтын буусан өргөөнд нь бараалхан өөрийнхөө хүзүүнд зүүж явсан эрдэнийн эрхиэ түүнд зүүн өгч, нутаг буцахад нь 100000 лан мөнгө өгөх зэргээр хүндэтгэл үзүүлсэн байдаг.

Манжийн төр Халхад хувилан тодорсон хутагт болон тэдний сүм дугана, шавь нараас ямар нэгэн татвар авахгүй байх хууль гаргасан байна. Манжийн хаан монголын нэр хүнд бүхий лам, хуварга, хутагт нарыг өөртөө үнэнч байлгах, төрийн бодлогод дуулгавартай оролцуулах үүднээс тэднийг хааны зардлаар Бээжинд авиачин, “Тунли ном унших жасаа” гэдэгт суулган оюун ухаан, сэтгэл санааг нь татах ажлыг богино, богино хугацаанд хийдэг уламжлал тогтоожээ.

Халх монголд олон хувилгаан, хутагтууд төрж,,том жижиг, сүм, дугана, хүрээ хийдүүд байгуулагдаад ирэхээр Түвдээс лам нар залагдан ажиллах нь ихэссэн байдаг билээ. Зарим судлаачдын хийсэн тооцоогоор зөвхөн Халхад хувилгаан хутагтын тоо зуу дөхсөн хэмээн тэмдэглэсэн нь бий.

ХҮШ зууны дунд үеэс Халхад хувилгаан хутагтуудаа тойрон хүрээлж, тэдний төлөө амь, амьдралаа зоиулсан сүсэгтний бүлэглэлүүд бүрэлджээ. Лам нарын тоо ч эрс нэмэгдсэн байна. Манж нарыг эсэргүүцсэн их, бага хөдөлгөөн, бослого тэмцэлд лам нар төдийгүй хутагтууд оролцох хандлага ч илэрх болжээ. Ийм нөхцал байдлыг манж нар онцгой анхаарч хууль гарган мөрдүүлсэн байна.

Энэ хуулиар Жэвзүндамба хутагтын хойд дүрийг монголоос биш, Түвэд орноос тодруулж байх, бусад хувилгаан хутагт нарыг шууд тодруулахыг хоригложээ. Хуулинд зааснаар: Феодал, ноёд биш гэр бүлээс шашины том хутагтын дүрийг тодруулахад хүрвэл аймгийн чуулганаар хэлэлцээд боломжтой хүний нэр, материалыг Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яаманд ирүүлж болно гэжээ. Хуулийн дагуу ирүүлсэн материал, хүний нэрийг тус яам нягтлан шалгаад тусгай дүгнэлт үйлдэн хаанд уламжлана.

Ийм шат дамжлагаар тодорсон хүний асуудлыг хааны алба дахин лавлаж магадлаад боломжтой гэж үзвэл хаанд нэг бүрчлэн танилцуулна. Эцэст нь хаан зөвшөөрч улаан өнгийн бэхээр бичсэн зарлиг гаргаснаар уул хутагтад тамга олгох эрх нээгдэнэ. Хутагтад Манж, Монгол, Түвэд хэл дээр бичвэртэй тамга олгоно. Манж хаанаас ийм тамга авсан арван гурван хутагтын нэг нь Наро Банчэн юм.

Халхын Наро Банчэн хутагтын хоёр дахь үеэр тодрон үйл ажиллагаагаа явуулж байсан Наваанчойронданзанжамц 1772 онд Манж хаанаас хутагтын шавь захирах мөнгөн тамгыг гардан авчээ. Энэ хутагтаас эхлэн дараа, дараачийн үеийн Наро Банчэн хутагт нарын эрх, үүрэг нь хуулийн дагуу нэмэгджээ.

- Тамгатай болсноор Монголын шашин сүм хийдийн хүрээнд байр, сууриа баттай олж, 700 гаруй шавиа нэгтгэн захирах болов.
- Шашины эрх мэдлийн талаар хэн нэгэнд хамаарагдахгүй, захиргааны хувьд хошууны засаг ноёны адил аймгийн чуулганы газарт харьяалагдана.
- Шавь нар нь Манжийн төрийн алба, гувчуураас бүрэн чөлөөлөгдөж, зөвхөн өөрийн хутагт, сүм, хийдэд үйлчилнэ.
- Тамгатай хутагтын оршин суугаа аймаг, хошуунаас тусгайлан газар олгоно. Наро Банчэн хутагтад Сайн ноён хан аймгийн “Хошууч мэргэн гүний хошуу”-ны урьд хэсэг, Завхан голоос хойших нутгийг мэдэлд нь өгчээ.
- Хутагт мэдлийн газартаа өөрийн сүм, дугануд, хийдээ зугуухан байгуулж, шавь нар, сүсэгтэн олны мөргөлийн төв болгосон байна. 1918 оны тоо бүртгэлээр сүүлчийн хутагт Жүгдэрнамжилын харьяанд 130 гаруй өрхийн 658 шавь (хүн) тоологджээ.

Манж хааны зарлигаар Монголын зарим хутагт нарт тусгай тамга олгодог болсноор Халхын хутагтууд тамгатай, тамгагүй гэж хуваагдсан байна. Харин тамгагүй хутагтын дотор Богд Жэвзүндамба хутагтын шавьд ихээхэн эрх, ямба бүхий хутагт байсан бөгөөд тэднийг “Голын долоон хутагт” хэмээн тусгайлан үздэг байв.

Шарын шашины ёс жаяг, онол үзэлд Далай лам, Банчэн эрдэнэ нарыг шашины хамгийн дээд шүтээн хэмээн хүндэтгэж хутагтаас ангид тооцогддог уламжлал байдгийг тэмдэглэвэл зохино.

Наро Банчэн хутагт судлалын цаашдын төлвийн талаарх зарим санаа

Монголын түүхэнд бурханы шашин хийгээд хувилгаан хутагтын асуудлыг их, бага хэмжээгээр, янз бүрийн өнцгөөс тайлбарлан бичсэн

нь бий. Харин 1990-ээд оноос эрдэмтэн, судлаачид, сэтгүүлчид, шашин судлал сонирхогчид, лам нар хувилгаан хутагтын талаар чамгүй олон хэвлэлийн хуудас бүхий ном, товхимол хэвлүүлээд байгаа билээ.

Улаанбаатар хот, аймгуудын төв, сум, томоохон хот, суурин газруудад олон тооны сүм, дугана, хурал номын газрууд шинээр бий болсоор багагүй хугацаа өнгөрөв.

Ардчилал, шинэчлэлийн замаар замнасан өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд бурханы шашин судлал өргөжиж, түүний дотроос хутагт судлал үүсэн хөгжих суурь нь тавигдлаа. Жалханз хутагт Дамдинбазар, Зая хутагт Лувсанпэрэнлэй нарын амьдрал үйл ажиллагааг шинжлэх ухааны талаас нарийвчлан судалж хэд хэдэн хүн эрдмийн зэрэг хамгаалаад байна. Тамгатай, тамгагүй хутагтуудыг судлах, тэдний нэр төр, үйл ажиллагаа, сүм хийдийг нь сэргээх, намтар түүхий нь бодитойгоор бичиж, хүүхэд, залуучууд, олон түмэнд мэдүүлэх гэсэн санаачлагууд ихээр гарах боллоо.

Сүүлийн жилүүдэд тамга бүхий хутагт нарын дийлэнх хэсгээр сурталчилгаа, судлагааны чиглэлээр ном зохиолууд хэвлэгдээд байна. Харин Халх монголд зургаан удаа хувилан мэндэлж, Манж хаанаас шавь захирах мөнгөн тамга авч, эзэмшил нутагтаа сүм хийд байгуулан, бие даасан үйл ажиллагаа явуулж ирсэн Наро Банчэн хутагтын талаар доривтойхон судалгаа, сурталчилгааны бүтээл ховорхон байна.

Тодорхой учир шалтгааны улмаас Наро Банчэн хутагтын хурал ном, шавийн нь ажил төрөл бүдгэрэн, сүүлчийн хутагт хувилан тодролгүй өдий хүрч ирэв. Олон түмэн, түүний дотор Завхан аймгийнхан, Наро Банчэн хутагтын шавь, шавийн удам угсааныхан, зарим сэхээтэн, лам хуврагууд хутагтын сүм хийд, хурал номын үйл ажиллагааг сэргээх, хойд дүрий нь тодруулахыг хүсэмжилсэн олон санал санаачлагууд гараад байгаа билээ. Үүнтэй уялдуулан судлаачийн хувьд дараах санааг илэрхийлье..

- Наро Банчэн хутагтын судалгааны баг байгуулан түүндээ төрөл бүрийн мэргэжилтэн, лам хуврага, удам угсааныхан, шавь нараас нь төлөөлөл оролцуулан өргөн хүрээг хамарсан ажил зохион байгуулах нь чухал болов уу?
- Одоо цаг үед алив нэгэн ажил төрөл зохион байгуулахад эдийн засгийн боломж зайлшгүй тавигдана. Үүнтэй уялдан

менежментийн ажиллагааг эхлээд, хайж шийдэх.

- Ойрын болон хэтийн зорилт, ажил төрөлөө тодруулсан төлөвлөгөө байх нь мэдээж.
- Хутагтуудын хэрэглэж явсан эд, өлгийн зүйл, судар ном, зураг мэтийг цуглуулан ирээдүйд музей байгуулахад бэлтгэх, Үндэсний төв номын санд байгаа шавийн газрын зургийг томруулж, боломжит газар байрлуулах.
- Хутагтын удам угсааныхан болон шавь нарын нь дурсамж, тэдгээрийн удмынхнаас төрсөн алдар гавьяатай хүмүүсийн түүх намтраар ном бүтээж хэвлэн гаргах.
- Наро Банчэн хутагтын шавийн газар нутагт байгаа ховор ан амьтан, байгаль экологитой холбоотой газрын зургуудаар альфом, цаг тооны бичиг, өнгөт гэрэл зургийн юмуу сурталчилгаа, ухуулгын материал, Сй бэлтгэн олны хүртээл болгох.
- Дотоод яам, улсын төв болон Архангай аймгийн архив, Үндэсний номын сангийн гар бичмэлийн фонд, Гандан хийдийн номын санд байгаа Наро Банчэн хутагттай холбоотой материалуудыг шүүн түүвэрлэж эмхтгээд уншигчид, гадаад, дотоодын судлаачдад хүргэх ажлыг зохион байгуулах.
- Хутагтын хүрээ, хурал,номын газрыг сэргээх, гэгээнтэн Жүгдэржамжилын хойд дүрийг хайн тодруулах ажлыг Монголын бурхан шашины төв, Шашины дээд сургууль, гадаад, дотоодын холбогдох хүмүүс, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах шаардлага тавигдаж байна.

Наро Банчэн хутагтын Халхад хувиран тодорсон зургаан хутагтууд олон шавь, шүтэн бишрэгчид ихтэй, нэр хүнд бүхий ид шидтэй гэгээнтнүүд байв. Энэ эрхэм хутагтуудын намтар түүх, сүм дугана, хурал номын газар, шавь нартайгаа ажиллаж байсан үйл ажиллагаа нь монголчуудын шашин, оюуны чухал өв сан болон улам зузааран баяжсаар байх нь дамжиггүй.

Хурлын илтгэгч З.Лонжид
Доктор (Ph.D), профессор, МУИС-ийн Зөвлөх профессор

ХАЛХЫН ХУТАГТУУДЫН ТУХАЙ СУДАЛГААНЫ ТОЙМ

Эхлэл

Монгол нутагт бурханы шашин дэлгэрч мандсан түүхийг улируулан шинжлэхэд орхиж боломгүй нэг чухал сэдэв бол үе үеийн богд гэгээнтнүүд хутагт хувилгаадын намтар, тэдний шашин номынх нь ажил үйлсийн судалгаа байх ёстой. Иймээс ч мэргэдийн туурвисан олон арван бүтээл туурвилыг ахмад түүхчид анхааран шинжилж ашиглаж байжээ. Харин энэ талын судалгааны түүх шастирыг эдүгээгийн түүхчид, түүх сонирхогчид уншиж болгоосон буюу өөрсдийн бүтээлдээ эх сурвалж болгон ашигласан нь ховордуу бололтой.

Бидний ажигласнаар бол энэ талын судалгаа Чингийн эхэн үед нилээд эрчимтэй эхэлсэн боловч 1870-аад оноос эрч нь суларсаар 1890-ээд оны сүүлчээс Чин улсын Шинэ Засгийн бодлого хэмээгчийг Монголд хэрэгжүүлэх болсноор үндсэндээ зогссон байж магадгүй ажээ. Харин 1911 онд манай өвөг дээдэс төрийн тусгаар тогтнолоо сэргээснээс эхлэн бурхан шашины ихэс дээдсийн намтар цадиг бүтээл туурвилыг олны хүртээл болгох талаар төрөөс анхаарч нилээд бүтээл гаргасан бололтой. Гэвч 1928 оны 12-р сараас эхэлсэн Зүүнтний их хийрхлийн гурван жил гаруй хугацаанд эрдэмтэн лам нар урьдын адил ном бүтээх эрхгүй болсон авч 1933 оноос байдал зөөлөрсөн боловч улс төрийн байнгын хардал сэрдэл газар авсны улмаас шашины нэрт зүтгэлтнүүдийн тухай бүтээл туурвих нь бүү хэл тэдний тухай нааштай үг хэлэхээс ч айж имээх байдал газар авсны уршгаар бурханы шашины хутагт хувилгаад лам хуврагуудыг хамгийн муу үг хэрэглэж гутаах сурталчилгаа 1980-аад оны эцэс хүртэл бараг 60 жил үргэлжилсээр шашин судлалын салбар бүр мөсөн зогссон байна.

Цагаан морин жилийн хувьсгалаас хойш энэ чиглэлийн судалгаа хийхийг төрөөс огт хориглоогүй боловч дэмжиж хөхүүлэх талаар даацтай бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд дутмаг анхаарч байна гэж би хувьдаа боддог.

Гэвч шашины хурал номын газрууд, төрийн ба хувийн өмчийн зарим их сургуулиуд энэ талаар анхаарч хэд хэдэн удаа эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж буй нь судлаачид санал бодлоо солилцох боломж олгож байна. Мөн тогтмол сэтгүүл, ажил хэвлүүлж богино долгионы радио нэвтрүүлэг байнга хийдэг болсон нь өргөн олон бурханы шашины нэрт хүмүүсийн намтар ном буяных нь үйлсийн тухай мэдлэгтэй болоход зохих тус дөхөм болж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

1990 оноос өмнөх судалгааны байдал

За ингээд бидний хөндөж буй үндсэн сэдэвтээ орж хэдэн зүйл ярья. Сурвалж баримтад дурьдсанаас үзэхэд 1913 онд Монгол Улсын Дотоод хэргийн бүгд захиран шийтгэгч яамнаас Богд эзэн хаанд хаантанд уламжилсны дагууд богдын зарлигаар Халхын алдартай эрдэмтэн түүхч, гүүш хувраг лам нарын хамтран боловсруулсан “Зарлигаар тогтоосон Монгол Улсын шастир”-ын есдүгээр дэвтэрт халхын дөрвөн аймаг их шавийн тамга бүхүй үгүй хутагт хувилгаан... хүний намтрыг хураангуй бөгөөд нилээд тодорхой байдлаар өгүүлсэн байна. Энэ бол манай улсад алдаршсан шашины ихэс дээдсийн судалгааны анхны бүтээл болжээ. Тус шастирыг туурвихын тулд харьцангуй богино хугацаанд ихээхэн өргөн цар хүрээтэй судалгаа хийж амжуулсан нь тэд үнэхээр чин сүсгээрээ хандаж эзэн хааны зарлигийг нэр төртэй биелүүлснийг нотолж байна. Тус шастирын 11-р дэвтэр буюу “Монгол улсын ерөнхийлөн үйлдсэн шастир”-т “Очирдара Богд эзний шастирыг гүнээ хичээнгүйлэн номын ёсоор зохиож таван дэвтэр болгон өөр өргөх” тухай тэмдэглэсэн байдаг боловч энэ бүтээлийг туурвиж эхэлсэн төгссөн тухай тодорхой мэдээ олдохгүй байна. Харин Улсын номын санд хадгалж буй “Богд Жэвзүндамбын анхан төрлийн нэр оршивай орон дацан анхан байгуулсныг бичсэн буянаар бурханы шашин өнө үүр орших болтугай” гэсэн нэгэн гар

бичмэлд Жэвзүндамба хутагтын 23 дүрийн тухай бичихдээ 16, 17 буюу бидний монголчуудын ярьж заншсанаар өндөр гэгээнтэн ба түүний дараахь дүрийн намтрыг нэлээд тогтож өгүүлжээ. Мөн уул бичмэлд дурдсанаар бол Жэвзүндамбын 23 дүрээс 12 нь (1, 2,3,4,12,14,18,19,20,21,22,23) Энэтхэгт; 9 нь (5,6,7,8,9,10,11,13,15) Түвдэд, хоёр нь (16,17) Халхад тодорсон байна.

Мөнхүү 9-р дэвтэрт Их шавьд тодорсон хутагтуудын тухай бичсэнээс үзэхэд тус шавьд захируулдаг 7 хутагтын 66 дүр тодорсноос Энэтхэгт 6 , Түвдэд 18, Халхад 39, Ордост 1, Хөх нуурт 1, хаана тодорсон нь тодорхой бус дүр нэг байна. Тэдгээр 7 хутагт тус бүрийн хэдэн дүр тодорсныг шастирт нэг бүрчлэн жагсаажээ. Үүнд:

1. Донхор хутагт Цэрэндорж 17 дүр

   Энэтхэгт эхний 3

   Түвэдэд 7 дүр (4,5,6,7,8,9,10-р дүр)

   Ордост (11-р дүр) Хөх нуурт 1 (12-р

   дүр)

Халхад сүүлчийн 5 (13,14,15,16,17-р дүр) сүүлчийн 17-р дүр Цэрэндорж 1937 онд цаазаар авахуулжээ.

2. Номунхан Жигмэддорж 10 дүр

   Түвэдэд 4 дүр (1,2,3,4)

   Халхад сүүлчийн 6 дүр тодорчээ.

Хувилгаан Дугаржав 6 дүр бүгд Халхад тодорчээ. 3-р дүр Цэвээндорж их хүрээний Хамба номун хан бөгөөд Тэнгэрийн тэтгэсний 42-р (1777) онд хүрээний хамба номун хан мөн 47-р (1782) онд

3. Жэвзүндамба хутагтын (1774-1814) монгол үсгийн багшаар томилогдож байжээ.

4. Эрдэнэ мэргэн Бандидаа номунхан Лувсанцэрэндамбийдонмий

   10 дүр тодорсон. Үүнээс

Энэтхэгт 1,2-р дүр

Түвэдэд 3,4-р дүр

Халхад сүүлчийн 6 нь тодорчээ.

5. Хувилгаан Дэмбэрэлдаш 13 дүр тодорсон. Үүнээс эхний 1,2-р дүр энэтхэгт 3,4,5,6,7-р дүр Түвдэд сүүлчийн 8,9,10,11,12,13-р дүр халхад тодорчээ.
6. Бамбар хувилгаан Гонсронпэрэнлэйгэндэн 6 дүр бүгд Халхад тодорсон байна.
7. Хувилгаан Эринчинбадамын 4 дүр бүгд Халхад тодорчээ.

Энэхүү шастирт бичсэнээс үзвэл Халхын 4 аймаг бүгд 69 хутагт хувилгаантай байж тэдний 301 дүр тодорчээ. Түшээт хан аймаг тамгатай хутагтгүй байжээ.

1. Тус аймгийн 21 хувилгааны 68 дүр тодорч тэд бүгд монголоос тодорсон байж магадгүй байна. Халхын бусад аймгийн хутагтуудын заримынх нь анхны дүр Энэтхэг Түвэдэд тодорсон байхад Түшээтхан аймгийнх яагаад бүгд халхад тодорсон байх вэ? гэдэг сонирхол татаж байна.
2. Сэцэнхан аймаг 14 хутагт хувилгаантай байсан бөгөөд тэдний 2 нь тамгатай хутагт 12 нь хувилгаан, Бандидаа нар байв. Мөн энэ хоёр хутагтын 16 дүрийн 5 нь Түвдэд тодорсон ба Эрдэнэ Ялгуусан хутагтын анхны дүр нь Баруун зуу (Лхас)-гийн Сэр хийдийн Жаягба дацангийн Эрдэнэ цорж Дашдэндэв хэмээгч байсныг Халхын Сэцэнхан Шолой (1577-1652) 1691 оноос өмнө 5-р далай лам Агваанлувсанжамц (1617-1682)-аас гуйж залж ирээд өөрийн хөвгүүн Ананд Далай Жононд тусгайлан өгч тахиулсан ажээ. Түүний дүр 6 удаа хувилж төржээ. Энэ хоёр тамгат хутагтаас гадна тус аймагт 44 хувилгааны 60 дүр тодорсон нь цөм халх нутагт мэндэлцгээсэн ажээ.
3. Засагт хан аймгийн хутагт хувилгаан бүгд 6-тай үүнээс тамгатай хутагт 3-ын 42 дүрээс 25 нь Энэтхэгт, Түвдэд, 17 нь Халхад тодорч Жалханз хутагт Дамдинбазар 1921,1922 онд хоёр удаа Монгол Улсын Засгийн Газрын тэргүүнээр өргөмжлөгдөж байжээ. Тус аймгийн Сартуул сэцэн засгийн хошуунаас 3 хувилгааны 5 дүр тодорчээ. Дашрамд хэлэхэд тус хошууг түмэн

адуу, мянган тайжтай халхын ганц хошуу гэж аман сурвалжид тэмдэглэсэн байдаг 1918 оны тоогоор энэ хошуунд 1301 тайж бүртгэсэн байдаг нь аймгийн бүх тайж нарын 31,8% халхын бүх талын нарын 9,1 хувь болж байжээ. (И.Майский Современная Монголия. Иркутск. 1921. Стр 3-9; 51-53)

4. Сайнноён хан аймаг нөгөө гурван аймгаасаа хамгийн олон буюу 28 хутагт хувилгаадтай. Тэдний 8 нь шавь захирах шаинзудбатай буюу тамгатай байжээ. Тэдний 131 дүр тодорсноос Энэтхэгт 49, Түвэдэд 36, Халхад 46 дүр тус тус тодорчээ.

Халхын тамгатай 13 хутагтын хоёр нь буюу Сайн ноён хан аймгийн Шаваа ширээтэй хутагт 1912 онд, Сэцэн хан ялгуусан хутагт 1913 онд Богд эзэн хаанаас шавь захирах тамга шагнуулжээ. Үүний учир бол тэр хоёрын аль аль нь Чингийн үед 500-700 гаруй шавьтай болсон байж. Өөрөөр хэлбэл шавь захирах болзол шалгуурт тэнцсэн байжээ. Гэвч Чингийн түшмэд хээл хахууль ахиухан авах үүднээс тийнхүү цааргалж байсныг нотлох сурвалж байдаг юм билээ.

Өнөөдрийн хурлын гол сэдэв болж буй үе үеийн Наро Банчэн хутагтын тухай Завхан, Говь-Алтайн зарим сумдад домог болон түгсэн аман мэдээ хууч яриа нилээд байдаг бөгөөд 14-р буюу 5-р дүр Пүрэвжав бол хамгийн догшин дүр нь юм гэнэлээ энд тэнд морилж ном сургаал айлдах, мэтгэж маргах дуртай, өөрт нь таагүй хандсан сүсэгтнүүдийг ном дүрэм зөрчсөн хэмээн залхаан шийтгэдэг байсан юм гэнэлээ хэмээсэн яриа байдаг. Мөн Наро Банчэн хутагтын шавьд харьяалагддаг эрх цорж Дилова болон оросын эрдэмтэн Майский нарын бүтээлд тэрхүү догшин дүрийн тухай тун сонин мэдээ үлдээсэн байдгийг олон хүн мэдэх билээ.

Үүнээс гадна архивын данс баримтыг сайтар шүүрдвэл түүний тухай зарим нэг мэдээ ч олдох бололтой байдаг. Миний үзсэн нэг сурвалжид бичсэнээс үзвэл Наро Банчэн хутагт бээр өөрийнхөө

Шанзудба-ын хамт 1899 онд Их Хүрээнд ирж санваартан хүний ёс зөрчсөн учир хэрхэн шийтгэх тухай саналаа хүрээ сайд Пингээс ГМТЗЯЯ-нд мэдэгдсэнийг тус яамнаас Бадруулт хаанд өргөн толилуулсны дагууд 1900 оны эхээр зарлиг буулгаж түүнийг зэмлэсэн ажээ. (ҮТА. М. 179-1-1129-д үз). Гэтэл энэ тухай 1917 оны 8-р сарын 25-нд Сайн ноён хан аймгаас Дотоод Яаманд өргөсөн

“Наро Банчэн хутагт Жүгдэрнамжилын ул эх”-д ер дурдаагүй байдаг. (ҮТА А 204-1-2 2-р бичиг).

Энэ дашрамд тэмдэглэхэд “Монгол Улсын шастир”-т эх сурвалж болгосон хутагт хувилгаадын уг эх ҮТА-т нилээд хэд байдаг юм билээ. Тэдгээрийг үзвэл зарим үйл явдлын тухай, хутагтууд хэзээ хаана морилж, хэд хичнээн сүм дуган бариулсан суварга ном бүтээлгэсэн зэргийг тодруулах боломжтойг хэлье.

Төгсгөл

Манай халх монголын 4 аймагт байнга сууж буян хурааж бурханы сургаал түгээж байсан хутагт, хувилгаадын тухай цаашид ултай судлах зайлшгүй хэрэгцээ байгаа юм. Манай түүхчид сүүлийн 22 жил Монголын эх түүхийн олон сэдэв асуудлыг судалж янз бүрийн бүтээл нилээдийг хэвлүүлсэн боловч Халх болон нийт монголд шавь захирч, хүрээ хийд тэргүүлж байсан хутагт хувилгаад олонд алдаршсан хувраг лам нарын талаарх судалгаа шинжилгээ дөнгөж гараагаа эхэлж буй учир энэ чиглэлээр мэргэшсэн судлаачид бэлтгэх нь зүйтэй мэт санагдаж байна. Үүнээс гадна XIII Далай ламын багш Дандар аграмба, говийн ноён хутагт Данзанравжаа, Их монголын баруун хязгаарын олон монголчуудыг баруун монголыг илбэн тохинуулах ноён хутагт Номун хан Дамбийжанцан, Дархадын Зөөлөнгийн Хүрээний бурханч лам Шарав зэрэг өргөн түмэнд алдаршсан лам нарын тухай урьдал болгон судлууштай.

Болгоож чагнасан та бүгдэд баярлалаа.

Хурлын илтгэгч М.Гантуяа
Доктор (Ph.D), профессор
Шашин судлалын тэнхмийн эрхлэгч, МУИС

ХУТАГТ ХУВИЛГААД ТОДРУУЛАХ МОНГОЛ ҮНДЭСНИЙ ГҮН УХААН

Монголд тодорсон Наро Банчэн хутагтуудын мэлмий гийсний тэгш сайхан ой давхцаж буйг тэмдэглэн энэхүү эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан байгууллага, хүмүүст талархлаа илэрхийлж хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсэж ерөөе.

Би хэдийгээр Наро Банчэн судлалаар ажилладаг хүн биш ч билиг ухааны ид чадлаа үзүүлж, Монголын түүх соёлд жинтэй хувь нэмэр оруулсан Наро Банчэн зэрэг Монголд тодорсон олон сайхан хутагт хувилгаадын амьдрал, үйл ажиллагаа нь Монголчуудын үндэсний ухамсрын үлгэр жишээ мөн гэж үздэг өөрийн бодол саналаа энэ хурлын төлөөлөгчид, зочидтой хуваалцах боломж олгосонд гүнээ баярлаж байна.

Үндэсний үзэл суртал, шашин шүтлэгээ сэргээх замаар өнгөрсөнтэйгээ холбогдож, үндэсний ахуй ёсоо хадгалж үлдээх нь ард түмэн бүрийн үндэсний ухамсрын салшгүй хэсэг билээ.

1990-ээд оноос өмнө “үндэсний ухамсрын” илрэлийг “үндсэрхэх үзэлтэй” хольж хутган, тухайн үеийн социалист гэгдэж байсан орнуудын хооронд нэгдмэл үзэл суртал буюу интернационалист үзэл давамгайлж байх учиртайг ухуулан сурталчилж байсан. Харин 90-ээд он гарснаас хойш тэрхүү интернационалист үзлийн оронд глобальчлал буюу даяаршлын үзэл санааг түлхүү сурталчлах болсон юм. Хэдийгээр дэлхийн олон орны ард түмэн хөгжлийн нэгэн нэгдмэл зорилготой нь улам бүр тодорхой болж байгаа ч, тэрхүү даяаршлын урсгалд ард түмэн бүхэн өөр өөрийн гэсэн өнгө аяс, уламжлал соёлоо тодорхойлж хөл нийлүүлж алхах нь зүйн хэрэг. Даяаршлын үзэл санаан дор үндэсний соёл, уламжлалыг үгүйсгэж

хэрхэвч болохгүй, үүнийг ямар ч ард түмэн хүлээн зөвшөөрөхгүй буй за.

Эрт дээр цагаас монголчуудын ахуй соёл, тусгаар тогтнол, эрх чөлөө, хөгжил дэвшлийг хангахад Монголын лидерүүд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн байдаг.

Монголчуудын хутагт тодруулах үйл ажиллагаа ч тэр, тодорсон хутагт хувилгаадын амьдрал тэмцэл нь ч тэр, бүхэлдээ Монгол түмний үндэсний ухамсрын илрэл мөн билээ. Монголд Манж Чин улсын ноёрхол тогтсон хүнд хэцүү цаг үед Монгол түмнийхээ оюун санаа, мэдлэг боловсрол, ахуй соёл, амь амьжиргаа гээд нийгэм-соёлын цогц асуудлыг өөр өөрсдийнхөө нутаг хошуунд шийдвэрлэн хэрэгжүүлж байсан тухайн үеийн үндэсний манлайлагчид нь хутагт хувилгаад байсан юм. Үндэсний өөрийн удирдлагатай байхыг эрмэлздэг монгол гүн ухаан хутагт хувилгаадыг тодруулах үйл ажиллагаагаар бодит амьдралд илэрч хэрэгжиж байсан.

Энэ үзэл санаа бүр эрт үеэс арай өөр агуулга, хэлбэрээр боловч уламжилж ирсэн түүхтэй. Тухайлбал, “Монголын Нууц Товчоон” дахь Алун-гуа эхийн сургаалаас үүдэлтэй эв нэгдлийн үзэл санаа бол үе үеийн монголчуудын эрхэмлэж ирсэн билиг сургаал мөн билээ. Монголчууд эвтэй байхдаа хүчтэй байдаг гэж сүүлийн үед их ярилцах боллоо. Гэхдээ монгол зон олон маань чухам хэрхэн яаж эвлэлдэн нэгдэх вэ гэдэгт л асуудлын гол нь оршдог. Монголын Нууц Товчоонд тэнгэр язгуурт алтан ургийн эзэн Богд, хаад язгууртнуудыг жирийн хүмүүсээс ялган онцгойлж, дээдлэн хүндэлж ирсэн эртний түүхтэй ард түмэн. Чухам тэдгээр онцгой дээд ид хүч, билиг ухаант хаадын удирдаж манлайлах арга ухаанаар л монголчууд нэгэн зүйлд сэтгэлээ нэгтгэж, багласан таван сум мэт бат бэх, хүч чадалтай болж байв.

Харин монголчууд бутарч, Манжийн эрхшээлд ороход монгол түмнээ удирдан манлайлж, нэгтгэн зоригжуулах үүргийг орчлонгийн тоо томшгүй олон төрөлхтний тусыг бодох бодь сэтгэлт бурхан бодьсадвын хувилгаан дүрүүд буюу Монголын билиг ухаант хутагт хувилгаад гүйцэтгэж болсон юм. Энэ үеэс монголчуудын дунд бусдын соёлыг өөрийн соёлтой зэрэгцүүлэн хөгжүүлэх, нэг үгээр хэлбэл, үндэсний ухамсар ба даяаршлын үзэл санааг хослон барих үзэл өргөн дэлгэрсэн байна.

XVII зуунаас Монголд Энэтхэг, Түвдөөс уламжлалтай Буддын соёл өргөн дэлгэрч эхэлснээр эртний уламжлалт билиг сургаалаа Буддын гүн ухаанаар баяжуулан, алтан ургийн хаад язгууртнуудаа эртний Энэтхэгийн Махасамади тэргүүтэй хүрдэн эргүүлэгч чакраварти их хаадын номын буянт үйлийн шүтэн барилдлагад нэгтгэн, түүх бичлэгээ цаг хугацааны өмнөх болон хойд үеийн залгамж холбоонд нь нэхэн үргэлжлүүлсэн Алтан дэвтэр, Асрагч нэртийн түүх, Шар тууж, Эрдэнийн товч гээд түүхийн сурвалжууд шил даран бүтээгдэж эхэлсэн байдаг. Эдгээр түүхийн сурвалжуудад Монгол түмнээ тэргүүлэн манлайлагч алтан ургийн хаад язгууртнууд нь зөвхөн Монгол түмнээ нэгтгээд зогсохгүй Энэтхэг, Төвд зэрэг бусад улс түмнүүдтэй номын барилдлагаар холбосон эх түүхийг нөхөн сийрүүлсэн байна. Энэ нь угтаа үндэсний ухамсар ба даяаршлын үзэл гэсэн хоёр үзлийг хослон барьж, улс орон, ард түмнээ хөгжүүлэх, олон орны ард түмнүүдтэй номын барилдлагаар эвлэлдэн нэгдэж, үндэсний ухамсар, оюун сэтгэлгээгээ улам баяжуулах үзэл санааг агуулж байлаа.

“Үндэсний ухамсар” гэсэн ойлголтыг олон орны философич, судлаачид бусад ард түмнийг дорд үзэгч “үндсэрхэг үзлээс” ялган тодорхойлдог. Буддын гүн ухааны үзлээр, хүмүүн төрөлхтөн нь зөвхөн улс үндэстэн дотроо эвлэлдэн нэгдэх төдийгүй, дэлхий нийтээрээ, тэр ч бүү хэл, энэ орчлонгийн, зүйрлэвэл, Ганга мөрний элсний тоо төдий тийм хязгааргүй тоот ертөнцийн, мөн л Ганга мөрний элсэн тоот төрөлхтөнтэй шүтэн барилдаж орших ба тэрхүү шүтэн барилдлагыг ухаарч гэгээрсэн бурхан бодьсадва нар ертөнц бүхэнд хувилан төрж, номын дууг дуурсган, олон түмнийг билиг ухаанаараа дагуулан тэргүүлж байдаг хэмээн сургадаг.

Монголчууд энэхүү гүн нарийн сургаалын үнэн мөн чанарыг ялган ухаарсны үндсэн дээр эртний сурвалжит эв нэгдлийн үзэл санаагаа орчлонгийн зургаан зүйл хамаг төрөлхтөнтэй шүтэн барилдах бурханы номтой хослуулж, Монголынхоо нийгэм-соёлын үйл хэргийг хамаг амьтны тусыг бодсон бурхан бодьсадва нарын хувилгаан төрөл, хутагт гэгээнтнүүдээрээ удирдуулан зохиож, ном буяныг нь шүтэн дээдэлж ирсэн билээ.

Ийнхүү Монгол түмнийг манлайлан тэргүүлэгчид нь тэнгэр язгуурт алтан ургийнхан гэж үзэж байсан бол энэ үеэс эхлэн Монгол түмнийхээ ахуй соёл, мэдлэг боловсрол, эрх чөлөө, тусгаар

тогтнолын төлөөх тэмцлийг билиг ухаан төгөлдөр хутагт хувилгаад тэргүүлж, манлайлж ирсэн байдаг.

Монголын хутагтууд зөвхөн ном буян, сүм хийд, хурал номын үйл ажиллагаагаар хязгаарлалгүй, улс орон нь Манжийн эрхшээлд орсон хүнд цаг үед ард түмнийхээ ахуй амьдрал, соёл боловсрол, улс орныхоо эдийн засгийн хүчин чадлын төлөө хүртэл цогц үйл ажиллагааг явуулж байжээ. XVIII зууны Оросын Монгол судлаач А.А.Позднеевын тэмдэглэлд өгүүлснээр: Манжийн хааны сангаас босгосон, монголчуудаас хутагт хувилгааддаа зориулан босгосон, хувь хүмүүсийн өргөлөөр босгосон, хошуу сумаас босгосон ийм дөрвөн төрлийн сүм хийдээс хамгийн баян бөгөөд том нь гэгээний буюу хутагтын хийд байсан тухай өгүүлжээ. Хутагтад зориулсан сүм хийдийг дагалдуулж хурал номын зардлыг нь тасалдуулалгүй хангаж байх үүрэгтэй шавь ардыг, мал ахуйтай нь өргөн барьдаг байсан уламжлалтай ба малгүй ядуу хүмүүс сүмийн мал маллалцаж, аажмаар чинээшигжиж хийддээ алба өргөх болдог байжээ. Мөн хутагтын хийдүүд нь аян жин, хятад худалдаачдаас авах татвар, зээлийн хүү зэргээр хөрөнгөжиж байв.

Хамгийн гол нь энэ бүх үйл ажиллагаа эргээд монгол түмэндээ зориулагдаж, тэднийг Манжийн хүнд хүчир алба гувчуураас эрх чөлөөтэй болгоход тус нэмэр болдог байжээ. Мөн хутагтын том хүрээ хийдүүдэд шавьлан суух лам нарын тоо жилээс жилд өсч байсан нь монгол эрсийг Манжийн цэрэг, өртөөний албаас татгалзуулах нэгэн төрлийн далд арга бодлого байсан гэж хэлж болно. Хутгатын сүм хийдүүд бол сургууль номын тулгуур уурхай, суурин соёлын төв болж өргөжин тэлж байлаа. Энэ мэтчилэн Монгол хутагт хувилгаадын ер бусын билиг ухааны хүчээр Манжийн татвараас ангид Монголын мал сүрэг өсч, малчин ардын ахуй амьдрал дээшилж, суурин соёл, бичиг эрдэмд гүнзгийрч, эрдэм ухааны уурхай болсон дацан сургуулиуд хөгжиж байлаа.

Үүгээр Өндөр гэгээн тэргүүтэй хутагт хувилгаад эх орон, ард түмэн, тусгаар тогтнолын төлөөх тэмцлээ илэрхийлж байсан ба нөгөө талаар, “үндсэрхэг үзэлд” хэт автагдалгүй, хамаг амьтны тусыг бодсон бодь сэтгэлт бурхад бодьсадвын хувилгаан дүрийнхээ чин зорилгод үнэнч байж, улс түмнүүдийн харилцааг эвлэрүүлэн зөөлрүүлэх, уян хатан, холч, ухаалаг бодлогыг хэрэгжүүлж байсан юм.

Монгол хутагт хувилгаад өөрсдийн амьдарч байсан хошуу нутгийнхаа ард түмний амьдрал ахуй, соёл боловсролд анхаарлаа хандуулж, нутаг орондоо буян номын үйл хэргийг дэлгэрүүлэх үйлст бүхий л хүчин чармайлт, ухаан билгээ зориулж байлаа. Тэдгээр олон Монголын хутагт хувилгаад дотроос Наро Банчэн гэгээнтний үйл ажиллагаа нь зөвхөн хошуу нутагтаа төдийгүй Монголын газар газарт ялгалгүй ном буянаа түгээн дэлгэрүүлж байснаараа ялгардаг мэт.

Мөн V Наро Банчэн, V Дилова хутагт нар хамт нэгэн сүмд номын дуу сонсон өсч, хамт ширээнд залагдаж, тарни бясалгалд хамт сууж байсан нь эрт Энэтхэгийн 84 шидтэний дотроос гүрү Дилова, гүрү Нарова нарын намтарт тэд үргэлж хамт байж нэг нэгэндээ түшиг нөхөр болж байсан эртний намтар түүх Монгол газраа дахин давтагдаж буй мэт сэтгэгдэл төрүүлдэг. Энэ нь монголчууд хутагт хувилгаадаа хичнээн зөв олж тодруулж байсныг харуулах мэт.

Үнэндээ ч, монголчуудын тодруулсан хутагтууд Монголын ард түмэн, түүх соёл, нийгмийн ахуй амьдралдаа хичнээн их үүрэг гүйцэтгэж, хичнээн ихийг бүтээж байсныг харахад тэд яах ч аргагүй онцгой дээд төрөлт, Монгол түмнээ манлайлан тэргүүлж, оройлон дуудагч ихэс дээдэс байсан гэдэг нь тодорхой.

Монгол хувилгаадын буян ном арвижих болтугай.

Тэдний хувилгаан төрөл Монгол газараа тасралтгүй төрөх болтугай.

Монгол эх орон минь цэцэглэн хөгжих болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хурлын илтгэгч С.Янжинсүрэн
Доктор (Ph.D), профессор
Шашин судлалын тэнхим, НШУС.МУИС

МОНГОЛЫН ТӨВД СУДЛАЛД ХУТАГТ ХУВИЛГААДЫН СУДАЛГААНЫ ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

Монголд түвд судлал хөгжөөд олон зуун жил болж байна. Энэ бүх хугацааг төвд судлалын уламжлалт судалгааны үе, шинэ буюу орчин үеийн судалгааны үе гэж ангилж болох юм. Бас тэрчлэн эл орчин үеийг төвд судлалын шинжлэх ухааны судалгааны үе гэж нэрлэж болно.

Түвд судлалын уламжлалт судалгааны үе нь монголчууд буддизмд суралцсан, түүний зохиол бүтээлүүдийг судалсан үе бөгөөд энэ үед монголчууд буддизмыг хутагт эрдэмтдийнх нь зохиол бүтээлүүдийг орчуулах, тайлбарлах хэлбэрээр судалж байв. Тэрчлэн монголчуудын дундаас хутагтууд төрөн гарч улмаар монгол хутагтуудын ном зохиол бичигдсэн байна. Цаг хугацааны хувьд энэ үеийг дундад зууны үеэс XX зууны үе гэж томъёолж байна.

Монгол дахь түвд судлалын орчин үеийн буюу шинжлэх ухааны судалгаа хөгжсөн нь Судар бичгийн хүрээлэн, одоогийн ШУА байгуулагдаж улмаар их дээд сургуулиуд бий болж үндэсний дээд боловсролтой сэхээтнүүд дотоод гадаадад бэлтгэгдэн Гандантэгчэнлийн хийдийн эрдэмт лам нарын тусламжтайгаар түвд хэлт утга зохиолыг сэргээн судалсан тэр үеийг тодорхойлж байна. Нэг үгээр бол XX зууны эхнээс одоог хүртэлх цаг хугацааг оруулж байгаа болон. Энэ үед ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн харьяанд байгуулагдаж, 1973 оноос ФСЭХ-д харьяалагдах болсон Буддын судлалын сектор, МУИС, Гандантэгчэнлин хийдийн дэргэд байгуулагдсан Номын гэр зэрэг сургалт судалгааны байгууллагууд онцгой үүрэг гүйцэтгэсэн болно.

Манай уламжлалт хийгээд орчин үеийн түвд судлалын

судалгааны арга зүйд эх сурвалж судлалын арга зонхилж ирсэн бөгөөд эл арга бол ачааны хүндийг үүрдэг, хэлний болон тухайн салбар ухааныхаа өндөр мэдлэг шаардсан амаргүй зорилт байдаг юм. Энэ арга манай түвд судлалын уламжлалт үед түгээмэл хэрэглэгдэх, улмаар уламжлагдах үндэс нь түвд хэлт буддын сургалтын тогтолцоо ХҮШ зууны үеэс монголд суурьтай хөгжсөнтэй нягт холбогдох юм.

Орчин үед буддын судлалд гол зонхидоо түүхэн болон герменевтик арга зүйг барьж байна. Энэ нь илүү оновчтой арга зүй гэж бид үздэг. Гэхдээ энд тусгай арга зүйнүүд хийгээд археологийн шинжлэх ухааны болон бусад олон салбарын арга зүйг түр хойш тавьж байгаадаа хүлцэл өчиж байна.

Монголчууд буддизмыг тал бүрээр судлахдаа буддын хутагт, хувилгаадын намтар түүх, үйл ажиллагаа, зохиол бүтээлээр дамжуулан судлах нь нэгэн зүйлийн судалгааны төрлийг нэмсэн юм. Ялангуяа үндэсний ухамсар сэргэх болсон 1990-ээд оноос хойш монголчуудын дундаас төрөн гарсан хутагт хувилгаадын түүхэн ой болон шинээр тодорсон хутагт хувилгаадыг ширээнд нь залахтай холбогдуулан эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах, хурлын илтгэлүүдийн эмхтгэлийг хэвлэн нийтэлж нийтийн хүртээл болгодог болсон нь монголын түвд судлал нэгэн алхам урагшлах, шинэ шинэ зорилго зорилт дэвшүүлэх, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд судалгааны ажлууд хийх алхам болж байна. Тухайлбал, 2009 онд ҮШ Богд Жэвзүндамба хутагт болон Хамба номун хан Агваанхайдав, 2010 онд II Богд Жэвзүндамба хутагт Лувсанданбидонмэ, 2011 онд Барагри ёнзин Дамцагдорж, 2012 онд Зуугийн лам Гончигжалцан, 2013 онд Эрдэнэ мэргэн Бандидаа Агваан-Ишсамбуу болон Сайн ноён ханы Данзанчойнзод лам нарын түүхэн ойг тэмдэглэх ажлын хүрээнд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж тус тус эрдэм шинжилгээний илтгэлийн эмхтгэлүүд гарсан ба Жадарын Хамба Агваанхайдавын 5 боть сүнбүмийг хэвлэн нийтэлсэн нь монголын буддын сэтгэгчийн бүтээлийг судлаач олны гар дээр бүрнээр нь тавьсан үйл явдал болсон юм.

Энэ 2014 онд Ламын гэгээний дүрийг ширээнд залах үйл явдал, Монголд Наро ванчин монголд заларсан анхны дүр Хутагт Бадамдоржийн 315, Ү дүр Догшин хутагт Пүрэвжавийн 130, Ү!

дүр Хутагт Жүрдэрнамжилын 110 жилийн ой, Гандантэгчэнлин хийд үйл ажиллагаагаа дахин сэргэсний 70 жилийн ой тус тус тохиож байгаатай холбогдуулан олон улсын болон бусад эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж илтгэлийн эмхтгэл гаргахаар төлөвлөсөн байна. Эл бүхий үйл ажиллагаа нь монголын төвд судлалыг өргөтгөж байгаа бөгөөд түүнд судалгааны шинэ хандлага, арга зүй, аспектаар авч үзэх нь нэн чухал болно.

Хутагт судлал, хувилгаан судлалын шинэ дэд салбаруудыг бий болгон тусгайлан судлах нь зохистой бөгөөд ингэхдээ монгол хутагт, хувилгаадыг бусад улс, үндэстний хутагт хувилгаадтай харьцуулан судлах, ялангуяа монгол хүний сэтгэлгээний онцлогийг нийгэм түүхийн нөхцөлд нь авч үзвэл монголын буддизмын онцлогийг нээн гаргах бас нэгэн алхам болно гэж үзэж байна.

Магадгүй үүний сацуу цаашид хутагт, хувилгаадын институцын асуудал ч яригдаж болох талтай.

Орчин үед буддизмыг шинжлэх ухаантай харьцуулах, үүний тулд тусгай орчинд буюу лабораторийн орчинд судалгаа хийх явдал бий болоод байна. Үүнд тухайлбал, 1987 онд Х!Y Далай лам Данзанжамцтай мэдрэл судлалын салбарын шинжлэх ухааны эрдэмтэд ярилцлага хийж улмаар Далай лам, 6 эрдэмтэн, 2 орчуулагч, цөөн тооны ажиглагчдын хүрээнд зохион байгуулагдсан анхны ярилцлага өргөжсөөр 1987-2002 оны хооронд ийм ярилцлага 10-ыг зохион байгуулжээ. Ярилцлагын үндсэн сэдэв нь шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдлыг хүний сайн сайхны төлөө зориулахад чиглэгддэг. Тухайлбал, Донтолт сэдвээр зохион байгуулсан ярилцлага хүний өмнө тулгамдсан нэгэн томоохон асуудлыг шийдэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа болсон гэж олон улс дүгнэсэн байна. Эл бүхий хугацаанд ярилцлага зохион байгуулаад зогссонгүй “Оюун санаа ба амьдрал” /Mind and Life/ судалгааны хүрээлэн байгуулж үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

2003 онд Массачусэтсийн Технологийн дээд сургууль дээр \Massachusetts Institute of Technology\ шинжлэх ухааны судлаачид, бясалгалчдыг эмнэл зүйн салбарт нэгтгэх боломжийн тухай ярилцлага зохион байгуулсан нь энэ ярилцлагыг шинэ төвшинд гаргасан гэж үздэг.

Мэдрэл, түүний эмчилгээний салбар болон хүний ууараг

тархины бүтэц, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа явуулж тодорхой амжилт гаргасан, судлагааныхаа төвшинг ахиулсан судлаачдыг урамшуулдаг ба төвлөрөл, бясалгал нь хүний мэдрэлд чухал үүрэгтэй хийгээд ухамсрын тухай шинжлэх ухааны онолыг гүнзгийгүүлэхэд онц ач холбогдолтой гэж үздэг. Мөн төвлөрөл бодролын үр дүнг лабораторийн орчинд үндэслэн судалгаа хийсэн хийгээд гарсан үр дүнг нь бодит амьдрал дээр хэрэгжүүлж байгаа судалгааны ажилд санхүүжүүлт \Varela awards, 1440 awards, 15000-25000 хүртлэх ам.доллар\ олгодог байна.

2012 онд ярилцлагыг олон нийтэд хүртээмжтэй болгох зорилгоор “Бясалгал судлалын дэлхийн анхдугаар их хурал”-ыг АНУ-ын Денвер хотноо зохион байгуулсанд 740 төлөөлөгч оролцож мэдрэл судлал, мэдрэл судлалын шинжлэх ухаанууд, боловсрол судлал, эмнэл зүйн салбар ухаанууд болон хүмүүнлэгийн ухаанаар 30 салбар хуралдаан зохион байгуулж 120 гаруй илтгэлийг хэлэлцэж Их хурлыг 2 жилд нэг удаа зохион байгуулж байхаар тогтжээ. 2013 онд Энэтхэгийн Мундгодод XXY! ярилцлагыг Депүн Лосэлин хийдэд зохион байгууж эрдэмтэн судлаачдын илтгэлийг сонсохоор 1000 гаруй лам хуралд оролцсон юм.

Хурал “Квант физик мэдрэл судлалын шинжлэх ухаан уруу” сэдвийн дор явагдсан ба судлаачид буддийн бясалгал хүний тархи, мэдрэлд хэрхэн нөлөөлж байгаа тухай ярилцсан нь сонирхолтой юм. Ялангуяа Висконсин Мадисоны их сургуулийн /Wisconsin-Madison University\ мэдрэлийн лабораторийн захирал Р.Давидсон \Richars Davidson\ лам нарын тархинд хийсэн туршилтын үр дүнгээ танилцуулж ялангуяа франц лам Матью Ричардтай \Matthieu Ricard\ хамтран 256 зүйлийн мэдрэлийн судлыг бясалгалын үйлдэл дээр судалж түүний тархин дээр хийсэн туршилтаар гамма долгионы төвшингийн неврологийн түүхэнд урьд үзэгдээгүй судалгааг танилцуулсан байдаг .

Энэ бүхнийг хэлэхийн учир нь: Хутагтан болон хувилгаан хүнийг төрөлхийн билгэ билгүүнтэй гэж буддизмд үздэг ч ялангуяа хутагтан хүний билиг оюуны асуудлыг ид шидийн гэхээсээ танин мэдэхүйн үйл явцтай нягт холбодог гэж би ойлгодог.

Бид буддын логикт хутагтныг илт онох мэдэл \mngon sum\, түүн дотроо егүзэрийн буюу налжор онсүмтэй \byor mngon sum\ холбож

шарвагын \nyon thos'phags pa\, барадигабуддын \rans rg-yal 'phags pa\, бодсадвын \byan chub sem pa 'phags pa\ болон бурхан хутагтан \ sans rgyas 'phags pa\ гэж ялгамжаатай авч үздэг. Хэзээ энэ хутагтны тал шинж илрэх вэ гэвэл чуулганы мөр \tsog lam\, барилдлага мөрийг \byor lam\ туулсан, үзэх мөрд \tshong lam\ хүрсэн бодгаль нь "Хутагтан буюу пагва" байдаг гэдэг. Эндээс үзвэл хутагт гэдэг нь төрөлхийн өгөгдсөн гэхээсээ оюуны танин мэдэхүйн үе шаттай үйл явцын илрэл, тодорхой үр дүн мөн гэж ойлгогдохоор байдаг.

Тэгвэл хутагтан хүний мэдрэлийн тогтолцоог дээрх адил лабораторийн орчинд судалж болох мэт санагдана. Ялангуяа урд, хойтохооо санадаг өвөрмөц бүхий мэдрэлийн тогтолцоог ерийн хүний мэдрэлийн тогтолцооноос ялгагдах ялгаа, тэр ялгаа шинжийг энгийн хүний ууараг тархинд бий болгож болох эсэхийг судлах нь манай неврологич эрдэмтдийн асуудал мөн гэж үзэж байна.

Ялангуяа нийгмийн ахуйгаас үүдсэн сэтгэлийн дарамт нь хүний оюун санааг зарим тохиолдолд сэргэхэд хүнд нөхцөлд оруулж байгааг шинжлэх ухаан мэдээлсээр удаж байгаа. Үүнд хутагт, хувилгаадын нөхөн санах чадварыг судлах, түүнд суурилсан хийсвэрлэлийн загвар, загварчлалыг бий болгох, үр дүнгээ туршиж үзэх нь шинжлэх ухааны ирээдүйн нэгэн том зорилт болох нь дамжиггүй.

Бас нэмж хэлэхэд, хутагт хувилгаад тантрын ном ёсонд мэргэн байдгийг бид мэдэх билээ. Буддын бясалгалчид өнөөдрийн хурлын гол сэдэв Наро Банчэнгийн бясалгалын 6 зүйлийг \Na ro chos drug -; 1. Дотоод илчийн \g Tum mo-candali-the yoga of inner heat\ 2. Илбийн биеийн \g Tum mo-candali-the yoga of inner heat\ 3. Тунгалаг гэрлийн \'od gsal-prabhasvara-the yoga of the clear light or radiant light\ 4.Зүүдний увдисын \rMi lam-svapnadarsana-the yoga of the dream state\ 5. Зуурдын орны \ bar do-antarabhava-the yoga of the intermediate state \ 6. Юүлэхүйн \pho ba –samkranti-the yoga of the transference of consciousness to a pure Buddhafied\ бясалгал, төвлөрлийн зүйлүүдийг голчилж судалсаар ирсэн. Эндээс үзвэл хутагт, хувилгаад нь энгийн ууараг тархи бүхий хүнээс илүү төвлөрлийн ухаанд суралцах чадавхитай, төвлөрч чаддаг болж байна. Энэ төвлөрлийг орчин үед стресс, депрессээс ангид орших нэгэн арга зүй болгож мэдрэл судлал, сэтгэц судлалд авч үзэх болжээ. Орчин үед бясалгал, бясалгалын арга хэлбэрүүдийг тал талаас нь авч судалдаг олон зүйл ухаан бий болж байгаа бөгөөд

түүнийг contemplative study, contemplative science, contemplative philosopy and humaity гэж өрнөдөд нэрлэж байгаа бөгөөд үүнийг бясалгалын ухаан, төвлөрлийн ухаан, нарийвчлан тунгаахуйн ухаан, бясалгалын философи гэж томъёолж болох мэт санагдана.

Энэчлэн хутагт, хувилгаадын өвөрмөц чанар нь тэдний ууараг тархи, тэдний онцлог бүхий сэтгэх, танин мэдэх чадавхид орших бөгөөд түүнийг шинжлэх ухааны арга зүйгээр, тусгай орчинд судалж түүнээс гарах боломжит эерэг үр дүнг практикт ашиглах боломж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Ном зүй

1. Дигнага. Шалгадаг хотлооос түүсэн, Монгол Данжуур, 183 дугаар боть.
2. Дхармакирти. Шалгадгийн тийн тайлбар, Монгол Данжуур, 183 дугаар боть
3. Зава Дамдин гавж. Ухааны эцсийн шинжлэл, сайн номлолын оньст толь \blo rig gi mtha'a dphyod ngo mt shar legs bshad 'phrul me long\ Бүрэн сүнбүм, Са боть, 427-745
4. Ч.Жүгдэр. ХY-ХYШ зууны монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. УБ., 1984
5. Еncyclopedia of Asian Philosophy, ed.Oliver Leaman Routledge, 2001
6. Г.Чулуунбаатар, Д.Дашжамц. Философи, Социологи эрхийн түүхийн хураангуй. УБ, 2002.
7. Davidson Ronald. M.Indian Esoteric Buddhism. Colambia University. 2003.
8. Mindandlifeinstitute.org
9. En.m.wikipedia.org
10. Dharmafellowship.org

Хурлын илтгэгч Г. Мягмарсамбуу
Доктор (Ph.D), профессор
БХЭШ Хүрээлэнгийн дэд захирал
Эрдэмтэн нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ БА ЧОЙЖИНЧ ЛАМ НАР

Монгол улсынхаа тусгаар тогтнолын төлөө тэмцэж явсан чойжинч лам нарын талаар өгүүлэхийн өмнө чойжин гэж чухам юу болох талаар товчхон авч үзье.

Их тарнич Ловон Бадамжунай анх ҮШ зууны эцсээр чойжин сахиусыг бүтээн, тэдгээрийг урин залж, чойжин буух дэг ёс, зан үйлийг боловсруулан Самъяа хийдэд чойжин буулгасан түүхтэй.

Чойжин гэдэг нь “номыг тэтгэгч сахиус” гэсэн утгатай түвэд үг агаад түүний гол үүрэг нь бурханы шашиныг сахин хамгаалж, түүнд саад тотгор үйлдэгч ад зэтгэрүүдийг тонилгон үгүй хийдэг. Мөн шид бүтээл болоод их бясалгал хийж байгаа бүтээлч дияанч нарт нөхөр хань болж, тэднийг шид бүтээл хийхэд садаа болж байдаг ад зэтгэрүүдийг үлдэн хөөж, сахин хамгаалах ам тангараг авсан хамгаалагч догшин сахиусууд юм. “Номыг тэтгэгч таван их хаанд тахил билиг өргөхийн зан үйл хэмээгдэх догшидын судар оршвой” нэрт сударт тэдгээр таван их догшидод тахил билиг өргөн даатгахдаа “Бурхан багш шавь өглөгийн эзэд нөхөд сэлт бүгдэд харшлагч хийгээд бурханы шашинд дайсан бологсдын амийг бүлитгэн (бүрилгэн -зох) хэнхдэгээс зүрхийг гарга. Харавтар улаан цусан хур оруул. Эсэргүүцэшгүй дайсанд золголдуул. Эдгэш үгүй өвчин хүртүүл. Амыг зууруул, булчингуудыг огтол” гэх зэргээр өгүүлжээ [3]. Ингэж чойжин сахиус нь шашин амьтанд тэрслэгчидийг хайр найргүй даран устгах учиртай.

Үүнээс гадна чойжин нь хүн ардад учирч болзошгүй гай, өвчин зовлон, ад зэтгэрийн хорлол, байгалийн аюул зэрэг муу муухай юм бүхнийг зайлуулж, авран хамгаалах бөгөөд энэ тухайд ном уншин залбирч даатгадаг байжээ. Тухайлбал, “Чойжингуудын сан”-д лам,

ядам, тэнгэр, бурхан, Жамсран тэргүүтэй чойжингууд, газар усны эзэд зэргийг урин залж, идээ тахил өргөсний дараа “эмгэг зовлон ад зэтгэрийг арилга. Нас буян цогийг дэлгэрүүл. Хүмүүн эдлэх жаргал бүгдийг эрхшээлдээ хураа. Хамаг хорлогч дайсан тотгор нугуудыг хоцрол үгүй даруй тоосон товрог болго. Богд ламын өлмий маш батад. Тарнийн шашин номыг үлэмж дэлгэрүүл. Авралт бүхийн ачаар бүрэн өлзий хутаг орш” гэх зэргээр өгүүлжээ [4]. Мөн сударт ад тотгор ба ширүүн салхи, шороон шуурга, догшин мөндөрийг буцаахыг даатган залбиржээ. Үүнээс үзэхэд чойжин сахиус нь байгаль, нийгмийн аль ч үзэгдэл, үйл явдалд нөлөөлөх, өөрчлөн хувиргах чадалтай байна. Ингэж бурханы шашинтнууд олон зууны туршид өөрсдийгөө болон өргөн олныг үгүйрэл, хоосролоос ангижруулж, жилийн гай барцадыг арилган, сайн сайхныг дэлгэрүүлэн, үйлс бүхнээ бүтээж, идээ будаа, эд баялагаа арвижуулж, элбэг хангалуун аж төрүүлэх, шашинд тэрсэлсэн дайсагнагч бүхнийг даруулахаар сахисан их тэнгэр догшин чойжин сахиусуудад тогтмол даатган тахисаар иржээ.

Харин чойжин лам гэдэг нь догшин чойжин сахиусыг шүтэж, чойжин буух замаар сахиусаа урин залж, түүнтэйгээ шууд харьцан, зарлиг тааллыг нь сонсон амьтан бүхэнд тусалж, ад зэтгэр, аюул зовлон зэргийг дарж устгах ер бусын их ид шидтэй лам юм. Чойжин лам янз бүрийн хэлбэрээр тодордог байна. Тухайлбал, тэрээр багаасаа их өвдөж зовох, ухаан санаа нь балартах, татаж унах зэрэг элдэв шинж тэмдэг илэрдэг. Ингэж чойжин болох шинж тэмдэг илэрсэн хүнийг тусгай багшид шавь оруулан удирдуулж чойжин болгодог. Мөн чойжин ламыг таалал төгсөхөд дараагийн чойжинг тодруулах арга ухаан ч байдаг ажээ. Үүнд, тухайн ламын сууж байсан хийдийн лам нарын дунд түүний солхог буюу урин заллагыг уншдаг. Ингэхэд тэдгээр лам нарын дундаас хэн нэг ламын биед нь өөрчлөлт орж, унаж татах зэрэг шинж тэмдэг илрэхэд түүнийг залж чойжингийн ном эрдмийг тусгайлан зааж сургадаг ажээ (13). Үүний зэрэгцээгээр бас удам дамжин чойжин лам болох явдал ч байдаг ажээ.

Чойжингийн хувцас нь жирийн ламын хувцастай адилгүй бөгөөд дуулга, өргөн ханцуйт дээл, цээжмэг, хормогч, луут гутал, алт буюу мөнгөн толь зэргээс бүрдэг бөгөөд чойжин буух зан үйл нь ч нэн өвөрмөц, нарийн дэг ёстой байдаг. Гэвч цаг бага учраас тэр бүхнийг энд тодорхой ярих боломжгүй юм.

Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн үеэс тал нутгийн нүүдэлч малчид догшин чойжин сахиусуудыг эх нутагтаа урин залж, шүтэн бишрэх болсон төдийгүй монголчуудын дундаас ид шидтэй чойжин лам нар төрөн гарах болсон байна. Тэдгээр чойжин лам нар зөвхөн шашин номын үйлийг эрхлээд зогсохгүй бас төр улсынхаа төлөө бие сэтгэл оюунаа зориулж, монгол түмнийхээ эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө шашин номынхоо ид шидээр ч, эр биеийнхээ хүч чадлаар ч тэмцэж явсан юм. Ялангуяа, монголд оронд Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл эрчимтэй өрнөсөн XX зууны эхэн үед лам хувраг, хутагт хувилгаадын улс төрийн идэвхи сэргэж, энэ хөдөлгөөнд идэвхтэй оролцон, харийн түрэмгийлэгчдийн эсрэг зэвсэгт тэмцэлд оролцон, хил хязгаарт олон цэрэг эрийг дагалдан явж байлаа. Тэд дайн тулааны талбарт увдист номоо уншин, догшин сахиусаа залж, хатуу үйлийг бясалгаж харийн дайсны халдах сэтгэлийг хариулан буцаах замаар төр улсынхаа тусгаар тогтнолыг сэргээхэд үнэтэй хувь нэмрийг оруулсан юм. Тухайлбал, Ардын Хатан баатар Магсаржав, Лосол, Дэрэн, Жамъян зэрэг чойжинг нэрлэж болох агаад эдний дундаас шинэ үеийн Монгол Улсын төр, цэргийн томоохон зүтгэлтнүүд ч төрөн гарсан юм. Энд юуны урьд Богд хааны дүү Лувсанхайдав, Ардын Хатан баатар Магсаржав, Лосол нарыг онцлон дурдах нь зүйтэй.

Гончигцэрэнгийн Лувсанхайдав (1872-1918). XX зууны эхээр амьдарч байсан монгол төрийн томоохон чойжингуудын нэг, ҮШ Богд Живзундамбын төрсөн дүү. Тэрээр 1872 онд Төвдийн Шала хэмээх газар Гончигцэрэнгийн тавдугаар хүү болон төрсөн бөгөөд ах нь Монголын шарын шашины тэргүүн ҮШ Богдоор тодорсон учир 1874 онд тэд эцэг, эх, ах дүүгийнхээ хамт Их Хүрээнд иржээ.

Их Хүрээний Хамба номун хан Балданчоймбол монголын шашиныг хамгаалуулах зорилгоор ҮШ богд Жэвзүндамбатай зөвшилцөн түүний дүү Лувсанхайдавыг догшин сахиусны чадал онгод оршсон чойжин болгохоор шийджээ. Ингээд 1884 онд Түвэдээс чойжин Сээтэвийг урин авчирч Лувсанхайдавыг чойжин болгох сургуулийг удирдуулж, Их Хүрээний Ванга аймгийн монгол лам Лувсанпэлжээгээр чойжин буух уншлага номыг уншуулдаг байжээ.

Лувсанхайдав Түвдийн чойжин Сээтэвийн удирдлагаар хэдэн жил чойжин болох сургууль хийж Найчун чойжин, Зумэр, Доржсүг

сахиусыг дуудан чойжин буудаг болсноор түүнийг Монголын шашины гол чойжин болгожээ.

ҮШ Богд Жэвзүндамбын зарлигаар Лувсанхайдавыг жил бүрийн цагаан сарын шинийн 8-нд зүүн Хүрээний цогчин дуганд гурван сахиусны үүднээс чойжин бууж байх журам тогтоожээ. Лувсанхайдав анх удаа Цогчин дуганд чойжин буухад Богд Жэвзүндамба залран ирж, “Миний шашиныг хамгаалж дэлгэрүүлэн, бурхан багш, лам гурван эрдэнийг муугаар бодож байгаа буруу номтныг даран сөнөө” хэмээн айлджээ. Мөн Их Хүрээнд жил бүрийн өвлийн адаг сарын 28-нд шашин, төрийг бэхжүүлэх, гадны ад зэтгэр, дайсныг дарах, шашиныг ариунаар мандуулах зорилгоор чойжин буулгадаг байжээ.

Лувсанхайдав “Нийслэл Хүрээний голын чойжин сахиусны гүдэмбэ, гүжир хамбо, Эрдэнэ билэгт тунгалаг билэгт хутагт” гэсэн янба тушаалтай, Эрдэнэ билэгт тунгалаг бишрэлт хутагтын тамга, Найчун сахиусны шашины тамга, Нийслэл Хүрээний голын Чойжин сахиусны сүмийн хувраг тушаалтныг захирах тамга гэсэн үсэгтэй 4 тамга барьдаг байжээ.

1912 оны зуны сүүл сард Богд хааны зарлигаар Нийслэл Хүрээний голын чойжин сахиусны гүтэмбэ Лувсанхайдавт өргөмжлөлийн тамга шагнан олгож, хойчийн өдөр хувилгааныг үүрд залгамжлуулахаар болсон ба мөн 1916 онд Лувсанхайдавыг Төрийн чойжингоор өргөмжилж, “Халхын шашиныг хамгаалагч” хэмээх өндөр нэр хүндийг олгосон тул дээдэс, доодост их шүтэгдсэн нэр нөлөө ихтэй, шашины нэрийн өмнөөс төрийн хэрэгт оролцдог хүн байжээ.

Чойжин лам Лувсанхайдавын хурал номын ажилд зориулж хоёр удаа сүм барьжээ. Эхнийх нь 1898-1901 онд Зүүн хүрээнд шашиныг хамгаалагч Лувсанхайдавын Чойжин сахиусны хурлын их, бага хоёр сүм, лаврин орд, хашаа байшин, жас зэрэг цогцолбор барилгыг барьж дуусгасан байна. Гэвч тэр нь галд өртсөн тул хоёр дахь сүмийг 1904 оноос эхлэн барьж 1908 онд дуусгажээ. Энэхүү “Өршөөлийг хөгжүүлэгч сүм” нь Махранзын сүм, Гол сүм, Ядамын сүм, Зуугийн сүм, Хотол чуулганы тус амгалангийн тив сүм зэргээс бүрддэг бөгөөд Монголын уран барилгын хосгүй дурсгал, шашин соёлын үлэмжийн үнэт өв сан болон өдгөө нийслэл хотод маань сүндэрлэж байгааг та бүхэн сайн мэдэх билээ.

Гүжир хамба гүтэмбэ Эрдэнэбилэгт тунгалаг бишрэлт хутагт

1918. 3.28-ны өглөө гэнэт ухаан алдан унаж өвчин тохиоход эм гүрмээр шавдан засуулсан боловч илаар болж чадалгүй мөн өдрийн луу цагт жанч халжээ.

Дарьзавын Лосол (1890-1939). Сэцэн хан аймгийн Дайчин бэйс Дашцэрэнгийн хошуу (одоогийн Хэнтий аймгийн Батноров сум)-нд төржээ. Тэрээр 9 наснаасаа хүрээ хийдэд шавилан сууж, нууц тарнийн арга ухаанд суралцан чойжин лам болсон байна. Чойжин лам Лосол 1913 онд Өвөр Монголыг чөлөөлөх дайнд цэргийн ламаар явж чинадын дайсныг дарах хэрэгт шашин номын хүчээр тусалсан тул цоржын (номын богд) ямба, 1919 онд хүрэн жолоогоор шагнагджээ. Тэрээр 1919 оноос төр улсынхаа тусгаар тогтнолыг сэргээх нууц тэмцэлд оролцож, МАН-ыг үүсгэн байгуулж, 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалыг ялуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Түүний гавьяаг Ардын засгийн газар өндөр үнэлж 1922 онд Чин сүжигт номч мэргэн цолоор шагнажээ. Чойжин Лосол цэргийн ламаар удаа дараа явж олон цэргүүдийг ухуулан ятгах, санаа сэтгэлийг нь засаж залруулах, харийн дайсны халдах сэтгэлийг номхотгон доройтуулах арга ухаан төгс байсан тул 1921 оны 7 дугаар сард Бүх цэргийн ламаар томилогдож, 1923 оноос Цэргийн эмнэлгийн газрын эрхэлсэн түшмэлийн алба хашиж байгаад 1925 онд хар болж, улмаар 1925-1939 онд төр, нам, олон нийтийн удирдах албан тушаал хашиж байв. Тэрээр 1939 онд “хувьсгалын эсэргүү” гэгч хилс хэрэгт шийтгүүлэн хэлмэгдсэн бөгөөд 1962 онд цагаатгагдсан байна.

Ардын Хатан баатар С.Магсаржав (1878-1927). Монгол цэргийн ялан дийлэх арга ухааныг шарын шашины нууц тарнийн шид бүтээлтэй хослуулан эзэмдэж, юунд ч үл дийлдэх баатар хүчийг олж, төр улсад тэрсэлсэн харийн дайсны омог хүчийг шантлан ёстой л “тойвтныг бөхийлгөж, толгойтныг сөгдүүлэн” явсан монгол төрийн догшин чойжингуудын нэг нь Халхын Сайн ноён хан аймгийн Хатан баатар Дархан чин ван Сандагдоржийн Магсаржав юм. Тэрээр 1912-1922 онд улс орныхоо тусгаар тогтнолыг хамгаалсан зэвсэгт тэмцлийн манлайд явж, 30 гаруй удаагийн байлдаанд орохдоо ганц ч удаа ялагдаагүй ажээ. Хатан баатар дайнд орохын өмнө чойжин бууж цэрэг эрсээ зоригжуулдаг байсан тухай түүний цэрэг явсан цөөнгүй хүн дурсан өгүүлсэн байдгийг та бүхэн мэднэ. Хатан баатар Магсаржав 1921 онд Ховд баруун хязгаарыг цагаантнаас чөлөөлөх байлдааныг удирдаж, Үндэсний ардчилсан хувьсгалын ялалтад

үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд 1922-1927 онд Цэргийн яамны сайдаар ажиллаж, АЖЦ-ийг байнгын цэрэг болгон хөгжүүлж, улс орныхоо батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үйл хэргийг гардан удирдсан юм.

Ийнхүү улс орныхоо тусгаар тогтнолыг сэргээн баталгаажуулах их үйл хэрэгт шашины хутагт хувилгаад лам, тэр дундаа чойжинч лам нар үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Төр, улс түмэн олныхоо сайн сайхны төлөө эрдэм номынхоо хүч чадлаар тэмцэн зүтгэж явсан олон арван чойжин лам нарын төлөөлөл болгож бид дөрвөн хүнийг онцлон дурдлаа. Цаана нь үлдсэн олон чойжин лам нарын амьдрал, үйл ажиллагаа, шашины эрдэм чадал, арга ухааныг нь судлан сурталчлах явдал нэн шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна.

Өнөөдөр Монгол улс хөгжлийнхөө шинэ гараанд ирээд байна. Улс орны эдийн засаг хөгжиж, ард түмний аж амьдрал бага ч болов дээшилж, хүн амын тоо түргэн хурдацтай нэмэгдэж, олон улсын тавцанд манай улсын нэр хүнд байр суурь бэхжиж байгаа зэрэг нааштай өөрчлөлтүүд багагүй байгаа боловч өнөөгийн Монголын нийгэмд саар зүйл маш их байгааг та бид сайн мэдэж байгаа. Ийм цаг үед уламжлалт шашин соёлоо түгээн дэлгэрүүлэх нь чухал байна. Өнөөгийн Монголын нийгмийн хөгжилд учирч байгаа саад бэрхшээлийг даван туулахад уламжлалт шашины гүйцэтгэх үүрэг их юм. Үүний тулд өнөөдөр хот хөдөөд үйл ажиллагаагаа явуулж байгаа сүм хийдийн үйл ажиллагааг идэвхжүүлэхийн зэрэгцээгээр шашины уламжлалт зарим зан үйлээ дахин сэргээх шаардлагатай байна. Ийм зан үйлийн нэг нь чойжин лам, түүний эрдэм ухаан, ид шид болохыг эцэст нь онцлон тэмдэглэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хурлын илтгэгч Ц. Отгонбаяр гавж
Доктор (Ph.D)
ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙД

“ЖЭВЗҮНДАМБА ХУТАГТЫН ТӨМӨР ХАЙРЦАГНЫ БИЧГЭЭС ЭШЛЭХҮЙ”



Эрхэм хүндэт эрдэмтэн мэргэд, энд уригдан ирсэн зочин гийчэд та бүгдийн энэ өдрийн түмэн амгаланг айлтгая.

Манай бурханы шашинд янлагдүнбү буюу долоон гишүүний дараалаар ямарваа нэгэн чого зан үйл хийхдээ эхлээд мөргөл, тахил өргөхүй, номончлохуй, даган баясахуй, дурьдлага хийхүй, залбиран талбирахуй, буянаа зориулахуй ерөөхүй гэх дараалаар явагддаг уламжлалтай билээ. Монгол ардын үлгэрүүдэд ч мөн ялгаагүй эрт урьдын цагт гэж эхлээд амар сайхандаа жаргаваа гэж төгсдөг шиг эрдэмтэн мэргэдийн номын их хуралдай амжилттай явагдаж эхлэл, өрнөл маш сайхан болж, эрэмбэ дараагаараа миний ээлж ерөөл төгсгөлийн хэсэгт оногдож буй учир билиг дэмбэрэл дэгнэхийг эрхэмлэн үзэхүйн үүднээс засгийн газрын архивт эх нь хадгалагдаж буй Богд Жэвзүндамбын төмөр хайрцагны ном хэмээх 18 зүйл бүхий бичгийн зөвхөн нэгэн хэсгийг Эрдэмтэн Аким гуай Б.Тунгалагаар крилл үсгэнд хөрвүүлүүлэн “Цог” сэтгүүлд гаргасныг уг эхтэй нь дахин тулгаж хэл бичгийн ухааны эрдэмтдээр хянуулан ямар нэгэн найруулгагүйгээр бичсэнээ сонордуулъя.

Богд Жэвзүндамба хутагт монгол улсын хаан сууж байхдаа 1924 онд таалал барив..

Орд харшид эд хогшлыг хурааж дансалснаа тэмдэглэжээ. Гэтэл нэгэн жижиг төмөр хайрцагтай юм гаргасанд задалж үзэх хэмээвээс түлхүүр нь үл олдох тул нярав байсан Дамдинг баривчилж ял тулган байцааваас Дамдины хүзүүнээс булигаар гэртэй түлхүүр гарсныг авч уул хайрцгийг задлан үзвээс арван найман зүйлийн гэрээ бичиг байв. Энэ гэрээ бичгийн үндсэн зүйлүүдийг ирээдүй

цагт гадаад улстай 1,2,3 дугаар цуст дайн болох тухай хэлэлцэн тоймлон тогтоосон байв.

Энэ 3 дугаар гэрээ бичгийг Бадаргуулалт төрийн 18-р оны үед (1892 он) Утайн таван үзүүрт ууланд дэлхийн 5 гүрний хаадууд болон богд хутагтуудын хамтаар чуулган чуулж 3 дугаар гар бичгийг баталжээ. Энэ таван гүрний хаадын болон Ванчин богд, Далай лам, Сажи богд, Жэвзүндамба хутагт, Дамбийжанцан богд эдгээр хамтаар байж гар бичигтээ дурдсан нь: Халх монгол оронд төмөр хулганаас усан бичин жил /1960-1992 он/ хүртэл халх монголын хойд зүгээс хүний дүрстэй адууны байдалтай олон янзын шар нүүртэй /Си яан/ хэмээх нэртэй хүмүүс ирж монголын Цогт эрдэнийг булаан авч, энэ үед эм хүмүүн төрийн эрх баримой. Лам хүн цэрэгт мордмой. Мөн лам хүн хар хүний боол болмой. Ноён хүмүүс нохой мэт болмой. Ядуу гуйлгачин хүн түшмэд болмой. Худалдаачин хүн зарлага болмой. Хууль байвч дагах хүнгүй. Ном байвч унших хүнгүй. Уншдаг байвч цөөхөн, тэр цагт хүрээ хийд байвч цэрэг түшмэдийн балгас болно. Энэ цагт Монголын шашин төр төдийхөн болно хэмээсэн зарлиг бичгийг хаадын чуулганд өргөн мэдүүлээд 5-н гүрний хаадын чуулган Богдын хамтаар 18 гэгээд, 84 шидтэний хамтаар дагалдуулан ирүүлж ирээдүй цагт ямар ямар байдалтай болохыг тодорхой хэлэлцэгтүн хэмээснийг ёсоор болгон хэлэлцжээ. Эдгээр 84 шидтэний хамтаар Жагар, Намхай Бодалагийн орноос 12 хэлмэрч залж ирээд эдгээрийн хамтаар хэлэлцсэн нь Халх монгол орны Цогт эрдэнийг баруун хойд зүгээс оросууд ирж сая булаан авсны дараа ямар, ямар болохыг дахин өгүүлснийг авч хэлэлцэгтүн хэмээн зарлиг буулгасан нь Богд Жэвзүндамба хутагт халх орныг төмөр хулгана жилээс усан хулгана жил хүртэл даах, дараагаар нь гал барс жилээс төмөр морин жил хүртэл Заяын гэгээн даах, мөн түүний дараагаар өмнө зүгт хятад орны газарт төмөр морин жилээс эхлэн Жан-Зүй-Лин, Ү-Фи-Фүйн таван үед хямран байлдахад Жанжаа богд өөрийн биеэр эвсүүлнэ. Мөн түүний дараа хятад орны чанад буй япон хэмээх нэгэн хүчирхэг гүрэн хятад орныг боолчлон улмаар монгол орны зүг халдахаар төмөр хонин (1931 он) жилийн намрын эхэн сарын 10 ба 15, мөн сүүл сарын 22 ба 25-ны өдөр Монголчууд Тан Шан улсын хавчилгаар хямран байлдах болно. Тэр үед Дамдин Дорлиг бурхан төрмой. Энэ үеэр тэнгэрийн дуу их ба салхи гармой, газар хөдөлж хүний сэтгэл номхотгомой.

Эс бол хүний сэтгэл аяндаа номхорно хэмээн хэлэлцсэн бичгийг дэлхийн 5-н хаадын чуулганы 6-р зүйлд өргөн мэдүүлэв. Хутагт та нар Халх Монгол оронд ямар ямар бэрхшээл тохиолдох ба чухам аль аль орнуудад ямар болохыг дахин хэлэлцэгтүн хэмээн зарлиг айлтгасанд олон богд хутагт тэр ихэс нарын чуулганаар хэлэлцэн тогтоосон нь:

Нэгдүгээрт. Хятад орны байлдааныг япон ба түвд улс дармой.

Хоёрдугаарт. Орос орны байлдааныг Англи, Америк улсууд дармой.

Гуравдугаарт. Монгол орны байлдааныг Япон, Түвд, Хятад улс дармой хэмээсэнд Богд Жэвзүндамба хутагт хамаг Монгол орон чухам ямар болох буй хэмээхэд Богд гэгээд, хутагтууд цөм дахин хэлэлцээд төмөр хонин жилийн сүүлд усан бичин жилийн (1931-1932) эхэнд цуст байлдаан болно. Эл байлдааныг өмнө зүгээс түм түмэн Япон, Хятад цэргүүдийг дагалдуулан түмэн настны хөвгүүн ба богд хутагт нар хамтаар ирмой.

Мөн тэр зүгээс том шарга морьдын хамтаар дээд монголын олон тооны цэрэг сэлт ирж буруу үзэлтэн нарыг бүгдийг махан овоо цусан далай болгомой.

Тэр цагт монгол иргэд минь сүсэг бишрэлийг хичээ, хичээ! Юуны өмнө маань мэгзэмийг Дарь эх, Жинлавцогзол, Самбалхүндэвийн сүн эдгээр номуудыг өдөр шөнөгүй уншиж бурханд мөргөж байгтун.

Оточ бурханы лагшин дүрийг олноор бүтээ. Хоёр замын уулзвар дээр маань олныг босго. Дэмид бурханы суварга олныг бүтээ.

Энэ мэтээр буяныг үйлдвээс муу цагийн ба олон янз аюулаас гэтэлгэмой.

Эдгээр буяныг эс үйлдвээс муу цагийн аюулд аль болохоор дайрагдмой.

Иймийн тулд монгол иргэд минь сүсэг бишрэлээ хичээ, хичээ.

Үүний дараагаар Халх Монгол орны дотор, баруун хоёр аймагт малын мөргүй. Зүүн хоёр аймагт хүний мөр үгүй болно.

Тэр цагт урьд байгуулагдсан Эрдэнэ зуугийн хийд дээр Богд Жэвзүндамба хутагтыг зална. Тэр цагт Гунгаа нэртэй хаантай болмой. Дүйшан нэртэй ууланд Энх-Амгалан хааны хүү Далай-

Амгалан гэгч хүн усан тахиа жилд (1993) хаан суумой. Энэ үед Монголчууд их амгалангаар жаргамой хэмээсэн зарлиг бичгийг ертөнцийн дээд 5-н хаадын чуулганы 18-р зүйлд батлав. Өлзий хутаг орших болтугай.

Аргын 1889 он, Манжийн Бадаргуулалт төрийн 14 дүгээр он, Монголын шар хулгана жил.

Дээрхи бичгийн талаар олон эрдэмтэн судлаачид тайлбар хийж зүйл бүрээрээ таарч байгааг нотлон сайшаасан байдаг. Тэр ч бүү хэл Ерөнхий сайд асан Бямбасүрэн гуай маш их итгэл үнэмшилтэй хандаж 1960 оны төмөр хулгана жилээс 1992 оны усан бичин жил хүртэл халх монголын хойт зүгээс Си Ян нэртэй хүмүүс ирж монголын цогт эрдэнийг булаан авч гэдгийг тайлбарлахдаа ашигт малтмал болох Эрдэнэтийн зэсийн үйлдвэрийг хэлж байна гэж таамаглан, Өндөр жанрайсиг бурханыг засгийн газрын тогтоол гарган Эрдэнэтийн зэсээр бүтээлгэсэн ба Дамдин дорлиг бурханы хувилгаан гарч дарна гэснийг Эрдэнэт концерн гэх хувийн өмчийн компани байсныг Д.Дорлигжав захирал орж Эрдэнэт үйлдвэр хэмээн 100% төрийн өмчит үйлдвэр, монгол улсын саалийн үнээ болгосныг хэлж байгаа гэх тайлбарыг хийгээд Гунгаа нэрт хаан гэдэг нь Ерөнхий сайд байсан Гунгаадорж гуайг хэлж байгаа болов уу. П. Очирбат Ерөнхийлөгчийг гэсэн ч усан тахиа жил 1993 онд зална гэсэн он нь таарч байна

Энх-Амгалангийн үр сад гэдэг нь гээд инээж, манж монголын цус ойртож эфү нараас гаралтай байхыг хэн байг гэхэв гэж сонирхолтой тайлбар хийдэг. Мөн Соёлын гавъяат зүтгэлтэн Бурханч лам Г. Пүрэвбат бээр “Ирээдүйг эш үзүүлсэн бошгууд” гэдэг 200 гаруй хуудас бүхий номондоо маш дэлгэрэнгүй тайлбарласан байдаг бол, Түвдэч эрдэмтэн доктор, Аюулгүйн зөвлөлийн гишүүн асан Л.Хүрэлбаатар тайлбар хийхдээ Жэвзүндамба хутагт халх орныг төмөр хулгана жилээс “1912 он” усан хулгана жил буюу 1972 он хүртэл даах ба 1971 онд Зая гэгээнтэн Лувсанданзанпүлжинжигмэд мэндлээд гал бар жил буюу 1986 оноос монгол орныг дааж эхэлсэн гэдэг нь үг болон утгаараа биелэн, яг таарч зүй зохисоороо болж байна гэж Архангайн хөгшчүүлд тусгайлан тайлбарласан ба манай аав тэргүүтэй хөгшчүүл ч баярлан нулимс унаган байсныг би харж байсан юм.

Тунгалаг тамирын хөвөөндөө

Туг дарцагаа хиисгээд

Тунгалаг гэгээн хутагтаа

Туулай жилдээ зална гэсэн эшлэл биелэх нь гэцгээж удалгүй 1999 оны шороон туулай жил Зая гэгээнтэн маань тодорсон баярт үйл болж эшлэл биелсэн байдаг. Тэгвэл мөнхүү бичигт:

Урьд байгуулагдсан Эрдэнэ зуугийн хийд дээр Жэвзүндамба хутагтыг зална гэсэн бошго нь биелэлээ олж, 9-р Богдийг Эрдэнэ зуу хийдэд залсан ба Богд арван найман гэгээд, наян нэгэн шидтэний хамтаар дагалдуулан ирүүлж гэсэн нь 9-р Богд морилоод арав гаруй хутагтууд тодруулан, удалгүй энэ цэвүүн цагийг эрт хувилгаанаар тохинуулахаар Наро Банчэн хутагтын дүр тодрохыг хэлж байгаа гэсэн Л.Хүрэлбаатар агсны тайлбарыг анхааран үзвээс үнэхээр нэгийг бодогдуулам байхаас гадна өнөөдрийн эрдэм шинжилгээний бага хуралтай утга дүйж байгааг онцлох нь зүйтэй. Манайхан гадны Ванго мэтийнхний үгийг итгэж өөрийнхөө Богдийн зөвхөн бидэнд зориулсан бошго эшлэлд итгэл муутай, маания уншиж бурхандаа мөргөсөөр ирсэн дээдсийг мухар сүсэгтэй боловсролгүй гэдэг хоч зүүдэг нь зохис муутай санагддаг. Жэ Рэнбочи Богд ламын Бодь мөрийн зэргийн хураангуйд,

Энэ эдүгээгийн сайн үйл бүхэн

Ирээдүйн бэлгэдлийн үндэс гэж айлдсанчилан өнөөдрийн энэхүү эрдэм шинжилгээний хурал нь билиг дэмбэрэлтэй зүйл болж байна.

Наро Банчэн хутагтын ойрын хамаатан болох Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн иргэн Санжаахүүгийн Цэвээнлхазал гуайн дурсамжаас өгүүлбэл: Равжаа гэдэг айл зургаан хүүхэдтэй байсан ба том хүү Лувсанцэрэнгийн гэр бүлд 1904 онд Наро Банчэн хутагт Зүгдэрнамжил мэндэлж, 3-р хүү Номхонбороос миний аав Санжаахүү 1915 оны Луу жилийн зуны эхэн сард одоогийн Шилүүстэй сумаас хойш байдаг Эрдэнэ бадрах уулын хаваржаанд мэндэлсэн гэдэг. Энэ хавын нутаг манайхны дээдсийн хаваржаа намаржаа байсан юм билээ. Бага хүү Бат очир нь номтой лам хүн байж байгаад 1940 онд хилс хэргээр цаазаар авахуулсныг цагаатгасан. Манай аав Санжаахүү маань бидэнд хутагтын хамаатан гэж хүнд хэлж болдоггүйг үргэлж анхааруулан захиж, Нароба Дилова хоёр

хутагт минь наран, саран хоёр минь гэж Отгонтэнгэр хайрхандаа цай идээнийхээ дээжийг үргэлж өргөж байхыг захидаг байсансан. Цаг тайван болсон хойно аав минь Л. Доржгочоо ахтай хамтарч 1940 онд нураасан суваргыг нь хоёр хутагтын эд зүйлсийг дотор нь хийж сэргээсэн. Аав маань Пүрэвжав хутагтын чандрыг гэгээн овооонд, Жүгдэрнамжил хутагтын шарилыг Шилүүстэй уулын ар зоо болох Хавтгай уулын өвөр, шарилын хунхад нутаглуулсан гэж хэлсэн. Хутагтын төрсөн дүү Хорол эмгэн манайд амьдардаг сийрэгхэн ухаантай нэгэн байсан бөгөөд хутагтын талаар надад хуучлахдаа Энэтхэгийн наян дөрвөн шидтэний эхний хоёрт тоологдог өндөр хэргэмтэй. Түвд Лхасад хоосон чанарын талаар ном хаялцаж байгаад цонхоор тусах нарны цацрагт гаансаа тохоод хоосон чанар гэж иймэрхүү зүйл байхаа гэж цаадуулаа бишрүүлсэн. Мөн Бээжинд нар жаргаалгүй ид шид үзүүлсэн. Цагаан тохойдоо сүмээ бариулаад хөлс мөнгийг нь цагаан чулууг мөнгө болгон хувилгасан зэрэг олон сонирхолтой үлгэр домог шиг зүйлийг хүүрнэдэгсэн. Барон Унгерн, Дамбийжанцан, Польшийн эрдэмтэн Осендев, Пржевалский зэрэг хүмүүс бараалхаж, амьдралын төөргөө асуудаг байсан гэх ба Хатанбаатар ван байнга очиж чойжин бууж сэлэм зангиддаг байсан. Сүүлийн зангидсан сэлэм 1940 он хүртэл дуган сүмд залагдаж байжээ. Хамгийн сүүлд буурай маань хутагт шавь нартаа Отгонтэнгэр хайрхандаа үе, үеийн хутагтууд тахилага хийж шүтдэг байсандаа ч тэрүү Отгонтэнгэр талдаа завхан голоо дагаж төрнө миний хойд дүр гэж айлдсан байдаг. Энэ нь манай 9-р Богд хойд дүрээ монголд төрнө гэж бошголж, Зая гэгээн Лувсанжигмэднамжил гэгээн Тээл гэдэг газар Даага эцэхгүй газар төрнө гэж лүндэгнэсэнчилэн хаа мэндлэхээ айлдсан иш үзүүлжээ. Иймээс дээдсийн үзүүлсэн эш бошгын дагуу хойд дүрийг тодруулах нь чухалтай мэт санагдаж байна

Очир бээр огтлогч хэмээх Бурхан багшийн айлдсан их хөлгөн сударт: Амьтны төрлийг дөрөв хуваагаад, өндгөн ээцээс төрөгсөн ба, умайн ээцээс төрөгсөн ба, зөөлөн дулаан ээцээс төрөгсөн ба, хувилж төрөгсөн ба гэж зарлигласан байдаг. Эхнийхээр тахианаас тахиа төрдөггүй өндөг гардаг. Гарсан өндгөнд амин хий ордог гэдгийг айлдаж тахиа өндөг хоёрын аль алинаас төрдөг вэ гэдгийг 2500 жилийн тэртээ айлдсан байна

Умайн ээцээс төрөгсөн ба гэдгээр эхээс умайгаар дамжин төрдөг

амьтан бүгдэд хамрагдах ба дараагийнхаар нь эхгүй мөртлөө төрдөг чийгэн улаан зэрэг амьтдад хамруулж, хамгийн сүүлчийнхээр хутагт хувилгаадад хамрагдан нисваанис үйлийн эрхээр бус ерөөлөөр хувилж төрсөн хувилгаадад хамрагдана.

Жишээ нь, 14-р Далай лам Данзанжамц бээр:

Орчлонгийн зовсон амьтан бүгд ажирч дуусахуй хүртэл

Олон дахин энд төрнө хэмээн ерөөл тависаар байгаатай адил

Нарны гэрэл мунхгийн харанхуйг гийгүүлж

Наро Банчэн гэгээний номын адистэд дэлгэртүгэй.

Анхаарал тавьсан та бүхний ажил үйлс өөдрөг байг. Баярлалаа

Хурлын илтгэгч Л.Алтанзаяа
Доктор (Ph.D), профессор
МУБИС

НАРО БАНЧЭН ХУТАГТЫН ШАВЬ НАРТ ХОЛБОГДОХ ЗАРИМ МЭДЭЭ

Наро Банчэн хутагтын шавь нарын тухай эрдэмтэд зохиол бүтээлдээ хөндөн бичсэн бөгөөд тодруулах зүйлс бас бий. Энэхүү илтгэлд Монгол Улсын Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй баримтад тулгуурлан Наро Банчэн хутагтын шавь нарт холбогдох зарим мэдээг танилцуулж, саналаа дэвшүүлнэ. Бид "Наро Банчэн хутагтын бүгд шавь нарыг захирах тамгын бичиг дэвтэр", "Чуулганы дарга нартаны газраас удаа дараа хууль дүрэм болгож тушаасан бичгийн дэвтэр"-ийн зарим мэдээнд тулгуурлан бэсрэг өгүүлэл нийтлүүлж байсан.

Дээрх бичиг дэвтэрт зөвхөн Наро Банчэн хутагтын шавь нарт төдийгүй Халхын хутагтуудын шавь нарт холбогдох баримтыг тэмдэглэсэн. Дэвтэр тус бүрийн талаар товч танилцуулъя. "Наро Банчэн хутагтын бүгд шавь нарыг захирах тамгын бичиг дэвтэр" нь шар даавуун гадартай, 118 хуудас үдмэл дэвтэр бөгөөд 1704-1869 оны мэдээ баримтуудыг бичжээ. Энэхүү дэвтэрт Наро Банчэн хутагтын шавийн захиргааны хэрэг явдалд холбогдох болон бусад газартай харилцсан бичгүүдийг хуулан бичсэн байна.

Харин "Чуулганы дарга нартаны газраас удаа дараа хууль дүрэм болгож тушаасан бичгийн дэвтэр" нь шар даавуун гадартай, 110 хуудас үдмэл дэвтэр бөгөөд түүнд 1793 оноос Х1Х зууны сүүлч үе хүртэлх мэдээ баримтуудыг тэмдэглэжээ.Үүнд Тэнгэрийн тэтгэсний (1736-1795) үеийн 2, Сайшаалт ерөөлтийн (1796-1820) үеийн 3, Төр гэрэлтийн (1821-1850) үеийн 23, Түгээмэл элбэгтийн (1851-1861) үеийн 5, Бүрэнт засагчийн(1862-1874) үеийн 14, Бадаргуулалт төрийн (1875-1908) үеийн 3 буюу нийт 50 зүйлийн хууль дүрэм тогтоосон жишээг дэлгэрэнгүй бичсэн байна. Тэдгээрийг дэс дараалаар нь танилцуулбал дараах мэт болно. Үүнд,

Тэнгэрийн тэтгэсний онуудад “Хан, ван, гүнгүүдийн хөвгүүдэд хувилгаан гарахыг цаазласан, Хутагт хувилгааныг алтан бумбанд оруулж тодруулъя хэмээсэн”, Сайшаалт ерөөлтийн онуудад “Иргэд монголчуудын холбогдсон хэрэгт хууль буулгасан, Чуулганы дарга нараас нийлэх хэрэгт дутагдваас хонь үхэр авахуулъя хэмээсэн, Хутагт лам нарыг , Жэвзүндамба хутагттай адил ямба ёс хэрэглэж болохгүй хэмээсэн”,

Төр гэрэлтийн онуудад “ Шар суртахуун хөгжүүлье хэмээсэн, Тамга дээгүүр бичиг бичиж болохгүй хэмээсэн, Ядуу ардыг хураамжлан захируулъя хэмээсэн, Хошуу шавийн баригдсан ардыг дамжуулан хүргүүлье хэмээсэн, Аливаа хэрэгт болзоо хожимдож болохгүй хэмээсэн, Иргэн монголчууд лугаа холбогдсон хэргийг тодорхойлон мэдүүлье хэмээсэн, Аливаа албаны бичгийг суман өртөөгөөр явуулъя хэмээсэн, Насжсан, өвдсөн, эмгэглэсэн ба эмчүүдэд золио авах, Суман өртөөний морь малын хөлс тогтоосон, Баруун зуу зэрэг газар явсан морь малын хөл хураах эсэхийг тогтоосон, Тайж ард лам нарыг зоригоор явуулахгүй учир, Зоригоор гарч хэрэг гарган явах иргэнийг бариулах зэрэг учир тушаасан, Хутагт лам нарт шавь болгох хүнийг Их Журганаа мэдүүлж шавь болгоё хэмээсэн, Ял тушаах чинээгүй хүний оронд тайж түшмэдийг шахаанд оруулах хэмээсэн, Ялд хураах барааны үнэ тогтоосон, Даяа Иүй Да лугаа түншилье хэмээсэн, Албанд зарласан мөнгө барааг болзооны дотор ирүүлье хэмээсэн, Хутагт нарын шавийн нутаг тохиолдох суман өртөөг мөн шавиас гаргуулахгүй хэмээсэн, Тушаалгүй хүнээр тамгын жасаа тэргүүлүүлэхгүй хэмээсэн, Аливаа албаны бичгүүдийг хойш урагш явуулах өдрийг хожимдуулж болохгүй хэмээсэн, Нутгийн захын овоо тэмдгийг байцаан үзээд да тогтмол мэдүүлж байтугай хэмээсэн, Хулгай нарын хэргийг хууль тогтоож ирсэн, Шизүн төгст хуандийн их хэргийн учир элдэв ёслолыг тушаасан”,

Түгээмэл элбэгтийн онуудад “Манай шавь нутгийн Хуримт зэргийн газрын тарианы тухай тушаасан, Номгон зэргийн газар суман нутаглах, Улаа унаж болохгүй, унаваас тэмдэгт бичиг авч уна хэмээсэн, Жи Ху, Нийслэл хотноо зэрэг газар бараалхахыг тогтоосон, Аливаа мэдүүлэх хэргийн бичгүүдийг доторлохгүй сийрүүлэн мэдүүлж байгтун хэмээсэн”

Бүрэнт засагчийн онуудад “ Албанд явсан хүн морь малын

хөлсний аймгийн тогтоол, Аливаа албанд аймгийн тэгшид өгөх авах мал барааны тогтоол, Аймгийн ор холбооны жишиг тогтоосон зүйл, Аливаа албаны тэгшид ногсон мөнгө барааг болзоонд өгч авахуулъя, өнгөрвөөс одож авсан хэрэгслийн үнэ хөлсийн олгуулъя хэмээсэн, Зах нийлсэн хошуу шавь нарууд тайж ард өгөх авах хулгайн сүйтгэл өрний зэрэг зүйлд хэмээгүй бусдын малыг зоригоор барилан авахыг зогсоож тушаасан, Өртөө хавсарга улааны мал улаач гэр шүүс тасалдсаны хөлсийг тогтоон тушаасан, Албаны бичиг саатуулж болохгүй хэмээн дүрэм хэмжээ тогтоож тушаасан, Аливаа хүнд ялт оргодлыг оргуулсан газраас хугаацаа хугацаж бариулахаар тушаасан, Дээдийн түмэн өлзийн ном унших тухай байгуулсан сүрэг, сэмхэнээр үрэгдүүлэхийг ба... хэмээсэн, Ялгуусан хутагтын суух дэс тэмцсэн учир, Да жанжин жасааны мэдээ нар албаны сүрээр илүү зассаныг цаазлан тушаасан, Наро Банчэн хутагтын цол өргөмжлөх хэмээснийг уламжлан айлтгавай хэмээсэн, Гутгаар тайж Буяндэлгэрт Түшээ гүнгийн зэрэг, дэд зэргийн тайж Санжжавт тогосын отог тус тус шагнасан зэрэг тухай, Аливаа хулгайн сүйтгэлийг уритад болгон өгөөд хулгай нарыг гүйцэтгэн шийтгүүлье гэх зэрэг дүрэм тогтоон тушаасан”

Бадаргуулалт төрийн онуудад “ Түнш Даяа Иүй Да пүүсэнд өгөх авах мал барааны үний учир тушаасан, Аливаа худалдааны иргэдээс авах бараа зүйлийг бэлнээр өгч авахуулъя гэх зэргийг тогтоон тушаасан, Аймгийн сумуудаар явуулах элч нарт үнэмлэх тэмдэгт бичигтэй явуулах ба дөрвөн цагийн эцэст мэдүүлж байх зэрэг учрыг хэмээн тушаасан” зэрэг бичгүүд юм.

Ерөнхийдөө чуулган дарга нарын газраас тушаасан бичгүүд байгаа нь Наро Банчэн хутагтын шавийн захиргаа ямар хууль дүрмийг баримтлан байсныг илтгэж буйгаараа онцлог юм. Эдгээр бичиг дэвтэрт тэмдэглэсэн түүхэн баримтуудыг дараах хэдэн төрөлд ялган үзэж болох юм.Үүнд,

- Наро Банчэн хутагтын намтар, уг эхэд холбогдох мэдээ,
- Наро Банчэн хутагтын шөвь нарын захиргааны хэрэг болон бусад засаг хошууд, аймгийн чуулганы дарга нарын газартай харилцсан,
- Наро Банчэн хутагтын шавь нарын захиргаанаас өвөр чуулганы засаг хошуутай харилцсан,

- Наро Банчэн хутагтын шавь нарын захиргаанаас Халхын Жэвзүндамба хутагт, Эрдэнэ шанзудба нартай харилцсан,

Наро Банчэн хутагтын шавь нарын захиргаанаас Банчэн эрдэнэ, Жанжаа хутагт нартай харилцсан хэргийн мэдээ зэрэг болно. Эдгээрээс жишээ болгон заримыг нь танилцуулъя.

“Наро Банчэн хутагтын уг эх”-ийг “Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир”-ын есдүгээр дэвтэр “Дөрвөн аймгийн тамга бүхий, үгүй хутагт хувилгаан нарын шастирын хураангуй” -д товчлон оруулсан байна.

1917 оны 7 сарын 29-нөө “Наро Банчэн хутагтын шавьнарыг бүгд захирагч тамга” дарж өргөсөн өргөх цэст Наро Банчэн хутагтын уг эхийг товчлолгүйгээр бичсэн байдаг. Тухайлбал, өргөх цэст бичсэн “Энэтхэгийн газарт Шигэмүни бурханы үед” хэмээсэн бол шастирт “Энэтхэгийн оронд” хэмээн товчлон бичив. Мөн өргөх цэст Наро Банчэн хутагт Бадамдоржийг “Шэнзцу өршөөлт хуанди эзний гэгээнээ бараалхсанд Наро Банчэн хутагт цол, биеэр явахад наян хоног, элч явахад дөч хоногийн хүнс олгож” зэргийг шастирт хасаж бичсэн байна. Мөн хутагтуудын хувилгаан гарсан ба жанч халсан оны сар, Их журган(Гадаад Монголын төрийг засах явдлын яам-ГМТЗЯЯ-Л.А)-д мэдүүлж сүмийн нэр шагнуулсан, хувилгаан гарсан “Жүгдэрнамжилын нэрийг хэвт ёсны хоёрдугаар онд Их журганы газраас Найралт найрамдах оронд тахисан алтан бумбанд оруулж татаж гаргаад Зарлигаар тогтоосон хувилгаан Жүгдэрнамжилыг мөн он найман сарын хорин есөнд шавь нарт нийлүүлэн тавцанд суулгажээ” зэргийг хураан бичжээ. Өргөх цэст Наро Банчэн хутагтын шавийн Диловагийн хувилгаан Эрх цорж Жамсранжавын уг эхийг залгуулан бичсэнийг шастирт мөн хураангуйлан оруулжээ. Тийнхүү Монгол улсын тамгатай хутагтуудыг шастирт өргөх цэст дурдсан Наро Банчэн хутагтын уг эхэд буй Манжийн үеийн зарим хэрэг явдал, он тооллын тодотголыг хураангуйлж бичсэн байна. Харин өргөх цэсийн эх сурвалж нь үе үед Наро Банчэн хутагт, Эрх цоржийн хувилгаан нарын уг эх, түүнийг мэдүүлснийг тэмдэглэсэн данс байсан бололтой.

Наро Банчэн хутагтын уг эхийг байцаасан зүйлд, 1845 оны 7 сарын 17-нд Сайн ноён аймгийн(Цэцэрлэгийн-Л.А) чуулган

даргын газраас “Их Журганы газраас тушаасан бичгийн дотроо, хутагт хувилгаан нарын анх хувилгаан гарснаас одоо хүртэл дүр дүрийн гавъяа зүтгэл, бас шинэлэхийн жасаанд орсон, орсонгүй, орсон болвоос аль онуудад хэдэн удаа жасаалсан, тусгайлан бараалхсан, шагнасан, хүртсэн зүйлүүд, нирван болсон, хувилгаан гарсан учир, онууд, тамга, жуух буй үгүй, буйг нь аль онуудад ямар юмаар үйлдэж шагнасан, хэддүгээр хэдэн үеийн хувилгааныг шавгад оруулж татаж гаргасан, хэрвээ шавгад оруулаагүй нь болвоос хаанаас яахин хувилгаан тодруулсан, бас одоогийн дүр насанд хүрсэн эсэх, хүрсэн аваас хэд хэд жасаалсан зэргийн нэг нэгээр урьдын мэдүүлсэн аясыг бодож, зүйл дараалан тодорхой цэс үйлдэж” мэдүүлэхэд бэлтгүүлэхийг тушаасны хариуд өргөсөн цэсийг сийрүүлэн бичсэн дансыг тэмдэглэсэн байна.

Өөрөөр хэлбэл дансанд тэмдэглэсэн дэлгэрэнгүй зүйлээс Наро Банчэн хутагт, Эрх цоржийн хувилгааны уг эхийг бичихдээ хураангуйлан ашиглаж бичсэн өргөх цэсийг үндэслэн “Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир”-ын “Дөрвөн аймгийн тамга бүхий, үгүй хутагт хувилгаан нарын шастирын хураангуй”-д оруулж найруулан бичсэн ажээ.

Наро Банчэн хутагтын шавь нарын дотоод хэрэгт холбогдох зарим бичгүүдээс онцлог бүхий нь дараах мэт юм. Тухайлбал, Бэйс Төгрөгөөс Далад ангийн дунд суусан эмч Санжайрашд “Чиний шавь Чойрч далад Очирмуны эм хөвгүүнийг надад тушааж авсан хэрэг бөгөөд чиний ач над их тул чамайг амар суулгахын тул манай хүн чиний балчирт орвоос болтугай. Чиний шавь нар Чойрч, Цонхолдой, Рагва, Донойдай өвс усны эрхээр явтугай. Үүний тул тэмдэг өргөв.” хэмээх бичгийг 1704 оны зуны сүүл сарын 10-нд өгснийг хуулан бичиж үлдээжээ. Мөн 1705 онд чин ван Шамбаас гэлэн Санжайрашийг амар явуулах хэмээсэн бичиг бий. Энэхүү бичгүүд нь Наро Банчэн хутагтын Ордосоос гаралтай шавь нарт холбогдох бөгөөд хошууны ламын шавь нарын тухай хуучин мэдээ болохын хувьд сонирхол татна. Ялангуяа засаг ноёдоос лам, түүний шавь нарт тусгай эрх дархыг олгон тэмдэг бичгээр баталж байсан нь хожим Наро Банчэн хутагтын шавь болсны дараа ч хэвээр хадгалагдан дансанд тэмдэглэжээ.

1847 оны Их зуугийн чуулганы дэд дарга Ордосын Далад хошууг захирагч засаг хошууны бэйс Гүн билигт сэцэн дайчин

ахайтны бичигт дараах зүйлийг дурдав. Тус хошуун дахь Манжийн хааны зарлиг соёрхсон “Шашины ерөөлт сүм”-ийн Эрх цорж блам дурдсанаар, Халхын Сайн ноён аймгийн Наро Банчэн хутагт “Ачит багш Эрх цорж блам бээр хутагт миний урьд төрлийг урьж расан(дацан) засуулаад Найралт төвийн 3-р (1725) он айлтгаад хүргэн 20 дуутай шагнасан дараагаар хутагт миний бие засаг бэйстэний хошуунд хувилж 17 насан дээр ноёдын газраас Их Журганд мэдүүлж уламжлан айлтгасанд Богд эзэн хишиг хүртүүлж хутагт олгосон хойно Халхын Үй жанжны газраас урьд төрлийн газар суулгахыг айлтгаж 27 насан дээр Халхын газраа суулгав.” хэмээжээ. Мөн Эрх цорж, Наро Банчэн хутагт нар Манжийн хааны түмэн өлзийн тул ба шашин амьтны тусад байгуулсан сүм дуганд 1803 онд нэр гуйж ГМТЗЯЯ-нд мэдүүлж уламжлан айлтгаад хааны зарлигаар “Шашины ерөөлт сүм” хэмээх нэр шагнасан байна. Иймд уг хийдийн харьяат шавь нарт угийн хурал дуутай бариулаад хийдийг тахиж албагүй явуулахыг засаг бэйстэй зөвлөлдсөнд Наро Банчэн хутагт, да блам хоёрт эцгийн нь өгсөн шавь нараас тэдний хар дүү Гүнчиний хүүд олгосон 4 хамжлагаас бусыг Эрх цорж бламын шавь нарын хамт үүрд алба улаагүй, зөвхөн хааны “Шашин ерөөлт сүм”-ийг тахиж явуулахын тулд олгосон батлах тамгат бичгийг шинэтгэн олгохыг гуйсанд 1806 оны бичгийг шинэтгэж өгсөн байдаг.

Өөрөөр хэлбэл, Ордосын Далад хошуун дахь Наро Банчэн хутагт, Эрх цорж нарын шавь нарын талаар харилцан, батлах тамгат бичгийг үе үед шинэтгэсээр байсан нь тус шавийн захиргааны хэргийн нэг өвөрмөц тал юм. Эрх цорж, Наро Банчэн хутагт нарын урьд төрлүүдийн багш шавийн барилдлага нь уламжлан үргэлжилсээр тэдний шавь нарын харилцаа, хамааралд тусгалаа олсон байдаг.

Түүнчлэн тамгатай хутагтуудын шавь нарын захиргааны албан хэргийг засаг хошуудын нэгэн адил бичиглэхийг тушааж байсан нь анхаарал татна. Тухайлбал, 1822 оны 8 сарын шинийн 6-нд Цэцэрлэгийн чуулганы дарга, дэд дарга нараас Наро Банчэн хутагтын шанзудба Наваанданзанд тушаан илгээсэн бичиг илгээсэн байна. Түүнд, ГМТЗЯЯ-ны бичигт дурдсанаар, албаны бичгийн он, сар, өдөр бичсэни дээр тамга дарах ёстой боловч олон газрын бичигт тамгын дээгүүр доор бичиж хуулийг зөрчсөнийг анхааруулжээ. Иймд дотоод, гадаад олон чуулганы дарга нарт тушааж, цаашид хуулийг

дагаж үсэг бичсэний дараа “тамга дартугай” хэмээжээ. Мөн бэрээ бичвэл уг бичгийг хойш буцааж “хуулийг зөрчсөн засгуудыг нэр зааж буруушаан шийтгэсүгэй” хэмээснийг аймгийн засгууд, хутагт нарын шанзудба нарт явуулж, цөм нэгэн адил дагаж шийтгүүлэхээр болсон байна.

Мөн 1823 он 2 сарын 28-наа аймгийн жанжин нараас “Ядуу ардыг хураамжлан захируулъя” хэмээсэн бичигтээ “Харьяат чуулганы дарга нар болвоос нэгэн аймгийн олон ардын аж төрөх газрыг олгуулж элдэв хүмүүжүүлэн тэжээх аж төрөх эрхийг хүлээсэн хүн. Туслагч жанжин хэбэй болвоос нэгэн аймгийн цэргийн эрдмийг боловсруулан хулгай, худлыг арилган газар орныг ариун болгох эрхийг хүлээсэн хүн. Зүй нь өөр өөрийн тушаалын доторх хэргийг хянаж харьяат аймгийн засаг нарыг удирдан сургаж сайныг хөхүүлэн, мууг нь залхаан цаг бүр санаа гүйцэтгэж элдэв явдлыг цөм өөр өөрийн хэвийг олгуултугай.Хэрхэв хэмээн чухал тушаалыг хүлээж тоо хийж сууваас болохгүй. Жич, байцааваас хулгай худлын хэрэгт баригдсан ялт хүний дотор лам нар нэн үлэмж, энэ цөм Хүрээний хутагт лам нар, засаг нар шарын шажныг хүндэлсэн нэр бүхий атал энгийн учир доорд лам нарыг лам болгож ер цуглуулан ном сургахыг шимтэхгүй түүний зоригоор газар газарт хэрэн явуулаад сая муу самуун хулгай болон явахад хүргэсний тулд хамтаар тушаан ухуултугай хэмээн тушаажээ. Иймийн тулд үүнийг жасааны хэргийгхүлээн шийтгэх туслагч жанжин ван Цо-д тушааж уламжлан дөрвөн аймгийн чуулганы дарга туслагч жанжин нарт явуулаад олон засаг тайж, хутагт нарт чандлан сургаж ухуулаад үүрд дагаж явуулъя” хэмээсэн тул аймгийн засгууд хутагт нарын шанзудба нарт явуулж хойшид ардуудад аж төрөх боломж олгож, ялангуяа лам нар ёсыг зөрчин архи уух, хэрэн хэсэж худалдаа хийх, хулгай худал, самуун хэрэг дэгдээхийг цаазлан зогсоож, хурал хийдийн газраа номын сургуульд хичээлгэн явуулахыг тушаасан байна. Иймд шанзудба нар нь засгуудын нэгэн адилаар тушаалыг хэрэгжүүлж байсан төдийгүй хошуу, шавь нарын доторх лам нар болон ядуу ардын байдал ч ижил төсөөтэй байсан аж.

Наро Банчэн хутагын шинэ хувилгааныг сурвалжлахад Банчэн эрдэнэ, Гүмбүм хийдийн мэргэд, Жанжаа хутагт нараас лавлаж байсныг тэмдэглэжээ. Энэ тухай танилцуулбал дараах мэт.

Наро Банчэн хутагтын шанзудба Наваандэчингээс Жанжаа

хутагтад илгээсэн захианд дурдсанаар, 1817 оны 12 сарын шинийн 9-нд Наро Банчэн хутагт жанч арилжсан учир Баруун зууд гүнцог хүргэж манз бариад шинэ хувилгааныг тодруулахыг Банчэн эрдэнэд айлтгасанд лам чойжингоос асуу хэмээсэн ажээ.Харин лам чойжин “Амдо, Халх хоёрт эртүгэй” гэж сунтаг бүхий бичиг ирсэн тул сурвалжлан эрсэн байна. Ингээд Сайн ноён аймгийн чуулганы дарга засгийн төрийн жүн ван Дамцогжавын 2-р хүү Түнжижав, мөн аймгийн туслагч жанжин засгийн төрийн жүн ван Чогсомжавын хошууны тэргүүн зэрэг тайж Гомбожавын хүү Ядамжав, мөн аймгийн засгийн улсад туслагч гүн Сономбалжирдоржийн 2-р хүү Бадамсэд, Ордосын хошууны бэйс Дондовсэрэнгийн хошууны залан Гүнгүгийн хүү Сономпил, Амдогийн Чойбзүн хийдийн шавь Абуднамжилын хүү Дашравдан, Жамбалдорж нарыг сурвалжлан олоод тэдний дотор Наро Банчэн хутагтын хувилгаан буй эсэхийг Гүмбүм хийдийн мэргэдээс лавлаж “Жамбалдорж, Түнжижав, Бадамсэд, Сономпил энэ 4 хүүд, бас ч Жамбалдорж, Түнжижав хоёрын нигуур өндөр байна” хэмээх хариу авсан байна. Энэ тухай Сайн ноён аймгийн чуулганы дарга нар, туслагч жанжинд мэдүүлсэнд “ Манай аймгийн ван, гүн нар хэрвээ тэдний хүүдийн дотор хувилгаан буй хэмээвээс Журган хууль(ГМТЗЯА-ны хууль зүйлийн бичиг-Л.А)-д Халхын хутагт хувилгааныг ван, гүн нарт хувилгахыг байлгаж Богд эзэн(Манжийн хаан-Л.А) зарлиг буулгаж хууль тогтоосон тулд бидний хөвгүүдийг хувилгаанд нэр оруулж болохгүй. Тийм боловч харьяат шавь нарын газраас сурвалжлан олсон энэ 4 хүүгийн нэрсийг Жанжаа гэгээнтнээ айлтгаж аль нэгэн учрыг тодорхойлж бидний газраа мэдүүлтүгэй” хэмээжээ. Ингээд Жанжаа хутагтад тэдгээр “дөрвөн хүүгээс чухам хэн хэдийн нэрийг яахин заан мэдүүлж, уламжлан айлтгаж, алтан хумхад оруулах аль нэгнийг” тодорхойлон заахыг гуйсан байна.

Харин Жанжаа хутагтаас ямар хариу өгсөн нь тодорхойгүй боловч 1826 онд шанзудба Наваандэчингээс Сайн ноён аймгийн чуулганы дарга нарт илгээсэн бичигт тэмдэглэснээр, Түнжижав, Сономпил нар төрсөн нь цөм сайн тэмдэг буй бөгөөд тэдэнд хутагтын хуучин хэрэглэж байсан эдийг таниулахаар илгээсэнд Түнжижав хонх, дамарын зэрэг юмыг танисан ажээ. Иймд эдгээр хөвгүүдийн нэрийг чуулганы дарга нарын газраас уламжлан явуулж алтан бумбад оруулж хувилгааныг тодруулахыг гуйн мэдүүлсний

дагуу ГМТЗЯЯ-нд илгээв. Тэндхийн түшмэд нэрсийг шавгад бичиж Найралт найрамдах ордон дахь алтан бумбад хийж Жанжаа хутагт нарт тушаан гурван өдөр ном уншуулсан бөгөөд түшмэл Се, На нар хутагт нарын хамтаар үзэж шавга татан Түнжижавын нэрийг татаж гаргажээ. Энэ тухай 1828 оны 2 сарын 20-нд хаанд айлтгасанд “хэлэлцсэн ёсоор болгогтун” хэмээн зарлиг буулгасан тул ГМТЗЯЯ-аас Халхын Сайн ноён аймгийн чуулган даргад мэдэгдсэн ажээ.

Наро Банчэн хутагтын ураг төрлийн нэрийг жагсаан бичсэн нь чухал баримт болно. Үүнд, “өвөг авга блам Жүдэб гэгээн, авга блам Чобсан гэгээн, авга блам Гүмши(Рүмши?) гэгээн, ах Рагүва хутагт, Алшаагийн Добсан хутагт эмээ ээж, ээж, ах Ишчоймбил, авга эм, авга хүргэн, төрсөн эгч, төрөл ургийн сүлбээтэй хутагт хувилгаан их бага блам нар, сангуудын хэрэг мэдэгч нартай нийт дөчин хүн хүн. Хувилгаантны төрсөн нагац нэг өргөв.Төрсөн нагац рабжамба. Жүн ван Цэрэндонров, тайж Үржинжав болон ураг төрлийн сүлбээтэй нийт 23 өргөв” хэмээжээ.

Наро Банчэн хутагтын хувилгааныг сурвалжлахад Сайн ноён аймгаас туслаж байв. 1819 онд тус аймгийн ихэс зөвлөлдөн аймгаас шавийн 1500 лан мөнгө, зайсан Гэлэгдорж, дөрвөн хөтөлтэйн хэрэгсэлд ачилга уналгын тэмээ 15, хүнсний мөнгө 240 лан, мөнгө ачих хомтой тэмээ хоёрыг гаргуулж туслажээ. Харин шавиас 500 лан мөнгө, торго зэрэг эд 500 лан, зайсан Гэлэгдорж нарын хэрэгсэлд дутагдахыг шавиас гаргуулсан байна. Тухайн үед Жэвзүндамба хутагтыг залж ирэхэд Сайн ноён аймгаас явах гүн Далхжав, туслагч түшмэд нарыг дагалдуулан явуулж байв. Учир нь цөөхөн шавь нарын чинээ бага бөгөөд ган гачигт нэрвэгдэх явдал гардаг тул 1861 онд хутагтын хувилгааныг сурвалжлахыг мэдүүлэн хандив өргөхийг хүссэн байдаг. Иймд тамгатай хутагтын шавь нарын захиргаа болон тухайн аймгийн засаг хошуудын харилцааг нягтлан үзүүштэй юм.

XIX зууны 2-р хагаст Наро Банчэн хутагтын шинэ хувилгааныг тодруулахад Жэвзүндамба хутагт гол үүрэг гүйцэтгэх болсон ажээ. Жишээ нь, Наро Банчэн хутагтын шанзудба Гэлэг-Очироос Жэвзүндамба хутагтын хүрээний Хамба номун хан, дэд хамба, Эрдэнэ шанзудба, да лам нарт захидал илгээжээ. Түүнд Наро Банчэн хутагт жанч халсан тул шинэ хувилгааныг хаанаас гарахыг Жэвзүндамба хутагтад айлтгаж заасан лүндэнг дагаж ирээд

хувилгааны төлөв бүхий 3 хөвгүүдийг олсон тухай мэдүүлжээ. Иймд Наро Банчэн хутагтын хувилгаан алин болохыг заахыг эрж Жэвзүндамба хутагтад айлтгуулахаар, олсон хөвгүүдийн нэрсийг бичиж харьяат шавийн Цорж Лувсансодов, донир Балдан нарыг зарж бараалхуулсан байна. Хамба номун хан, дэд хамба, Эрдэнэ шанзудба, да лам нар таны газраас уламжлан айлтгуулж "өнчин шавь нар бидний хүслийг хангахыг гуйж Дээрхийн гэгээн танаа өргөх бичиг ба мандалын харамжинд мөнгө 50 лан, хадаг нэгийг хамтатган үүний тул тусгайлан Хамба номун хан, дэд хамба, Эрдэнэ шанзудба, да лам нар танаа түмэн амгаланг айлтгаж өргөн дэвшүүлэв" хэмээсэн байна.

Наро Банчэн хутагтын Эрх цоржийн хувилгаан Рашпунцаг, шанзудба Гэлэг-Очир нараас Очирдара богд гэгээн (Жэвзүндамба хутагт-Л.А)-д айлтгаж лүндэнгийн гүрмийг бүтээж Наро Банчэн хутагтын хувилгааныг сурвалжлан эрээд, Сайн ноён аймгийн засаг Бүмдарийн хүү Ширизагд, тахиа жилтэй, 4 настай , гүн Эрхэмжаргалангийн хошууны Очирсуурийн хүү Хишигнэмэх, нохой жилтэй, 3 настай, Хэбэй амбан жанжин Засагт хан аймгийн Мөнх Түшээ гүний хошууны залан Чогсомын хүү Бэрва, нохой жилтэй, 3 настай хөвгүүдийг олжээ. Өргөсөн бичигт "Эдгээр ариун цэвэр төлөвтэй хөвгүүдийн нэр зүйлийг олж Очирдара богд гэгээн танаа өргөсөн үүний дотор манай хутагтын хувилгаан буй болвоос Очирдара богд гэгээн нигүүлсэн өршөөж тодорхой цохож заахыг мөргөн айлтгав. Хэрэв энэ дотор үгүй болвоос аль оронд ямар овог язгууртай хүнээс хувилгаан гарсныг Очирдара богд гэгээнтэн нигүүлсэн өршөөж тодорхой лүндэн буулгахыг айлд айлд айлдан соёрх" хэмээснийг 1864 оны цагаан сарын 11-нд айлтгажээ. Мөн өдөр буулгасан лүндэнд "Бэрва Хишигнэмэх хоёрт хувилгааны нигууртай" хэмээснийг шар үсгийн бичгээр өөр бичиж цорж Лувсансодов, донир Балдан нарт тушаасан ажээ. Мөн тэдгээр хөвгүүдийн нэр дээр тийз тэмдэг дарсан байна. Иймд шанзудбагийн газраас хөвгүүдийн нэрсийг уламжлан мэдүүлж, шавга татуулахаар харьяат засгууд, ургийн хүмүүс санаа дагах эсэхийг баталгаажуулж байв.

1864 оны 10-р сард Цэцэрлэгийн чуулганы даргаас Наро Банчэн хутагтын шанзудба Гэлэг-Очирт чуулганы даргын газраас Наро Банчэн хутагтын шинэ хувилгааныг шавга татуулж тодруулан

заахыг эрж ГМТЗЯЯ-ны түшмэлийн тэнхимд өргөх битүүмжилсэн дугтуй бичгийг хүргүүлснийг хүлээн авч зайсан Санжмятав, донир Балдан нарыг мордуулан 60 хоногийн хугацаанд хүргүүлэхийг тушаажээ.

Мөн чуулганы даргын газраас Наро Банчэн хутагтын шинэ хувилгааныг ширээнээ залж, Бат-Оршил өргөн, наадам бэлэглэхэд тогтоосныг мэдэгдээд эр эм шүдлэн хонь хийгээд наадмын элдэв хэрэгсэл зүйлийг цөм Эрдэнэ Бандидаа хутагтын хувилгааныг ширээнд залахад гаргуулсан даншогийн ёсоор гаргуулъя хэмээн тушаажээ. Түүний дагуу хуваахад “даншогийн эр эм шүдлэн хонь тав таван зуугаас 216-ыг ноёдын пүнлүүнээс гаргуулахад засаг Бүмдар бие өнгөрсөн тул түүний 100 ланг үл хэрэгсэн, бүгд пүнлүүний 100 ланд эр эм хонь олгуулж, бас бай мөрийгөөс тэмээ 2, морь 3, торго 1, бүхэл булигаар 3-ыг Зая Бандидаа хутагт, Эрдэнэ Бандидаа хутагт, Чин сүжигт номун хан нарын гурван шавиас хуучин удаагаар гаргуулах эднийг тайлж, үлсэн нэг бүр нэжгээд лан бодсон даншогийн эр эм шүдлэн хонь 784, бай мөрийний нэг бүр 6 лан бодсон торго 2 зах, гурваад лан бодсон бүхэл булигаар 5, нэжгээд лан бодсон эм шүдлэн хонь 60, үүний 1 лан бүрийг 100 шар цай бодож бас сул шар цай 500, хуримын үнэ сул шар цай 6000, эл зүйл нийлсэн бүгд шар цай 9 түм 3600-ыг эдүгээ аймгийн албан гаргаж бүхий 4389 эрийн нэг бүрт 21 цай онуулж тогтоох 1431 цайнаас сум эргүй засаг Тогмидын хошуунаас 620-ыг гаргуулан үлсэн 811-ыг зохисоор нэмэх” -ээр болсон байна. Мөн Наро Банчэн хутагтын шинэ хувилгааныг залахад аймгаас тайж Жигмэддовдонрашийг гаргаж есөн цагаан бэлэг ба бэлгэ ёслолыг гүйцэтгэхийг тушааж байв. Эдгээр жишээ нь Наро Банчэн хутагтын шавь нарын төдийгүй бусад тамгатай хутагтуудын шавь нарын дотоод хэргийн болон аймаг, хошуудтай ямар харилцаатай байсан түүхийг улам нарийвчлан үзүүштэйг илтгэнэ.

Дээрх хэдэн зүйл баримтад тулгуурлан дараах саналыг дэвшүүлж болох байна. Үүнд,

“Наро Банчэн хутагтын бүгд шавь нарыг захирах тамгын бичиг дэвтэр” нь Монголын тамгатай хутагтын шавь нарт холбогдох хэрэг зүйлийн бичгийг хуулан нэгтгэж дэвтэрлэдэг байсны жишээ болсноороо шавь нарын тамгын газраас хэрэг шийтгэхдээ аймгийн чуулганаас илгээсэн зарлиг, тушаалуудыг баримталж байсныг

илэрхийлж байна. Тийнхүү бусад тамгатай хутагтуудын шавь нарт холбогдох данснаас ялгагдах өвөрмөц онцлогтой данс үлдсэн нь тус шавь нарын захиргааны бичиг хэргийн ёс журам нэлээд эртнээс тогтсон байсныг илтгэнэ.

Наро Банчэн хутагтын зарим шавь нар нь тухайн шавь нарын нутгаар хязгаарлагдахгүй Ордосын Далад бэйсийн хошууны нутагт “Шашин ерөөлт сүм”-ийн харьяат байдлаар оршсоор байсан нь засаг хошуу болон тамгатай хутагтын шавь нарын харилцаа, захиргаа, нутгийн хэргийг тусгайлан авч үзэх өвөрмөц жишээ болж байна.

XIX зууны эхээр Наро Банчэн хутагтын шинэ хувилгааныг тодруулахдаа Банчэн эрдэнэ, Жанжаа хутагт нарт хандан лавлаж байсан бөгөөд XIX зууны 2-р хагас болоход чуулганы дарга нараар уламжлуулан ГМТЗЯЯ-д мэдүүлэхийн өмнө Жэвзүндамба хутагтын лүндэнгээр нэр сонгодог болжээ. Мөн Найралт найрамдах ордонд шавга татуулж тодруулсны дараа шинэ хувилгааныг залахдаа аймгаас тайж хүн гаргаж есөн цагаан ба бэлгэ ёслолыг гүйцэтгэж байсан төдийгүй Наро Банчэн хутагтын хувилгааныг залахад бусад хутагтын жишгээр аймгаараа даншог өргөж, хошуудын сум эрийн тоогоор даншогийн зардлыг хуваарилж байсан нь нэг талаар засаг хошуудтай ижил түвшинд харилцаж байсны, нөгөө талаар хутагт, хувилгаад хийгээд ван, гүн, тайж нарын уламжлалт харилцааны илэрхийлэл билээ.

Уг сэдвийг цаашид улам нарийвчлан, бусад хутагт нарын шавь нартай харьцуулан судлууштай юм.

Хуралд зориулж сэтгэлийн үг хэлсэн
Н. Нанзаддорж гавж, Дэд хамба
ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙД

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Өнөөдрийн хурал маань бас нэг онцлогтой сайхан хурал болж өнгөрч байна гэж бодож байна. Яагаад гэхээр нэгдүгээрт манай эрдэмтэн мэргэд ялангуяа ахмад эрдэмтэд их оролцсон энэ талаараа бас онцлог болж байна.

Гандантэгчэнлин хийдэд олон удаа ийм хурал зохион байгуулсан. Гэхдээ ийм өргөн хүрээ хамарсан, эрдэмтэн мэргэдийг хамруулсан хурал ховор болж байсан юм. Тэгэхээр нэгдүгээр онцлог нь тэр юм болов уу гэж би бодож байна. Өнөөдрийн илтгэл тавьсан эрдэмтэн мэргэдийнхээ илтгэлийг сонсоод сууж байхад, бас урьд дуулж мэдээгүй эрдэм мэдлэг, шинэ санаа авч байна.

Наро Банчэн хутагт манжийн хаанаас тамгатай, монголын түүхэн дэх томоохон тамгатай хутагтуудын нэг юм. Нутгийн ард түмэн ялангуяа нутгийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа юм байна. Наро Банчэн хутагтын хойд дүрийг тодруулъя гэсэн санал гарч байна. Ерөнхийдөө монголын уламжлалт хутагт хувилгаадаас 9 дүр тодорчихоод байгаа. Манжийн хаанаас тамгатай, Богд хаанаас тамгатай томоохон хутагтуудын дүр бол тодорсон байгаа. Ингээд Наро Банчэн хутагтын дүрийг тодруулъя гэсэн саналыг Гандантэгчэнлин хийдийн төлөөлөх хүний хувьд миний зүгээс дэмжиж байна. Гандантэгчэнлин хийд хутагт хувилгаадыг тодруулъя гэсэн бодлогыг барьж ажиллаж байгаа. Эрдэмтдийн илтгэл дээр гарч байсан хутагтуудыг хоёр хуваагаад бага хутагт хувилгаад, томоохон байр суурьтай хутагтууд гэж хоёр хуваасан. Гандантэгчэнлин хийдийн шашины бодлогууд эхний ээлжинд томоохон хутагт хувилгаадаа тодруулаад явуулсан нь дээр юм болов уу гэсэн бодлого бариад явж байна. Тэгэхээр Наро Банчэн хутагт бол Монголын тамгатай томоохон хутагт юм. Үүн дээр

хамтран ажиллахад бэлэн байна. Нутгийн зөвлөл тусгай комисс байгуулаад Гандантэгчэнлин хийдэд албан ёсоор хандвал бидний зүгээс дэмжээд цаашдаа хамтран ажиллахад бэлэн байна.

Хуралд зориулан Дилов хутагтын илгээмжийг уншиж танилцуулсан.
А. Батцэнгэл гэвш
“Дилова хутагт” сангийн гүйцэтгэх захирал

Сайхан хурал боллоо. Яагаад гэвэл бурхан шашины хөгжилд хутагт хувилгаадын хийсэн үйлс хэрэг бол маш их зонхилох байр суурийг эзэлж байсан. Ер нь шашины эзэн гэдэг бол эгэл жирийн бус хутагт хувилгаад голлож байдаг байхаа гэж боддог.

Саяны хурлын үеэр Дилова хутагт бид хоёр ойрын үед холбоо бариагүй байж байгаад яг хурлын үеэр Дилова хутагт над руу мессеж бичиж холбогдсон. Ийм хурал болж байна гэдгийг би хэлсэн. Гандантэгчэнлин хийдийн Дэд хамба айлдлаа. Ер нь хутагтын хойд дүрийг тодруулах ажил дээр бол Гандангийн зүгээс үйл ажиллагаа явуулахад бэлэн байна гэж айлдсан. Яг үүнтэй адилхан Дилова хутагт ч гэсэн Наро Банчэн гэгээний хойд дүрийг тодруулахад өөрийн зүгээс туслахад бэлэн байна. Хэрвээ миний зүгээс туслалцаа хэрэгтэй бол би туслахад бэлэн байна гэж хэллээ. Үүнийг би та бүхэнд дуулгах гэсэн юм.

Дилова хутагтын тухай товчхон танилцуулъя. Жамсранжав гэдэг хүн Америкт гараад тэндээ таалал төгссөн. Түүний хойд дүр нь Америкаас тодорсон халимаг үндэстнээс тодорсон хүн байгаа. Түүнээс хойш Наро Банчэн Дилова хутагт бие биенээ ээлжлэн тодруулж явсан. Багш нь шавийгаа, шавь багшийгаа гэж ээлжилж явж байгаад яг одоогийн байдлаар Дилова хутагт Наровагаа тодруулах ийм үе дээрээ ирчихсэн байгаа.

ТАВДУГААР БҮЛЭГ

НАРОБАНЧЭН ХУТАГТЫН НОМЫН УРИА.

ДОЛООН БУРХАН ОДНЫ ТАХИЛГА

Эрт цагт Бурхан багш бээр долоон одны өмнө идээний дээд, зул, хүж, цэцэг, хадаг зэргийг төрөл бүрийн үр жимсийн хамт бэлтгэн долоон үеэр өргөж байжээ. Үүнчлэн бид долоон одны тахилга хийхдээ эхлээд илтгэл, сан уншиж цагаан дэвсгэр дээр долоон одны байрлалаар тахил байрлуулан зургаан тарни, зургаан мутарлагын адис үйлдэн ийн унших нь:

Ялж төгс нөхцсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан үнэхээр туулсан Бурхан Намсаг дор мөргөн тахин номончилмой.

Нэгдүгээр жи:

Номын чанар их амгалангийн уужим хот мандлаас

Намсаг Бурхан ялж төгс нөхцсөн бээр

Бүхнээс хутагтын орчлонг болгоон

Бурханы эрдэмд төгс боловсров

Дамлин хэсээх од ануу:

Дээд бурхадын хувилгаан

Дансүрэн арш танд тахил өргөе

Дансүрэн арш танд сүслэн мөргөе

Тань зүүн зүгийн одны эзэн

Миндүг, нарма, го, лаг, намсо

Мөнхүү жал, гаг, хэмээх долоон од

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин зовлон барцад бүгдийг арилгаж

Өөдлөн нас урт эдлэл арвижиж

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цаг учрал хотол чуулган

Эрхэм баясгаланг олох болтугай

Тарни ануу:

НАМО САМАНДА БУДАНАМ

УМ-АМРИТА-ЯА-ЕЭ-СУХА

Долоон удаа уншиж мөргөнө.

Ялж төгс нөхцсөн тэргүүнчлэн ирсэн дайныг дарагсан үнэхээр туулсан Бурхан Зүгдэр дор мөргөн тахин номончилмой.

Хоёрдугаар жи:

Их амгалан билиг билгийн ордноос

Илт туулсан Зүгдэр бурхан

Эрдэнийн язгуурын орчлонд

Эрдэм бүгдийг гүйцээн соёрхов

Гүман хэмээх од ануу:

Гэтэлгэгч Бурхадын хувилгаан

Дансран арш танд тахил өргөе

Дансран арш танд сүслэн мөргөе

Тань зүүн зүгийн одны үндэс

Тэрхүү Мэндүг төргүүт од гараг

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн ,

Өвчин зовлон барцад бүгдийг арилгаж

Өөдлөн нас урт эдлэл арвижиж

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цаг учрал хотол чуулган

Эрхэм баясгаланг олох болтугай.

Тарни ануу:

НАМО-САМАНДА-БУДАНАМ

УМ-ЦЭНДА-ХЭМ-НИ СУХА Долоон удаа уншиж мөргөнө

Ялж төгс нөхцсөн тэргүүнчлэн ирэгсэн дайныг дарагсан үнэхээр туулсан Бурхан Тамжиджав дор мөргөн тахин номончилмой.

Гуравдугаар жи:

Билиг билгийн номын хот мандлаас

Бурхан ялж төдгс нөхцсөн тамиджав

Наран саран дэлгэрсэн орчлонд

Ном бүгдийг төгс гүйцээв

Лүйшүн хэмээх гараг ануу:

Лавтай Бурханы хувилгаан

Дансран арш танд тахил өргөе

Дансран арш танд сүслэн мөргөе

Тань урд зүгийн одны эзэн

Тэрхүү чү,дэ,бо,мэ,наг,сарэ,сага од

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин барцад бүгдийг арилгаж

Өөдлөн насжиж эдлэл арвидан

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цог учрал хотон чуулган

Эрхэм дээд баясал олох болтугай

Тарни ануу:

НАМО-САМАНДА-БУДА-НАМ

УМ-НИ-МИ-РИ-НЭ-ЛА-ГАДА

НАВАРА-ПҮР-ДҮСҮ-СУХА Долоон уншиж мөргөнө.

Ялж төгс нөхцсөн тэгүүнчлэн ирсэн дайныг дарагсан үнэхээр туулсан Бурхан Хорвоонжиг дор мөргөн тахин номончилмой

Дөрөвдүгээр жи:

Их амгалангийн орд харшаас

Илт туулсан Бурхан хорвоонжиг

Гэмээ ухаардаггүй хорвоод

Гэгээн эрдэм буянаа төгсгөв

Вүнгү хэмээх од ануу:

Винайн төгссөн

Бурханы хувилгаан

Дансран арш танд тахил өргөе

Дансран арш танд сүслэн мөргөе

Та ануу урд зүгийн одны эзэн

Тэрхүү чүтдэ, тэргүүт однууд

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин барцад бүгдийг арилгаж

Өөдлөн насжиж эдлэл арвидан

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цог учрал хотол чуулган

Эрхэм дээд баясал олох болтугай

Тарни ануу:

НАМО-САМАНДА-БҮДА-НАМ УМ-БИДА-СУХА

Долоон удаа уншиж мөргөнө

Ялж төгс нөгцөгсөн тэргүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан үнэхээр тугуулгасан Бурхан Сиртүв дор мөргөн тахин номончилмой

Тавдугаар жи:

Номын чанарын уужим мандлаас

Номын хаан сиртүв бурхан

Ариухан сайхан бээр орчлонд заларч

Авшиг увидасыг туйлд нь болгоов

Линчин хэмээх од ануу:

Лавтай Бурханы хувилгаан

Дансран арш танд тахил өргөе

Дансран арш танд сүслэн мөргөе

Та ануу баруун зүгийн одны эзэн

Тэрхүү:лхацан, нон,чүв,чүдод

Чүмод жишин, дошин одод

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин барцад бүгдийг арилгаж

Өөдлөн насжиж эдлэл арвидан

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цог учрал хотол чуулган

Эрхэм дээд баясал олох болтугай

Тарни:

НАМО-САМАНДА БҮДАНАМ

УМ-БАРА-ДЭЗА-РА-МА-РА-НА-СУХА

Долоон удаа уншиж мөргөнө. Ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан үнэхээр тугуулгасан Бурхан Одсүрэн дор мөргөн тахин номончилмой.

Зургаадугаар жи:

Их амгалан билиг билгийн агаараас

Илт туулсан Бурхан Санжа Одсүрэн

Номонд сүсэглэн орчлон дээр

Ном бүгдийг төгс гүйцээв

Хүгү хэмээх од ануу

Хүчит Бурхадын хувилгаан

Дансран арш танд тахил өргөе

Дансран арш танд сүслэн мөргөе

Та ануу баруун зүгийн одны эзэн

Тэрхүү зүгийн одод бүгд

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин барцад бүгдийг арилгаж

Өөдлөн насжиж эдлэн арвидан

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цог учрал хотол чуулган

Эрхэм дээд баясал олох болтугай **Тарни**

НАМОСАМАНДА БУДАНАМ

УМ-САРВА-ДАРА-САМАЯ-СУХА

Долоон удаа уншин мөргөнө

Ялж төгс нөхцсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан үнэхээр туулсан Бурхан Шагжтүв дор мөргөн тахин номончилмой.

Долоодугаар жи:

Их амгалант номын ордноос

Илт туулсан Бурхан шагжтүв тэргүүт

Индранил эрдэнийн орчлон дээр

Их оточийн эрдэм төгсгөв

Погүн хэмээх од нь

Пагва хутагтын хувилгаан

Дансран арш танд тахил өргөе

Дансран арш танд сүслэн мөргөе

Тань хойд зүгийн одны эзэн

Тэрхүү мондү, мондэ, түмдод

Түммад, намдүй тагар бран

Тэргүүт хойд зүгийн одод бүгд

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин барцад бүгдийг арилгаж

Өөдлөн насжиж эдлэл арвидан

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цог учрал хотол чуулган

Эрхэм дээд баясал олох болтугай.

Тарни ануу:

НАМА САМАНДРА-БУДА НАМ

УМ-СА-ВА-ДА-СА-РА-МЭЗА-СУХА

Долоон удаа уншиж мөргөнө

Даллага ануу:

Арван зүгийн архад бүгдийн

Адис жинлав нас буяны даллан авъяа

Хурай хурай хурай

Дээрх огторгуйд залран буй

Тэнгэр долоон одын нас буянг даллан авъяа

Хурай хурай хурай

Завсар орчлонгийн нар сар

Найман их гарагийн нас буяныг даллан авъяа

Хурай хурай хурай

Миндаг нарма тэргүүт хорин найман

Магнай их оддын насан буянг даллан авъя

Хурай хурай хурай

Эртний Энэтхэг түвд монголчуудын

Энх тунх насан буяныг даллан авъя

Хурай хурай хурай

Орон бүгдийн төгс эдлэлийн авч

Ойр таарах барцадыг арилгаж

Өвчин ад бүгдийг хөөж

Өнө мөнхийн насан хутагтыг даллан авъяа

Хурай хурай хурай

Буяны төгөлдөр нөхрийг тааруулж

Бусад морь мал машид элбэг

Орчлон сан баялаг бүгд

Ойртуулан арвижуулан дамжуулан авъяа

Хурай хурай хурай

Өлзий хутаг зуны далай мэт

Өнө мөнхөд орших болтугай

Өвчин зовлон зуд турхангүй

Өнөд насан хутаг дэлгэрэх болтугай

Өлмийн лянхуа бат оршиж

Өнөр баян болох болтугай.

ЭЗЭН ЧИНГИС БОГДОД СЭРЖИМ ӨРГӨХ ЁС ХИЙГЭЭД ҮЙЛСЭЭ ЗАХИРУУЛЖ САНАСАН ЗҮЙЛИЙГ ТҮРГЭН БҮТЭЭХ СЭЛТ ОРШВОЙ

Гурван оронгийн номын хаан Зонхова бурханд мөргөмой Үүнд Чингис хаанд сэржим өргөхийг хүсэгч бээр өөрийгөо Ядам бурхапд тодруулснаар нанчод мэт адистлаад

Сэржимийн ариун дээжист тахил үүнийг

Гурван ертөнцийн итгэлт Содномжамц хийгээд

Чингисийн язгуурт мэндэлсэн Ёндонцамц

Бүхнийг айлдагч V Лувсанжамц тэргүүтэн

Эзэн богдын бодит удам залгамжилсан

Багш бурхадыг айлтган тахияа

Санасан бүхнийг зөнд нь бүтээн зохио

Ариун сэржимийн дээжист тахил үүнийг

Номыи сахиус нийт хийгээд ялангуяа

Огторгуйн тэнгэр эзэн богд Чингист

Залбирьяа санасан тусыг аяанд нь бүтээж зохио

Ариун сэржимийн дээжийн тахил үүнийг

Эзэн Богдын зарлиг магтаалаар хувилсан хатан

Гадна дотны түшмэд нөхрийн чуулган хоцроолгүйд

Залбирч тахия Санасан тусыг зөнд нь бүтээн зохио

Намо гүрү Базар Бира ваяяа

Дэвсгэр дээр улаан шар наран арслангийн дээр

Цагаан онгонд тунгалаг улаан өнгө тогтсон Богд

Хаана саатавч шашныг сахин санасан горилыг хангаад

Миний сэтгэсэн тус бүгдийг үтэр түргэн бүтээ

Цуугиан цурхираант эгшиг дэлгэрсэн шамдах сэтгэлээр
их тэнгэр таны нас
Дүр байдал магад рид хувилгааны хүч чадлаар торох үгүйеэ залар
Цай архи ундаа эм цусан далай цагаан балин амтат рашааны далай
Арван тавны сар дэлгэрсэи мэт гэгээний хот мандлыг мишээж таал
Бурханы шашны сахиус урьд цагт Охин тэнгэр цагт орших
Сүүлийн цаг үүнд Далай лам Содномжамц бээр
Эдүгээс эхлээд Богд Зонховын шашныг аривжуулна хэмээн
очирын зарлиг
Өвдөх өтлөх үхэх үгүйн рашааны цогийг санах цаг боллоо
Баасан гараг мэт маш цагаан сэтгэлээр зургаан зүйлийн эцэг эхийг тэтгэ
Хоосон чанарын агаараас амирлах дэлгэрэх эрхшээх догшноор бүжиглэх
Шар үст тэр ч гурван мянган ертөнцийн орныг сүрээр дарах хүчит өмөгт

Хоцроолгүй хааны сүр жавхланг үүсгэж хар зүгийн шулмасыг дарж
Үндэс хийгээд навч цэцгийн үр дэлгэрч чандманын өмгийг арвитгаад
Халуун хүйтэн тэгшрэх зун цагийн хур ямар мэт хүссэнчлэн буугтүн
Ялгуулсан Сидхи хаан эцэгт хүн эдийн хувь дэлгэрээд
Залиас төрсөн мэт номын бус зүгийн язгуур сэлтсээс гэтлээд
Шар малгайтны шашны сахиусаас бүү алгасраг
Идэж үйлдэх бадарсан нөхрөөр хүрээлсэн их Тэнгэр таныг хүсэх цагт
Оволзож бадарсан цагийн адгийн галаар хар зүг бүхнийг өвс мэт шатаа
Гайхамшигт тонилох зам арван буяны ёс цаазыг арвижуулж
асрахаар тэтгэ
Хашаа хүрээ бүгдийг эдээр дүүргэж хүн малыг арвижуулан зохио
Бурханы арван таалал Зонховын шашныг дэлгэрүүлэн зохио
Бүхнийг арван буяны цааз зарчимаар амар жаргахыг арвижуулан зохио
Хаан хатан хүү түшмэд харьяат албат сэлтийг
Хари унаж оршсон хувилгаан сахиус тэнгэрийн увш та

Усан тахил тэргүүтэн тахилыг таалж надтай нөхөрлүүлэн зохиогтүн
Үг найруулга төдий далдыг орхисон бөгөөд тусын зэндмэнэ
эрдэнийг барьж
Энэрэх санаагаар хөлбөрөлт үгүй багш бурханы таалал
Нигүүлсэнгүйн чандманын далайд мөнхөд оршин үйлдэж
Очир номын сахиустай нөхөрлөн заларсан үүгээр
Алины дотроо хүссэн тусыг айлтгасан цагт номын ёсоор бүтээн зохиов.

ОЧИРВААНИЙ ХУВИЛГААН ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ ЗАЛБИРАЛ ТАХИЛ ӨРГӨХ ЗАН ҮЙЛ

Намо гүрү бира вааяа

Үүн дор эзэн Чингис хаан дор залбирал тахил үйлдэхийг хүсэгч нэгэн бээр тахил балин тангарагийн эд нүдний гайхал тэргүүтэн ямар мэт хэрэгтэй эд нугуудыг бүрэн гүйцэд ер гол лугаа зохилдуулан бэлдээд адистидла Бодит ануу:

<u>Аяа цагийн эисийн галын</u> өмөг бадарсны голд
Ахуй их цусан далай тосон давалгаа эрчилсний төвд
Аймшигт арсланг эрдэнийн эмээл хазаар тэргүүтэн
Асар их үнэт эрдэнэсийн чимгээр чимэсний дээр
Цагаан өнгийн Хум үсэгнээс сарны гэрэл цацран
Чандын дайсан тотгорыг таслаж гурван ертөнцийг хурааж
Янагш хураагдан Хум үсгэнд огоот шингэх болсноор

Ялгуусан Чингис хаан гурван ертөнцийг эрхээр болгогчийн
Лагшингнйн өнгө нь цагаан буман сарны гэрлээр хүрээлсэн
Лавтай нэгэн нүүр хоёр мутарт гурван мэлмий хилэгнэн эргэлдсэн
Баруун мутартаа цагаан жадыг огторгуйн төвд далайсан
Басхүү зүүн мутар дахь тэвшний амсраас эрдэнэ бялхасныг
Зүрхэндээ барьснаар сайтар нирвааны үгээгүйг арилгагч
Цээжиндээ цагаан торгон өмсгөлийг элбэг дэлбэг асаасан
Доод биедээ таван өнгийн банзалигаан хормогч дор ч
Тодорхойяа индранила тэргүүтэн эрдэнийн чимэглэсэн
Үснирийн титэм сонорын чимэг хоолойн зүүлт мутар өлмийдөө

Үлэмж сайн эрдэнийн бугуйвчиг чандмань сугавчлуурыг унжуулсан

Үнэт манжлагат титэм гайхамшигтай есөн эрдэнэсийн

Үзэсгэлэнт оройг тэргүүндээ өмссөнөөр илэрхий жавхлантай

Эрдэнийн сөөхий гутлыг өмссөний гаван хоншоортын дээр

Эрхэмсэг хаан тэр цэнгэлийн дүр байдлаар ямбалж

Эргэн тойрон тэнгэр лус ягчис албин шулмас хийгээд

Эрхэт дагинас айсхит дээрэнгүйт найман аймаг тэргүүтэн

Тангарагтны далайн цэргийн чуулганаар хүрээлүүлсэн

Тансаг гурван орныг гурван очироор бэлгэдэх боллоо

Аяа номын төвийн их амгалангийн тийн цэнгэлээр

Алимад хувилгаан бүжиглэлийг зохиогч тэнгэрийн дээд хаан

Чингис хэмээгдэхийг буман нөхдийн чуулган сэлттэйгээр

Чанх өмнийн огторгуй дор айлтгал залан ирүүллээ

Хэмээн мэдэхүй зоригдол лугаа сэлтэйгээр зуун үсэгтийг
гурвантаа өгүүл тэндээс наманчлал нь

<u>Аяа хамаг ном</u> туурвилын хязгаар лугаа хагацсан боловч

Аюулт нисваанисын эрхээр гангараг харшилсан нугуудыг

Их хаан нөхөд сэлт дор айлтган наманчилваас

Илт уналт доройтлыг засаад хоцроолгуй шидийг хайрлагтун

Тэндээс хангалын эдүүдийг ер мэт адистэдлаа

Богд эзэн Чингис хааны сан.

Мөнх тэнгэрийн заяагаар

Ертөнцийн сахиус болсон

Суут богд Чингис хаан, дотоод нөхдийн хамтаар

Жаргалант Сухабадып орд харшаасаа

Заяат түшмэд ба нохор сэлт бүгдээрээ

Ямар бас алин энд оршсон тэнгэр лус

Ягч рагча газар усны эзэд, догшид бүгдээрээ

Үйлс хүслийг хангахаар залран соёрхоо.
Хэмжээлшгүй эрдэнээр чимсэн арслан ширээ
Найман дэлбээт лянхуат суудлын дээр
Төгс хүчит сахиус эзэн богд Чингис хаан
Хамаг нөхөд, дотоод түшмэд ба тэнгэр лус
Бүгдээрээ баясаад залран суун соёрхоо
Сэтгэл лүгээ зохилдох ариун тахил
Зуун амт бүрдсэн идээний дээж
Сүүний амт төгссөн рашааны шимээр
Суут богд Чингис хаан, нөхөр сэлтийг тахимуй
Бадрангуй галын цог машид бадарсан дөл
Бадрангуйн зул хийгээд зулын гэрлээр тахимуй
Зандан, гүгэл, арц, хүжисийн анхилуун үнэрээр
Сангийн их үлэмжит өнөөдөр тахимуй
Заа, Суут богд Чингис хаан нөхөд лүгээ нэгнээ
Бүгдээр ариусах тахилаан зоогло
Хамаг түйтгэр амирлахуйн шидийг өгөн соёрх
Эмгэг ад амирлахуйн шидийг өгөн соёрх
Буруу тэмцэл амирлахуйн шидийг өгөн соёрх
Буян хишиг дэлгэрэхүйн шидийг өгөн соёрх
Оюун билиг нэмүүлэхүйн шидийг өгөн соёрх
Омог хүчин бадрахуйн шидийг өгөн соёрх
Тэнгэрийн хааны зарлигаар эдийг барин тэтгэгч
Төгс хүчин үйлдэгч түргэн рид хувилгааны хүчнээр
Тэрс номт хаадын дайныг талхан товрог болгоод
Таван өнгө дөрвөн харийн улсаа товчлон
Найман түмэн дөрвөн мянган хаадын эрхэм болсон

Номын хүрдэн хаан мэ г их аугаа хүчнээр
Тэрс номт, догшин, тотгорлон хорлогчийг чадагч
Төгс хүчин сахиулсан таныг магтан мөргөмүй
Эзэн юугээн тахин магтан шүтсэний хүчээр,
Аяа мину нөхөд хийгээд эдлэл малыг арвитга
Урт насан амар жаргал эрхшээлийг бататга
Онц хүслийг бүтээхүйн үйлсүүдийг зохио
Заа, хүн хийгээд хүн бусын хорлолыг хариул
Цэрэг аян догитин тотгор хорлолыг хариул
Чуулганд хорлол хийгч өст дайныг хариул
Бурхан багшийн шажин лугаа харшлагч дайсныг
Бат очирт мэсээр нэвт нэвт мэслэ
Амин голын судлыг тас тас огтчин
Очир дарын шажиныг арван зүгт дэлгэрүүл
Тангараглан буцагсдыг хүлэн хүлэн эцүлгэ.

Богд Чингис эзний даллага оршвой.

Хум, төгс цогт Очирваань тодорхойяа
Хувилгаан амьтаны тусын тулд
Ертөнцийг тэтгэгч эзэн
Чингис хаан хэмээн алдаршсан
Тэнгэр хаан хатад нөхөд сэлт
Энд ирэн соёрх
Эрхэм тансаг Бор тохой оронд орш
Шажин хийгээд шажины богд ир
Сахигч дөрвөн зүйлсийн үйл бүтээгч

Хүчит номын хаан Увш Энд ирэн соёрх
Зээ, Мах цусан зоог хийгээд цай ба сархад
Ундаа тэргүүт Чакравардын зоог
Их хуримыг Чингис хаан
Танд өргөмүй
Очирдар Далай лам Наваанжамцийн гэгээн ба
Бус бас хувилгаан Саянжамц тэргүүтэн
Язгуурын үндсэн лам нарын зарлигийг
Алмайдаж давалгүй тангаргийг дуртган
Егүзөр бид нарын үйлсүүдийг зохио
Хүн эд малыг улам дэлгэрүүл
Ялангуяа үлэмж төгс их хөлгөний сүмийн зүг
Харьяат лам шавь хийдийн хэргийг мандуул
Аймаг хүн ач үрийг дэлгэрүүл
Хүн мал эмнүүлэхийн үйлсүүдийг зохио
Зээ. Лам ядам гурван чухаг
Дээдсийн адистэдийн их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишиг авмуй
Хурай. хурай. хурай
Дээд зүгийн тэнгэр нарын
Хотол төгссөн их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишигт авмуй
Хурай,хурай,хурай
Дунд зүгийн Чакравард хааны
Хаан язгуурын их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишигт авмуй
Хурай, хурай, хурай

Богд эзэн Чингис хааны

Хүрдэн эргүүлсэн их хишгийг

Энэ өдөр өлзий буян хишигт авмуй

Товчилруун сансар нирваан сайн

Дөрвөн чуулган бүхий их хишгийг

Энэ өдөр өлзий буян хишигт авмуй

Хурай, хурай, хурай

Лам бурхдын өлзий хутаг орш Ядам бурхдын өлзий хутаг орш

НАРО БАНЧЭН ХУТАГТ БЭЭР ТАХИЛГА ХИЙХ СҮСЭГТЭН ОЛОНД СОЖИН ХАЙРЛАХУЙ

Арван зүг дор оршисон Бурхан бодь садва бүгд дор бодь хутагтыг онохуй хүртэл би ямагт цаг бүхэнд алгасрал үгүй тахил өргөн надад дор шидэс бүтээлийг ханьцаш үгүй хайрлан соёрх.

Бүх амьтныг гэтэлгэх хүслээр бурхан ном хуврага, гурав дор Бодийн хутаг олохуй хүртэл Бат сэтгэлээр би бээр аврал одуулмой.

Ухаарч нинжин их сэтгэлээр

Ухрангуй шамдан амьтанд тусламой.

Бурханы оронд оршиж

Бүгдээрээ бодь сэтгэлийг үүсгэмой.

Бурхан ном хийгээд чугуулганы дээд дор бодийг хүртэл

би бээр итгэмой.

Бусад хийгээд өөрийн тусыг бүтээхийн тулд

би бээр бодийн сэтгэлийг үүсгэмой.

Арван зүг ямагтад оршсон.

Агуу бурхан бодьсадва заларсны дунд

Өөрөө бодьсадба болохын тухайд

Өнөөгөөс бодь сэтгэлийг үүсгэе

Сахил авах тайлбар сэлт

Эхлээд багшийн өмнө нигүүлсэнгүй сэтгэлээр биширч намайг тойроод бурхад бодьсадва хүрээлэн буй гэж бодоод гурав мөргөж, багшийн урьд сахил өгнө үү хэмээн мандал өргөсний сүүлээр би тэргүүт огторгуйн энтэй тэнцэхүй хамаг амьтны тусын тухайд бурханы хутаг олох болтугай түүний тухайд маргааш өглөө нар мандтал сахил авч ёсчилон сахих хэмээн бодоод

Арван зүгт оршигсон бүгд бурхад

Архад бодьсадва надад таалал соёрх

Ачит Ловон багш таалал соёрхоо

Тэр мэт урьдын ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн

Үнэхээр тугуулгасан Бурхан Дажан хэмээх адил, их заан, их ажил хийсэн үүрэг үүрсэн өөрийн тусыг сүүлд олоод орчлон бүгдийн үйлийг зогсоон, Үнэхээрийн зарлиг, сайтар тийн гэтэлгэхийг таалалдаан барин, сайтар гэтэлгэхийн энэрэнгүйн ухаан тэдгээр бээр хамаг амьтны хэрэгийн тухайд, туслахын тулд, гэтэлгэж үйлдэхийн тулд, зудгүй байхын тухайд, өвчингүй байхын тухайд Бодийн зүгийн номыг огоот төгсгөхийн тухайд, өвчингүй байхын тухайд Бодийн зүгийн номыг огоот төгсгөхийн тухайд, ханьцашгүй, үнэхээр төгссөн бодийг магадтай олохын тухайд сахил авч ёсчилон дагагч /Нэрээ оруулж унших/ бээр энэ цагаас эхлэн маргаашийн мандах наран хүртэл хамаг амьтаны хэргийн тухайд, тэдэнд тус хүргэхийн тухайд зовлонгоос гэтэлгэхийн тухайд, зуд турхангүй байхын тухайд өвчин хуучгүй байхын тухайд бодийн зүгийн номыг огоот дэлгэрүүлэхийн тухайд, ханьцашгүй бодийг магадтай олохын тухайд, сахилийг ёсчилон авч үйлдмой.

(3-н удаа унших)

Сүүлийн удаа уншиж дуусмагц өөрийн бие сэтгэлд сахил төрлөө гэж баясал бясалгаад, багшаас “Арга энэ болой” гэхэд сайн болой” гэж хариулж үүлдээд сахил төрүүлээд. Бодь сэтгэл төрсөн анхны санааг сайтар тодруулж эртний архад нар амь тасдахаас эхлэн арван 10 нүгэл тэргүүтнийг бие хэлний унал бүгдийг тэвчиж сэтгэлээрээ тэр бүгдээс буцсан ёсчилон би бээр тухайд нэг өдөр тэвчиж сургаалийг ёсчилон сахимой гэж санаандаа баттай бодоод:

Унших ануу.

Тэгээд амьтны амь тасдах үгүй Тэнэглэж хулгай хийх үгүй Худал үгийг машид тэвчиж Хуурмаг гэмийг санан гэмшиж

Архи сархадыг огоот тэвчиж

Алдаас өндөр суудалд суулгүй

Үдээс хойш хоол идэлгүй

Үнэр эрх гоёлыг болон

Үймүүлэх бүжиг шийг тэвчиж

Үнэхээр Архад дээдэсийн журмаар

Тэрчилэн олон нүглийг тэвчиж

Тэргүүн бодийг олох болтугай.

Орчлонгийн бүхий л зовлон

Оломгүй далайгаас гэтэлтүгэй

Тарина даган уншина.

УМ АМУГА ШИЛА САМВАР ВАРА ВАРА МАХА ШҮДЭ САДУ БАДМА” ВИ” ВҮ” ХИДА” ВҮЗА” ДАРА” САМАНДА, АВОЛОГО” ДЭ” ХУМ” ПАД СУУХА.

хэмээх Шагшаа бодийн тарни эгүүнийг багшийг даган 21 удаа уншсаны дараа

Сахилаар Шагшаа бодь гэм үгүй

Сайтар ариусан төгөлдөршиж

Омогийн сэтгэл үгүй болж

Огоот билиг баримад олтугай

Гурван удаа мөргөнө.

Тайлбар.

хэмээн ерөөл тавин нэг удаа багшийн өмнөөс аман авч шүтээний өмнө сахин омог юугаа рашаанаар угааж тангараг дамцагаа сахиж бурхан дор мөргөн тахиж итгэл одуулан шүтээнээ Аръяабал бурхан илт байна гэж бодоод бие хэл итгэлээрээ сүсэглэн гурав мөргөж анхны санаагаа ариун байлгаад

БАГШ БОЛГООН СОЁРХОО гэж шавь нар хэлэхэд ловон бээр АРГЫН ДЭЭД БОЛОЙ гэхэд САЙТАР САХИН ДАГАМОЙ гэж шавь нар хариулнаа.

Тэгээд амьтны амь тасдах үгүй

Тэнэглэж хулгай хийх үгүй

Худал үгийг машид тэвчиж

Хуурмаг гэмийг сана гэмшиж

Архи сархадыг огоот тэвчиж,

Алдаас өндөр суудалд суулгүй

Үдээс хойш хоол идэлгүй

Үнэрт тамхи гоёл чимэг

Үймүүлэх бүжиг шийг тэвчиж

Үнэн архад дээдсийн журмаар

Тэрчлэн олон нүглийг тэвчиж,

Тэргүүн бодийг олох болтугай

Орчлонгийн бүхий л зовлонгийн

Оломгүй далайгаас гэтэлтүгэй.

хэмээн 3 удаа уншиж дуусмагц сахил төрсөн гэж бодоод урьдын адил ерөөл магтаал үйлдэх нь тэгчин сожин буюу нэг өдрийн сахил мөн болой.

Зод буюу авидармын тайлбараас буяны үндэс нугуудыг ч сахиж сэргээж үйлдэх тухайд сожин буюу сахил хэмээнэ тиймийн тухай бурхан багш сожин олон удаа авсан байдаг.

Мөн буян багатайг арвидуулах хийгээд нүгэл гэмийг наманчилан чухалтай гэж 8-н санваарийн номонд зарлигласан буй заа.

Гармашадув- бээр 3-н сургааль болох шагшаабодь, бясалгал билгүүн 3н суурь үлэмжийн сургаалтай адил хэмээжээ.

Зод буюу авирмадаас- Шагшаа бодийн гишүүн, сэрэмжийн гишүүн, номхотгох гишүүн тэрчилэн 8н сахилийн үес мэт хорхойний амь тасдахаас эхлэн амьтан бүгдийн амь тасдах, бусдын өгөөгүй зүйлийг авахаас эхлээд бүх хулгай, ариун бус явдал, худал хэлэх зэрэг болон согтуурруулах ундаа архины язгуур бүгдийг тэвчих, гишүүн чухаг дэгээд гураваас бусад тохиолдолд бүжиг, дуу, хөгжим, урлах, тачаах, хүнээс онцгой гоёл чимэг зүүх, биендээ гаж үнэр түрхэх сүрчих гар хөл хүзүүндээчимэг зүүх зэрэг гоёлыг хорих, эрдэнийн чимэгт ширээнд тэр тусмаа дохойгоос өндөр суудалд суухгүй байх сахилын хугацаанд үдээс хойш сүү тараг мэт халбага тогтох болон будаа зэрэг ямар нэгэн идэх зүйлийг тэвчих ба цаг бусын хооллолт тэвчих эдгээр тэвчигдэхүүн анхны дөрөв, шагшаа бодийн 5-р сэрэмж, үлдсэн гурав нь номхотголийн гишүүнд хамрагдана. Найман сахилын үед бодь сэтгэл анхны санааг заавал хэрэгтэй гэдгийг анхны сахил буюу равжүнгийн сахил увашийн сахил нь 8-н

гишүүнийг ам авдаг сахидаг ч энэ үе дэх сожингийн сахил бодийн сэтгэл төрөх анхны санааг машид хэрэгтэй хэмээн хамаг амьтны тусын тулд гэж бодох нь хүч аньс ихтэй мөн түүнчилэн багшийн өмнө ам авч сахих нь машид тус эрдэм ихтэй гэж хэлдэг энгийн хүмүүс хот мандлын тахилыг адистэдлэж чадахгүй учир Би ямагт нэгэн эгшин бээр Аръябал бурханы лагшинг эрхшээж байна хэмээн бодож УМ БАДМАНДА ГЭРДЭ хум пад.

хэмээх тариныг өгүүлэхийн цагт өөрийн зүрхнээс хилинт тэнгэр (тову тэнгэр) тоолошгүй цацарч тахилын ойр орших түүтгэрийг далай цаад уруу хөөсөн гэж бясалгаад.

ДҮНШАГ БУЮУ УНАЛЫГ НАМИНЧЛАХУЙ

Хамаг амьтан цаг цагт цаглашгүй ачит лам багшдаа итгэмүү
Бурханд итгэм үү Дээдийн номд итгэм үү
Бурсан хуврагуудад итгэм үү
Их Багш ялж төгс нөгцсөн, түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр төгссөн, цогт ялгуулсан бурхан Шагжтүвийн
өлмийд мөргөм үү.
Түүнчлэн заларсан очирын зүрхээр сайтар эвдэгч танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эрднийн гэрэл цацруулагч танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан лусын эрхшээлт ялгуулсан танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан баатруудын өмөгт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан баясгалант цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан гал эрдэнэ танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эрдэнэ саран гэрэлт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан үзсээр их туст танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан саран эрдэнэт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан хиргүй тунгалаг танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогийг хайрлагч танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан асар ариун явдалт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан ариунаар өгөгч танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан усан тэнгэр танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан усан тэнгэрийн тэнгэр танаа мөргөм
Түүнчлэн заларсан сайн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт зандан танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан хязгааргүй жавхлант танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт гэрэлт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан гаслан үгүйн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан хурьцахуй үгүйн хөвүүн танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт цэцэгт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан ариун гэрлээр нэн цэнгэн илт мэдэгч
танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан лянхуан гэрлээр нэн цэнгэн илт мэдэгч
танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эдийн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан дурьдахуйн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт билэг найраг нь ихэд даяар алдаршсан

танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эрхт оройн ялсаны тэмдэг хаан
танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан сайтар дарагч цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан дайснаа машид ялсан танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан сайтар даран ажирсан цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эрдэнийн лянхуагаар сайтар дарагч
танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан дайснаа дарж үнэн төгссөн бурхан, эрдэнэ хийгээд лянхуан дээр сайтар саатан заларсан уулсын хаан
хэмээх алдарт танаа мөргөм үү
Тэдгээр бурхад тэргүүтэй 10 зүгийн ертөнцийн оронд түүнчлэн заларсан, дайснаа дарсан,үнэнхүү төгссөн, ялж төгс гэтэлсэн бурхан аль төдий заларсан бөгөөд ахуй залран буй ялж төгс нөгцсөн тэдгээр бурхад намайг таалалдаа багтаан соёрх оо.
Миний энэ нас хийгээд эхлэлийн хязгаар үгүй төрлөөс
Энэ орчлонд орчин төөрсөн төрөл тутамдаа
Элдэв хилэнцэт үйл үйлдсэн хийгээд
Элдэвлэн бусдыг хилэнцэт үйл үйлдэхэд хүргэсэн
Эл бас хилэнцэт үйлэнд даган баяссан буюу
Тахил шүтээний эд буюу
Түүнчлэн бурсан хуврагын эд бөгөөд
Арван зүгийн бурсан хуврагуудын
Алив эдэд шунан булаах хийгээд
Аль бусдаар булаалган үйлдэх ба
Аль хэн нэгэн булаан үйлдэхүйд даган баяссан
Завсаргүй таван нүглийн үйл үйлдсэн буюу
Зориуд бусдыг үйлдэхэд хүргэсэн хийгээд
Заримууд үйлдэн байхуйд даган баяссан
Арван хар нүглийн мөрд чанх орсон хийгээд
Арван хар нүглийн мөрд бусдыг оруулсан ба
Аль бусад орж байхуйд даган баяссан юм уу
Аль нэг хилэнцэт үйлийн түйтгэрээр
Ашид миний сэтгэл тамд очих буюу
Адгуусны төрөлд одох эсвэл
Ашид өлсөн цангах бирдийн орноо төрөх
Бурхан заларч номоо номлоогүй
Бурангуй харанхуй буйд оронд төрөх буюу

Тэрс номлолт лалын орноо төрөх
Урт наст тэнгэрийн орноо төрөх ба
Улмаар эрхтэн дутуу болон төрөх
Угаас буруу үзлийг баримтлагч болох
Бурхан заларч номоо номлохуйд
Баясах сэтгэл үл төрсөн гэх мэт
Барагдашгүй муу үйлийн түйтгэр буй тэдгээр бүхнээ
Билгэ билгүүнт бурхан Билгэ билгүүний мэлмийн Их эрхэт
Үнэн шалгуурын мөн чанарт
Үнэн болгоолтоор болгоогч тэдгээрийн мэлмийн өмнө
Гэмшин наминчилмуй Арилган наминчилмуй
Үл нуух болой. Үл хаацайлах болой
Хойшид ч таслан боомтильё.
Ялж төгс нөгцсөн бурхан бүгд намайг таалалдаа багтаан соёрх
Миний энэ төрөл хийгээд
Магад эхлэлийн хязгаар үгүй цагаас
Мунхран мунхран орчлонд орчин орчин
Төрөл бүхэндээ бусдад ядаж түдэвч
Адгуусны оронд төрсөн амьтаст
Өчүүхэн төдий идээ хоол өгсөн буяны ёзоор юу буй
Өөрөө би Шагшаабадыг сахисны буяны ёзоор юу буй
Үнэн ариун явдал мөрөөр явсан буяны ёзоор юу буй
Үнэнхүү гэтлэхүйн мөрд бусдыг оруулан
Үйл сайны үрийг боловсрохуйд найралдсаны буяны ёзоор юу буй
Өөртөө дээд бодийн сэтгэлийн үүсгэсэн буяны ёзоор юу буй
Өнөд ханьцашгүй билгэ билгүүний буяны ёзоор юу буй
тэр бүхнээ нэгнээ хураан цогцлуулж Ханьцаш үгүй Үнэлш үгүй
Дээдийн ч дээд Багшийн ч багшид Тэр бүхэлд зориулан басхүү
Тэнцэшгүй үнэн төгс бодь хутгийг олохын тулд зориулъя.
Ямар мэт урьд цагт заларсан бурхад төгс зориулсан хийгээд
Ямар мэт ирээдүйд залрах бурхад төгс зориулах хийгээд
Ямар мэт өдгөө залран буй ялж төгс нөгцсөн бурхад
Ямар мэт төгс зориулсан тэр мэт
Би бээр өдгөө зориулъя
Хилэнц унал бүгдийг тус тусад нь наминчилъя
Хэн буян үйлдэнэ тэр бүхэнд даган баясья
Хамаг Бурхадад номоо номлохыг сануулан дуртгая
Хэзээд соёрхол талбия

Ханьцашгүй дээд билгэ билгүүнийг би олох болтугай
Хүмүүний дээд одоо залран буй ялгуулсан бурхад аль
Хэдүй заларсан хийгээд ирээдүйд залрах
Сайшаалт эрдэмт хязгааргүй далай мэт бүхэнд
Сайтар алга найралдуулан залбираад авралыг ихэд айлтгам уу би
Ум сарва дата гада идам гүрү радна манда-ла хам-нир-яа да-яа-ми

ЖИВШАГ БУЮУ ЕР УНАЛЫГ НАМИНЧЛАХУЙ

Ү ха-лаг. Очир баригч их багш тэргүүтэй 10 зүгт залран буй хамаг бурхан, бодьсадва нар хийгээд ариун аяга тахимлэг (гэлэн) нар минь намайг таалалдаа багтаан соёрх оо! хэмээх нэрт миний эхлэл үгүй цагаас төрөл тутамдаа өдгөөг хүртэл хүсэл шунал уур хилэн мунхагийн эрхээр бие хэл сэтгэлиийн үүднээс 10-н хар хилэнц нүгэл юуг үйлдсэн хийгээд завсаргүй 5-н нүгэл үйлдсэн хийгээд завсаргүй 5-н нүглийн шадар 5-н нүглийг үйлдсэн хийгээд

Ангид гэтэлгэгч санваартай харшилсан

Бодьсадвын сурталтай харшилсан

Тарнийн тангарагтай харшилсан

Эцэг эхээ үл хүндэтгэсэн

Орон хийдийн хамба багшийг үл хүндэтгэсэн

Ариун явдалт буяны садан юуг үл хүндэтгэсэн

Чухаг дээд гуравт хорлол үйлдсэн

Дээдийн номыг тэвчсэн

Хутагтан хуврагуудыг басамжилан доромжилсон

Амьтанд хорлол үйлдсэн тэргүүтний

Хилэнц нүглийн үйлийн чуулган хэдийн чинээ үйлдсэн хийгээд бусдыг үйлдэхэд хүргэсэн, бусдууд үйлдэхүйд даган баяссан тэргүүтэй Товчилбоос илт өндөр (тэнгэр ба хүмүүний төрөл) хийгээд тонилохуйн (орчлонгоос оюун санаагаараа гэтлэх) тотгор болсон орчлонгийн төрөл хийгээд муу заяаны шалтгаан болсон гэм уналын цогц хэдий чинээлэг би үйлдсэн тэр бүхнээ Очирт их багш тэргүүтэй 10 зүгт залран буй бурхан, бодьсадва нар хийгээд ариун хуврагуудын мэлмийн өмнө гэмшин наминчилъя.

Үл нуух болой. Арилган наминчилъя.

Хойшид ч таслан боомтилъё.

Гэмшин наминчилж амгалант оронд зорчоод үл гэмшсэн, үл наминчилсан нь үгүй болой.

Арван зүгийн бурхад бодьсадба

Ачит, Барэдига, сурч боловсорсон

Амьтан бүгдийн буян аль бээрч

Аминчилан би бээр даган баясаму

Орчлонд хаана ч зул болон бадарч

Оройноос бурхан болохоор яаралгүй

Номой дорой над мэт бүгдэд

Номын хүрдийг зогсолгүй эргүүлэн
Гаслангаас гэтэлгэх замыг заан
Гагцхүү хамаг амьтны амгалангийн тулд
Галав олон оронд тоосны тоотой адил
Гар хумхилгүй залбирч үйлдэе би
Мөргөн тахин номончилан
Мөнхүү даган дурдан баясан залбирснаар
Өчүүхэнч төдий буян юу хурааснаа
Өрөвч энэрэлээр бодь дор зориулмой

ЯМАНДАГ НЭГ БААТАРТ

Би ямагт нэгэн агшин бээр цогт очирт ямандаг нэг жигүүрт, хоёр мутарт дэгүг болон тодба барьсан бурхан болон хувирмой.

Чодбо жинлов

Нанчод жинлав

Умаа савава шүдо сарва дарма савава шүдо хум хоосон чанарын агаараас элдэв цэцэг, нар, саран олбог дээр хум-үсгээс хувилсан очир, хум-үсгийн мөн чанарт огоот хувирч би ямагт цагт ямандаг бурхан хар хөх дүртэй, есөн нигүүр, гучин дөрвөн мутар, арван зургаан бойвгоо баруунаа хумж зүүнээ жийсэн хүч төгөлдөр оршин гурван ертөнцийг ч болгоочих хүчтэй ха ха хэмээн хэлээ сунгаж, соёоогоо ярзайлган уурт дүрээр байхын сацуу хөмсөг хийгээд мэлмий нь эвдрэх галавын цаг мэт бадарч, үс нь дээшээ босож, орчлон хийгээд орчлонгоос хагацсан тэнгэр нугуудад занасан дэгзүв хэмээх мутарлагтай, аймшигтай нугууд ч айж үйлдэхээр «пэм» хэмээх их дууг луу мэт дурсгаж тэрс хүмүүний мах цус, чөмөг, өөх зооглож аймшигт гатсан таван гавалаар тодбо хийсэн нойтон тавин толгойгоор тодбоны чимэг хийсэн хар могойгоор тахих тухайд хүний ясан хорол хийгээд ээмэг тэргүүтэн ясан чимгээр чимсэн, нүцгэн дүртэй хөмсөг үс тэргүүтэн нь галав юүлэхийн цаг мэт галаар бадарсан гол нигуур нь үхэр хоншоорт маш урт хурц эвэртэй хоёр эвэрийн дээдэх төвийн улаан нигуур машид аймшигтай цус үсчүүлсэн түүний дээр шар манзшир өчүүхэн хилинтэй залуугийн цогоор чимсэн оройн үс таван салаатай, эвэрийн үндсэн баруун талын нигуур анхных хөх, түүний баруун нигуур улаан, зүүн нигуур шар, эвэрийн үндсэн зүүн талын анхны нигуур цагаан түүний баруун нь хар хөх, түүний зүүн нигуур хар нигуур бүр машид хилинтэй есөн нигуур бүгд гурав гурван мэлмийтэй баруун зүүн мутрын анхны хоёр нь зааны арьс нойтон толгой гар болон хөлийн арьс зүүнээс нь дээш барьсан үлдсэн анхны баруунаар дэгүг хоёрдохоор биди бало, гурваар мэс, дөрвөөр тонгорог, таваар ганаяа, зургаа даста, долоогоор дун, наймаар сум, есөөр дэгээ, арваар юүгдо, арван нэгээр хадамгаа, арван хоёроор хорол, арван гурваар таван үзүүрт очир, арван дөрвөөр очирт алх, арван таваар сэлэм, арван зургаагаар урт дамар барьж үлдсэн зүүн гарын анхныхаар цустай

тодбо, хоёроор асурын толгой, гурваар нүва, дөрвөөр чөмөг, таваар цалам, зургаагаар нум, долоогоор гэдэс, наймаар очир, есөөр гар, арваар дүртодын даавуу арван нэгээр төрөлхтөн арван хоёроор мятав, арван гурваар тодбо, арван дөрвөөр дэгзүв мутарлаг, арван таваар гурван үзүүрт зэвсэг, арван зургаагаар салхин уут барьсан баруун хөлийн анхныхаар хүн, хоёрдохоор махи, гуравдугаараар үхэр, дөрвөөр илжиг, таваар тэмээ, зургаагаар нохой, долоогоор хонь, наймаар үнэг, зүүн хөлийн анхныхаар тас, хоёроор шар шувуу, гурваар хэрээ, дөрвөөр нөзо, таваар шаазгай, зургаа их шувуу, долоогоор чимжа, наймаар шад нугуудыг дарсан гишгэлттэй.

Асар хийгээд хүчит гавжүг зургаан хоншоор нар сарыг өлмийдөө хураасан түүнээс гал бадарч орчлонгийн төвд оршино хэмээн бодоод Би ямагт тангарагтан бодисадбын таалалын саран дэвсгэр дээр билиг билгүүний бодисадва залуу манзушир шар лагшинтай ялимгүй хилинт баруун мутраар сэлэм далайсан зүүнээр судар тэвэрсэн хоёр өлмийгөөр завилсан гучин хоёр булиг, наян найраг төгөлдөр чимсэн үсээ тав салаалан шуусан чимэг бүрээр чимэглэсэн түүний таалалын «а» үсэгэс хувирсан нарны хот мандалын төвд, бясалгаач бодисадба хум - үсгээс хөх гэрэл таван зүгт цацарч өөрийн хоёр мэлмийд «чим» үсэг, магнайд «гам» үсэг хүйсэнд «сам» үсэг, оройд «ам» үсэг, хоолойд «а» үсэг таалалд «хум» үсгийн мөн чанартай болмой. Таалалын «хум» үсгээс гэрэл цацарч мөн чанарын орноос бясалгасантай адил цогт ямандаг бурхан өмнийн огторгуйд залармой. За-хум-бам-хо тангарагтан хоёр үгүй нэгдмой.

Дахин таалалын «хум» үсгээс гэрэл цацарч авшигийн тэнгэр нугуудыг залмой. Тэдгээр нь илт авшиг хайрлан соёрхоо. хэмээн залбирснаар авшигийн тэнгэр авшиг хайрлаж мижидва бурхны язгуурт хувирмой.

Умаа-ямандагаа-сава-рэ-ба-ра. Аргам, бадээж гондэ бүсви, дүйви, нэвдээ шавдаа брайдийнзаа хум суха.

Нанчод: Ума-ямандага хум пад умаа хум.

Магтаал нь:

Дүрсийн дээд эзэн их

Баатрын дээд байдалтай

Номхотгохуй бэрхийг номхотгогч

Очирт ямандагийг магтан мөргөе.

Тарни таалах нь:

Өөрийн тааллын бясалгаач бодисадбааг тойрон тарнийн эрхэн эргэлдэн гэрэл цацрааж амьтаны тус хийгээд бурхад бодисадба нарын адистэд бүгдийг хураан тарнийн үсгэнд шингээмой.

1. **Ума-ара-база-надэ**
2. **Ума-ямаа раза - саду мэ ями дүрү на-ёдояа. Ёдоно ягча -ягча- яца- нэра маяа - хум под**
3. **Ума-христэ бидида - нана хум пад**
4. **Ямандага хум пад - базарсадын аг унших**

Балин өргөх ануу:

Өөрийн тааллын хун үсгээс гэрэл цацарч цогт ямандаг бурхан өмнийн огторгуйд урин залмой хэлнээс гэрэл цацарч бүх балин шимийн амьтан бүгдийг золин дайлмой

ума-ямандага-эдам-балиндаа ха-ха-ха-хэ-ха-хэ (7 удаа уншина)

Ума - ямандагаа аргам

Ума - ямандагаа бадээм

Ума - ямандагаа гандэ

Ума - ямандагаа бүсви

Ума - ямандагаа дүйви

Ума - ямандагаа алого нэвдэ

Ума - ямандагаа шавда

Ума - ямандагаа хум суха

Нанчод:

Ума - ямандагаа хум пад - умаа хум

базарсамбадуу - (уншина)

1. Мартаад огоот мэдээгүй
Уншаад хүч хүрээгүй
Тэр мэт явдлуудыг минь
Тэгүүнчлэн өршөөж болгооно уу.
2. Илүүдүүлсэн болон тасалсан
Чогийнаа данг доройтуулсан
Миний мартсан бүгдийг
Магад өршөөн соёрхоно уу
3. Ариун сэтгэлээр ёсчлон шамдаг
Хийсэн буянаар амьтан нугууд
Төрсөн болон төрөл авахдаа
Манзуширтай хагацалгүй орштугай.

БОГД ОЧИРВААНЬ ХАЙРХАНЫ ТАХИЛГЫН ЗАН ҮЙЛ

1. Онодог буюу үүсгэл

Ума савава шөдө савадарма савава шөдө хум

Хоосон чанарын агаараас өөрийн өмнөх огторгуй

Бам үсгээс цацран гарсан элдэв лянхцэцэгийн чуулган жигдэрсний төвийн цоморлигоос хүйсэн дээр

Рам үсгээс цацарсан нарны хот мандал машид гэрэлтэн гэгээрэн дэлгэрсний дээр Хөх хун үсэгнээс төгс гүйцэд хувиран хөх таван үзүүрт очирын төвд хун үсгээс гэрэлтэн гэрэл цацарч 10 зүгт түгээд хамаг амьтны өвчин ад хилэнц бүгдийг арилгаад бурхан бодьсадва нарт баясуулахын тахил өргөмой.

Тэгүнбээр хүч төгөлдөр адис жанлав бүгдийг өөрийн орон дор хурааж очирт хун үсэг сэлт огоот уусан хувирч ялж төгс нөгцөгсөн нууцын эзэн цогт Очирваань бурхан хөхөмдөг лагшинтай Индранилийн эрдмийн уул буман нарны тунгалаг гэрэл туссан мэт машид үзэсгэлэн төгс сүр зальтай.

Нигуур нь машид хилэнт бадарсан дөрвөн хурц соёо ярзайсны завсар хэл нь машид хөдөлсөн хум пад хэмээх дуу нь луу мэт сүржигнэн дугарч улаанаар эргэлдсэн 3 мэлмий нь оч мэт цахилж хилэнт дүрийг эрхшээгсэн хөмсөг, сахал, үс шанхан цагийн эцэс гал мэт улаанаар бадарч баруун мутартаа занах дэгзэв хэмээх мутарлах сэлтээр таван үзүүрт очир барин огторгуйд далайж бүхий шуламс тотгорыг егүүтгэсэн хийгээд зүүн мутараараа мунхаг нугууд руу дэгзэв буюу занахуйн мутарлага элдэв эрдэнээр бүтээсэн титэм ээмэг бугуйвч ээмэг чихний чимэг бугуйвч хөл гарны чимэг тэргүүт унжлагаар чимэглэсэн нь дөрвөн язгуурын лусын чимгээс илүү дээд лагшин нь хөх баринтагтай, доод лагшин нь барын арьсан хормогчтой догшин дүрийн сүр хүч бүгдийг гүйцэд дүүргэсэн. Лагшингаас мэндэлсэн бэлэг бэлгийн оч машид бадарсны төвд баруун бойвгоо хумисан зүүнээ жийснээр буруу удирдагч омогт найман аймгийг гэсгээхийн ёсоор оршсоны дээр үндэс дамжуулагч багш хийгээд түүнийг тойрон ядам бурхан бодисадва баатар дагинас номыг тэтгэгч сахиусын чуулган хүрээлсэн хийгээд өмнө нь зарилгийг магтагч их хаан Намсрай бурхан нөхөр сэлтийн хамт

оршсоны эрхэм нөхөр бүгдийн оройд лагшин доржийн мөн чанарт цагаан УМ үсэг хоолойд зарлигт доржийн мөн чанарт улаан А үсэг зүрхэнд тагаалалдоржийн мөн чанарт хөх хун үсгээр тодрон хувирч би хийгээд тангарагтаны хөх хун үсгийн гэрэл гох дэгээ мэт ягчисийн дээд эрхэм ороноос ялж төгс нөгцөгсөн нууцын эзэн цогт очирваань бурхан багш ядам чухаг тэгээд 3 бээр хүрээлүүлэн залган соёрхоо.

2. Жандин буюу заллага

ЖИ.

Уужим замбуулангийн хойдын хойд зүгт

Ургах нар мэт алтан долоон уулын төв

Эрдэнийн сүмбэр уул давхарласны голд

Эзэгнэж нууцын тарнийг баригч

Эртний араш бүтээл бүх орны

Эх хүмүүн тэнгэрт хүслийн эрдэм

Гадаад дотоод нууцын тахил еээр

Гагцхүү хотолчуулган есөн хүслийг хангая

Нууц тарний дуу дуурсгасан орон

Нийт орны дээд ягчисийн төвд

Бэлэг бэлгийн таван мөн чанарт

Бүхий л эрднийн орд харш эхийн

Арслант ширээ лянх нар саран дээр

Ачит бурхан гурван цаг бүгдийн

Лагшин хийгээд шашиныг сахигчийн эрхэм

Лавт эрхэт сүрт догшиноор оршимуй

Нөхөр та нарт залбирах нь

Нэгийг ч марталгүй урьдийн тангаргаа

Цэвүүн цагт шашинаа хамгаалж

Цэцэн хөвүүн шиг шашинаа тэтгэ

Бясалгал бээр манай өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Бүхий л харшлах шалтгаан барцадыг арилгаад

Хүчит эрхэт дэлгэрэх амирлахын

Хүсэл бүгдийг сэлтгэлчилэн бүтээлгэхээр

Сүжиг бишрэлээр урин залнам

Сэтгэл энрэхүйн лагшинг бүтээж

Тагаалал энэрэлийн голд оршин

Торолтгүй энэ оронд залран соёрхоно

Хум

Онцгой багш ядам бурхад Очирваань бурхан тэнгэр сэлт Дагинас хамгаалагч сахиусын чуулган Даган энэ оронд залран соёрох

УМА ГҮРҮ САРВА БУДА БОДИ САДУ БАЗАРВААНИ ДАГИЙНИЙ САБА РЭ БАРА БАЗАР САМААЯА ЗААН ЗААН ЗАА ХУМ БАМ ХО хэмээн тарниар урин залаад дахин тагааллын хум үсэгнээс гэрэл цацарч авшигийн тэнгэр нугуудыг урин залагдсан тэнгэр бээр энд илд авшиг өгүүлэн соёрох хэмээн залбирваас тэдгээр нугууд УМА САРВААН ТАТА ГАДА АВЭХИ ГАДА САМАЯА ШИРИ ААХУМ хэмээн авшиг хайрлаж Мэжидваа бурхан титэмээр чимэглэсэн дор хувирмой.

Хум

Бурууд дагуулагч гурван ад давхарласан суурин дээр

Буман эрдэнээр бүтээсэн арслант ширээ засч

Бадам цэцэг нар сар бадарсныг давхарлан олбоглож

Бат сууринд заларч гэрэл цацраан соёрх

Алим бээр их ачаар амгалангийн орныг

Агшин төдийд сэтгэлдээ ургуулан бүтээгч

Ачит эрдэнийн их багш мэтийн

Алтан очир баригчийн өлмийд сөгдмүй

Хүч ихт хатуу догшин ч

Хаан бээр буяны язгууртан

Номхоруулахуйяа бэрхийг номхотгогч

Номын очир баригч доор мөрөгмүй

Ягчисийн эрхэм дээд орноос

Ямагт нууц тарнийг эрхшээхийн эзэн

Буруу бүгдийн чуулганыг номхотгон зохиогч

Бурхан очирваань танд мөргөмүй

Тахил өргөх ануй:

Уужим орны тэнгэрийн зайгаа

Увдислан өргөх тахил юүгээ

Бидний бишрэл сүжгээр бэлтгэснийг

Бурхан очирваань нөхөрсэлтэд өргөмүй

УМА ГҮРҮ САРВААН БУДА БОДИ САДУ БАЗАРВААНЫ ДАГИЙНИЙ САРВА ДАРМА БАЛА САВАРИБАРА АРГАМ БРАДИЗА СУХА

- БААДИН БРАДИЗА СУХА
- БҮСВИ БРАДИЗА СУХА
- ДҮЙВИ БРАДИЗА СУХА
- АЛОГИ БРАДИЗА СУХА
- ГАНДИ БРАДИЗА СУХА
- НЕВДИ БРАДИЗА СУХА
- ШАВДА БРАДИЗА СУХА

Хүслийн таван тахил өргөхүй.

Уужим орны тэнгэрийн зайгаа

Увдислан өргөх тахил юүгээ

Бидний бишрэл сүжгээр бэлтгэснийг

Бурхан очирваань нөхөрсэлтэд өргөмүй

УМА ГҮРҮ САРВААН БУДА БОДИ САДУ БАЗАРВААНЫ ДАГИЙНИЙ САРВА ДАРМА БАЛА САВАРИБАРА - РҮБА БРАДИЗА СУХА

- ШАВДА БРАДИЗА СУХА
- ГАНДИ БРАДИЗА СУХА
- РАСА БРАДИЗА СУХА
- ВАРША БРАДИЗА СУХА

Нанчид өргөхүй буюу дотоодын өргөлөг.

Ум арван зүгийн гурван цагийн хамаг тэвүүнчилэн эрэгсэдийн лагшин зарлиг тагаалал эрдэм үйлс бүгдийг нэг хураасан мөн чанарт номын зохицос 84мянга гарахын орон хутагт хуварга бүгдийн ачит язгуурын багш эх эрдэнийн нягуурт өргөмой. умаахум. Дамжлагын багш дээд нугуудад өргөмой умаахум. Ум базарвааны хум пад умаахум. Дамжлага дөрвөн аймаг их лугаа шүтэгдсэн ядам

мандалын тэнгэрийн чуулган нөхөр лугаа сэлт нугуудад өргөмой умаахум. Ум би шарааны умаахум. Урьд бурхантай уулзаад дээдийн номыг сонссон хутагт хуваргуудад шүтэгч номын сахиус хүчит цог заль төгс нугуудад өргөмой умаахум. Баатар налжирваань нугуудад өргөмой умаахум. Орны тэнгэр савдаг газрын эзэн зочид сэлт нугуудад өргөмой умаа хум.

Хум хоосон чанарын араншинт тахилын зай

Хүний амжиргааг цувиралтгүй болгох амгалангийн сан

Хязгааргүй орны тэр ямагт байх нугуудыг

Хичээнгүй сүсгийн сэтгэлээр би өргөнөм.

Мунхагаар тачаагдсан тасрашгүй хилэнг

Муучлалгүй авсан бие хэл сэтгэл бээр

Муу явдлыг хэдий чинээ үйлдсэн бүгдээ

Мугуйт үзсэн сэтгэлээр тус тус наманчилмой.

Бодисадва шарвагаан брадига нар

Бүхий л амьтны сайн явдлын чуулган

Хоосон бүгдийг хоцроолгүй дүүргэх санг олсонд

Хотол сэтгэлээр даган баясана бид

Бодь модны дэргэд бясалган номын рашаан олж

Бүхий л амьтаныг хол ойр гэлгүй тэгш бээр

Хүслийн рашааны баясгалант номыг хайрлаж

Ханьцашгүй номын хүрдийг эргүүлэхүй дор айлтагамуй.

Дэлхийн амьтны гэрэлтүүлэгч зулын дээд

Тэрчлэн гаслан бүгдээс хагацаагч таалалтай

Амьтны буяны орныг уужим болгож

Адаг орчлонг дуустал залархыг залбирнам

Тэр мэт миний тэргүүлэшгүйгээс хураасан

Тэр өчүүхэн буяны ёзоорнууд

Тэсэхүйеэ бэрх зовлонт амьтныг

Тэнцэшгүй бодит орохын хөрөнгө болход зориулнам

Хураангуй мандал.

Газар дэлхийг анхилам хүжсээр сүрчин цэцэг дэлгээд

Сүмбэр уул, дөрвөн тив, нар сараар чимэглэсэн үүнийг

Гэтэлгэгч бурханы гайхамшигт орноо зоригдон өргөснөөр

Сац амьтан бүхэн арилсан орноо эдлэхүй болтугай.

Умаа сарваан дата гада раднаа мандала хам ниряа даряами. Доржсимба бурханы бясалгал

Өөрийн тагааллын хум үсгээс гэрэл цацарч ялж төгс нөгцөгсөн Доржсэн бурхан дагинасын хамт урин заларч өмнийн огторгуй дор оршин хувирмой.

Ум базар саду самаяа ману балая базар саду дэн эйва дэста дэрда мива судахи, мива сухи мива анурагда сарваан сэдэ миваряцима сарва гарма сүзэми зэндин шри гүрү ха ха ха хо сарваан дата года базар мами мунза базар маха самая садуун а хум.

Наминчилгаа.

Хум

Багш ядам ялж төгссөн нууцын эзэн

Баатар сандагдорж нөхөр сэлт надад дор таалан соёрх

Тэргүүлэшгүй цагаас аваад эцэс өнөөдөр хүртэл

Тэнэглэл бээр нүгэл завсаргүй тав тэргүүтнийг

Хичнээн үйлдэж, үйлдэхэд оруулж даган баяссан

Хор адыг гэмшиж бурхад нөхөр сэлтийн

Ямагт өмнө наминчлан хойшид хориод

Ялангуяа дээд тэнгэр очирваань бурханы

Лагшин зарлиг тааллын тангарагаас

Лавтай харшлах юу үйлдсэн бүгдээ наминчилан

Наминчилахын орон доор үйлдэх тэргүүтнээр

Наминчиллын мөн чанарын тусгалаас хагацаж тэгшид оршуулмой

ТАГААЛАЛЫГ ХАНГАХУЙ АНУЙ БУЮУ ГАНС:

Хум

1. Амгалан хоосон огторгуйн уужим мандалаас

Аливаа тахилын үйл дэлгэрээд

Очирваань бурхан тэнгэрийн чуулган

Олны мэлмийд үзэгдэн хувиртугай

2. Эрдэнээр бүтсэн уужим саванд

Энгүй эргэлдэх рашаан далай

Үзэсгэлэнт цэцэг урган дэлгэрч

Үнэрт хүжис үүл мэт жигдэрээд

Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг

Онцгой баясалаар сэтгэл ханаснаас

Эвдрэх барцад бүгд буцаад

Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд

Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла

Зул өргөхүй:

3. Өөдрөг үнэр далай мэт ханхалж

Амтат идээ сүмбэр уул мэт овоолж

Аялгуут хөгжмийн дуу дуурсгасныг

Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг

Онцгой баяслаар сэтгэл ханаснаас

Эвдрэх барцад бүгд буцаад

Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд

Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла

Морь сарлаг хайнаг хонь нохой тэргүүтнийг өргөхүй:

4. Сэвжид хийморийн морь салхи шиг давхиж
Сүрлэг эвэрт сарлаг хайнаг сэжилж
Хар халзан хонь майлан тургиж
Хар нохой баавгай мэт цойлон давхисныг өргөе
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг
Онцгой баяслаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд
Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла
Гарьд бар чоно арслан өргөхүй:
5. Харьхарах дуут арслан бар чоно тэргүүт
Харах сонсох үнэр амтлахын цогийг барьсаныг
Хүслийн эрдэм тавын чуулганыг өргөе
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг
Онцгой баяслаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд
Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла.
Дөрвөн тив наран саран чимэг өргөхүй.
6. Сүмбэр уул дөрвөн тив нар сар сэлт
Шүхэр хийгээд дувааз лавир тэргүүт
Сайн хумх сэтгэл хэмжээлэшгүй хийгээд
Сайтар гурван үүд лугаа нууцын шүтээн өргөе
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг
Онцгой баяслаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд

Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла.

Хөө хуяг сэлэм өргөхүй:

7. Орон бүгдийг тийн ялагч
Онцгой хатуу очирт хуяг
Очироор бадарсан сэлэм тэргүүт
Олон дайсныг дарагч зэвсгийн чуулганыг өргөе
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг
Онцгой баясалаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд
Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла

Чимэг баримтаг өргөхүй:

8. Эрдэнээр бүтсэн олон чимэг
Эрээн могойн чуулган номхон лус хийгээд
Тэнгэрийн зайт хөх торгон баринтаг
Тэгээд барын арьсан хормогч тэргүүтнийг өргөе
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг
Онцгой баясалаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд
Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла

Балин жансаг өргөхүй:

9. Ариун рашааны адис тэдээр
Агуй уул мэт балин нь сүндэрлэж
Гадаад дотоод дээдийн зай хэрэглэгдэхүүн бүгдийг
Газраас сансарт дүүртэл дүүргэж өргөе.
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг

Онцгой баясалаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд
Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла

Төрийн долоон эрдэнэ өргөхүй:

10. Төрт ёсны долоон эрдэнэ хийгээд
Төмөр гох зул тав тэргүүтнийг
Ялган аривлан аривтгасан тахилыг
Яндашгүй далайн давалгаа мэт өргөе
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг
Онцгой баясалаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд
Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла
11. Номхорхуйяа бэрхийг номхоруулахын тулд
Нигуур лагшин хилэнт дүрийг барьсан ч
Машид амирлангуй номын лагшины агаараас
Магад хөдлөхгүй шүтээний дээд үүнийг
Очирваань нөхөр сэлтийн таалал баясаг
Онцгой баясалаар сэтгэл ханаснаас
Эвдрэх барцад бүгд буцаад
Эвлэрэх сэтгэл бүгд бүтээд
Энгүй дээдийн шидэс бүтээлийг хайрла

Хум. Буцаалга ануй:

Эрхэм багш ядам сахиусны чуулган нугуудын
Эртний айлдсан тангаргаа марталгүй

Налжир шавь бүхнийг эндүүрэлгүй
Нийтийг авран эвийг бүтээхийн цаг дор буулга
/3 удаа унших/

Хум.

Нууцын эзэн тэнгэрийн чуулганы
Нэжгээд өргөсөн тахил балины далайг таалаад
Налжир өглөгийн эзэд нөхөр сэлтэд
Наад цаад муу санаа саадыг буцаатугай.
Тотгорын язгуурт наян мянгыг буцаатугай
Адын язгуурт гурван зуун жарыг буцаатугай
Өвчний язгуурт дөрвөн зуун дөрөвийг буцаатугай
Халдварт гурван зуун жарыг буцаатугай
Нялхасын арван таван адыг буцаатугай
Муу заяаны наян дөрвөн адыг буцаатугай
Эрлэгийн хүрдийг эргүүлснийг буцаатугай
Шулмасын ад тавьсаныг буцаатугай
Чөтгөрийн цалам шидсэнийг буцаатугай
Идээний шимийг ад хорлосныг буцаатугай
Босоо ороолонг буцаатугай
Жил сар өдөр цагийн тотгорыг буцаатугай
Муу зүүд зүүдэлснийг буцаатугай
Хашлага шалтгаан барцад бүгдийг буцаатугай
Буцааснаар бүхий сайн үйл цагтаа буутугай
Шидэс бүтээл оршоох ануй

Хум

Зохилдохуй үйл бүгдийг хоцроолгүй
Зөв цагт над дор хайлан соёрх

Шашин эдлэл нөхөр сэлтийг
Сахиуслан хамгаалж дэлгэрүүлэн зохио.
Адис тэдийг хайрлагч эх буюу Жанлавцогзол.
Адистын дээдийг хайрлагч ихэс багш нар болон
Авралын хурыг буулгагч амирлангуй ба догшин тэнгис
Барцад бүхнийг арилгагч дагнис чойжин нугууд
Бишрэнгүй бээр бие сэтгэлээрээ мөргөн зальбиръя
Ариун сэтгэлээр бэлдсэн тахилын чуулганыг
Агуу огторгуйд дүүрэн түгээн дэлгэрүүлж
Алс хэтээс хурсан нүгэл хилэнцийг тэвчин
Аливаад дуурсагдах буяныг даган баясмуу
Асар дэлгэр номын хүрдийг эргүүлэн соёрхооч
Ачит тэр хүрд орчлонгийн эцэс хүртэл оршиг
Аяа үүгээр гийсэн буяны алив цогцос
Анхлан бүхний ухааныг гийгүүлэн тэтгэж
Ашид билгийн гэгээг гэрэлтүүлэхээр зорь тугай
Мунхаг цагийн их харанхуйгаар бүрхэгдсэн энэлсэн
Муу заяаны туйлыг нигүүлсэнгүй сэтгэлээр авар
Үйлийн үрийн гасланг сэтгэлээр боловсорсон
Үнэнхүү зовлонгийн их түймрийг намжааж
Өш хонзонгийн зовлонт сэтгэлийг арилган
Өрөвч ухааны гайхамшигт цогцос дэлгэрэх болтугай
Аврагтун аврагтун үнэн итгэлт дээдэс минь
Болгоогтун болгоогтун их нинжийн сан минь
Эндүүрэл алгасралгүй эртний зарлиг сонс
Эхлэн таалан соёрхож авралаар түргэн тэтгэ
Ариун шашны гэрэл арван зүгт дэлгэрч

Амьтан бүхэн амгалангийн цогийг дуурсган

Алмад түүтгэрийг зогсоох билгийн хутгийг

Асар түргэн дэлгэрүүлж хайрла

Дээд гурван эрдэнийн адистэд хийгээд

Дээдийн номын урвалтгүй барилдлагааны хүч

Хүндэтгэн сүслэн сахих бидний үйлсээр

Хүсэл бүхэн сэтгэлчлэн бүтэх болтугай

Аврал бүхнийг хураасан багшийн адистэдээр

Ахуй үесийн доройтол бүхэн амирлаж

Хорвоод сайн үйлс сүндэрлэн бүтэж

Хотлоороо цэнгэхийн өлзий орштугай

Балин өргөх ануу:

Эрхэм багш ядам цогт Очирваань нөхөр сэлтийн хэлний очироос гэрэл цацарч дэлгэрч балин шим орчлонг гийгүүлэн соёрхмой.

УТАА-ГҮРҮ-САРБА-БУДДА-БОДИ-САДУ-БАЗАР-ВАНИ-ДАГИЙ-САРВА ДАРМА-БАЛО-СА-ВА-РЭ-БА-РА-ЭДАМ-БАЛИМДА-ХА-ХА-ХА-ХЭ-ХА-ХЭ. (3 дахин уншина)

АРГАМ-БАДЭН-БҮСВИЙ-ДҮЙВИЙ-АЛОГЭ-ГАНДЭ-НЭВДЭ-ШАВДА-АХУМ

Нанчид өргөлөг:

УМА-ГҮРУ-САРВА БУДА БОДИ-САДУ-БАЗАР-БАНИ ДАГИЙ-САРВА-ДАРМА БАНА-САРВА-РЭ-БАРА Умаахум.

-Үйлс хайрлахуйн соёрхол

Тахил өргөлөгийн балин хүслийн таван эрдэм төгөлдөр, рашааны их далай энэ ямагтад багш ядам бурхан бодьсадва, дагинас, номын сахиус, ялангуяа цогт нууцын эзэн очирваань, тэнгэрийн чуулган нөхөр сэлт нугуудад өргөмой.

Таалаад Бурханы шашинг сахиж, чухаг дээд гурвыг магтан, хуврагын аймгийн тэтгэл багшийн насыг нэмэн хамаг амьтаны амгалан жаргаланг түргэн илт төгсгөн бурхан болохуй дор адистэдлэн соёрхоо ялангуяа, егүзор бясалгааг бид нар өглөгийн эзэд нөхөр сэлт нугуудын ад өвчин, дайсан тотгорын хорлол тэргүүт харшлах шалтгаан, барцад, үл зохилдох зүг бүхэн амирлах дор зохион соёрхоо.

Зохилдох шалтгаан болох нас хийгээд буян цог лугаа учирч эд эдлэлийн язгуур дамжлага арвидаж, яруу алдар есөн хүслийн хотол чуулган өлзий бүгд арвидан дэлгэрэх дор зохион соёрхоо.

Гурван ертөнцийн есөн төрөлтөн идэхүй, эдлэхүй бүгдийг эрхэнд нь орчуулан зохион соёрхоо. Бурханы шашин хийгээд шашиныг баригч дээд төрөлтөн нугууд Егүзэр бясалгаач бид нар өглөгийн эзэн нөхөр сэлт нугуудад хорлол үүлдэх хүн хийгээд хүмүүн бусын дайсан, уруу татагч бүгдийг одоо ямагт хатуугаар хашраах дор зохион соёрхоо.

Магтаал ануу:

НАМУ ГУРҮ МАНЗУ НРАРЯА

Хум

Хүч чадлаар тотгор бүгдийг хөөж

Хязгааргүй олон хувилж бурханы үйл бүтээж

Бурхан бүгдийн нууцын санг баригч

Бүхий л ягчисын аймгийг өнөд тэтгэн

Индранилээр цацарсан хөх уул мэт

Их эрдэнийн сүмбэр уул мэт машид үзэсгэлэнтэй

Эвдрэх цагийн гал мэт цацарсан

Энгүй хүчит тан дор мөргөмүү

Баруун уулын завсар үүл манан буух шиг

Баргар улаан шаргал үс нь дошгирон босож

Буух хурын ус цохилон гялбаж

Бүлтийх гурван шүдтэнд мөргөмүү
Богино бахим бүдүүн лагшин
Бархирах луун дуун сүртэй зарлигтай
Огторгуйн энтэй жишихгүй таалалтай
Онцгой бэрхийг номхотогчид мөргөмүү.
Бурангуйг цочоох дөрвөн соёо нь
Босож ярзайсан нь долгорын амийг авмаар
Гоц арзгар хөмсөг сахал нь бадарч
Галын оч шиг цацруулагчид мөргөмүү
Сэтгэл дулаан эрдэнээр машид чимж
Сүрт лусын чуулгаанаар мөчөө гоёж
Асарлан бадрах очирон үзүүрт
Аймшиггүй оршсон танд мөргөмүү.
Огторгуйг дүүргэж инээсэн дуугаар
Орон гурвыг хөдөлгөж өлмийгөөр бүжсэн
Нийт шуламыг эцэслэн егүүтгэгч
Нууцын эзэн амьтаныг аврагчид мөргөмүү
Тарина бүгдийг сэтгэлдээ багтаагчийн
Тагаалал, зарлиг, лагшинг магтаж
Хилэнцийн чуулган бүгд арилж
Хэцүү гурван зовлонгоос гартугай.
Нас буян цог алдаршаад
Дияан билигийн ухааны дээдээр
Надад шинийн сар мэт арвижаад
Дээд гурван үүдээр илт бүтээх хайрлан соёрх

Оршоолго.

Орны лээл ягчисын ордноос
Огторгуйд үзэсгэлэнт индранил өнгөтэй
Бурхан бүгдийн нууцын сан баригч
Баатар их сүрт та оршин соёрхоо.
Гүл буюу дурдлага Хум.
Хүч чадал эрхшээн очир баригч
Хилинт дүр баригч бурхад
Очирваан дүр баригч бурхад
Очирваан нөхөр сэлт нугууд
Онцгой дайсаныг дарах цагт дор буу
Шулмас эмсийн чуулган нугууд
Шашны бурханы жир дайсан
Чин сүжигээр багшийг шүтвэл
Чухаг дэгээд гурваан илүү
Гэндэж хуврагын хувийг булааж
Гэмгүй амьтаны амийг хөнөөх
Тарничин намайг хорлож үйлдэх үгүй
Тэгш алгасрал зохиол үгүй
Аюулт шулам эрлэг ягчис зэрэг
Аймаг найм цэрэглэн босгоход
Эвдрэх ёртой ч рит хувилгаанаар
Эцэслэн товоргон дайсны орныг
Аянга мөндөр хижиг өвчин
Аймшигт мэсээр хур буулгаж
Буруу зүгээс хураасан тахил
Байшин дотроос шимийг гарга

Хар үндэстэй шулам ураг
Харь дайсан муу үйл хилинцийг
Өдөр цаг жилээр нь мөшгөж
Өнөө цаг дор хөөн зохио

ЗАЯ ГЭГЭЭНИЙ ЗОХИОСОН ОТГОН ТЭНГЭРИЙН САН

Нууцын эзэн залраад тэтгэсэн тэнгэрийн дээд
Отгонтэнгэр оюунаар алдаршсан
Нөхөр сэлтийг сүсгээр урин залья
Эртнээс энд залран морилсонд
Энгүй амгалангийн сан тахил зооглоод
Би тэргүүт хүмүүнийг ялгалгүй
Барцад саад бүгдийг анирлуулж
Зохилдох цон учралыг дэлгэрүүл
Товчилбоос би тэргүүт амьтан бүгдийг
Түр агшин ч хагацалгүй байж
Төрөлхтөн бүхний аврал саданд зохио
Арван зүгийн хотол чуулганыг дуудан
Аз, эдлэл, цог учрал алдар хийгээд
Өлзий амгалан хотлоор гийж
Өөдрөг байдал хичээнгүй зэрэг
Өвөг садан нөхөр дор зохио
Хураабаас бидний ерөөлөөр
Хүссэн тус бүгдийг бүтээтүгэй.

Отгонтэнгэрийн ганшаг буюу тагаалал баяслага (Нийтийн бус)

ЖИ

Элдэв эрдэнээр чинсэн орд харш

Хотол чуулган төгс чимэг гоёлтой
Маш цагаан мишгэлзэнгүй нүүртэй төвд нь заларсан ч
Гадна дайсныг дарах сүр хүчтэй
Дээд тэнгэр отгонтэнгэр гэж алдаршсан
Нөхөр сэлтийн чуулган залран соёрх

Бүгдийн эд сан болсон шинст хайрхан
Товцог уул, богдын гол мөрөн
Хан,чин уулууд тайгу орших зэрэг
Энэ зүгийн эзэд залран соёрхоо

Номын чанарын агаараас цацарч
Мэдэхгүй, сэрэмжгүй эрхээр буй та нарын
Таалалд харшлах гэм бүгдийн
Таалан болгоохын агаар номончилон
Сэтгэлд зохист үзэсгэлэнт дээдийн эндээг
Очирт хөө хуяг элдэв мэс зэргийг
Хүслийн таван эрдэм тахил, балин, сангаар
Хүчит тэнгэр хан хатны таалал баясаг

Харшлах бүгдийг зохилдуулж бүтээ.
Бар араатан морь элдэв зэрэг
Баахан сарлаг хонь ямаа амьтныг оруулах
Улаан цагаан Зандан ошил зэрэгийн үнэртэн
Утаан хөшиөг үүл тэнгэр бурхан
Дээд тэнгэр отгоны хан танан ариусаг
Дэргэдэх түшмэл шавь нар ариусаг

Зарлиг хүлээсэн жинст зэрэг савдаг ариусаг
Их уул товцог хайрхан ариусаг
Богдын гол ханчин улаатай хийгээд
Ус ууланд орших эзэд ариусаг
Аруулагт зочилсон бүгд ариусаг
Дээд тэнгэрийг мөнхөд шүтэн тахиж
Аав мэт энэрч эсрэгийг буцаа
Усны хөөс шиг үлдэн хөөж
Ус гол ээж шиг энэрч хайрла

Цаст уул мэт үзэсгэлэнт лагшинт
Цааргалсныг уяраах яруу их зарлигт
Энэ нутаг бээн энэрхүй таалалтай
Эвийг бүтээхийн сан танийг магтая

Тахил болсон сангийн идээн далайг болгоож
Тахисан айл гэр бүр дүүрэг
Хүмүүний удам, нас, баялаг алдар зэрэг
Хязгааргүй хишиг хурчилан бууг
Бадам цэцэг нараар цоморлоглох шиг
Буян амгалан бумаар арвинийн
Хориг саад бүгдийг амирлуулж
Ариро чуулганы өлзий ортугай.

ОЧИРВААНЫ СЭРЖИМ БУЮУ АЛТАН УНДАЛГАА ӨРГӨХҮЙ

Хум

1. Их таван хүсэл эрдмийн алтан ундаагаар
Илт дамжлагын багш едам дор
Тахил өргөхөд таалан нь баясаад
Адистан шидэс бүтээл хайрлал

Хум

2. Их таван хүсэл эрдмийн алтан ундаагаар
Чухаг дээд гурав сахиусны чуулган дор
Тахил өргөхөд таалан баясаад
Илт бүтээл хайрлан үйлсийг дэлгэрүүлэн зохио

Хум

3. Таван хүсэл эрдэмийн алтан ундаагаар
Нууцын эзэн очирваан нөхөр сэлт дор
Тахил өргөхөд таалан баясаад
Дээд зохист шидэс бүтээл хайрла

Хум

4. Таван хүсэл эрдмийн алтан ундаагаар
Номчилон дагагч бисман тэнгэр зэрэгт
Тахил өргөхөд таалан баясаад
Санасан хэрэгийг номчилон бүтээж зохио

Хум

5. Таван хүсэл эрдмийн алтан ундаагаар
Номыг сонсогч гадна дотны нөхөд дор
Тахил өргөхөд таалан баясаад
Дөрвөн үйлсийг дэлгэрүүлж зохио

Хум

6. Таван хүсэл эрдмийн алтан ундаагаар

Гурван ертөнцийн дисийн чуулган дор

Тахил өргөхөд сэтгэл нь баясаад

Ном лугаа зохилдон нөхөр дор зохио

Гэрдөг хутагт Цүлтэм бээр зохиов

Нангод буюу дотоод тахил адислагаа



Умаа-христэ-бидида-нана хум-пад, умаа-савава шүдо-сарва-дарма-савава шүдо-хум-хоосон чанарт хувирмой.

Хоосон чанарын агаараас ям-үсэг хийн хот мандал хөх нум хэлбэртэй бадангийн мөн чанартай, түүний дээр рам-үсэгээс гарсан цагаан толбо, толбын зүүн дотор бүрэм үсгээс гарсан үхрийн махбодийн хувь мөн чанартай. Урьд зүгээс ам-үсгээс хувиран гарсан нохойн махбодь гү-үсгийн чанарт баруун зүг «зарам» үсгээс хувирсан зааны махбодь дай-үсгийн мөн чанарт хойд зүгээс «хан»

үсгээс хувиран морин махбодь «ха»-үсгийн мөн чанарт, төв голд хум-үсгээс хувирсан хүмүүн махбодь «най» үсгийн мөн чанарт зүүн урьд зүгт лам үсгээс хувирсан өтгөн би-үсгийн мөн чанар, Баруун урьд зүгт мам-үсгээс хувирсан цус - рай үсгийн мөн чанарт, баруун хойд зүгт вам - үсгээс хувирсан цагаан дусал шүй үсгийн мөн чанарт, зүүнхойд зүгт дам-үсгээс хувирсан чөмөг май үсгийн мөн чанарт, төв голд вам үсгээс хувирсан шээс мү үсгийн мөн чанарт тэдгээрийн дээр ум-үсэг цагаан, а-үсэг улаан хум - үсэг хөх гурвын дээр дээрээс давхарламой.

Өөрийн тааллын хум үсгээс гэрэл цацран салхи гарч салхилан галын бадраан толбо доторх зай нугууд хайлан буцалмой, гурван үсгээс гэрэл дэс дараалан цацарч лагшин дорж нугуудыг дуудан гурван үсэг ээлжлэн толбон дотор шингэн хум үсгээс өнгө, үнэр бүгд гэм ариусан, «о» үсгээс рашаан охь болж, ум-үсгээр улам бадран арвидмой.

Умаа хум. 3 удаа унших

Тахил адислагаа

-Умаа христэ бидида нана хум пад умаа савава-шүдо-сарва дарма-савава шүдо хум хоосон чанар дор хувирмой хоосон чанарын агаараас А-үсгээс гарсан толбо уужим агуу ихийн дотор хум, хум үсэг хайлан гарсан тахилын ус, нүүр сэрүүцүүлэх усан тахил, цэцгэн тахил, хүж, үул, үнэртэй ус, идээ, хөгжим тэргүүт амгалан уужим байдалт тахилын зай, зургаан мэдрэхүйн төгс эдлэлд цуваралтгүй амгаланг үүсгэж үйлдмой.

Аргээн-ахум
Бүсвээн-ахум
Ологээн-ахум
Нэвдээн-ахум
Рубаан-ахум
Гандээн-ахум
Варшаан-ахум
Бадээн- ахум
Дүйвээн-ахум
Гандээн-ахум
Шавдаан-ахум
Шавдаан-ахум
Расаан-ахум

агдүг-чагдүг буву зургаан мутарлаг зургаан тарина унших.

Ум.

Аяндаа бүтсэн их амгалангийн ордноос

Гурван цагийн бурхад цэцгийн цоморлогт

Язгуур баригч баатар дагинасын тойрог чуулган

Торолтгүй тааллаараа залран соёрх

Өмнийн огторгуйд уужим цэцгийн цомогт

Арслант ширээ нар саран дэвсгэрт

Сэтгэл булаам солонго татан хүрээлсний төвд

Өлмий гэрэлтэн залран соёрх

Гадны тахил орчлонг дүүрч

Дотны тахил цувралтгүй далай мэт

Нууцын тахил үгээс хэтийдсэн амгалантай

Амьтны тусын тухайд цэнгэн соёрх

Язгуур бүтээгчийн цэцгэн эрх

Цогт төгөлдөр оройн зул мэт

Очирыг баригч богд лам бээр

Элдвээр бүжин зохиосонд мөргөмүү

Цогт шашиныг тэтгэгч нөхөр сэлт

Тэдний зарлиг тангараг оршин

Дөрвөн үйлс аяндаа бүтээд

Номын дууг дэлгэрүүлж зохио.















МОНГОЛ ОРНЫ САН

Би ямагт нэгэн эгшин дор нэг нигуурт хоёр мутарт Аръяабал бурхны дүрийг эрхшээмой.

Ариусгалын тахил балин гадаад дотоод нууцын

Агуу сүсэгтнүүдийн мөнхийн мэлмийг дүүрч

Цувралтгүй бэлэг билгийн рашааны усан далай

Цалиглан давлах тахил мэт болтугай.

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа агуу хүчит бүрэг хангай хийгээд

Алдарт бүрэн Орхон Сэлэнгэ мөрөн

Асарлах уул урсах ус бүхнээ оршсон

Ачит их навдаг шавдаг бүгдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Онон Алтай хавийн их уулс ус

Олноо алдартай Увс их арал тэргүүт

Ихэнх уул усан бүхнээ оршсон

Илч этгээдийн хамаг шавдагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хэнтий улаан сүрэг болон

Хэрлэн Туул Хөлөн тэргүүт

Догшин уул усан бүхнээ оршсон

Дорно зүгийн шавдаг бүхнийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа

Умар зүгийн монгол орны их сүлдэн тэнгэр

Уул хангай ханы дөрвөн их тэнгэр

Эх хөвгүүн гадаад дотоод түшмэл

Элчис үйлчний нөхдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Бас бус дөрвөн зүг найман зовхисын

Бараантан шовхрох их хайрхан

Ус гол их мөрөнд оршсон

Улс орны тэнгэр шавдаг хамгийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Ялангуй ба бүрний нөхөр сэлт

Ямарваа шүтээн мөр үйл хамаг гуравнаа

Алинд ч оршсон энэ зүгийнхээ

Алдарт орны тэнгэр хамаг шавдагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хангай ханы аймагт харъяалагдсан

Хань болох Идэр Тэрх хоёр Хас өлзийт

Цагаан нуур Чулуутын Хамаг шавдаг орны тэнгэрийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Даллага авах

Хоёр түүтгэрээс ариуссан номын шим

Хэлбэрэлт үгүй бат бүхний суурь

Өндөр үгүй бат бүхний суурь

Өнөөдрийн идээр даллан авъяа

Хурай Хурай Хурай

Ариун огторгуйн төв хүчнээс

Алаглах солонго зуран хээлсэн мэт

Өмнүүрхэн ургах хишиг бүгдийг

Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Асар арвин төгс долоон эрдэнээр

Аварга их тивүүдийг эрхшээгч

Өнхрөх хүрдийг эрхшээгч хишгийг

Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Олноо өргөгдсөн хаанаас эхлээд Оргил эхт Гангын урсгал мэт Өнөд үргэлжлэх хишиг буяныг Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Гурван сургаалын ёзоорыг баригч хөвүүн

Гунхашгүй мөчрийн үзэсгэлэнт нахиа

Хоёр зэргийн эцэст хүрсэн үрээр

Хосгүй үзэсгэлэнт төгс номын хишиг ба

Үхлийн эзний аймгийг ч ялсан

Үхэлгүй бүтээх насны хишиг

Өнөд оршоох буян заяаг ч

Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

МАНДАЛ ӨРГӨХ ЁСОН ОРШВОЙ.

Орон дэлхийг өргөн айлтгомой. **Ум базар бүмэ-а-хум**

Их эрхэт алтан дэлхий . **Ум базар рэ-хэ а-хум**

Гадуур төмөр уулаар эргэн тойрон хүрээлсний төвд, уулсын хаан Сүмбэр уул, Дорноо үлэмжийн биет, Өмнөө Замбуу тив, Өрнөө Үхэр эдлэгч тив, Умараа Муу Дуут тив болон Биет хийгээд Үлэмж биет завсрын тив, Дохиурт хийгээд Бус дохих завсрын тив, Хэлбэрэлт хийгээд Дээд мөрт зорчигч завсрын тив, Муу дуут хийгээд муу дуутын нөхөр завсрын тив, Эрдэнийн уул, Галбарагча мод, Гаминдини үнээ. Эс тарьсан тутарга, Хүрд эргэнэ, Чандмань эрдэнэ, Хатан эрдэнэ, Түшмэл эрдэнэ, Заан эрдэнэ, Морь эрдэнэ, Баатар эрдэнэ, Их сангийн хумх, Үзэсгэлэнт эх, Эрхич эх, Дууч эх, Бүжигч эх, Цэцгэн эх, Хүжирч эх, Үнэртэн эх, Наран, Саран, Эрдэнийн шүхэр, Хамаг зүгээс сайтар ялгагч ялгуусны тэмдэг, Төв дунд тэнгэр хүмүүний хотол төгс цог учрал бүрдсэн эдгээрийг ачит ёзоорын ба дамжлага сэлтийн цог төгс лам дээдэс хийгээд, Итгэлт нигүүлсэнгүй Аръяабал нөхөр лүгээ сэлтэд өргөмүй. Их нигүүлсэнгүйгээр амьтны тусад таалан соёрхоо.Таалан соёрхоод би тэргүүтэн хамаг амьтныг адистэдлэн соёрхоо.

Газар дэлхийг анхилам хүжсээр сүрчин цэцэг дэлгээд

Сүмбэр уул, дөрвөн тив, нар сараар чимэглэсэн үүнийг

Гэтэлгэгч бурханы гайхамшигт орноо зоригдон өргөснөөр

Сац амьтан бүхэн арилсан орноо эдлэхүй болтугай

Тус амгалан гарахын орон шашин өргөжин дэлгэрснээр

Шашиныг баригч төрөлхтөн бүгдийн бие батжин сайжирч

Түйтгэрт амьтан бүхэнд амгалан жаргалан гарахын орон

Шагжамүнийн шашин өнө мөнхөд орших болтугай

Богд тойн ламын нас сүүдэр машид батжаад

Буянт цагаан үйлс арван зүгт дэлгэрэх ба

Зонхабын шашины зул гурван газрын амьтдыг

Зүдрээгч мунхагийг ашид гийгүүлэх болтугай

Буяныг ихэд дэлгэрүүлэгч төгс баясгалант Их хөлөгний хийд
Сансрын эцсийг хүртэл оршин өргөжин үйлс нь дэлгэрээд
Саруул оюунт олон мэргэд үргэлжид хурдан чуулаад
Бахдам номлол бүтээлийг шинийн саран мэт арвижуулсугай

Багш шавь нугуудын ном лугаа зохилдох шалтгаан
Ямар мэт санасанаар сэтгэлчлэн бүтэх хийгээд
Барчид саад өвчин, ад, тотгорлогчийн чуулган
Ямар мэт буйг амирлуулан адистлэн соёрхоо.

Дээд их эрдэнэ бодийн сэтгэл
Эс төрсөн нь төрөх болтугай
Эрт төрсөн нь доройтолгүй
Дээш дээш арвижих болтугай
Орон үүнд өвчин, мэсний аюул, зуд турхан зэрэг
Үл зохилдон доройтуулагчийн нэр ч гаралгүй
Оройн дээд Зонхабын шашин зүг бүхнээ дэлгэрээд
Үймрэгч амьтан бүхнээ амгалан жаргалан төгс болтугай

Өмөг болсон их нигүүлсэхүй, энэрлийн мөн чанарт бээр
Би тэргүүтэй хамаг амьтны харшлах шалтгааныг арилгаж
Өвчин, ад, хилэнцийн түйтгэрийг сайтар амирлуулаад
Балартуулагч гэм хирээс нүдийг илааршуулан адистэдлэ

Эцэг, эх хамаг амьтан амгалан лугаа төгс болтугай
Энэлгээт муу заяаны орон бүгд үргэлжид хоосроод

Энэрэлт Бодьсадбын аль ч газарт оршсоноор
Эндүүрэлгүйгээр тэдний ерөөл бүтэх болтугай

Өглөгийн эзэн нөхөр сэлт нүгүүдийн
Нас үүнээ санасан хэрэг бүтэх бөгөөд
Өмөг бус зэтгэр амирлан, өлзий хутаг
Номчилон санаснаар бүтэх болтугай

Гайхамшигт Бодьсадба сэлт Бурхадын адистэд ба
Аяа шүтэн барилдлага хуурмаг үгүй үнэн хийгээд
Гагц бас миний ариун санааны хүч чадлаар
Асар ариун ерөөлийн орон энэ нь бүтэх болтугай
Бишрэнгүйгээр мөргөж, тахиж, наминчилсан хийгээд
Бишрэнгүйгээр даган баясаж, дуртган залбирсанаар
Бишрэнгүйгээр өчүүхэн буян юу хураасан бүгдээ
Бишрэнгүйгээр би бээр бодийн уг доор зориулмой

Хотол хүслийн баялаг нь зуны далай мэт аврижиж
Хориг гэм үгүй язгуурын явдал үргэлжид тасралтгүй
Хоног өдөр бүхэнд Зонхабын шашны номын дуу дуурсаж
Хотол чуулганы цогоор цэнгэхийн өлзий хутаг орштугай

Умаа сарваан дата гада раднаа мандала хам ниряа даряами

ТҮЙ БУЮУ УГААЛ ӨРГӨХҮЙ.

Тэгүүнчлэн ирсэн бурхан бүгд бээр надад илт авшиг хайрлан соёрх хэмээвээс бурхадын таалалаас гойгарму буюу цагаан баринтагт тэнгэр тэргүүт охин тэнгэр нугууд бээр рашаан дүүрсэн Бумба бариад-

Тэр мэт бурхан мэндэлмэгц

Тэнгэр нугууд угаал өргөсөн адил

Тэнгэрийн ариун рашаан дор

Тэгүүнчилэн би бээр угаал соёрхоё

УМА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-А-ХУМ

ТҮЙ буюу угаал өргөхүй

Бурханы лагшин зарлиг таалал хир үгүй ч

Бусдын бие хэл сэтгэлийг ариулахын тухайд

Бурханы лагшинд угаал өргөснөөр

Бүхий л хүмүүний сэтгэл ариустугай

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-ГҮЧИЙН-00

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

0гоот төгс лагшинт тан дор

0рчлонгийн хүлээс үгүй ч гэсэн

Адаг биднийг ариулахын тухайд

Ариун усаар соёрхол өргөе

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-ГҮЧИЙН-00

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Эрхэм бурхан шавь нугуудад
Эрдэнийн бумбандах ариун усаар
Сэтгэл зохисоор дүүргэх лус нь
Силнэнгийн дуутай хамт угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА
ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Өглөгийн чанарт энэ усаар
Өөдгүй хармын хирийг угааж
Өгөгдэхүүн болсон цэвэр усаар
Өөр бусдад угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Шагшаабодийн чанарт усаар
Шантрах муу гэмээ ариулаад
Сахилын цэвэр энэ усаар
Сахиагүй бүгдэд угаал өргөмү

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-

ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Тэсвэрийн чанарт энэ усаар
Тэсэшгүй уурын гэмээ ариулаад
Асралын чанарт энэ усаар
Амьтан бүхэнд угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Хичээлийн чанарт энэ усаар
Хойшлуулахын залхууг арилгаад
Хичээнгүйн цэвэр рашаанаар
Хотлыг шамдуулах угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Самадийн чанарт энэ усаар
Саад алгасрал гэмийг арилгаад
Бясалгалын үнэрт энэ усаар
Бясалгаагүй түмэнд угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Ухааны чанарт энэ усаар
Ухаараагүйн гэмийг арилгаж
Увидаст энэ рашаанаар
Ухааны хур буулган өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Угаалын дээд цог төгөлдөр
Таалал ханьцасгүй энэ усыг
Билгээр адислан рашаалсанаар
Бүгд хүсэл биелүүлж хайрла

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-00
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРЭХИЙН ЕРӨӨЛ

Баатар долоон бурханд мөргөмү
Амьтны тусд урьд би
Аль бэрх хатуужлыг эдлээд
Амар жаргалаа зориулсны хүчинд
Ариун шашин өнөд бадартугай

Өвчтөний тусд урьд би
Өөрийн амь амьдралын зольж
Үгээгүү амьтныг эмнэсний тулд
Үнэн шашин өнөд бадартугай

Эхнэр хийгээд хөвгүүд охид
Эд эрдэнэ, хөлөг хэрэгслээ ч
Эгнэгт гэгээрлийн төлөө зольсноор
Эрхэм шашин өнөд бадартугай

Эцэг, эх, ширвага, брадига
Энэрэлт бурхан, арш дээдэст
Эндэлгүй би вээр тахил өргөснөөр
Эрдэнэ шашин өнөд бадартугай

Олон сая галавт би
Онц элдэв зовлонг амсч
Оюун гэгээрүүлэх номыг эрснээр
Онол шашин өнөд бадартугай

Асар нарийн ёс журам
Аливаа хатуужлыг үргэлж сахин
Арван зүгийн бурхадыг тахиснаар
Аврал шашин өнөд бадартугай

Эргэж буцахгүй хичээл зүтгэлээр
Эсрэг хүчин бүхнийг ялж
Эндүүрч төөрөгсдийг аварсан тул
Эрдэмт шашин өнөд бадартугай

Хүлцэл тэвчээрийг үргэлж эрхэмлэн
Хөнөөлт сэтгэлийн өвчинд баригдсан
Хөөрхий дордсыг уучлан хайрласнаар
Хүндэт шашин өнөд бадартугай

Ганга мөрний хумхийн тоо шиг
Дээд түвшний дияан бясалгалыг
Гаргууд сайн эзэмшсэн тул
Гайхамшигт шашин өнөд бадартугай

Билиг ухаан нээхийн тулд
Бэрх хатуужлаар аглагт сууж
Бичиг шаштир судалсны хүчинд
Бишрэлт шашин өнөд бадартугай

Өршөөлт энэрлээр мах цус
Өнө амьдрлаа ч огоот зориулж
Үе мөчөө харамгүй өгснөөр
Үнэн ном машид дэлгэртүгэй

Алдас нүгэлтнийг урьд би
Агуу хайраар асран сэнхрүүлж
Аль зохих замд нь оруулснаар
Алдаршгүй номын өглөг арвижтүгэй

Арга билгийн хүчээр би
Атхаг үзлээс бусдыг чөлөөлж
Ариун үнэнд залуурдсаны тулд
Авралт ном үлэмж дэлгэртүгэй

Хураах дөрвөн үйлсээр би
Хорсол тачаалын галаас аварч
Хор хилэнцийн хүчийг ялснаар
Хувьт шавь нар минь өнөд орштугай

Буруу зөрүү номтныг би
Буртагт үзлийн уснаас гэтэлгэж
Буцалтгүй үнэн үзэлд оруулснаар
Буянт нөхөд минь өнөд бишэртүгэй

Бурхан шашин үүрд бадартугай

НОМ ЗҮЙ

1. “Монголын сүм хийдийн түүхэн товчоон” Ерөнхийлөгчийн тамгын газраас эрхлэн хэвлүүлсэн, Улаанбаатар, 2009 он
2. Монгол улсын шастир
3. Хутагтуудын өлгий миний шилүүстэй
4. Халхын тамга бүхий хутагтуудын товчис
5. Үндэсний Архивын газраас авсан материалаас
6. Их Монгол оронд уламжлагдсан ирээдүйг эш үзүүлсэн бошгууд
7. Дилов хутагтын дуртгал
8. Чингис хааны тахилгын сударыг монгол хэлэнд орчуулан оруулав
9. Монгол нутгын санг түвд хэлнээс орчуулан оруулав
10. Уналыг наминчлахуй хэмээх судрыг түвд хэлнээс монгол хэлэнд орчуулан оруулав
11. Тэгчин сожин авахуй судрыг төвд хэлнээс орчуулан оруулав,
12. Түвдэнпэлжээлин хийдээс гаргасан Отгонтэнгэр хайрханы тахилгын сударыг түвд хэлнээс орчуулан оруулав
13. Наро Банчэн хутагтын залбиралын түвд сударт түвдөөр нэмэлт оруулав
14. Зая гэгээний зохиосон Отгонтэнгэр хайрханы сангийн сударыг түвд хэлнээс орчуулан оруулав
15. Эрдэм шинжилгээний хурлуудын илтгэлүүдийг бүрэн эхээр нь оруулав
16. Ямандага нэг баатрын буюу Бажигжигжидын судрыг түвд хэлнэс орчуулан оруулав
17. Очирвааны сэржмийн судрыг түвд хэлнээс орчуулан оруулав
18. Долоон одны тахилгын судрыг түвд хэлнээс орчуулан оруулав

"Wherever the Buddha's teachings have flourished,

either in cities or countrysides,

people would gain inconceivable benefits.

The land and people would be enveloped in peace.

The sun and moon will shine clear and bright.

Wind and rain would appear accordingly,

and there will be no disasters.

Nations would be prosperous

and there would be no use for soldiers or weapons.

People would abide by morality and accord with laws.

They would be courteous and humble,

and everyone would be content without injustices.

There would be no thefts or violence.

The strong would not dominate the weak

and everyone would get their fair share."

✻THE BUDDHA SPEAKS OF
THE INFINITE LIFE SUTRA OF
ADORNMENT, PURITY, EQUALITY
AND ENLIGHTENMENT OF
THE MAHAYANA SCHOOL✻

Taking Refuge with a mind of Bodhichitta

In the Buddha, the Dharma and the Sangha,
I shall always take refuge
Until the attainment of full awakening.

Through the merit of practicing generosity
and other perfections,
May I swiftly accomplish Buddhahood,
And benefit of all sentient beings.

The Prayers of the Bodhisattvas

With a wish to awaken all beings,
I shall always go for refuge
To the Buddha, Dharma, and Sangha,
Until I attain full enlightenment.

Possessing compassion and wisdom,
Today, in the Buddha's presence,
I sincerely generate
the supreme mind of Bodhichitta
For the benefit of all sentient beings.

"As long as space endures,
As long as sentient beings dwell,
Until then, may I too remain
To dispel the miseries of all sentient beings."

GREAT VOW
BODHISATTVA EARTH-TREASURY
(BODHISATTVA KSITIGARBHA)

“ Unless Hells become empty,
I vow not to attain Buddhahood;
Till all have achieved the Ultimate Liberation,
I shall then consider my Enlightenment full !”

Bodhisattva Earth-Treasury is
entrusted as the Caretaker of the World until
Buddha Maitreya reincarnates on Earth
in 5.7 billion years.

Reciting the Holy Name:
NAMO BODHISATTVA KSITIGARBHA

Karma-erasing Mantra:
OM BA LA MO LING TO NING SVAHA

With bad advisors forever left behind,
From paths of evil he departs for eternity,
Soon to see the Buddha of Limitless Light
And perfect Samantabhadra's Supreme Vows.

The supreme and endless blessings
of Samantabhadra's deeds,
I now universally transfer.
May every living being, drowning and adrift,
Soon return to the Pure Land of Limitless Light!

✻ The Vows of Samantabhadra ✻

I vow that when my life approaches its end,
All obstructions will be swept away;
I will see Amitabha Buddha,
And be born in His Western Pure Land of
Ultimate Bliss and Peace.

When reborn in the Western Pure Land,
I will perfect and completely fulfill
Without exception these Great Vows,
To delight and benefit all beings.

✻ The Vows of Samantabhadra Avatamsaka Sutra ✻

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.
May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA

南無阿彌陀佛

《外蒙文：顛津恆度仁波切與近 300 年蒙古佛教的歷史》

財團法人佛陀教育基金會 印贈

台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: http://www.budaedu.org

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

Printed in Taiwan

3,500 copies; September 2018

MO038 - 16016